



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ЭМХЭТГЭЛ

/2013 он/

Сүхбаатар 2013 он

Гарчиг

Нэг. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол

- 1) Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 5-17
- 2) Үндсэн чиглэл батлах тухай 18-42
- 3) Аймгийн ИТХ-ын 2012-2016 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө батлах тухай 43-49
- 4) Сүхбаатар, Зүүнхараа хотуудыг улсын зэрэглэлтэй хот болгох саналын тухай 50
- 5) Малчид, тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг хангах журам батлах тухай 51-55
- 6) Сэлэнгэ аймгийн хөгжлийн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам батлах тухай 56-62
- 7) Орхон, Сайхан сумдын хилийн цэсэд өөрчлөлт оруулах саналын тухай 63-67
- 8) Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар сумдын хилийн цэсэд өөрчлөлт оруулах саналын тухай 68-73
- 9) Аймгийн 2012 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан батлах тухай 74
- 10) Аймгийн хөгжлийн сангийн төсөв батлах тухай 75
- 11) Аймгийн эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай 76-102
- 12) Аймгийн 2013 оны тодотгосон төсөв батлах тухай 103-123
- 13) Аймгийн 2014 оны төсөв батлах тухай 124-140
- 14) Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны ажлын тайлан 141-143

Хоёр. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол

- 1) Улсын тэргүүний тариаланч хамт олноор шагнуулах тухай 144-145
- 2) Улсын тэргүүний тариаланчаар шагнуулах тухай 146
- 3) Улсын сайн малчнаар шагнуулах тухай 147
- 4) Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тухай 148
- 5) 2013 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод, түлээ бэлтгэх тухай 149-155
- 6) Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны ажлын төлөвлөгөө батлах тухай 156-166
- 7) Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай /Орхон сумын ЭМТөв/ 167
- 8) Зөвшөөрөл олгох тухай /7 дахь өдрийн адвентист сүм/ 168
- 9) Соёлын өвийг бүртгэх тухай 169
- 10) 2013 онд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээг батлах тухай 170-179
- 11) Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын 2012 оны үйл ажиллагааны тухай 180-181
- 12) Орон нутгийн Сэлэнгэ телевизийг өөрчлөн байгуулах тухай 182
- 13) Комисс байгуулах тухай /ЖДҮ/ 183-184

14)Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны дэгийг батлах тухай	185-190
15)Аймгийн ХАБ, эрүүл ахуйн салбар хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, дүрмийг шинэчлэн батлах тухай	191-194
16)ХАБ, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	195-196
17)Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	197
18)Ахмадын байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай	198
19)Сэлэнгэ энерго үйлдвэрийн газрын талаар авах зарим арга хэмжээний тухай	199
20)Баруунхараа тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ыг татан буулгах тухай	200
21)Тогтоол хүчингүй болгох тухай	201
22)Мэргэжлийн комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	202-203
23)Комисс байгуулах тухай	204
24)Зөвлөл байгуулах тухай	205
25)Эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдал, цаашдын зорилтын тухай	206-207
26)Нэрэмжит болгох санал уламжлах тухай	208
27)Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай /Түшиг сум 90 жил/	209
28)Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай /Зүүнхараа САА-90 жил/	210
29)Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр батлах тухай	211-218
30)Төлөвлөгөө батлах тухай /Ажилтай орлоготой Монгол хүн/	219-229
31)Баяр наадам зохион байгуулах тухай	230
32)Хүндэт иргэнээр өргөмжлөх тухай	231
33)Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай / Ерөө сум 90 жил/	232
34)Хилийн цэсийн эргэлтийн цэгүүдийг хүлээн зөвшөөрөх тухай	233-239
35)Журам батлах тухай	240-246
36)Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	247
37)Нэмэлт модны хуваарь батлах тухай	248-250
38)Гачууртын алтны үндсэн ордыг ашиглах төслийг дэмжих тухай	251
39)МАН-н талаар гаргасан тогтоол шийдвэрийн биелэлтийн тухай	252-253
40)Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай / Зүүнбүрэн сум 90 жил/	254
41)Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай / Шаамар сум 90 жил/	255
42)Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ТУЗ-ийн ажиллах журмыг батлах тухай	256-260
43)Тохижилт, ариун цэвэр, цэвэрлэгээний талаар албан байгууллага, иргэдээс дагаж мөрдөх журам	261-265
44)Зарим бүтээлийг бүх нийтээр судлах сурах тухай	266
45)Сэлэнгэ телевизийг татан буулгах тухай	267
46)Орон сууц хувьчлах тухай	268-269
47)Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай / Цагааннуур сум 90 жил/	270

48)Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай / Зүүнбүрэн сумын сургууль 90 жил/	271
49)Тэмцээн зохион байгуулах тухай	272
50)Түлээний мод бэлтгэх тухай	273-274
51)Төсөлд хамруулах тухай /Шаамар/	275
52)Аймгийн аудитын тайлангийн тухай	276
53)Улсын сайн малчнаар шагнуулах саналыг дэмжих тухай	277
54)Улсын сайн малчнаар шагнуулах саналыг дэмжих тухай	278
55)Улсын сайн малчнаар шагнуулах саналыг дэмжих тухай	279
56)Улсын тэргүүний тариаланч хамт олноор шагнуулах саналыг дэмжих тухай	280-281
57)Улсын тэргүүний тариаланчаар шагнуулах саналыг дэмжих тухай	282-283
58)Олон нийтийн оролцоо, төрийн үйлчилгээ хөтөлбөр батлах тухай	284-291
59)Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр батлах тухай	292-298
60)Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай / Мандал сум 90 жил/	299
61)Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай / 4-р цэцэрлэг 70 жил/	300

Нэг.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 03 сарын 21-ний өдөр

Дугаар 12

Сүхбаатар

**Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл
ажиллагааны хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1.-ийн “д”, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтуудыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг иргэд, олон нийтийн оролцоонд тулгуурлан шуурхай зохион байгуулж, биелэлтийн явц үр дүнг жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, иргэдэд мэдээлж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Бүрэнбат/-д даалгасугай.

3.Хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн бүтээлч санаачилга гарган ажиллахыг аймгийн бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, нутгийн захиргааны байгууллагуудад даалгаж, аж ахуйн нэгж, байгууллагууд, нийт иргэдэд уриалсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2012-2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Үйл ажиллагааны хөтөлбөрийн эрхэм зорилго:

Хүнээ дэмжиж, хөгжилд түүчээлье

Үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго:

Нэг. Иргэдийн эрэлт, хүсэлт санал санаачилга, оролцоонд тулгуурласан хөгжлийн бодлого, үйл ажиллагаагаар Сэлэнгэ нутгаа хөгжүүлнэ.

Хоёр. Хүний хөгжил, хэрэгцээг хангах ажил үйлчилгээгээр Сэлэнгэчүүдийн амьдралд дэвшил гаргана.

Гурав. Иргэдийнхээ эрх ашгийг эрхэмлэсэн төрийн ил тод, шуурхай үйлчилгээг Сэлэнгэ нутагт төлөвшүүлнэ.

НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1. Хөдөө аж ахуйн бодлого

Мал аж ахуй, газар тариаланг эрчимжүүлэн хөгжүүлж, өндөр ашиг шимт малын өсөлт, үр тариа, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлтээр улсад тэргүүлж, эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн бүс нутаг болно.

1.1.1. Газар тариалангийн салбарын хөрөнгө оруулалтыг дэмжин, хөрс хамгаалах шинэ дэвшилтэт техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний га-гийн ургацыг нэмэгдүүлнэ.

1.1.2. Тариалан эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгжийг олон үйлдэлт хөдөө аж ахуйн машин, тоног төхөөрөмжөөр хангах бодлого хэрэгжүүлнэ.

1.1.3. “Хүнсний ногоо” хөтөлбөр хэрэгжүүлж, ногоочдын хөдөлмөрийг хөнгөвчлөх зорилгоор “Хүнсний ногооны техник үйлчилгээний дундын парк”-ийг сумдад байгуулж, төмс, хүнсний ногооны тарилт, арчилгаа, хураалтын ажлыг механикжуулна.

1.1.4. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд үр тариа, төмс, хүнсний ногоо хадгалах зориулалтын тоног төхөөрөмж бүхий зоорь, агуулахын аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

1.1.5. Гадаргуугийн урсацын усыг ашиглах бодлого, зохицуулалтын арга хэмжээ авч, усалгаатай тариаланг нэмэгдүүлнэ.

1.1.6. Иргэд, айл өрхийн төмс, хүнсний ногооны үр, жимс жимсгэний суулгац үржүүлэх, зах зээлд нийлүүлэх санал, санаачилгыг дэмжиж, боломж, нөхцөлөөр хангана.

1.1.7. Үр тарианы үр үржүүлэх, үрийн чанарыг сайжруулах иргэн, аж ахуйн нэгжийн санал, санаачилгыг дэмжиж, хатуу буудайн тариалалтыг нэмэгдүүлнэ.

1.1.8. “Ээлжлэн тариалалтын систем” аймгийн хөтөлбөр хэрэгжүүлж, цулгүй уриншийн эзлэх хувийг бууруулан, эзэмшилт уринш, ногоон хучилттай технологиор хөрсний үржил шимийг сайжруулна.

1.1.9. Малчид, тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг хангах журмыг олон нийтийн санал санаачилгад тулгуурлан боловсруулж мөрдөнө.

1.1.10. “Хамгаалагдсан тариалан” аймгийн хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

1.1.11. Хөдөө аж ахуйн биржийн анхан шатны нэгжийг сумдад байгуулж, иргэд, аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн борлуулах нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.

1.1.12. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, малын үржлийн албыг бэхжүүлнэ.

1.1.13. Сүргийн бүтцийн зохистой харьцааг бүрдүүлж, өндөр ашиг шимт болон нутгийн шилмэл малын, нийт малд эзлэх хувийг тогтвортой нэмэгдүүлнэ.

1.1.14. Малчид, мал бүхий иргэдийн малын чанарыг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх санал, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн, өндөр ашиг шимт малын гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийх, хээлтүүлэгчээр хангах арга хэмжээ авч, малын үржлийн ажил үйлчилгээг сайжруулна.

1.1.15. Орон нутгийн өмчит “Цөм сүргийн аж ахуй”-г бэхжүүлэх, Сэлэнгэ, Казакийн цагаан толгойт, Халимаг, Лимузин, Хар ангус үүлдрийн үхэр, Хангай, Ерөө, Орхон үүлдрийн хонины удмын санг хамгаалах, махны чиглэлийн адуу, хонь, сүүний чиглэлийн ямааны шинэ үүлдрийг нутагшуулах замаар мал аж ахуйг эрчимжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

1.1.16. Зөгий, гахай, шувуу, туулай үржүүлэх иргэдийн санал, санаачилгыг бүх талаар дэмжинэ.

1.1.17. Мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн эмч, мэргэжилтний мэргэшил, ур чадварыг дээшлүүлж, багаж, тоног төхөөрөмж, эм урвалжийн

хангалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээний чанар, үр дүнг сайжруулан, мал, мах экспортлох нөхцөлийг бүрдүүлнэ.

1.1.18.Иргэд, малчид, тариаланчид, өрхийн аж ахуй эрхлэгчдийн хүч хөдөлмөр, хөрөнгө санхүү, үйл ажиллагаагаа нэгтгэх, хорших санал, санаачилгад бүх талын дэмжлэг үзүүлнэ.

1.1.19.Малчин, мал бүхий айл өрх, малчны бүлгүүдийн үлгэр дуурайлал болохуйц нутаг бүрийн онцлог шингэсэн арга ажиллагааг судалж дэлгэрүүлнэ.

1.2.Байгаль орчны бодлого

Байгалийн баялгийг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, хөрс, ус, агаарын бохирдлоос сэргийлэх ажилд иргэдийн тавих хяналт, оролцоог нэмэгдүүлнэ.

1.2.1.Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлүүд, ойн мэргэжлийн байгууллагуудын менежментийн гэрээний хэрэгжилтийн дүнг жил бүр багийн иргэдийн нийтийн хуралд танилцуулж, олон нийтэд ил тод мэдээлдэг болгоно.

1.2.2.Ойг нөхөн сэргээх иргэд, олон нийтийн үүсгэл санаачилга, оролцоог нэмэгдүүлж, сумдад мод үржүүлгийн газар шинээр байгуулахад дэмжлэг үзүүлэн, сум дундын ойн ангиудын үүрэг, хариуцлагыг өндөржүүлж, жил бүр 1500-аас доошгүй га талбайд ойжуулалт хийнэ.

1.2.3.Иргэдийн санал, оролцоонд тулгуурлан айл өрхийн түлшний модоо бэлтгэхэд учирч байгаа хүндрэл, бэрхшээлийг арилгах бодлого хэрэгжүүлж, аймгийн хэмжээнд эрх зүйн шинэ зохицуулалт бий болгоно.

1.2.4.Усны эх үүсвэрийн, ан, амьтны, ургамлын аймгийн, агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого зохион байгуулж, экологийн тэнцвэрт байдлыг хангах нэгдсэн арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлнэ.

1.2.5.“Сэлэнгэ-ногоон бүс нутаг” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, “Ногоон төгөлийн эзэн” иргэн, айл өрх, байгууллагыг жил бүр шалгаруулж алдаршуулна.

1.2.6. Байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёлын дурсгал бүхий Сайханы хөтөл, Оргидог булаг, Хоёр элс, Дулаанхааны рашаан, Номтын рашаан зэрэг газруудыг хамгаалалтанд авна.

1.2.7. Ашигт малтмал хайх, олборлох, байгалийг нөхөн сэргээх үйл ажиллагаанд жил бүр иргэд, олон нийтийн төлөөлөл оролцсон шалгалтыг зохион байгуулж, олон нийтэд ил тод мэдээлнэ.

1.2.8.“Сэлэнгэ цэвэр орчин” дэд хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэн, хог хаягдал ялган боловсруулах бага оврын үйлдвэрийг сумдын бүсийн төвүүдэд байгуулж, хог хаягдал зайлуулах техник,тоног төхөөрөмжийг нэмэгдүүлнэ.

1.2.9. Байгаль орчинд сөрөг нөлөөгүй түлшний хэрэглээг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

1.2.10. Малчдад өвөлжөөний газрыг эзэмшүүлж, бэлчээр, хадлангийн талбайг хортон мэрэгчдээс хамгаалах, бордох, услах, олон наст тариалах, сэлгэх, өнжөөх арга хэмжээг зохион байгуулна.

1.2.11.Газар өмчлөл, эзэмшил, ашиглалттай холбогдсон мэдээллийн ил тод байдлыг хангаж, цахим хуудас шинээр ажиллуулна.

1.2.12.Иргэдийн санал хүсэлт, оролцоонд тулгуурлан Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Сайхан сумдын хилийн цэсийг шинэчлэх саналыг холбогдох газарт тавьж шийдвэрлүүлнэ.

1.2.13.Ус, цаг уур, байгаль орчны хяналт-шинжилгээний сүлжээ нэгжийг өргөтгөн, шилэн кабельд холбож, техник технологийн шинэчлэл хийнэ.

1.2.14.Цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тундас нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэн, мөндөр зайлуулах арга, техникийг судалж, турших ажлыг эхлүүлнэ.

1.3. Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний бодлого

Үйлдвэрлэлийн нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадлыг нэмэгдүүлж, худалдаа, үйлчилгээний чанар, хүртээмжийг хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн сайжруулна.

1.3.1. “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих” аймгийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.

1.3.2. Аж үйлдвэрийн салбарт хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, аж ахуйн нэгжүүдийн боловсруулах үйлдвэр байгуулах санал, санаачилгыг дэмжин, орон нутгийн хөгжил, иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд оролцох үүрэг, хариуцлагыг нь нэмэгдүүлнэ.

1.3.3. Бичил уурхай эрхлэгчдэд хууль, тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлнэ.

1.3.4. Сүхбаатар суманд оёдлын шинэ үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

1.3.5. Байгалийн түүхий эд болон дэвшилтэт технологид түшиглэсэн барилгын материалын үйлдвэр байгуулах иргэд, аж ахуйн нэгжийн санал, санаачилгыг дэмжинэ.

1.3.6. Жимс жимсгэнэ, зөгий, гахай, шувуу, мал, ургамлын гаралтай түүхий эдийг түшиглэсэн анхан шатны болон боловсруулах үйлдвэрүүдийг дэмжиж, экологийн цэвэр бүтээгдэхүүний хэмжээг өсгөнө.

1.3.7. Аймгийн хэмжээнд үйлдвэрлэгдэж байгаа бүтээгдэхүүний стандарт, чанарын баталгааг сайжруулж, зураасан код, үндэсний тохирлын тэмдэгтэй бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлнэ.

1.3.8. Иргэдэд, худалдаа, үйлчилгээ, өрхийн аж ахуй, жижиг үйлдвэрлэл эрхлэхэд нь үзүүлэх мэргэшил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үйлчилгээний хүртээмж, үр нөлөөг дээшлүүлж, тогтмол ажиллагаатай “Бизнес зуучлалын төв” бий болгоно.

1.3.9. Худалдаа, үйлчилгээ, өрхийн аж ахуй эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг хөтөлбөр, төслийн санхүүжилт, арилжааны банкны зээлд хамруулах бодлого зохицуулалтыг өргөжүүлнэ.

1.3.10. Эрүүл ахуйн шаардлага хангасан, бизнесийн жишигт нийцсэн худалдааны төвийг шинээр байгуулж, бөөний худалдааны сүлжээг өргөжүүлнэ.

1.3.11. Сэлэнгэчүүдийн үйлдвэрлэсэн нэрийн бүтээгдэхүүнүүдийг дотоод, гадаадын зах зээлд нийлүүлэхэд дэмжлэг үзүүлж, “Сэлэнгийн ногоо” зах, “Намрын ногоон өдрүүд”, “Сэлэнгэд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулна.

1.3.12. Хэмжлийн ажлын эталоны хангамж, нарийвчлалыг сайжруулж, хэмжлийн нэгдмэл аюулгүй байдлыг хангана.

1.3.13. Баянгол, Зүүнбүрэн, Түшиг, Ерөө зэрэг сумдад “Ахуй үйлчилгээний төв”, Сүхбаатар сумын 5-р багт “Соёлын төв–ахуй үйлчилгээний цогцолбор”, Жавхлант суманд халуун усны барилга барьж ашиглалтанд оруулна.

1.3.14. Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дэргэдэх лабораторийн иргэд, байгууллагад үзүүлэх үйлчилгээний шуурхай байдал, чанар, хүртээмж, хүчин чадлыг сайжруулан, зориулалтын байртай болгоно.

1.3.15. Хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах төрийн хяналтын ажил үйлчилгээнд зохион байгуулалт, бүтэц, орон тоо, үйл ажиллагааны шинэчлэл хийж, үр нөлөөг сайжруулна.

1.4.Дэд бүтцийн бодлого

Төв сууринг дэд бүтэц, ногоон байгууламжтай хослуулан төлөвлөж хөгжүүлнэ.

1.4.1. Сумын төв, тосгодыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болгож, инженерийн дэд бүтэц, газар ашиглалтыг сайжруулан, орчин үеийн жишгээр хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

1.4.2.Аймгийн төвийн дулааны станцын хүчин чадлыг нэмэгдүүлж, төвлөрсөн шугам сүлжээг шинэчилж өргөжүүлнэ.

1.4.3.Төв суурин газруудын усан хангамжийг нэмэгдүүлж, зарим сумдын цэвэрлэх байгууламжийг сэргээн засварлана.

1.4.4.Сүхбаатар, Баянгол сумын гэр хорооллын дэд бүтцийг сайжруулан, инженерийн шугам сүлжээнд холбож, Сайхан, Мандал сумын төвийн инженерийн шугам сүлжээг шинэчилнэ.

1.4.5. Хүн амыг ундны цэвэр усаар хангах, хүртээмж, хамгаалалтыг сайжруулах, усан сангийн барилгуудад их засвар хийх ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

1.4.6. Цахилгаан дамжуулах Түшиг сум чиглэлийн шугамыг 35 квт-ын болгох, Цагааннуур сум, Дулаанхаан тосгоны 0,4 квт-ын шугамыг засварлах, шаардлагатай чиглэл, газруудад эрчим хүчний нөөц шугам бий болгох, ялгаварт тарифт шилжүүлэх арга хэмжээ авна.

1.4.7.Засгийн газрын “1000 айлын орон сууц” төсөл, “Амины орон сууц” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, төв суурин газарт “Эко хороолол”, “Мөрөөдлийн хотхон” зэрэг шинэ орон сууцны хорооллуудыг бий болгох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилга, оролцоог бүх талаар дэмжинэ.

1.4.8.Сүхбаатар сумын үерийн хамгаалалтын далан, байгууламжийг сэргээж, иргэдийн аюулгүй байдлыг хангана.

1.4.9.Нийтийн зорчигч тээврийн Сүхбаатар-Баянгол-Мандал чиглэлийг шинээр бий болгож, Сүхбаатар, Мандал, Сайхан сумдад авто тээврийн үйлчилгээний зогсоол, буудлууд барьж тохижуулна.

1.4.10. Аймгийн нутаг дэвсгэр дэх сайжруулсан авто замуудыг арчлах, засварлах ажлыг тогтмолжуулж, төв суурин газрын доторх авто замыг хатуу хучилттай болгох, Түшиг-Цагааннуур-Зүүнбүрэн-Шаамар, Ерөө-Хүдэр, Мандал-Баянгол чиглэлийн замыг сайжруулсан болон хатуу хучилттай болгох ажлыг шат дараатайгаар хийнэ.

1.4.11.Алтанбулаг-Улаанбаатар чиглэлийн олон улсын авто замаас Жавхлант, Ерөө сум хүртэлх сайжруулсан авто замыг хатуу хучилттай болгож, Дархан-Эрдэнэт чиглэлийн төв замаас Орхон, Сант сумын төв хүртэл сайжруулсан зам тавина.

1.4.12. Хүдэр, Хушаат, Ерөө суманд төмөр бетонон гүүр барьж ашиглалтанд оруулна.

1.4.13. Аймгийн хэмжээнд мэдээлэл холбооны дэвшилтэт технологи нэвтрүүлэх нэгдсэн бодлогыг шинээр тодорхойлон хэрэгжүүлж, сумдыг өндөр хурдны интернетийн үйлчилгээнд хамруулж, зарим сумдыг мэдээлэл холбооны гурвалсан үйлчилгээтэй болгоно.

1.5.Төсөв, санхүүгийн бодлого

Аймаг, сумын төсвийн төлөвлөлт, зарцуулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн хуваарилалтанд оролцох иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлж, ил тод байдлыг эрхэмлэнэ.

1.5.1. Төсвийн төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлийн хяналтанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг дээшлүүлнэ.

1.5.2. Аймаг, сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөг, аймгийн 2007-2021 оны хөгжлийн хөтөлбөр, сумдын таван бүсийн хөгжлийн хөтөлбөрүүдтэй уялдуулан Төсвийн тухай шинэ хуулийн шаардлагын дагуу иргэдийн санал, оролцоотойгоор боловсруулж мөрдөнө.

1.5.3.Татвар төлөгчдийн хүрээг өргөтгөж, орон нутгийн төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

1.5.4.Статистик цахим мэдээллийн сан бий болгож, мэдээллийн шуурхай байдлыг ханган, олон нийтэд нээлттэй болгоно.

1.5.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг цахимжуулан, олон нийтийн оролцоог ханган, ил тод, шуурхай байдлыг эрхэмлэнэ.

1.5.6.Орон нутгийн өмчийн цахим мэдээллийн санг бий болгож, сумдын эд хөрөнгө захиран зарцуулах эрхийг нэмэгдүүлэх, өмчийн ашиглалт, хамгаалалтанд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах арга хэмжээ авна.

ХОЁР. ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГО

2.1.Эрүүл мэндийн бодлого

Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

2.1.1.Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож, эрүүл аж төрөх ёс, зан үйлийг төлөвшүүлнэ.

2.1.2. Эрүүл мэндийн анхан шатны болон нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх ажлыг чанаржуулна.

2.1.3. Нэгдсэн эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааг сайжруулан “Эх-хүүхдэд ээлтэй аймаг” болох хөдөлгөөн өрнүүлнэ.

2.1.4.Сүрьеэ, хорт хавдар, ХДХВ/ДОХ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

2.1.5.Аймгийн нэгдсэн эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төвүүдийг мэдлэг, ур чадвар, ёс зүйтэй эмч, эмнэлгийн мэргэжилтнээр хангах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

2.1.6.Иргэдийн санал, нийгмийн шаардлагад үндэслэн, эм ханган нийлүүлэгчдийн хариуцлагыг өндөржүүлж, эмийн зохистой зөв хэрэглээ төлөвшүүлэх ажилд шинэчлэл хийнэ.

2.1.7. Аймаг, сумын Нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг сайжруулан, анхан шатны оношилгоо, шинжилгээний лабораториудыг бий болгож, аймаг, суманд шинжилгээ, оношилгоо хийх боломжийг бүрдүүлнэ.

2.1.8.Түргэн тусламжийн сүлжээг бэхжүүлж, нэгдсэн эмнэлгүүдийг иж бүрэн тоноглогдсон явуулын амбулаторитой болгоно.

2.1.9.Хувийн болон өрхийн эмнэлгүүдийн үйл ажиллагааг дэмжин сайжруулж, харьяалах иргэн, айл өрх бүртээ хүрч үйлчлэх боломж, нөхцөлийг дээшлүүлнэ.

2.1.10.“Эрүүл сум, хот, байгууллага” аймгийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг сайжруулна.

2.1.11. Ерөө сумын эрүүл мэндийн төвийг сум дундын эмнэлэг болгон өргөтгөж, Баянгол, Мандал сум, Шаамар сумын Дулаанхаан тосгонд эрүүл мэндийн төвийн барилга шинээр барьж, аймгийн нэгдсэн эмнэлэг, Ерөө, Жавхланта, Зүүнбүрэн, Хушаат сумын эрүүл мэндийн төвүүдийн барилгад их засвар, өргөтгөл хийнэ.

2.2.Боловсролын бодлого

Багш, хүүхдийг хөгжүүлэх боловсролын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлж, суралцагчдын суралцах, хөгжих сургалтын таатай орчинг бүрдүүлнэ.

2.2.1.Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, нүүдлийн болон хувийн цэцэрлэг, өдөр өнжүүлэх бүлэг шинээр нээн ажиллуулах байгууллага, иргэний санаачилгыг дэмжинэ.

2.2.2.Суурь боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, бага, дунд боловсролын чанар, үр ашгийг дээшлүүлэх сургалтанд боловсролын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.2.3.Монгол ахуй, уламжлал, ёс заншил, түүх, соёлын уламжлалыг дээдэлсэн эх оронч сэтгэлгээтэй, амьдрах ухаанд суралцсан иргэн төлөвшүүлэхэд чиглэсэн “Зөв Монгол Хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.2.4.“Цахим сургууль - Цахим сургалт” хөтөлбөрийг боловсруулж, сургууль, цэцэрлэгт үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.2.5. Албан бус боловсролын “Гэгээрэл” төвийн үйл ажиллагааг “Насан туршийн боловсролын төв” болгон өргөтгөж, сургалтын орчин бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.2.6. Хүний нөөцийн төлөвлөлт, хангалтанд зориулж, аймаг, орон нутагт эрэлт, хэрэгцээтэй мэргэжлээр гадаад, дотоодын их дээд сургуульд суралцагчид, төгсөгчдийн мэдээллийн санг бий болгож, амжилттай суралцаж байгаа оюутнуудад дэмжлэг үзүүлэн, шаардлагатай газруудад байршуулах бодлого хэрэгжүүлнэ.

2.2.7.Мандал сум дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг хөдөө аж ахуйн чиглэлийн шаталсан сургалттай коллеж болгож, Сайхан суманд Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв байгуулна.

2.2.8.Боловсролын салбар дахь гадаад, дотоод хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлэн, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллана.

2.2.9.Боловсролын салбарын ажилтнуудыг мэргэшүүлэх, чадваржуулах, нийгмийн хамгааллыг сайжруулах “Багшийн хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.2.10.Сумдад хүүхдийн хөдөлмөр амралтын зуслан, сувилал байгуулж, гадаадын улс, орны зусланд хүүхэд солилцон амруулна.

2.2.11.Сургалтын байгууллагын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, сургалтын орчинг сайжруулна.

2.2.12.Суралцагчдын сурч, хөгжих нөхцөлийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах зорилгоор сургуулиудыг бага оврын автобусаар хангах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.2.13.Ерөнхий боловсролын сургуулиудын “Үдийн хоол”-ны эрүүл ахуй, аюулгүй байдалд хяналт тавих тогтолцоог шинэчилнэ.

2.2.14.Алтанбулаг, Мандал, Жавхлант, Шаамар, Сайхан, Сүхбаатар, Ерөө сум, Орхонтуул сумын Рашаант, Ерөө сумын Бугант тосгонд цэцэрлэг шинээр барьж, зарим сумдын цэцэрлэгт өргөтгөл хийнэ.

2.2.15.Сант, Мандал суманд сургууль, Орхон, Хушаат, Сайхан суманд сурагчдын дотуур байр, Сүхбаатар сумын спортын мэргэжлийн сургалттай сургууль, Ерөө сум, Мандал сумын Түнхэл тосгоны сургуулиудад спорт заал шинээр барьж, Сайхан, Зүүнбүрэн сум, Шаамар сумын Дулаанхаан тосгон, Сүхбаатар сумын 6-р сургуулийн барилгыг өргөтгөж, Шаамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, Жавхлант сумын сургуулийн барилгад их засвар хийнэ.

2.3.Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн бодлого **Нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.**

2.3.1.Зорилтот бүлгүүдэд чиглэсэн нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлнэ.

2.3.2.Эх, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

2.3.3.Ахмад настны нийгмийн хамгааллын тусламж, үйлчилгээг чирэгдэлгүй шуурхай хүргэж, сумдын ахмадын байрны үйл ажиллагааг тогтмолжуулна.

2.3.4.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийн байгууламжуудыг орон сууц, сургууль, цэцэрлэг, нийтийн үйлчилгээний газруудад бий болгоно.

2.3.5.Хүүхдийн чуулганыг жил бүр зохион байгуулж, “Хүүхдэд ээлтэй баг, сум” болох хөдөлгөөн өрнүүлнэ.

2.3.6.Аймгийн төвд гэр бүл, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий “Гэр бүл-хөгжлийн ордон” байгуулна.

2.3.7.Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн, 6000-аас доошгүй шинэ ажлын байрыг бий болгож, айл өрхийн амьжиргааг сайжруулна.

2.3.8.Бага орлоготой 400-аас доошгүй өрхийн амьжиргааг олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ болон төсөл, хөтөлбөрт хамруулах замаар дээшлүүлнэ.

2.3.9.Хөдөлмөрийн бирж зохион байгуулж, хөдөлмөр зуучлалын аймгийн сүлжээ бий болгоно.

2.3.10.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагааг өргөжүүлэн хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулан ажил олгогчийн захиалгаар сургаж, ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлнэ.

2.3.11.“Ажлын байр-Амьдрах ухаан” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

2.3.12.Нийгмийн түншлэлийн гурван талт хэлэлцээр, “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

2.3.13.Малчид, ажилгүй иргэд, жижиг аж ахуй эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах хүрээг өргөжүүлнэ.

2.3.14.Мандал, Сайхан, Ерөө сумдад ахмадын сувилал, Баянгол, Жавхлант суманд ахмадын өргөө барьж, амралт, сувиллын үйлчилгээг өргөжүүлнэ.

2.4.Соёл, спорт, аялал жуулчлалын бодлого

Үндэсний урлаг, соёл, аялал жуулчлал, нийтийн биеийн тамир, спортын ажил, үйлчилгээний чанар, хүртээмжийг иргэд, олон нийтийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн сайжруулна.

2.4.1.Соёл, урлагийн байгууллагуудын удирдлага, зохион байгуулалт, менежментийг сайжруулах, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх ажлыг орон нутгийн онцлог, нөхцөл, боломжинд тулгуурлан төлөвлөж хэрэгжүүлнэ.

2.4.2.Соёлын байгууллагын ажилтнуудыг чадваржуулах, мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн хамгааллыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

2.4.3. Соёл, урлагийн боловсролыг хүүхэд, залуучуудад олгох, үндэсний соёл, уламжлалаа дээдэлдэг иргэн болгон төлөвшүүлэх арга хэмжээ зохион байгуулна.

2.4.4. Үндэсний уламжлалт зан үйл, ёс заншлыг дээдэлж, өвлөн хадгалуулах зорилгоор угийн бичиг хөтлөх ажлыг эрчимжүүлнэ.

2.4.5.Соёлын үнэт зүйлийг бүтээх, судлах, соёлын өвийг хадгалж хамгаалах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, үндэсний соёлд тулгуурласан аялал жуулчлалыг хөгжүүлэх санал, санаачилгыг бүх талаар дэмжинэ.

2.4.6.Сумд дахь “Орон нутгийн судлах танхим”-ыг тохижуулан, соёлын биет ба биет бус өвийг баримтжуулан, хадгалалт, ашиглалтыг сайжруулна.

2.4.7. Сумдын соёлын төвүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлж, алслагдсан баг, хөдөөгийн иргэдэд соёл урлагаар үйлчлэх явуулын үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөг дээшлүүлнэ.

2.4.8.Соёл, урлагийн салбарын гадаад, дотоодын хамтын ажиллагааг өргөжүүлж, аймаг, орон нутгаа сурталчлах, улсын болон олон улсын чанартай уралдаан, наадамд мэргэжлийн уран бүтээлчид, ардын авъяастан, хүүхэд залуучуудыг оролцоход дэмжлэг үзүүлнэ.

2.4.9.Аймгийн төвд үзэсгэлэнгийн танхимтай, орчин үеийн шийдэл бүхий кино театр байгуулна.

2.4.10.Соёл урлагийн байгууллагуудыг шаардлагатай хувцас, хөгжмийн зэмсэг, техник тоног төхөөрөмжөөр хангах, барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, засварлах ажлыг ээлж дараатай хийнэ.

2.4.11.Аймаг, сумын нийтийн номын сангийн үйлчилгээ, цахим номын санг өргөжүүлж, номын фондыг баяжуулна.

2.4.12. Шаамар, Хүдэр сум, Ерөө сумын Бугант, Орхонтуул сумын Рашаант тосгонд соёлын төв шинээр барина.

2.4.13.Тив, дэлхийн болон улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцсон тамирчдад дэмжлэг үзүүлнэ.

2.4.14.Спортын холбоо, клубүүдийн үйл ажиллагааг дэмжиж, өсвөр үеийн шигшээ багийн спортын төрлийг нэмэгдүүлж, ур чадварыг дээшлүүлнэ.

2.4.15.Хүүхдийн болон насанд хүрэгчдийн спортын наадам, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Паралимп”- ийг зохион байгуулна.

2.4.16. Улсын болон бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг аймагтаа жил бүр зохион байгуулна.

2.4.17. Аймгийн аялал жуулчлалын бодлогыг шинээр тодорхойлж, соёлын үнэт өв, түүхийн дурсгалт газруудыг тэмдэгжүүлсэн газрын зураг, аймгийн цахим “Нэвтэрхий толь” бүтээж, аялал жуулчлалын мэдээллийн санг бий болгоно.

2.4.18.Иргэд, олон түмний уламжлалт соёл, зан заншлыг хүндэтгэх, байгалийн унаган төрхийг хамгаалах зорилгоор “Ээж мод” орчмын газар нутгийг аймгийн хамгаалалтанд авч, иргэдийн сүсэг бишрэлийн зан үйлээ таатай орчинд, соёлтой үйлдэх боломжийг бүрдүүлнэ.

2.4.19.Нум сумны үйлдвэрлэл, үндэсний сур, шагайн харвааг дэмжин хөгжүүлж, нум сумыг аймгийн нэрийн бүтээгдэхүүн болгон, үндэсний сур, шагайн харваачдын улсад тэргүүлэх амжилтыг бататгана.

2.4.20.Алтанбулаг, Хүдэр, Жавхлант сумдад спортын ордон, Баруунбүрэн суманд спорт зал, Ерөө, Сүхбаатар суманд хөл бөмбөгийн зүлэгтэй талбай тохижуулан, өвлийн спортыг хөгжүүлж мөсөн гулгуурын талбайтай болгож иргэдийн нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх орчин, нөхцөлийг сайжруулна.

2.4.21.Орхон, Сант, Хушаат, Зүүнбүрэн, Шаамар сумдыг баяр наадмын талбайтай болгоно.

2.4.22. Аймгийн төвийн усан бассейныг ашиглалтанд оруулж, зарим сумдад гол мөрнийг түшиглэн наран шарлагын талбай байгуулан, иргэдийн усан спортоор хичээллэх боломжийг нэмэгдүүлнэ.

ГУРАВ. НУТГИЙН ЗАХИРГАА, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

3.1.Нутгийн захиргааны ажил үйлчилгээ

Нутгийн захиргааны байгууллагын ажил үйлчилгээний шуурхай, ил тод байдалд шинэчлэл хийж, иргэд, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж, үнэлэмжийг дээшлүүлнэ.

3.1.1. Нутгийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг боловсронгуй болгож, төрийн ажил үйлчилгээний шуурхай, ил тод байдлыг хангана.

3.1.2. Нутгийн захиргааны байгууллагын ажил, үйлчилгээнд олон улсын Чанарын удирдлагын тогтолцоо, MNS ISO 9001-2010 стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.

3.1.3. Аймаг, сумын Засаг даргын Тамгын газруудад “Иргэний танхим”, нээлттэй утас, цахим хуудас ажиллуулах, “Иргэдээ сонсьё” телевизийн шууд нэвтрүүлгийн тогтмол цагтай болох замаар иргэдийн эрэлт, хүсэлт, санал бодлыг хүлээн авч, шийдвэр, үйл ажиллагаандаа тусгадаг шинэ тогтолцоог бүрдүүлнэ.

3.1.4. Иргэдийн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэж хариу өгдөг үйл ажиллагаанд бүтэц, зохион байгуулалт, арга хэлбэр, мэдээллийн технологийн шинэчлэл хийнэ.

3.1.5.Төрийн байгууллагын ажил үйлчилгээ, төрийн албан хаагчийн хариуцлага ёс зүй, ажлын үр дүнг иргэдийн сэтгэл ханамж, үнэлэмжид тулгуурлан дүгнэж, гадаад, дотоодын хэрэгцээт сургалтанд хамруулах, мэргэшүүлэх, замаар ур чадварыг дээшлүүлнэ.

3.1.6.Аймгийн болон Сүхбаатар, Мандал сумын ЗДТГ, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн хэлтэс зэрэг газруудад ажил, үйлчилгээний ил тод, аюулгүй байдлыг хангах зорилгоор теле камертай болгоно.

3.1.7.Хушаат сумын ЗДТГ, Дулаанхаан, Рашаант тосгоны захирагчийн албаны конторыг шинээр барьж, зарим сумдын Засаг даргын Тамгын газар, багийн төвүүдийг тохижуулж, сумдад төрийн албан хаагчдын орон сууц бий болгоно.

3.1.8.Сүхбаатар, Мандал сумыг улсын зэрэглэлтэй хот болгох санал боловсруулж холбогдох газарт уламжилна.

3.1.9. Сум сурталчлах нэгдсэн арга хэмжээг аймгийн төвд зохион байгуулж, бүх сумдыг хамруулна.

3.1.10. “Сэлэнгэ түмэн” нэгдсэн арга хэмжээ, “Бид Сэлэнгийн үр сад” урлагийн наадам, “Сэлэнгэ- хөгжлийн гарц” илтэглийн уралдаан, аймгийн “Нээлттэй хаалганы өдөр” зэрэг аймгийн хөгжил, ажил амьдрал, онцлог, давуу талыг сурталчлах олон талт арга хэмжээг зохион байгуулна.

3.1.11.Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын мэдээ, мэдээллийн чанар хүртээмжийг нэмэгдүүлж, дэвшилтэт техник технологид суурилсан үйлчилгээг нэвтрүүлнэ.

3.1.12.Мэдээллийн технологийг ашиглан цаасаар үйлдэгддэг төрийн үйлчилгээний шат дамжлагыг цөөрүүлж, “Цахим засаглал” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.1.13.Хүүхэд, залуучуудад эх орноороо бахархах үзлийг төлөвшүүлэх, цэргийн насны залуучуудын бие, бялдрыг эрүүлжүүлэх, боловсролын түвшинг дээшлүүлэх арга хэмжээг шат дараатайгаар хэрэгжүүлнэ.

3.1.14.Орон нутагтаа цэргийн дүйцүүлэх алба хааж байгаа залуучуудыг бүтээн байгуулалтын ажил, ойжуулах, цөлжилттэй тэмцэх, байгалийг нөхөн сэргээх болон гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд татан оролцуулна.

3.1.15. Орон нутгийн гамшгийн эмзэг байдал, эрсдэлийг бууруулах гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлнэ.

3.1.16.Гамшгийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж ой хээрийн түймэр, үер ус, халдварт өвчин, зуд, барилга, байгууламжийн гал түймэр зэрэг болзошгүй

аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэл, эмзэг байдлын үнэлгээ хийх, аюулыг бууруулах, бэлэн байдлыг хангах ажлыг эрчимжүүлнэ.

3.2. Гадаад харилцааны ажил үйлчилгээ

Гадаад харилцааны уламжлал, залгамж чанарыг хадгалж, түншлэлийн харилцааг бүх талаар өргөжүүлнэ.

3.2.1. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэл, хамрах хүрээг өргөтгөж, шинэ түншлэлийн харилцааг хөгжүүлнэ.

3.2.2. Хил орчмын худалдааг дэмжиж, хилийн Алтанбулаг, Сүхбаатар боомт дахь хяналт шалгалтын байгууллагуудын үйлчилгээг шуурхай болгоно.

3.2.3. Иргэд, бизнес эрхлэгчдийн санал, санаачилга, оролцоонд тулгуурлан

“Бизнес аялал”-ыг зохион байгуулж гадаадын төсөл, хөтөлбөрт хамрагдах, хөрөнгө оруулалтыг татах боломжийг нэмэгдүүлнэ.

3.2.4. Хөрш зэргэлдээ Оросын Холбооны Улс, Буриад Улсын хэл соёл, зан заншил, түүх өв соёлоос судлах, суралцах, харилцах бүхий л харилцааг өргөжүүлж, “Эв мод”-ны наадам зэрэг олон талт арга хэмжээг зохион байгуулна.

3.2.5. Хил орчмын бүс нутгийн засаг, захиргааны нэгж, байгууллагын харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлж, сумдыг гадаадын ижил төстэй засаг, захиргаадын нэгжтэй харилцаа тогтооход дэмжлэг үзүүлнэ.

3.3. Хүний эрхийг хангах, хууль эрх зүй, авлигагүй орчны ажил үйлчилгээ

Хүний эрхийг хангах, хууль эрх зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх ажил үйлчилгээний үр нөлөөг сайжруулна.

3.3.1. Шүүх эрх мэдэл, хууль сахиулах, хүний эрхийг хамгаалах чиг үүргийн байгууллагуудын ажлын уялдаа, хамтын ажиллагааг хангах нэгдсэн бодлогыг тодорхойлж хэрэгжилтийг хангана.

3.3.2. Хууль, эрх зүйн мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг иргэд, олон нийтийн эрэлт, цаг үеийн шаардлагад нийцүүлэн зохион байгуулж, үр нөлөөг дээшлүүлнэ.

3.3.3. Хүний эрхийг хангахад нутгийн захиргаа, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

3.3.4.Нутгийн захиргааны байгууллагуудад архив, албан хэрэг хөтлөлтийн AMS цахим программ нэвтрүүлэх, Төрийн архивын сан хөмрөгийг цахим санд шилжүүлж үйлчилгээг хөнгөвчлөх, хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авна.

3.3.5.Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах ажилд иргэдийн оролцоо, хяналтыг сайжруулан, Сүхбаатар, Мандал сумдын тодорхой цэгүүд, Хөтөл, Дулаанхааны төв замын уулзвар, Бүдүүний гүүр дэх хяналтын байруудад телекамер байршуулна.

3.3.6.Олон улсын болон орон нутгийн төв зам бүхий Сүхбаатар, Баянгол, Сайхан сумдад замын цагдаагийн байнгын цэгүүд, хөдөлгөөний аюулгүй байдлын телекамерын хяналт бий болгоно.

3.3.7. “Архидалттай тэмцэх” хөтөлбөрийг олон нийтийн санал, оролцоонд тулгуурлан боловсруулж хэрэгжүүлнэ.

3.3.8.Байгаль хамгаалах хуулийн эсрэг гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэхэд идэвх санаачилга, үр дүнтэй оролцож буй иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгжүүдэд хуулийн дагуу урамшуулал олгоно.

3.3.9.Хүүхдийг ёс суртахуун, зан заншлын буруу зуршилд автахаас урьдчилан сэргийлэх, болзошгүй осол, гэмт үйлдлээс хамгаалахад чиглэсэн арга хэмжээг тогтмол зохион байгуулна.

3.3.10.Хууль сахиулах байгууллагуудын ажиллах орчин, иргэд, олон нийтэд үзүүлэх үйлчилгээг сайжруулж, ажил үйлчилгээний шуурхай, ил тод байдлыг дээшлүүлнэ.

3.3.11.Иргэд болон авлигатай тэмцэх төрийн бус байгууллагын сүлжээтэй хамтран авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлж, авлигагүй орчин бүрдүүлж ажиллана.

**ХАМТЫН СЭТГЭЛ, ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛЭЭР
АЙМАГ, СУМ, БАГ, АЙЛ ӨРХӨӨРӨӨ ХӨГЖИН ДЭВЖИЦГЭЭЕ.**

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 21-ний өдөр

Дугаар 13

Сүхбаатар

Үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “а” заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ аймгийн эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

2.Аймгийн эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, аймгийн нийт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлан таниулах, биелэлтийг бүтэн жилээр гаргаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг аймгийн Засаг дарга /С.Бүрэнбат/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2013 ОНД
ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

№	Бодлогын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	Хариуцах байгууллага	
Нэг. Эдийн засгийн бодлого				
1. 220.7 мянган тн үр тариа, 55.1 мянган тн төмс 35.2 мянган тонн хүнсний ногоо үйлдвэрлэж, 150.0 мянган га уринш, 150.0 мян тн байгалийн хадлан бэлтгэнэ.				
1	1	150000 га-д үр тариа, тэжээл, тосны ургамал, 3500 га-д төмс, 2500 га-д хүнсний ногоо тариалж, 145000 га-гийн уринш бэлтгэх	2013 онд 220.7 мянган тн үр тариа, 55.1 мянган тн төмс, 35.2 мянган тн хүнсний ногоо хураан авч, 150.0 мянган га-гийн уринш бэлтгэсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ
2	2	Үр тариа үйлдвэрлэгчдийн аймгийн нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулж, өндөр бүтээмж бүхий шинэ техник, тоног төхөөрөмжийг танилцуулах сургалт, талбайн өдөрлөгийг зохион байгуулах	Тариалангийн үйлдвэрлэлийн бодлого тодорхойлогдож, технологийн шинэчлэлийн үр дүн гарсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ
3	3	Тариалан эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгжийг олон үйлдэл бүхий хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжөөр хангах бодлого хэрэгжүүлэх	Тариалан эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгжүүдийн олон үйлдэл бүхий техникийн хангамж нэмэгдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ
4	4	"Хүнсний ногоо" хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах	Хөтөлбөр хэрэгжиж тодорхой үр дүнд хүрсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ
5	5	Үр тариа, төмс, хүнсний ногоог хадгалах зориулалтын тоног төхөөрөмж бүхий зоорь, агуулахыг зарим сумдад барих	Үр тариа, төмс, хүнсний ногоог хадгалах зориулалтын тоног төхөөрөмж бүхий зоорь, агуулахын тоо нэмэгдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ
6	6	Гадаргуугийн урсацын усыг ашиглах бодлого зохицуулалтын арга хэмжээ авч усалгаатай тариаланг нэмэгдүүлэх	Усалгаатай талбайн хэмжээ нэмэгдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ
7	7	"Чацаргана", "Жимс, жимсгэнэ" хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх	Жимс, жимсгэний ургацын хэмжээ өсч, иргэдийн орлого нэмэгдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ

8	8	“Ээлжлэн тариалах систем” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, хөрс хамгаалах агротехнологийг нэвтрүүлэх, хөрсийг бордох, олон наст тариалж эзэмшилт уриншийн туршилтын ажлыг эхлүүлэх	“Ээлжлэн тариалах систем” хөтөлбөр хэрэгжиж, эзэмшилт уриншийн туршилтын үр дүн гарсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ
9	9	Газар тариалангийн техник тоног төхөөрөмжийг шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажил арга хэмжээг зохион байгуулах	Хөдөө аж ахуйн чиргүүл дүүжин машины 50, зүтгэх хүчний техникийн 60, ургац хураалтын техник 50, үтрэмийн техникийн 55 хувийг тус тус шинэчилсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ
10	10	Хөрсний үржил, шим дээшлүүлэх зорилгоор бордооны хэрэглээг нэмэгдүүлэх.	Тариалангийн үйлдвэрлэлд бордооны хэрэглээ нэмэгдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ
11	11	Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, тариалах ургамлын төрлийг олшруулах	Хүлэмжийн тоо нэмэгдэж, тариалах ургамлын төрөл, хэмжээ өссөн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ
12	12	Төмс, хүнсний ногоо үйлдвэрлэгчдийн зөвлөгөөн, талбайн өдөрлөгийг Мандал, Сант, Шаамар сумдын “Агропарк”-ийг түшиглэн бүсчилсэн сургалтуудыг зохион байгуулах	Төмс, хүнсний ногоо үйлдвэрлэгчдийн мэдлэг, чадвар дээшилсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ
13	13	2 жилээс дээш хугацаагаар газраа ашиглаагүй тариалангийн газрыг төсөл сонгон шалгаруулах замаар дахин эзэмшүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Тариалангийн талбайн ашиглалт, эзэмшилт сайжирсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ
14	14	Төмс, хүнсний ногоо тариалагчдад зориулсан техникийн үйлчилгээний нэгжийг бүсийн төвүүдэд байгуулахад дэмжлэг үзүүлэх	Төмс, хүнсний ногоо тариалагчдын хөдөлмөр хөнгөвчлөгдөж, орлого нэмэгдэхэд нөлөө үзүүлсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ
15	15	“Малчид, тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг хангах журам”-ыг олон нийтийн санал, санаачилгад тулгуурлан боловсруулах	Малчид, тариаланчдын харилцаа сайжирна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ
16	16	“Хамгаалагдсан тариалан” хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Эрт ургацын ногооны хангамж нэмэгдэнэ.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ
2.Цэвэр эрлийз, нутгийн шилмэл омгийн малын тоог урьд оныхоос 10 хувиар өсгөж, иргэдэд төрөөс үзүүлэх мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг чанартай технологийн хугацаанд явуулж, малын тооны өсөлтөөс татгалзаж, эрүүл чанартай малтай болно.				
17	1	Малын ашиг шимийн түвшинг тогтоож, үржил селекцийн ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулан, фермерийн аж ахуй эрхлэх, өндөр ашиг шимтэй малыг	Мах, сүү, ноос, ноолуурын чиглэлийн мал үржлийн ажлыг сумдад хэрэгжүүлэх үндэслэл бий болж, эрчимсэн мал аж ахуй эрхлэгчдийн тоо	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ

		өсгөн бойжуулахыг дэмжих	нэмэгдсэн байна.	
18	2	Малын зохиомол хээлтүүлгийн үйл ажиллагааг технологийн дагуу явуулах, мэргэжилтэнг бэлтгэж, хамрагдах малын тоог нэмэгдүүлэх	Хээлтүүлэгч малын тоо нэмэгдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ
19	3	Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан хосолсон загвар аж ахуйг танилцуулах, өндөр ашиг шимт махны чиглэлийн “Цагаан суффолк” үүлдрийн хонины үржүүлгийн технологи, арга ажиллагааны үзүүлэх сургалт, малчдын зөвөлгөөнийг Зүүнбүрэн суманд зохион байгуулах	Махны шинэ хэвшлийн хонины үржлийн ажлыг эрхлэх арга ажиллагааг эзэмшсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ
20	4	Бэлчээр, хадлангийн талбайн кадастрын зураглалыг шинэчлэн тогтоож, бэлчээрийг зүй зохистой ашиглах, талхагдал, доройтлоос сэргийлэх, хортон мэрэгчидтэй тэмцэх, олон наст тариалах зэрэг арга хэмжээг зохион байгуулах	Малчдын бүлгүүд өөрсдөө үйл ажиллагаа явуулах арга зүйгээр хангагдсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ, ГХБХГ
21	5	Малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх технологит хугацаанд нь хамруулж, тандалт, хяналтыг журмын дагуу явуулах	Мал сүрэгт урьдчилсан тандалт, сэргийлэх арга хэмжээг хугацаанд нь чанартай зохион байгуулсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ
22	6	Малын халдварт өвчний голомтыг устгах, ариутгал, халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулахад байгаль орчинд халгүй технологи нэвтрүүлж, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах	Малын гоц халдварт өвчин гарахгүй байх нөхцөл хангагдсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ
23	7	Хоршоо, мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэх	Арьс шир, ноосны анхан шатны боловсруулах үйлдвэр байгуулагдсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ
24	8	Мал сүргийг бүртгэлжүүлэлт, ээмэгжүүлэлтэнд хамруулах	Цөм сүргийн үржлийн малыг 100 хувь бүртгэлжүүлсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ
25	9	Махны шинэ хэвшлийн хонины аж ахуйг байгуулахад дэмжлэг үзүүлэх, малыг бордох замаар махны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	Малчдын орлого нэмэгдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ
26	10	Малын уурагт тэжээлийн хангамжийг олон наст ургамал тариалах замаар хангахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх	2 аж ахуйн нэгжид усалгаатай 3-га-аас доошгүй га талбайд тариалж, малыг уурагт тэжээлээр тэжээх, талаарх ойлголт иргэдэд бий болсон	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ

			байна.	
3. Байгаль орчныг хамгаалах талаар гарсан Монгол Улсын хуулиудын хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг эрчимжүүлж уул уурхайн нөхөн сэргэлтийг нэмэгдүүлэн, цөлжилттэй тэмцэх ажлыг эрчимжүүлнэ.				
27	1	Ойн нөөцийг хамгаалах, ойн нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулан улс, орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгөөр 1500 га талбайд ойжуулалт хийх	Ойжуулсан нийт талбайн хэмжээ 1500 га-гаар нэмэгдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БОАЖГ
28	2	Ойн хөнөөлт шавьжтай тэмцэх ажлыг зохион байгуулж, ойд арчилгаа цэвэрлэгээ хийх сургалт зохион байгуулах	Ойн хөнөөлт шавьжтай тэмцэх ажлыг 8800 га талбайд гүйцэтгэсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БОАЖГ
29	3	“Сэлэнгэ-ногоон бүс” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	Аймгийн хэмжээнд ногоон байгууламж нэмэгдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БОАЖГ
30	4	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах	Ой, хээрийн түймрийн гаралт багассан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БОАЖГ
31	5	Хог хаягдлыг бууруулах “Сэлэнгэ-Цэвэр орчин” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх	Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах таатай нөхцөл бүрдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БОАЖГ
32	6	Булгийн эхийг тохижуулах, хамгаалах ажлыг зохион байгуулах.	Булаг, шандын эх хамгаалагдсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БОАЖГ
33	7	Байгаль орчны сургалт, сурталчилгааг зохион байгуулах.	Хууль, тогтоомжийн хэрэгжилт сайжирсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БОАЖГ
34	8	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц бүхий газрыг иргэн, аж ахуйн нэгжид эзэмшүүлэх талаар холбогдох байгууллагуудад санал боловсруулж хүргүүлэх	Түгээмэл тархацтай ашигт малтмалын үйлдвэрлэлд орон нутгийн хяналт сайжирна.	Аймгийн ЗДТГ
35	9	Уул уурхайн нөлөөгөөр эвдрэлд орсон газрыг тогтоож, олборлолт явуулж буй аж ахуйн нэгж болон мэргэжлийн байгууллагуудаар нөхөн сэргээх ажлыг хийж гүйцэтгүүлэх журам боловсруулан хэрэгжүүлэх	Нөхөн сэргээлт хийгдсэн талбайн хэмжээ нэмэгдэнэ.	Аймаг, сумдын ЗДТГ, БОАЖГ
36	10	Зориудаар үүлэнд нөлөөлж хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	Хур тунадсыг нэмэгдүүлсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, УЦУОША

37	11	Газар хөдлөлтийг бүртгэх станцыг барьж, ашиглалтанд оруулах	Газар хөдлөлтийг бүртгэх, мэдээлэл дамжуулах үйл ажиллагаа эхэлсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ГХБХГ
38	12	GPS байнгын ашиглалтын станц барих ажлыг эхлүүлэх	GPS станцын барилгын ажил эхэлсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ГХБХБГ
4. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн болон жижиг, дунд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний төрөл тоо, хэмжээг нэмэгдүүлж, худалдаа, ахуйн үйлчилгээний салбарт соёлч, шуурхай үйлчилгээг нэвтрүүлж, стандартын шаардлага хангасан аж ахуйн нэгжүүдийг бий болгоно.				
39	1	“Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих” аймгийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх	Жижиг, дунд үйлдвэр, ажлын байрны тоо нэмэгдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ
40	2	Жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй эрхлэгчдэд зориулсан сургалтыг зохион байгуулах	Жижиг дунд үйлдвэр, өрхийн аж ахуй эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагаа эрхлэх мэдлэг чадвар дээшилсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ
41	3	“Зөгий” хөтөлбөрийн хүрээнд 5-аас доошгүй иргэдийг зөгийн аж ахуй эрхлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх	Бүтээгдэхүүний тоо, хэмжээ нэмэгдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ
42	4	Зураасан код, үндэсний тохирлын тэмдэгтэй бүтээгдэхүүний ач холбогдлыг таниулах, тоо хэмжээг нэмэгдүүлэх талаар үйлдвэрлэл эрхлэгчдэд сурталчилах ажлыг зохион байгуулах	Үндэсний тохирлын тэмдэгтэй бараа бүтээгдэхүүний тоо нэмэгдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, Стандартчилал хэмжилзүйн хэлтэс
43	5	Рапсын тос, сагад будааны үйлдвэр шинээр байгуулах иргэдийн санал, санаачлагыг дэмжих	Рапсын тос, сагад будааны үйлдвэр ашиглалтанд орсон байна.	Аймаг, сумдын ЗДТГ
44	6	Иргэдийн хэрэгцээнд зориулан нөөцийн мах бэлтгэн нийлүүлж, үнийн өсөлтийг тогтворжуулах	Махны хангамж, нэмэгдэж үнэ тогтворжсон байна.	Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс, “Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ
45	7	Малын тэжээлийн үйлдвэр, цехийг бүсчилэн байгуулах	Малын тэжээлийн үйлдвэр, цехийн тоо хэмжээ нэмэгдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ
46	8	Түгээмэл тархацтай байгалийн баялгийн нөөцөд тулгуурлан барилгын материалын үйлдвэрлэлийг эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх	Барилгын материалын үйлдвэрлэл нэмэгдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ

47	9	“Сэлэнгийн ногоо” захыг Улаанбаатар хотод ажиллуулж, “Сэлэнгэд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг зохион байгуулах	Аймгийн брэнд бүтэгдэхүүнийг сурталчилж, борлуулалт нэмэгдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ
48	10	“Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх” тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд аттестатчилал явуулж, худалдаалах цэгийг шинэчлэн тогтоох	“Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх” журам хэрэгжсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ
49	11	Аймгийн төвд эрүүл ахуйн шаардлага хангасан, бизнесийн жишигт нийцсэн худалдааны төвийг барих	Стандартын шаардлага хангасан худалдааны төвтэй болсон байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ, Мэргэжлийн хяналтын газар, “Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ
50	12	“Зочид буудлын ажиллах журам”-ыг шинэчилэн боловсруулах	Зочид буудлын үйл ажиллагаа сайжирсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ
51	13	Үйлчилгээний салбарт ажиллагсдын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулах	Үйлчилгээний салбарт ажиллагсдын 80 хувь нь мэргэжлийн чиг баримжаатай болсон байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААЖДҮГ
52	14	Ерөө, Сүхбаатар, Түшиг сумдад “Ахуй үйлчилгээний цогцолбор төв”-ийг ашиглалтанд оруулах	Ахуйн үйлчилгээний төвлөрсөн цэгтэй болж, иргэдэд үйлчилгээ ойртсон байна.	Сумдын ЗДТГ
53	15	Аймгийн Мэргэжлийн хяналтын байгууллагын дэргэдэх лабораторийн зарим тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх	Хүнсний баталгаат байдал хангагдана.	Мэргэжлийн хяналтын газар
54	16	Хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангахад тавих хяналтын ажил үйлчилгээний арга хэлбэр, зохион байгуулалтанд шинэчлэл хийх	Хүнсний баталгаат байдал хангагдана.	Мэргэжлийн хяналтын газар
5.Дэд бүтцийн салбарын хүрсэн түвшинг бататгаж, улсын болон орон нутгийн төсөв, иргэн аж ахуйн нэгжийн болон дотоод гадаадын зээл тусламжийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.				
55	1	Сайхан, Баянгол, Цагааннуур, Сүхбаатар сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураглалыг мэргэжлийн байгууллагуудаар хийж гүйцэтгүүлэх	Хотжилт, газар зохион байгуулалтын төлөвлөлт оновчтой болно.	Аймаг, сумдын ЗДТГ
56	2	Ногоон байгууламжийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх	Иргэдийн ая тухтай амьдрах орчин бий болно.	Аймаг, сумдын

				ЗДТГ
57	3	Амины орон сууцны шинэ хотхон хороололыг бий болгоход иргэдийн идэвх, санаачилгыг дэмжих	Орчин үеийн шаардлага хангасан амины орон сууцны хороолол бий болсон байна.	Аймаг, сумдын ЗДТГ
58	4	Орон сууцны шинэ хотхоны “Эко” хорооллын инженерийн шугам сүлжээг нэмэгдүүлэх	Иргэдийн орон сууцны хангамж нэмэгдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ
59	5	Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй барилга байгууламжинд хяналт тавьж, төсвийн жилд багтаан ашиглалтанд оруулах	Шаардлага хангасан барилга байгууламжууд бий болсон байна.	Аймаг, сумдын ЗДТГ
60	6	“Сэлэнгэ энерго” орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дулааны шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх	Инженерийн шугам сүлжээнд холбогдоогүй болон доголдож байгаа барилга байгууламж найдвартай эрчим хүчээр хангагдана.	Аймгийн ЗДТГ, “Сэлэнгэ энерго” ОНӨҮГ
61	7	“Урсгал ус” орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөн, шинэчлэх зураг төслийг боловсруулах	Зураг төсөл боловсрогдсон байна.	Аймгийн ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба, “Урсгал ус” ОНӨҮГ
62	8	Сүхбаатар суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан халдвартын 20 ортой эмнэлэг, 960 хүүхдийн сургуулийн дулааны шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх	Сургууль эмнэлгийн хэвийн үйл ажиллагаа хангагдана.	Аймаг, сумын ЗДТГ
63	9	Мандал сумын Хэрх тосгонд 35 кВт-ын дэд станц барих	Эрчим хүчний хангамж нэмэгдсэн байна.	Аймаг, сумын ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба
64	10	Мандал сумын цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх	Сумын бохир ус зайлуулах нэгдсэн сүлжээ бий болно.	Аймаг, сумын ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба
65	11	Сайхан сумын Хөтөл доторх инженерийн шугам сүлжээний бетонон хонгил барих ажлыг эхлүүлж, орон сууцны шинэ хотхон хорооллын инженерийн барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах	Хотын доторх дэд бүтэц сайжирч, барилга байгууламжийн зурагтай болсон байна.	Аймаг, сумдын ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба
66	12	Сүхбаатар сумын 4-р багийн гэр хорооллыг дулаан, цэвэр усны	Иргэдийн ажиллаж, амьдрах ая тухтай орчин бүрдэнэ.	Аймаг, сумдын

		шугамд холбох ажлыг эхлүүлэх		ЗДТГ-ын Худалдан авах ажиллагааны алба
67	13	Сүхбаатар сумын төвийн нийтийн эзэмшлийн талбайн хөрсөн замыг хэсэгчлэн засварлаж асфалто-бетонон зам, тохижилтын ажлыг эхлүүлэх	Орчин үеийн стандартаар тохижсон байна.	Аймаг, сумдын ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба
68	14	Хушаат сумын төмөр бетон гүүрийг ашиглалтанд оруулж, Хүдэр сумын төмөр бетон гүүрийн ажлыг эхлүүлж, Бугант-Ходоод чиглэлийн 9 км авто замын зураг төслийг боловсруулах	Орон нутгийн дэд бүтэц сайжирч иргэдэд ая тухтай зорчих нөхцөл бүрдэнэ.	Аймаг, сумдын ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба
69	15	Орхон суманд бэлчээрийн худаг, Жавхлант сумын баруун хороололд гүний худаг гаргах	Хүн, малын усан хангамж сайжирна.	Аймаг, сумдын ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба
70	16	Хушаат сумын “Дуулга” хорооллын цахилгааны шугам татах	Найдвартай эрчим хүчээр хангагдсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба
71	17	Орхон сумын төмөр замын 42-р зөрлөгийн хайрган авто замыг сайжруулах	Авто зам сайжирсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ
72	18	Баянгол сумын инженерийн шугам сүлжээ, Баруунбүрэн сумын дулааны шугам сүлжээг сэргээн засварлах, Орхонтуул сумын уурын зууханд халаалтын тогоо суурилуулах	Найдвартай дулааны эрчим хүчээр хангагдсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба
73	19	Орхонтуул, Хүдэр сум, Бугант тосгонд WI-FI утасгүй интернетийн орчинг бий болгох	Орон нутгийн төрийн байгууллага, иргэд мэдээ мэдээллээр шуурхай хангагдах нөхцөл бүрдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба
74	20	Түшиг суманд цэцэрлэгт хүрээлэн байгуулах	Сумын тохижилт сайжирна.	Аймаг, сумдын ЗДТГ
75	21	Шарын гол Жавхлант чиглэлийн 7	Орон нутгийн автозам	Аймаг,

		км сайжруулсан авто замыг хатуу хучилттай болгож, Мандал суманд хатуу хучилттай зам тавих	сайжирсан байна.	сумдын ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба
76	22	Сумдын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, гэрэлтүүлгийн ажлыг хийх	Зорчигчдын аюулгүй зорчих орчин бүрдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ

1. Төсвийн орлогыг нэмэгдүүлэн батлагдсан төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулж төсвийн ил тод байдлыг хангаж ажиллана.

77	1	Татварын бааз суурийг өргөжүүлж татвар төлөгчдийн тоог нэмэгдүүлэн татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэх	Орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, орлого зардлын зохистой түвшин хангагдсан байна.	Аймгийн ЗДТГ, Татварын хэлтэс
78	2	“Төсвийн тухай” хууль болон холбогдох заавар, журмын хэрэгжилтийг Сайхан, Цагааннуур, Түшиг сумдад шалган зааварлах	Төсвийн тухай хууль, төрийн сангийн төлбөр тооцооны журам хэрэгжсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ,
79	3	“Төсвийн тухай” хуулиар Сангийн яамтай хамтарсан сургалт зохион байгуулах	Төсвийн захиран зарцуулагчдын мэдлэг дээшилж, хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс,
80	4	Орон нутгийн өмчийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын эд хөрөнгийн бүртгэлийг цахимжуулах	Орон нутгийн өмч хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт сайжирна.	Аймгийн ЗДТГ, ОНӨА
81	5	Статистикийн сар бүрийн мэдээ, мэдээллийг шуурхай, цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээлж, ард иргэдэд хүргэх	Мэдээлэл иргэдэд тогтмол шуурхай хүрдэг болно.	Аймгийн ЗДТГ, Статистикийн хэлтэс

Хоёр. Нийгмийн бодлого

1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

82	1	Хүн амын эрүүл мэндийн эрсдэлт зан үйлийг өөрчлөх талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийж, урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулах	Эрүүл мэндийн боловсрол олгох ажил тогтмолжин, хүн амын 25-аас доошгүй хувь урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ЭМГ
83	2	Нарийн мэргэжлийн эмч нарын явуулын амбулаторийн багийн үйлчилгээг төвөөс алслагдсан хүн амд хүргэх ажлыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах	Алслагдсан сумдын хүн ам эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ЭМГ
84	3	Сургууль, цэцэрлэгүүдэд шүдний эмчийг тодорхой хуваарийн дагуу	Хүүхдийн шүдний өвчлөл буурсан байна.	Аймаг, сумдын

		ажиллуулж амны хөндийн өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах		ЗДТГ, ЭМГ
85	4	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын талаар иргэдээс мэдээлэл авах “Үйлчлүүлэгчийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авах цэг”-ийг бүх шатны эмнэлэгт ажиллуулах	Мэдээлэл авах утас ажиллуулж, шуурхай шийдвэрлэдэг болсон байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ЭМГ
86	5	Эрүүл мэндийн төвүүдэд эх нярайд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр эх нярайд хэрэглэгдэх яаралтай тусламжийн тоног төхөөрөмжөөр хангах	Эмнэлгийн тусламж үйлчилгээнд ахиц гарч, эх нярайн эндэгдлийн эрсдэл буурсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ЭМГ
87	6	Ерөө сумын Эрүүл мэндийн төвийг Сум дундын эмнэлэг болгох асуудлыг холбогдох газарт тавьж шийдвэрлүүлэх	Ерөө бүсийн иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ ойртсон байна.	Аймгийн ЗДТГ, Ерөө сумын ЗДТГ, ЭМГ
88	7	Нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвүүдэд яаралтай тусламжийн тасаг ажиллуулж, жишиг тасаг, нэгж байгуулах	Жишиг тасаг, нэгж байгуулагдаж иргэд чирэгдэлгүй үйлчлүүлж, тэдний сэтгэл ханамж дээшилсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ЭМГ
89	8	“Эх үрсийн төлөө хамтдаа” Монгол-Буриадын хамтарсан зөвлөгөөн зохион байгуулах	Харилцан туршлага солилцож, хамтын ажиллагаа өргөжинө.	Аймаг, сумдын ЗДТГ, ЭМГ
90	9	Сүрьеэ, хорт хавдар, ХДХВ/ДОХ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах	Халдварт өвчний гаралт буурна.	Аймаг, сумдын ЗДТГ, ЭМГ
91	10	Эмч, мэргэжилтнээр хангах бодлого боловсруулж хэрэгжүүлэх	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн төлөвлөлт, хэрэгжилт сайжирна.	Аймаг, сумдын ЗДТГ, ЭМГ
92	11	“Эмийн чанарын аюулгүй байдлыг хангах” сэдвээр эмийн санчдад, “Хүн амын дунд эмийн зохистой хэрэглээ” сэдвээр иргэдэд сургалт сурталчилгааг зохион байгуулж, эм ханган нийлүүлэгчид, эргэлтийн эмийн сан, хувийн хэвшлийн эмийн сангуудад үзлэг шалгалтыг зохион байгуулах	Иргэд чанартай, аюулгүй эмийн зохистой хэрэглээтэй болсон байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ЭМГ
93	12	Аймаг, сумын Нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг	Оношлогоо шинжилгээний чанар сайжирна.	Аймаг, сумдын ЗДТГ,

		сайжруулж, эмнэлгийн анхан шатны оношилгоо, шинжилгээний лабораторийг байгуулах		ЭМГ
94	13	Өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, сайжруулах.	Иргэдэд үзүүлэх, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ сайжирсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ЭМГ
95	14	“Эрүүл сум, хот, байгууллага” аймгийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн эхний шатны зорилтууд хэрэгжсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ЭМГ
96	15	Ерөө сумын халуун рашааны чанарыг тодорхойлох асуудлыг холбогдох газарт тавьж шийдвэрлүүлэх	Чанар тодорхойлогдсон байна.	Аймгийн ЗДТГ, Ерөө сумын ЗДТГ
97	16	Төв суурин газрын томоохон худалдааны төвүүдэд “Чихрийн шижин”-гээр өвчлөгсдөд зориулсан хүнсний бүтээгдэхүүний цэг тасаг ажиллуулах	“Чихрийн шижин”-гээр өвчлөгч иргэдэд хүргэх үйлчилгээний хүртээмж сайжирсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ
98	17	Ерөө сумын Эрүүл мэнийн төвийн цэвэр, бохир усны шугам, Хүдэр сумын эрүүл мэндийн төвийн гадна шугамын засварыг хийх	Эрүүл мэндийн төвүүдийн хэвийн үйл ажиллагаа хангагдсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба
99	18	Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Сайхан сумын сум дундын эмнэлэг, Баруунбүрэн, Жавхлант сумын Эрүүл мэндийн төвийн барилгыг их завсар, Шаамар сумын Дулаанхаан тосгоны Эрүүл мэндийн төвийг шинээр барих	Эмнэлэг, Эрүүл мэндийн төвүүдийн хэвийн үйл ажиллагаа хангагдсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба
100	19	Хушаат сумын Эрүүл мэндийн төвийн сантехникийн засвар хийж, эргэлтийн эмийн сан, стандартын моорог, гарааж шинээр барьж ашиглалтанд оруулах	Засвар хийгдэж моорог, гарааж баригдсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба
2. Багш, хүүхэд бүрийг хөгжүүлэх боловсролын чанарын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлж, суралцагчдын суралцах, хөгжих сургалтын таатай орчинг бүрдүүлнэ.				
101	1	Сургуулийн өмнөх боловсролд зорилтот болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрх, малчид, ногоочдын хүүхдүүдийн явуулын, нүүдлийн сургалт зохион байгуулах	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 97.8 хувьд хүрсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БСГ

102	2	Цэцэрлэгийн “Багш хөгжлийн төв”-ийг тохижуулах ажлыг зохион байгуулах	Багш нар мэргэжил боловсролоо дээшлүүлэх таатай орчин бүрдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БСГ
103	3	Суурь боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, бага, дунд боловсролын чанар, үр ашгийг дээшлүүлэх сургалтанд боловсролын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Суурь боловсролын хамран сургалт 99.0 хувьд хүрч, сурагчдын сурлага, хүмүүжлийн төлөвшилд чанарын ахиц гарсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БСГ
104	4	Хүүхэд бүрийг хөгжүүлэх “Авьяас”, “Ном” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх	Хүүхэд бүрийн хэрэгцээ, авьяас, сонирхолд тулгуурлан хөгжүүлэх боломж бий болсон байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БСГ
105	5	“Цахим сургууль-Цахим сургалт” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх	Сургууль, цэцэрлэг мэдээлэл технологийг сургалтын орчинд өргөн ашиглах боломжтой болсон байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БСГ
106	6	Албан бус боловсролын “Гэгээрэл” төвүүдийг компьютер, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичгээр хангаж, интернэтэд холбон Сүхбаатар сумын Гэгээрэл төвийг байртай болгох асуудлыг шийдвэрлүүлэх	Албан бус боловсролын үйл ажиллагаа сайжирсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БСГ
107	7	Аймаг, орон нутагт эрэлт хэрэгцээтэй мэргэжлээр гадаад, дотоодын их дээд сургуульд амжилттай суралцагчид, төгсөгчдийн мэдээллийн сантай болж, амжилттай суралцаж байгаа оюутнуудад дэмжлэг үзүүлэх журмыг боловсруулах, хэрэгжилтийг хангах	Оюутны суралцах идэвх сайжирч, орон нутагтаа ирж ажиллах сонирхол, хандлага бий болно.	Аймаг, сумдын ЗДТГ, БСГ
108	8	“Багшийн хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг эхлүүлэх	Төлөвлөгөөний дагуу тодорхой ажлууд хийгдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БСГ
109	9	“Хүүхдийг гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх арга зам” аймгийн зөвлөгөөнийг зохион байгуулах	Хүүхэдтэй холбогдсон гэмт хэргийн гаралт буурсан байна.	Аймгийн ЗДТГ, Цагдаагийн газар, БСГ, ХГБХХ сумдын ЗДТГ
110	10	Ерөнхий боловсролын 11-р ангийн төгсөгчдөд зориулж “Мэргэжил сонголт-2013” арга хэмжээг зохион байгуулах	Төгсөгчид мэргэжлийн талаар чиглэл, баримжаа авч, ирээдүйн мэргэжлээ сонгох аргад суралцсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БСГ

111	11	Зарим сургуульд автобусны үйлчилгээг бий болгох	Суралцагчдын аюулгүй байдлыг хангах, унаагаар үйлчлэх боломжтой болсон байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БСГ
112	12	“Үдийн хоол” хөтөлбөрийг хэрэгжүүлж, тогоочдын ур чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулж, хоол хүнсний хангамж, эрүүл ахуйн нөхцөлд үзлэг шалгалт зохион байгуулах	Суралцагчид эрүүл ахуй, аюулгүй байдлын баталгааг хангасан орчин бүрдэж, хоол хүнсний хэрэглээнд чанарын ахиц гарсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БСГ
113	13	Сант суманд сургуулийн барилга шинээр барих ажлыг эхлүүлэх	Сургалтын таатай орчин бүрдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба, БСГ
114	14	Мандал суманд 100 ортой дотуур байрны барилгыг барих	Дотуур байрны хүүхдийн хамрагдалт нэмэгдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба, БСГ
115	15	Сүхбаатар сумын Спорт сургуулийн спорт залны барилгыг шинээр барих	Сургалт явуулах нөхцөл бүрдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба, БСГ
116	16	Мандал, Шаамар сумд, Бугант тосгонд 100 ортой цэцэрлэгийн байрны барилгыг барих	Сургуулийн өмнөх боловсролын хамралт нэмэгдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба, БСГ
117	17	Мандал сумын Хэрх тосгонд цэцэрлэгийн барилгын өргөтгөлийг барих	Сургуулийн өмнөх боловсролын хамралт нэмэгдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба, БСГ
118	18	Алтанбулаг, Жавхлант сумд, Дулаанхаан тосгонд 75 ор, Мандал сумын Тарни багт 50 ортой цэцэрлэгийн барилгыг барих	Сургуулийн өмнөх боловсролын хамралт нэмэгдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба, БСГ

119	19	Баруунбүрэн суманд спорт зал, Сүхбаатар сумын 6-р сургуулийн барилгыг өргөтгөх	Сургалт явуулах орчин нөхцөл бүрдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба, БСГ
120	20	Шаамар сумын МСҮТ-ийн барилгыг засварлах	Сургалтын таатай орчин бүрдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба, БСГ, Хөдөлмөрийн хэлтэс
121	21	Сүхбаатар сумын 7-р цэцэрлэгийн барилгын цахилгаан эрчим хүчний асуудлыг шийдвэрлэх	Найдвартай эрчим хүчээр хангагдана.	Аймаг, сумдын ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба, БСГ
122	22	Цагааннуур сумын цэцэрлэгийн сантехник, цахилгаан барилгын засвар, Баянгол сумын сургуулийн ариун цэврийн өрөөний засвар, Сайхан сумын 20-р цэцэрлэгийн сантехник, Хүдэр сумын цэцэрлэгийн бохир усны гадна шугам засвар, Түшиг сумын сургуулийн сантехник, ариун цэврийн өрөөний засвар, Хушаат сумын сургуулийн барилгын цахилгааны засварыг хийх	Сургалтын орчин сайжирсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба, БСГ
123	23	Зарим сургууль, цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмж, ширээ сандал, зөөлөн, хатуу эдлэлийг шинэчлэх	Сургалтын таатай орчин бүрдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БСГ

3. Иргэд олон нийтийн санал санаачилгад тулгуурласан нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

124	1	Нийгмийн халамж, дэмжлэг тусалцаа шаардлагатай өрх, иргэнд тусламж, хөнгөлөлт олгох ажлыг зохион байгуулах	Зорилтот бүлгийн иргэд нийгмийн хамгааллын үйлчилгээг хүртсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, НХҮХ, ЭМГ
125	2	Эх, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах хөтөлбөр боловсруулан, батлуулж хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх	Хөтөлбөр хэрэгжиж, эх, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах зохицуулалт бий болсон байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХГБХХ, НХҮХ, ЭМГ
126	3	Сумдын ахмадын байр,	Ахмадын өргөө, сувиллын	Аймаг,

		ахмадуудын амралт сувиллын орчинг сайжруулж, Жавхлант суманд ахмадын өргөөг шинээр байгуулан Сүхбаатар суманд Буман нарс сувиллын барилгыг барих	байртай болж, ахмадын байр, амралт, сувиллын үйл ажиллагаа тогтмолжин хамрах хүрээ нэмэгдсэн байна.	сумдын ЗДТГ, НХҮХ, ЭМГ
127	4	Орон сууц, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний газарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг стандартын дагуу бий болгох ажлыг эхлүүлэх	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэцтэй болсноор үйлчилгээ авах боломж бүрдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, НХҮХ, ЭМГ
128	5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах “Нэг иргэн-нэг байгууллага” хөдөлгөөн өрнүүлэх ажлыг эхлүүлэх	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХГБХХ
129	6	Хүүхдийн чуулганыг зохион байгуулж, “Хүүхдэд ээлтэй баг, сум” болох хөдөлгөөн өрнүүлэх ажлыг эхлүүлэх	Хүүхдийн дуу хоолой, үзэл бодол санал санаачилгыг ажил хэрэг болгож, “Хүүхдэд ээлтэй баг, сум” бий болсон байна.	ХГБХХ сумдын ЗДТГ
130	7	“Хөгжлийн бэрхшээлтэй иргэд-хөгжил хамгааллын бодлого-шинэчлэл” зөвлөгөөн зохион байгуулах	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо сайжирч, бодлогын баримт бичигт тэдний санал тусгагдаж хэрэгжсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, НХҮХ, ХГБХХ, Цагдаагийн газар
131	8	Хөдөлмөр эрхлэлт, ажлын байр нэмэгдүүлэх бодлогыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санаачилгад тулгуурлан хэрэгжүүлэх	Шинээр 1500 ажлын байр бий болсон байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХГБХХ
132	9	Нийгмийн халамжийн үйлчилгээ болон төсөл, хөтөлбөрт хамруулах замаар бага орлоготой өрхийн амьжиргааг дээшлүүлэх	100-гаас доошгүй өрхийн амьжиргаа дээшилсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, НХҮХ
133	10	Бүх сумдад ажил хайгч, ажил олгогчийг шууд холбох хөдөлмөр зуучлалын биет болон онлайн сүлжээг нэвтрүүлж эхлэх	Иргэдэд мэдээлэл түгээх ажил тогтмолжиж, онлайн сүлжээ, бүртгэл мэдээллийн систем бий болсон байна.	Аймаг, сумдын ЗДТГ, Хөдөлмөрийн хэлтэс
134	11	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагааг өргөжүүлэн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулан элсэгчдийг ажил олгогчийн захиалгаар сургаж, төгсөгчдийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх	Сургалтын орчин сайжирч, хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулан элсэгчдийн тоо нэмэгдэж, мэргэжилтэй ажилтны ажлын байрны баталгаа хангагдсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, Хөдөлмөрийн хэлтэс

135	12	“Ажлын байр-Амьдрах ухаан” хөтөлбөр боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх	Ажлын байр нэмэгдэж, иргэдийн амьжиргааны түвшин дээшилсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, Хөдөлмөрийн хэлтэс
136	13	Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт салбар хороо, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хорооны бүрэлдэхүүн, ажил олгогчдыг чадваржуулах сургалт зохион байгуулах	Мэдлэг, мэдээлэл сайжирч чадваржсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, Хөдөлмөрийн хэлтэс, НДХ
137	14	Малчид, ажилгүй иргэд, жижиг аж ахуй эрхлэгчид болон шинээр байгуулагдсан аж ахуйн нэгж байгууллагуудад нийгмийн даатгалын хууль эрх зүйн сургалт сурталчилгааг зохион байгуулах	Даатгалд хамрагдах иргэд, аж ахуйн нэгжийн тоо нэмэгдэж, хуулийн хэрэгжилт сайжирсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, НДХ
138	15	Аймгийн төвд гэр бүл, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэх “Гэр бүл-хөгжлийн ордон”-ы барилгын зураг төслийг боловсруулж, хөрөнгө шийдвэрлүүлэх	Зураг, төсөв хөрөнгийн асуудал шийдэгдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ХГБХХ

4.Үндэсний урлаг, соёл, аялал жуулчлал, биеийн тамир, спортын аймаг, орон нутаг дахь ажил, үйлчилгээний чанар, хүртээмжийг иргэд, олон нийтийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн сайжруулна.

139	1	Соёл, урлагийн байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулах	Соёл урлагийн салбарын орон нутгийн бодлого тодорхойлогдсон байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БСГ
140	2	Соёлын салбарын ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтанд шат дараатайгаар хамруулах	Соёлын салбарт ажиллагсдыг мэргэжил ур чадварт ахиц гарсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БСГ,
141	3	”Бид Сэлэнгийн үр сад“ хүүхдийн урлагийн наадам зохион байгуулах	Хүүхдийн авьяас чадварыг нээн илрүүлж, гоо зүйн төлөвшилд ахиц гарсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БСГ, ХГБХХ
142	4	Угийн бичиг хөтлөх ажлыг зохион байгуулах	Аймгийн нийт өрхийн 10-аас доошгүй хувь хамрагдсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БСГ

143	5	Аймаг, сумын хамгаалалтанд авсан түүх соёлын үл хөдлөх дурсгалыг сурталчилж, соёлын өвийг хадгалж, хамгаалахад хувь нэмрээ оруулсан иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийг алдаршуулах ажлыг зохион байгуулах	Иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоо нэмэгдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БСГ
144	6	Сумдын “Орон нутгийн судлах танхим”-ыг тохижуулан, соёлын биет ба биет бус өвийг баримтжуулан, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах	Сан хөмрөгийн үзмэрийн тоо нэмэгдэж, иргэдийн түүх, соёл, танин мэдэхүйн мэдлэг дээшилсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БСГ
145	7	Сумдын соёлын төвүүд, номын сангийн үйл ажиллагааг идэвхжүүлж, алслагдсан баг, хөдөөгийн иргэдэд соёл урлаг, номоор үйлчлэх явуулын үйлчилгээ зохион байгуулах	Үйлчилгээнд алслагдсан сумдын хүн ам хамрагдсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БСГ
146	8	Улсын болон олон улсын чанартай уралдаан, наадамд мэргэжлийн уран бүтээлчид, ардын авъяастан, хүүхэд залуучуудыг оролцоход дэмжлэг үзүүлэх	Уран бүтээлийн чанарт ахиц гарч, өрсөлдөх ур чадвар дээшилсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БСГ
147	9	Спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлж нийтийн биеийн тамираар хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэх	Хүн амын бие бялдар чийрэгжиж, эрүүлжих боломж бүрдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БТСГ
148	10	Тив, дэлхийн болон улсын аварга шалгаруулах уралдаан, тэмцээнд амжилттай оролцсон иргэнийг шагнаж урамшуулах журмыг шинэчлэн мөрдөх	Оюуны болон спортын уралдаанд оролцогсдын амжилтын чанарт ахиц гарсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БСГ, БТСГ
149	11	Спортын холбоод, клубүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Спортын холбоод клубүүдийн материаллаг бааз бэхжиж, тамирчдын ур чадвар дээшилсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БТСГ
150	12	Аймгийн аялал жуулчлалын бодлогыг шинээр тодорхойлж, соёлын үнэт өв, түүхийн дурсгалт газруудыг тэмдэгжүүлсэн газрын зураг, аймгийн онлайн “Нэвтэрхий толь”, аялал жуулчлалын мэдээллийн санг бий болгох ажлыг эхлүүлэх	Мэдээллийн нэгдсэн сантай болсон байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БОАЖГ, БСГ
151	13	Үндэсний сур, шагайн спортыг хөгжүүлэх аймгийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	Үндэсний спортын материаллаг бааз нэмэгдэж, үндэсний спортоор хичээллэгсдийн тоо нэмэгдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БТСГ

152	14	Аймгийн Засаг даргын нэрэмжит цомын төлөөх спортын тэмцээн зохион байгуулах	Чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлж, спортоор хичээллэх сонирхол нэмэгдсэн байна.	Аймгийн ЗДТГ
153	15	Шаамар, Хүдэр сумдад Соёлын төвийг шинээр барих	Урлаг, соёлоор үйлчлүүлэх таатай орчин бүрдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба, БТСГ
154	16	Орхонтуул сумын Рашаант тосгонд соёлын төв болон Захирагчийн ажлын албаны байрыг шинээр барих	Урлаг, соёл, төр захиргааны ажил үйлчилгээний орчин бүрдсэн байна.	Аймгийн ЗДТГ, Орхонтуул сумын ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба, БСГ
155	17	Шаамар сумын Дулаанхаан тосгоны Соёлын төвийг хөгжим хэрэгслээр хангах	Урлаг, соёлын үйлчилгээний цар хүрээ нэмэгдсэн байна.	Аймгийн ЗДТГ, Дулаанхаан тосгоны зохирагчийн алба, БСГ
156	18	Амарбаясгалант хийдэд нийтийн ариун цэврийн цэг, хамгаалалтын хашаа, автомашины зогсоол шинээр барьж ашиглалтанд оруулах	Эрүүл ахуйн стандартын шаардлагыг хангасан үйлчилгээ бий болсон байна	Аймгийн ЗДТГ, Баруунбүрэн сумын ЗДТГ
157	19	Сүхбаатар суманд усан бассейн барих	Усан спортоор хичээллэгсдийн хэрэгцээ, орчин хангагдсан байна.	Аймгийн ЗДТГ, Худалдан авах ажиллагааны газар, БСГ
158	20	Зарим сумдад гол мөрнийг түшиглэж, наран шарлагын талбай байгуулах зураг төсөл боловсруулж, газрыг шийдвэрлүүлэх	Иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлэх таатай орчин бүрдэнэ.	Аймаг, сумдын ЗДТГ, БТСГ
159	21	Зарим сумдад хөл бөмбөгийн зүлэгтэй талбай байгуулах зураг төсөл боловсруулж газрыг шийдвэрлүүлэх	Зураг, төсөл, төсөв тодорхой болсон байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БТСГ
160	22	Сумдад мөсөн гулгуурын талбай байгуулах зураг төсөл боловсруулж газрыг шийдвэрлүүлэх	Өвлийн спорт хөгжих боломж бүрдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ, БТСГ
161	23	Зүүнбүрэн, Шаамар суманд баяр	Иргэд баяр наадмаар цэнгэх	Аймаг,

		наадмын талбай барих	тохилог орчин бүрдсэн байна.	сумдын ЗДТГ, БТСГ
162	24	Боохой Данзангийн нэрэмжит үндэсний бөхийн барилдааныг Цагааннуур суманд зохион байгуулах	Сум орон нутаг, алдарт тамирчдыг сурталчлах, алдаршуулах, үндэсний бөхөөр хичээллэгсдийн ур чадвар дээшилнэ.	Аймгийн ЗДТГ, Цагааннуур сумын ЗДТГ
163	25	“Буган халиун”-ы нэрэмжит хурдан морины уралдааныг Цагааннуур суманд зохион байгуулах	Сум орон нутгаа сурталчлан, уяачдын цол зэрэг ахиж, ур чадвар дээшилнэ.	Аймгийн ЗДТГ, Цагааннуур сумын ЗДТГ
164	26	Идэрчүүдийн волейболын улсын аварга шалгаруулах “Гоё кап” тэмцээнийг зохион байгуулах	Аймаг орон нутгаа сурталчлан, тамирчид туршлага судалж, ур чадвар дээшилсэн байна.	Аймгийн ЗДТГ, БТСГ
165	27	“Ээж мод” орчмын газар нутгийг аймгийн хамгаалалтанд авч, сүсэгтэн олны зан үйлээ таатай орчинд соёлтой үйлдэх боломж бүрдүүлэх	“Ээж мод” орчныг тохижуулж, иргэдэд таатай нөхцөлийг бүрдүүлсэн байна.	Аймгийн ЗДТГ, Шаамар сумын ЗДТГ
Гурав. Нутгийн захиргаа, хууль эрх зүйн ажил үйлчилгээ				
1.Төрийн үйлчилгээний шуурхай байдал, чанар, хүртээмж, төрийн албан хаагчдын ажлын хариуцлагыг дээшлүүлж, гадаад харилцаа хамтын ажиллагааны залгамж чанарыг хадгалан хяналт-шинжилгээ, үнэлгээний үр нөлөөг дээшлүүлнэ.				
166	1	Аймгийн Засаг даргын Тамгын газарт Олон улсын Чанарын удирдлагын тогтолцоо MNS ISO 9001:2010 стандартыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах	Төрийн ажил үйлчилгээнд байнгын сайжруулалтын тогтолцоо бүрдэж үйл ажиллагааны чанар хүртээмж дээшилнэ.	Аймгийн ЗДТГ
167	2	Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийг шаардлагатай төрийн байгууллагад тухай бүр явуулж, үр дүнг тооцож ажиллах	Нутгийн захиргааны байгууллагын ажил үйлчилгээнд чанарын өөрчлөлт гарсан байна	Аймгийн ЗДТГ
168	3	Аймгийн Засаг даргын Тамгын газрын зөвлөн туслах багийг зарим сум, тосгодод ажиллуулах	Мэргэшил арга зүйн зөвлөгөө дэмжлэгээр хангагдсан байна.	Аймгийн ЗДТГ
169	4	Нутгийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэгт төрийн ажил үйлчилгээний шуурхай ил тод байдлыг хангах чиглэлээр өөрчлөлт хийх	Төрийн ажил үйлчилгээний шуурхай ил тод байдал хангагдсан байна	Аймгийн ЗДТГ
170	5	Аймгийн ЗДТГ-ын “Иргэний танхим”-ыг үйл ажиллагааг тогтмолжуулж, нээлттэй утас ажиллуулах, “Иргэдээ сонсьё” орон нутгийн телевизийн тогтмол нэвтрүүлэгтэй болох, зарим сумдад иргэний танхим байгуулах зэрэг арга хэмжээ авах	Иргэдийн санал, хүсэл, өргөдөл, гомдол шуурхай шийдвэрлэгдсэн байна.	Аймгийн ЗДТГ

171	6	Төрийн байгуулагуудын ажил үйлчилгээ, төрийн албан хаагчийн хариуцлага, ёс зүй, ажлын үр дүнг, иргэдийн сэтгэл ханамж, үнэлэмжинд тулгуурлан үнэлдэг тогтолцоог бий болгох	Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн бодитой үнэлэгдсэн байна	Аймгийн ЗДТГ
172	7	Төрийн албан хаагчийг гадаад, дотоодын хэрэгцээт сургалтанд хамруулах, мэргэшүүлэх, ажиллах нөхцөлийг сайжруулах	Төрийн албан хаагчдын мэдлэг чадвар дээшилж, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.	Аймгийн ЗДТГ
173	8	Аймгийн болон Сүхбаатар, Мандал сумын Засаг даргын Тамгын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн хэлтсийг камержуулах ажлыг эхлүүлэх	Төвлөрсөн газруудын хяналт сайжирна.	Аймаг сумдын ЗДТГ, Хэлтэс албад
174	9	Баянгол, Сант сумын Засаг даргын Тамгын газрын барилгын засвар, Сант сумын багийн байрны засварын ажлыг хийж гүйцэтгүүлэх	Төрийн үйлчилгээ үзүүлэх таатай нөхцөл бүрдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ
175	10	Алтанбулаг боомтын шалган нэвтрүүлэх төв байрны засвар, зорчигчдын биед үзлэг хийх рентген төхөөрөмжөөр хангах, Алтанбулаг, Сүхбаатар хилийн боомтод иргэдэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа явуулж холбогдох арга хэмжээ авах	Судалгаанд үндэслэн сайжруулах арга хэмжээ авагдсан байна.	Аймгийн ЗДТГ
176	11	Сүхбаатар, Мандал сумыг улсын зэрэглэлтэй хот болгох санал боловсруулж холбогдох газарт уламжилах	Судалгаанд тулгуурлан санал боловсруулж хүргүүлсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ
177	12	Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар, Жавхлант сумдын өдөрлөг, “Сэлэнгэ түмэн” арга хэмжээг зохион байгуулах	Аймаг, сумдын онцлог, давуу тал олон нийтэд сурталчлагдаж мэдээлэл нэмэгдсэн байна.	Аймгийн ЗДТГ
178	13	Сэлэнгэ аймгаас гадаад, дотоодын их дээд сургуульд суралцдаг оюутнуудын дунд “Сэлэнгэ нутгийн хөгжлийн гарц” илтгэлийн уралдааныг зохион байгуулах	Оюутнуудын нутаг орноо гэсэн хандалга сайжирч, хэрэгжүүлэх боломжтой, оновчтой санал, санаачилгууд гарсан байна.	Аймгийн ЗДТГ
179	14	Аймгийн “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг зохион байгуулах	Иргэдэд хэрэгцээтэй төрийн үйлчилгээг хүргэсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ
180	15	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагууд, төв орон нутгийн сонин, телевизүүдтэй гэрээ байгуулж хамтран ажиллах	Төрийн зарим чиг үүрэг биелэгдэж, мэдээ мэдээллийн хамрах хүрээ өргөжинө.	Аймгийн ЗДТГ

181	16	“Цахим засаглал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хөтөлбөр эхний зорилтууд хэрэгжсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ
182	17	Орон нутагт цэргийн дүйцүүлэх алба хааж байгаа залуучуудыг бүтээн байгуулалтын болон ойжуулах, цөлжилттэй тэмцэх, байгалийг нөхөн сэргээх зэрэг ажилд татан оролцуулах	Сум орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулсан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, ЭМГ
183	18	Хүүхэд залуучуудыг эх орноороо бахархах үзлийг төлөвшүүлэх, цэргийн насны залуучуудыг бие бялдрыг эрүүлжүүлэх, боловсролын түвшинг дээшлүүлэх	Боловсролтой эрүүл чийрэг, бие бялдартай залуучууд болж төлөвшинө.	Аймаг, сумдын ЗДТГ
184	19	Орон нутгийн гамшгийн эмзэг байдал, эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх, сумдад иж бүрэн команд штабын сургуулийг зохион байгуулах	Гамшгаас хамгаалах чадавх сайжирна.	Аймаг, сумдын ЗДТГ, Онцгой байдлын газар
185	20	Мандал суманд Аврах гал унтраах ангийн барилгын ажлыг эхлүүлж, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, хохирлыг арилгах, сэргээн босгох ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх	Ой хээрийн түймэр, үер ус, халдварт өвчин, зуд, барилга, байгууламжийн гал түймрийн тоо багассан байна.	Аймаг, сумдын ЗДТГ, Онцгой байдлын газар

2.Гадаад харилцааны уламжлалт найрсаг харилцааг бэхжүүлж, бүс нутгийн худалдаа, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, шинэ түншлэлийн нээлттэй бодлого барьж, хамтын ажиллагааны хүрээг өргөтгөнө.

186	1	Зүүн хойд Азийн бүс нутгийн худалдаа, эдийн засаг, шинжлэх ухааны хамтын ажиллагааны арга хэмжээнд идэвхтэй оролцох	Тодорхой салбар, чиглэлүүдээр олон улсын туршлагаас суралцах боломж бүрдэнэ.	Аймгийн ЗДТГ
187	2	Хөрш зэргэлдээ ОХУ-ын Буриад улстай харилцах бүхий л харилцааг өргөжүүлж, олон талт арга хэмжээг зохион байгуулах	Харилцаа, хамтын ажиллагаа өргөжинө.	Аймгийн ЗДТГ

3.Хууль эрх зүйн ажлын үр нөлөөг сайжруулах

188	1	Шүүх эрх мэдэл, хууль сахиулах, хүний эрхийг хамгаалах чиг үүргийн байгууллагуудын ажлын уялдаа, хамтын ажиллагааг хангах нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулах	Хууль сахиулах байгууллагуудын ажлын уялдаа холбоо сайжирч, хүний эрхийг хамгаалах ажилд ахиц гарсан байна.	Аймгийн ЗДТГ, Цагдаагийн газар
189	2	“Хэсгийн байцаагч-2013” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах.	Хэсгийн байцаагч нарын мэдлэг боловсрол болон цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа сайжирсан байна.	Аймгийн ЗДТГ, Цагдаагийн газар

190	3	Хөтөл дэх Цагдаагийн тасгийг хэлтэс болгох саналыг холбогдох газарт уламжлах.	Цагдаагийн ажил үйлчилгээ иргэдэд ойртсон байна.	Аймгийн ЗДТГ, Цагдаагийн газар
191	4	Сүхбаатар сумын тодорхой цэгүүдэд теле камерийн хяналтыг бий болгох	Гэмт хэргийн илрүүлэлт, хяналт сайжирч, гэмт хэргийн гаралт буурсан байна.	Аймгийн ЗДТГ, Цагдаагийн газар
192	5	Цагдаагийн газрын барилгын засвар, парк шинэчлэлт, техник хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх	Албан хаагчдын ажиллах нөхцөл сайжирна.	Аймгийн ЗДТГ, Цагдаагийн газар
193	6	“Архидалттай тэмцэх” хөтөлбөр боловсруулж хэрэгжилтийг эхлүүлэх	Хөтөлбөрийн эхний шатны зорилтууд хэрэгжиж эхэлнэ.	Аймгийн ЗДТГ
194	7	Сум бүрт архидалтын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах төрийн бус байгууллагын санал, санаачилгыг дэмжсэн бодлого зохицуулалтын арга хэмжээ авах	Архины хор уршгийн талаар иргэдэд ухамсар, ойлголт бий болж, согтуугаар үйлдэгдэх гэмт хэргийн тоо буурна.	Аймаг, сумдын ЗДТГ
195	8	Зүүнбүрэн суманд Цагдаагийн кабон барьж ашиглалтанд оруулах	Албан хаагчдын ажиллаж, амьдрах нөхцөл бүрдсэн байна.	Аймаг, сумдын ЗДТГ
196	9	Нутгийн захиргааны байгууллагуудад архив, албан хэрэг хөтлөлтийн “AMS” программ нэвтрүүлэх.	Архив, албан хэрэг хөтлөлтийн цахим бүртгэл сайжирна.	Аймаг, сумдын ЗДТГ

Сэлэнгэ аймгийн нийгэм, эдийн засгийг 2013 онд хөгжүүлэх
үндсэн чиглэлийн товчоо

Д/д	Салбарын нэрс	Тусгагдсан бодлогын зорилтын тоо	хувь
1.	Эдийн засгийн бодлого	80	41,1
	Газар тариалангийн салбар	16	
	Мал аж ахуйн салбар	10	
	Байгаль орчны бодлого	12	
	Үйлдвэрлэл, худалдаа, ахуй үйлчилгээ	16	
	Дэд бүтцийн салбар	22	
	Төсөв санхүү	5	
2.	Нийгмийн бодлого.	83	43,1
	Эрүүл мэндийн салбарын үйлчилгээ	17	
	Боловсролын үйлчилгээ.	23	
	Нийгмийн хамгаалалын үйлчилгээ	15	
	Соёл урлагийн үйлчилгээ	27	
3.	Засаглалын бодлого	31	15,8
	Нутгийн захиргаа	22	
	Хууль эрх зүйн талаар	9	
	Нийт бодлогын зорилтын тоо	196	100

-----oOo-----

Сэлэнгэ аймгийн нийгэм, эдийн засгийг 2013 онд хөгжүүлэх
үндсэн чиглэлийн товчоо.

Д/д	Салбарын нэрс	Тусгагдсан бодлогын зорилтын тоо	хувь
1.	Нийгмийн бодлого.	82	42,2
	Эрүүл мэндийн салбарын үйлчилгээ	18	
	Боловсролын үйлчилгээ.	24	
	Нийгмийн хамгаалалын үйлчилгээ	14	
	Соёл урлагийн үйлчилгээ	26	
2.	Эдийн засгийн бодлого	85	43,8
	Үйлдвэрлэлийн салбар	9	
	Газар тариалангийн салбар	16	
	Мал аж ахуйн салбар	16	
	Худалдаа, ахуй үйлчилгээ	6	
	Байгаль орчны бодлого	9	
	Дэд бүтцийн салбар	24	
	Төсөв санхүү	5	
3.	Засаглалын бодлого	27	14,0
	Нутгийн захиргаа	17	
	Хууль эрх зүйн талаар	6	
	Хяналт-шинжилгээ, үнэлгээ	4	
	Нийт бодлогын зорилтын тоо	194	100

ооо

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 21-ний өдөр

Дугаар 15

Сүхбаатар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2012-2016 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012-2016 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИТХ-ЫН 2012-2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Аймгийн ИТХ-аас Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, бусад хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд 2012-2016 онд баримтлах бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааныхаа үндсэн зорилт, чиглэлийг энэхүү стратеги төлөвлөгөөгөөр тодорхойлж байна.

Стратеги зорилт 1: Аймаг сумдын ИТХ-ын нөөц чадавхийг бэхжүүлэх, зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгон төгөлдөржүүлэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1.1. Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн сургалт зохион байгуулах, мэдээ мэдээллээр хангах, хурлын ажилтнуудыг мэргэшүүлэх, давтан сургах, дотоод, гадаадад туршлага судлуулах ажлыг зохион байгуулах.

1.2. Аймгийн хурлын төлөөлөгчид, сумын ИТХ-ыг зөөврийн компьютер, модем зэрэг техник хэрэгслээр хангаж мэдээ мэдээлэл, хуралдааны баримт бичгийг цахим хэрэгслээр дамжуулдаг болох.

1.3. Хурлын төлөөлөгчийн урамшуулал, тойрогтоо ажиллах зардал, хурлын бүтцийн байгууллагуудын үйл ажиллагааны зардлыг бодитой тооцон төсөвт тусгах.

1.4. Аймаг, сумдын ИТХ-ын ажлын албаны орон тоог, ажлын ачаалал, шаардлагыг харгалзан шинэчлэн тогтоох, сумын хурлыг машин унаатай болгох асуудлыг ээлж дараагаар шийдвэрлэх.

1.5. Хурал түүний бүтцийн байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдөх дүрэм журмуудыг хууль тогтоомж, шинэ бодлого зорилттой уялдуулан шинэчлэн батлах.

1.6. Хурлын болон Тэргүүлэгчдийн хуралдааныг нээлттэй, өргөтгөсөн байдлаар хөдөө орон нутагт хийх, хуралдаанаар хэлэлцэх шаардлагатай асуудлыг иргэдийн саналаар тодруулах, хурлын зарим шийдвэрийн төслийг иргэдээр хэлэлцүүлэн санал авах зэрэг арга хэлбэрийг нэвтрүүлэх.

1.7. Хурлын хэвлэл мэдээллийн алба бий болгож, Хурлын үйл ажиллагаа шийдвэрийг иргэдэд мэдээлж хүргэж байх.

1.8. Хурлын Тэргүүлэгчид сум, байгууллагын ажилтай танилцах, аймаг, сумын хурлын “Нээлттэй хаалганы өдөр”, “Хурлын төлөөлөгчдийн өдөр” зэрэг уламжлалт арга хэмжээг тогтмол хугацаанд нэгдсэн удирдамжаар зохион байгуулах.

1.9.Сум, багийн хурлын ажилд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, хяналт шинжилгээ хийх, үнэлгээ дүгнэлт өгөх, арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах, ажлын туршлага арга барилыг харилцан судлуулах ажил зохион байгуулах.

Стратеги зорилт 2: Хуралдаанаар хэлэлцэх асуудал, гаргах шийдвэрийн боловсруулалтын шинжлэх ухааны болон эдийн засаг, эрхзүйн үндэслэлийг сайжруулах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.1. Хуралдаанаар хэлэлцэх асуудал, гаргах шийдвэрийн төслийн эдийн засгийн тооцоо судалгааг тухайн асуудал хариуцсан мэргэжлийн хэлтэс газруудаар хийлгэх.

2.2. Хуралдаанаар хэлэлцэх асуудал, гаргах шийдвэрийн эдийн засаг, нийгмийн эерэг, сөрөг үр дагаврыг тооцож харгалзан шийдвэрлэх.

2.3. Орон нутаг, иргэдийн эрх ашгийг хөндсөн асуудал, шийдвэрийн төслийг иргэд, олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах ажлыг зохион байгуулах.

2.4. Хэлэлцэх асуудал, шийдвэрийн төслийг Хурлын Тэргүүлэгч, Төлөөлөгч, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулан хянан боловсруулж сайжруулах.

2.5. Тухайн хэлэлцэх асуудал, холбогдох хууль тогтоомжийг хурлын тэргүүлэгч, төлөөлөгчдөд судлуулах, тайлбарлан ойлгуулах, бодлогын хороогоор хэлэлцүүлэх зэргээр урьдчилан сайтар бэлтгэж, гаргах шийдвэрийг хууль, тогтоомжид нийцүүлэн гаргах.

Стратеги зорилт 3: Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол шийдвэрийн биелэлтийн явцыг хянан шалгах, үр дүнг тооцох ажлыг сайжруулах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1. Аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэрийн биелэлтийн тухай мэдээллийг Тэргүүлэгчдийн хуралдаанаар жил бүр хэлэлцэн дүгнэлт хийж байх.

3.2. Аймгийн ИТХ Тэргүүлэгчдээс батлан гаргасан доорх бодлогын шийдвэрүүдийн биелэлтийн явц, үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийх.

3.2.1. Сэлэнгэ аймгийн 2021 он хүртэлх хөгжлийн хөтөлбөр

3.2.2. Цөлжилттэй тэмцэх хөтөлбөр

3.2.3. Ус хөтөлбөр

3.2.4. Ойг хамгаалах ашиглах, нөхөн сэргээх хөтөлбөр

3.2.5. Сургалтын чанар хөтөлбөр

3.2.6. Хүнсний ногоо хөтөлбөр

3.2.7. Ахуйн үйлчилгээ хөтөлбөр

3.3. Аймгийн дотоодын бүсүүдийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдлыг шалган танилцах, бүсийн зөвлөлүүдийн илтгэл мэдээллийг сонсон хэлэлцэх зэргээр хөтөлбөрүүдийн биелэлтийг хангах.

3.4. Аймгийн ИТХ-аас тодорхой салбарын чиглэлээр гаргасан тогтоол шийдвэрийн биелэлтийн явц, үр дүнгийн талаар тухайн салбар хариуцсан хэлтэс, газар, байгууллагын дарга, захирлын илтгэл мэдээллийг Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгч байх.

3.5. Хурлын тогтоол шийдвэрийн биелэлтэд Хурлын Тэргүүлэгчид, бодлогын хороо, ажлын хэсгийн хяналт шалгалтыг тогтмолжуулах.

Стратеги зорилт 4: Хурлын болон Тэргүүлэгчдийн хуралдаанаар аймгийн эдийн засаг, нийгмийн амьдралын тулгамдсан асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж бодлого зорилтыг тодорхойлох.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.1. Аймгийн ИТХ-ын хуралдаанаар доорх асуудлуудыг хэлэлцэн бодлогын шийдвэр гаргах.

4.1.1. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого зорилтын тухай

4.1.2. Уул уурхайн талаар баримтлах бодлогын тухай

4.1.3. Малчид тариаланчдын зохицлыг хангах журмын төсөл

4.2. Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан доорх хөтөлбөрүүдийг хэлэлцэн батлах.

4.2.1. Ажил орлоготой-Сэлэнгэчүүд хөтөлбөр

4.2.2. 1000 айлын орон сууц хөтөлбөр

4.2.3. Амины орон сууц хөтөлбөр

4.2.4. Сумын төвийн шинэчлэл хөтөлбөр

4.2.5. Ээлжлэн тариалах систем хөтөлбөр

4.2.6. “Мах, сүүний үржлийн мал” хөтөлбөр

4.3. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлийг хэлэлцэн баталж тухайн жилд онцлох зорилтыг тодорхойлж биелэлтийн явцад хяналт тавьж гүйцэтгэлийг хэлэлцэн дүгнэж байх.

Стратеги зорилт 5: Хурлын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангаж шийдвэр гаргах, хөрөнгө зарахад иргэдээр хэлэлцүүлэн санал авч байх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.1. Шууд ардчилал-иргэний оролцооны талаар төрөөс баримталж буй бодлого, стратегийн баримт бичгүүдийг удирдлага болгон доорх дүрэм журмуудыг шат шатны хурлуудаар хэлэлцүүлэн батлуулж мөрдүүлэх.

5.1.1. – Баг хорооны иргэдийн Нийтийн Хурлын дүрэм

5.1.2. – Орон нутгийн хөгжлийн сангийн дүрэм

5.1.3. – Нийтийн зар мэдээний журам

5.1.4. – Иргэний танхимын үйл ажиллагааг идэвхжүүлэн тогтмолжуулах

5.1.5. –Иргэдийн санаачилгаар санал хураалт явуулах журам

5.2. Нийтийн эрх ашгийг хөндсөн аливаа асуудлыг иргэдээр хэлэлцүүлэх, иргэдийн саналыг авах замаар тэдний өргөн оролцоотойгоор шийдвэрлэж байх.

5.3. ИТХ-уудын шийдвэр гаргах, хяналт тавих үйл ажиллагаанд иргэд, олон нийт оролцох боломжийг нээсэн зохицуулалт бүхий журам тогтоох.

5.4. Хурлын хяналт шалгалтын үйл ажиллагаанд иргэний оролцоо, нийгмийн аудитыг нэвтрүүлэн хэрэгжүүлэх.

Стратеги зорилт 6: Аймаг, сумдын эдийн засаг, санхүүгийн чадавхийг сайжруулах, төсвийн орлогыг нэмэгдүүлэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

6.1. Дотоод нөөц боломж, орлогын эх үүсвэрээ бүрэн дайчилж үйлдвэрлэл үйлчилгээг бий болгох, өргөжүүлэх замаар төсвийн орлогыг нэмэгдүүлэх ажлыг хурлын бодлого шийдвэрээр дэмжих.

6.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг иргэд, олон нийтийн нээлттэй санал асуулгаар багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэн тодруулж ач холбогдлоор нь эрэмбэлэн сонгож шийдвэрлэх.

6.3. Аймаг, сумдын төсвийн боловсруулалт, хуваарилалтыг бодитой тооцож үндэслэлийг сайжруулах, төсвийн зарцуулалт, гүйцэтгэлд хурлаас тавих хяналтыг тогтмолжуулах.

6.4. Орон нутгийн өмчийн албыг бэхжүүлж, өмчийн бүртгэл тооцоо, хяналт, ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах.

Хариуцлагатай уул уурхайг дэмжин хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж хөрөнгө оруулагчид, уул уурхайн бүтээгдэхүүн экспортлогч аж ахуйн нэгжүүдийн ашиг орлогоо нэмэгдүүлж, үйлдвэрлэлээ өргөжүүлэх сонирхлыг аймаг орон нутгийн хөгжил, иргэдийн амьжиргаа нийгмийн асуудлыг шийдэх бодлоготой уялдуулах чиглэл баримтлах.

Стратеги зорилт 7: Боловсрол, соёл, спорт, эрүүл мэндийн байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэн хэвийн үйл ажиллагааг хангах, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

7.1. Сургууль, цэцэрлэгийн барилга шинээр барих, өргөтгөх, засварлах, сургалтын техник хэрэгсэл, багшийн хангамжийг сайжруулах замаар сургалтын таатай орчин бүхий хүүхдэд ээлтэй сургууль, цэцэрлэг бий болгоход хурлын бодлогыг чиглүүлэх.

7.2. “Зөв Монгол хүүхэд,” Багш” хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж хүүхэд бүрийг эрдэм соёлтой, эх оронч, амьдрах ухаантай, зөв хүмүүжилтэй иргэн болгон төлөвшүүлэхэд сургууль хүүхдийн байгууллагагэр бүл, эцэг эхийн хамтын ажиллагааг хөгжүүлэх.

7.3. Шаардлагатай газарт соёлын төв, клуб шинээр барих, байгаа барилгуудын ашиглалтыг сайжруулах хөгжим, техник хэрэгслээр хангах ажлыг хурлын шийдвэрээр дэмжих.

7.4. Сумын эмнэлгүүдийг тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах, өрхийн эмнэлгүүдийг байр савтай болгох ажлыгшийдвэрлэх бодлого баримтлах.

7.5. Спортын барилга байгууламжийг шаардлагатай газарт шинээр барих, ашиглалтыг сайжруулах, сум бүрт гүйлт, гар бөмбөг, сагсан болон хөл бөмбөг, цана, тэшүүрийн задгай талбай байгуулах замаар нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх талаар шийдвэр гарган хэрэгжүүлэх.

Стратеги зорилт 8: Үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, дэмжих бодлого зорилтыг тодорхойлж бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулан хүртээмж чанарыг сайжруулах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

8.1. Хүн амын ажил эрхлэлт, өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг хурлын бодлого шийдвэрээр дэмжих.

8.2. Аймгийн төвд худалдаа үйлчилгээний цогцолбор төв, сумдад ахуйн үйлчилгээний төвүүд байгуулах төсөв хөрөнгийг баталгаажуулан шийдвэр гаргах.

8.3. Барилгын материал үйлдвэрлэх санал санаачилга, төслийг бодлогоор дэмжиж, хөрөнгө, зээлийн туслалцаа үзүүлэхийг хурлын бодлого шийдвэрээр дэмжих.

8.4. Хүнсний ногооны тариалалт хураалтыг механикжуулах, зоорины аж ахуйг хөгжүүлэх, Улаанбаатар хотод Сэлэнгийн хүнсний ногооны байнгын ажиллагаатай зах ажиллуулах асуудлыг шийдвэрлэх.

8.5. Айл өрхийн ахуйн хэрэглээний мод, түлшний хэрэгцээг хангах, ойгоос түлээ бэлтгэх асуудлыг журамлаж шийдвэр гаргах.

Стратеги зорилт 9: Нийгмийн дэг журам хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн иргэдийн амгалан тайван аюулгүй ажиллаж амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэхэд нутгийн захиргаа, хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагааг идэвхжүүлэн, иргэд олон нийтийн оролцоог сайжруулах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

9.1. Хууль зүйн сургалт сурталчилгааны хөтөлбөр боловсруулж батлан хэрэгжүүлэх.

9.2. “Архигүй Сэлэнгэ” хөтөлбөр баталж архидалт, архидан согтуурахтай бүх нийтээр тэмцэх.

9.3. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг шинэчлэн баталж хэрэгжүүлэх.

9.4. Хот хоорондын төв замын хяналтын пост болон аймгийн төвийн зарим гудамж талбай, худалдаа үйлчилгээний томоохон төвүүдийг төсвийн болон аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгөөр камержуулах ажлыг эхлүүлэх.

9.5. Гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлан нийтэд мэдээлж түүнийг арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, аж ахуйн нэгж байгууллагын оролцоог хангах.

9.6. Сум багт хэв журмын олон нийтийн байцаагчийн тоог нэмэгдүүлж, олон нийтийн эргүүл жижүүрийг иргэдийн өөрсдийн үүсэл санаачилгаар, зохион байгуулах.

Стратеги зорилт 10: Байгаль орчныг хамгаалах ажлыг хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг хязгаарлан бууруулах, нөхөн сэргээх замаар хүн амын эрүүл мэнд, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд чиглүүлэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

10.1. Иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх.

10.2. Байгаль орчныг хамгаалах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт хурлын шийдвэрийн биелэлтэд хурлаас тавих хяналтыг сайжруулах.

10.3. Бүх сумдад мод үржүүлгийн газар байгуулан ойг нөхөн сэргээх, мод тарих ажлын хэмжээг нэмэгдүүлэх, аймаг, сумын төвийн ногоон байгууламжийг 2012 оныхоос 2 дахин нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлэх.

10.4. Төв суурин газрын ахуйн хог хаягдлыг цэвэрлэх цуглуулах, тээвэрлэх, ангилах, ялгах, дахин боловсруулах, булшлах ажлыг хариуцан гүйцэтгэх, эзэнтэй болгож хөрөнгө, техникийн дэмжлэг үзүүлэх.

10.5. Байгалийн төрөл зүйл амьтан, ой ургамал, гол горхи, уст цэг, үйл ажиллагаанд өртөж эвдэрч элэгдсэн талбай, байгаль орчныг бохирдуулагч эх үүсвэр зэргийн тооллого судалгааг жил бүр ээлж дараатай хийж дүгнэлт гарган, авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх.

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 21-ний өдөр

Дугаар 18

Сүхбаатар

Сүхбаатар, Зүүнхараа хотуудыг улсын
зэрэглэлтэй хот болгох саналын тухай

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 7.123.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын болон Сэлэнгэ аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг нь харгалзан 15000-аас дээш хүн амтай Сүхбаатар, Зүүнхараа хотыг улсын зэрэглэлтэй хот болгох саналыг Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн газарт уламжилсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2013 оны 10 сарын 18-ны өдөр

Дугаар 25

Сүхбаатар

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “ж” заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.“Малчид, тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг хангах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү журмыг 2014 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн мөрдсүгэй.

3.“Малчид, тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг хангах журам”-ыг мөрдүүлэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг аймаг, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Энэхүү журам гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2007 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 40 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

МАЛЧИД, ТАРИАЛАНЧДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦЛЫГ ХАНГАХ ЖУРАМ

Нэг. Журмын зорилго

Энэхүү журам нь таримал ургамал, тариалангийн талбайг мал, тэжээвэр амьтдаас хамгаалахын тулд малчид, тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг ханган, тэдгээрийн үүрэг хариуцлагыг тодорхой болгож таримал ургамал тариалагч, малчин, мал бүхий иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Ерөнхий зүйл

2.1. Таримал ургамлыг мал, амьтдаас хамгаалах журмыг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын холбогдох хуулийн заалтыг баримтлан гүйцэтгэнэ.

2.2. Үр тариа, тэжээлийн ургамал, таримал хадлан, жимс, жимсгэнэ, төмс, хүнсний ногоо, олон наст ургамал болон ойг нөхөн сэргээх зориулалтаар тарьсан ба хашиж хамгаалсан мод, бут, сөөг, хот тосгоны ногоон байгууламжийн ургамлуудыг таримал ургамалд хамааруулна.

2.3. Энэ журамд Газрын тухай хууль, Тариалангийн тухай хууль, Таримал ургамлын тухай хууль, Таримал ургамлын үр сортын тухай хуулинд заасны дагуу тарьж эхэлснээс ургац хураан авч дуусах хүртэл хугацаа хамаарна.

2.4. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн таримал ургамал тариалсан талбайгаа хашаажуулах, тэмдэгжүүлэх, харуул хамгаалалттай байлгах үүрэг хүлээнэ.

2.5. Малчин, мал бүхий иргэд, байгууллага, аж ахуйн нэгж нь өөрсдийн мал, тэжээвэр амьтдыг байнгын хариулга, маллагаатай, хараа хяналттай байлгах үүрэг хүлээнэ.

2.6. Зөрчил гаргасан тохиолдолд Иргэний хууль, Газрын тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль болон энэ журамд заасны дагуу хохирлыг төлүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

Гурав. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болон сум, багийн Засаг даргын үүрэг

3.1. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үүрэг

3.1.1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бүрэн эрхийнхээ хүрээнд малчин, мал бүхий иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын малд төлбөр, хураамж ногдуулах хэмжээг тогтоох.

3.1.2. Малчид, тариаланчдын үйл ажиллагааг зохицуулсан журам батлах, өөрчлөх.

3.1.3. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь сумын Засаг даргын дэргэдэх үнэ тогтоох комиссын санал, тухайн зах зээлийн үнэ ханшийг үндэслэн малын жишиг үнэлгээг тогтоох.

3.1.4. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тариаланчид, ногоочид, малчдын саналыг өргөн тусгаж өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны газрыг багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

3.2 Сумын Засаг даргын үүрэг

3.2.1.Таримал ургамал тариалсан газрын нэр, байршил, тариалалт эхлэх, ургац хурааж дуусах хугацааны талаар шийдвэр гаргаж нийтэд зарлан мэдээлнэ.

3.2.2.Малчид, мал бүхий иргэдийн хаваржих, зусах, намаржих газар болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийн газрыг малын тоо, газар тариалангийн талбайн байршлыг харгалзан тогтоож, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.2.3.Холбогдох мэргэжилтнүүд, малчид, тариаланчдын төлөөлөл оролцсон хохирол тогтоох сумын комисс байгуулна. /Сумын Засаг даргын орлогч, багийн Засаг дарга, Байгаль орчны байцаагч, Газрын даамал, Хөдөө аж ахуйн тасгийн дарга болон Газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн, иргэний төлөөлөл гэх мэт/

3.2.4.Таримал ургамлын талбайд мал тэжээвэр амьтад орж хохирол учирсан тохиолдолд хохирлыг сумын комисс тухайн таримал тариалсан эзэн, тарианд орсон мал, тэжээвэр амьтны эздийг байлцуулан тогтоож баталгаажуулна.

3.2.5.Тариалангийн талбайд мал орж хохирол учруулсан мэдээлэл ирсэн тохиолдолд сумын комисс 2 хоногт багтаан газар дээр нь очиж, хоёр талын төлөөлөгч, хөндлөнгийн гэрчийг байлцуулан хохирлын акт тогтооно. Сумын комиссын зардлыг таримал ургамал тариалагч хариуцна.

3.2.6.Хохирол учруулсан нь тогтоогдвол холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий улсын байцаагч захиргааны хариуцлага тооцно.

3.2.7.Сумын комиссын тогтоосон хохирлын актыг талууд эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргана.

3.2.8. Малын өвөлжөө, хаваржаа, намаржааны болон сумын төв, суурин газрын ойролцоо таримал ургамал тариалсан талбайг хашаажуулах арга хэмжээг орон нутгийн хөгжлийн сан, төсөл, хөтөлбөр, аж ахуйн нэгж, малчид байгууллагын хөрөнгөөр хамтран шийдвэрлэнэ.

3.2.9.Малчид, тариаланчдын зөвлөлгөөн, уулзалтыг жил бүр зохион байгуулж малчид, тариаланчдыг мэдээ, мэдээллээр ханган ажиллана.

3.2.10.Таримал ургамлын талбайгаас 500 метрийн дотор өвөлжөө, хаваржааны газар шинээр олгохгүй байна.

3.2.11.Хамтын хөдөлмөрөөрөө хоршин, бүлэг хоршооны зохион байгуулалтанд орж, мал аж ахуйгаа эрчимжүүлсэн малчдад нутаг бэлчээрээ зүй зохистой ашиглахад дэмжлэг үзүүлж тэжээлийн ургамал тариалах талбай олгож болно.

3.3 Багийн Засаг даргын үүрэг

3.3.1.Энэхүү журмыг нийт тариаланч, малчин, мал бүхий иргэд аж ахуйн нэгж, байгууллагуудад таниулах сурталчлах ажлыг зохион байгуулна.

3.3.2.Сумын төв, суурин газрын малыг тариалалт эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд байнгын хариулга, маллагаатай байлгах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авна.

3.3.3.Багийн Засаг дарга хаваржаа, намаржаа, өвөлжөө, зуслан болон сумын төв, суурин газрын ойролцоо таримал ургамал тариалсан иргэн, аж ахуйн нэгж, тэнд нутаглаж буй малчид, мал бүхий иргэдтэй гурвалсан гэрээ байгуулж харилцан үүрэг хүлээж, журмын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллана.

Дөрөв. Таримал ургамал тариалагчийн үүрэг

4.1.Тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь өмчөө хамгаалах зорилгоор тариалсан талбайнхаа ойролцоо нутагладаг мал бүхий иргэн, айл өрх, аж ахуйн нэгжтэй тарианд мал оруулахгүй байх, оруулсан нөхцөлд хохирлыг хэрхэн тооцох талаар тохиролцон гэрээ байгуулна.

4.2.Таримал ургамал бүхий талбайд орж хохирол учруулсан мал, тэжээвэр амьтны эзэн нь тогтоогдоогүй нөхцөлд мал амьтныг зориулалтын хашаанд хашиж энэ тухай сумын комисст мэдэгдэн эзэн нь тогтоогдсон үед хашиж малласан хугацаанд гарсан зардал учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ.

4.3.Таримал ургамал бүхий талбайд мал орж хохирол учруулсан бол орсон малын тоо, зүс, ээмэг, тамга, малын мөр, таримал ургамлыг сүйтгэсэн байдлыг фото зураг, видео камераар баталгаажуулан баримтжуулна.

4.4.Тариалан эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага таримал ургамлаа мал, тэжээвэр амьтдаас хамгаалж хашаа барих, харуул сахиул гаргах замаар байнгын хамгаалалтанд байлгана.

4.5 Тариалсан талбайг тэмдэгжүүлж, 500 хүртэл га тутамд нэг манаач, сахиул байхаар тооцон унаа, холбооны хэрэгслээр хангаж ажиллана.

4.6. Сумын төв, суурин газрын ойролцоо таримал ургамал тариалсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь талбайгаа өөрийн хүч хөрөнгөөр хашаажуулна.

4.7.Таримал ургамал тариалагч, иргэн аж ахуйн нэгж, байгууллага тариалсан талбайд орсон мал, тэжээвэр амьтдыг тусгайлан хашиж, сумын комисс болон эзэнд нь мэдэгдэж тоо толгой, аюулгүй байдлыг бүрэн хариуцна.

4.8.Сумын комиссыг өөрсдийн унаа, зардлаар авч хохирлоо тогтоолгоно.

4.9.Таримал ургамалд мал, тэжээвэр амьтад хохирол учруулсан нөхцөлд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс тогтоосон жишиг үнэлгээнд үндэслэн учирсан хохиролд дүйцэхүйц мал, тэжээвэр амьтдыг барьцаалан авч төлбөрөө барагдуулсан нөхцөлд буцаан олгоно.

4.10.Малчдын өвөлжөө, намаржааны ойролцоо байрлах үр тарианы бригад болон төмс хүнсний ногоо тариалж буй аж ахуйн нэгж, иргэд малчдын өвөлжөөг харж хамгаалах талаар гурвалсан гэрээнд тусган хэрэгжүүлж болно.

4.11.Таримал ургамлаа эрсдлийн даатгалд хамруулна.

4.12.Гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу буюу зайлшгүй тохиолдолд харилцан тохиролцсоны дагуу зарим талбайгаас сүрэл, технологийн хаягдлаа талбайн захад гаргаж өгч болно.

4.13.Сумын төвийн ойролцоо таримал ургамал тариалсан иргэд, аж ахуйн нэгж нь ургац хураалтын үед мал бүхий иргэдийн малыг нэгдсэн хариулгатай болгох ажилд тусалж малчны цалин урамшуулалд дэмжлэг үзүүлж болно.

4.1.14.Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих зорилгоор тариалангийн талбайн орчмын малчдын хүсэлт захиалгаар тариалангийн сэлгээндээ тэжээлийн ургамал тариална.

Тав. Малчин мал бүхий иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

5.1.Малчин, мал бүхий иргэд сум багаас гаргасан хуваарьт газарт хаваржиж, зусаж, намаржина.

5.2.Малчин, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь таримал ургамал тариалсан, уриншилсан талбайд мал бэлчээхгүй, оруулахгүй байх үүрэг хүлээнэ.

5.3.Тариалангийн талбайн ойролцоо нутаглаж буй малчин, мал бүхий иргэд малаа ургац хураалт дуустал байнгын хариулгатай байлгах буюу алсын, отрын бэлчээрт гаргах арга хэмжээ авна.

5.4.Сум орон нутгаас зааж өгсөн бэлчээрт гараагүйгээр таримал ургамалд хохирол учруулсан нөхцөлд хохирлыг тухайн малчин, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 100 хувь хариуцна.

5.5.Таримал ургамал бүхий талбайн ойролцоо байгаа малчин, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бод малаа хаших хашаатай байж, шөнийн цагаар малаа хашиж байна.

5.6.Таримал ургамал хамгаалах журам зөрчигдөж байгааг мэдсэн иргэн сумын комисст нэн даруй мэдэгдэнэ.

5.7.Таримал ургамал тариалсан талбайд мал, тэжээвэр амьтан орсноос учирсан бодит хохирлыг сумын комиссын тогтоосон актыг үндэслэн энэ журамд заасны дагуу нөхөн төлнө.

5.8. Таримал ургамалд учруулсан хохирлоо 5 хоногийн дотор ямар нэгэн хэлбэрээр барагдуулна.

5.9. Хохирлын хэмжээ, хохирол төлөхтэй холбогдсон гомдлоо шүүхэд гаргаж болно.

5.10. Сумын заасан нутагт хаваржиж, зусаж, намаржиж байгаа малчин, мал бүхий иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн мал нь таримал ургамал тариалсан талбайд өдрийн цагаар орвол хохирлыг малын эзэн, тариан талбайн эзэн 50/50 хувь, шөнийн цагаар орвол малын эзэн хохирлыг бүрэн хариуцна. Шөнийн цаг гэдгийг оройн 22.00 цагаас өглөөний 06.00 цаг гэж ойлгоно.

5.11. Малчин, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эрчимжсэн хагас эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх бодлого чиглэлийг түлхүү барьж өндөр ашиг шимтэй цөөн тооны малаар сүргийн бүтцээ бүрдүүлэхийг эрхэмлэнэ.

5.12. Сумын төвийн болон суурин газрын мал бүхий иргэд хамтран багийн Засаг даргын зохион байгуулснаар малаа байнгын хариулгатай болгож шөнийн цагаар хашиж байна.

Зургаа.Журам зөрчигчид хүлээлгэх хариуцлага

6.1. Газрын тухай хуулийн 52.2, 53.3, 54.3-т заасан заалтыг зөрчсөн бол энэ хуулийн 63.1.8-д заасны дагуу Байгаль орчны хяналтын улсын байцаагч нь учруулсан хохирлыг үндэслэн иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс дөрөв дахин, байгууллага, аж ахуйн нэгжийг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож хохирлыг нөхөн төлүүлнэ.

6.2. Таримал ургамал тариалсан талбайд мал амьтан оруулж устгаж гэмтээсэн болон Захиргааны хариуцлагын тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан зөрчил гаргасан бол сум, багийн Засаг дарга энэ хуулийн 10.2, 12.5-ыг үндэслэн арга хэмжээ авна.

6.3. Өдрийн цагаар таримал ургамлын талбайд орсон малын учруулсан хохирлын 50 хувийг мал, тэжээвэр амьтны эзэн, 50 хувийг таримал ургамал эрхлэгч хариуцах ба шөнийн цагаар учруулсан хохирлыг 100 хувь малчин, мал бүхий иргэд, байгууллагаар төлүүлнэ.

6.4. Таримал ургамлын хөгжлийн үе шат /соёололт, бутлалт, гол хатгалт, түрүүлэлт, цэцэглэлт, үрийн бүрдэлт, цутгалт, сүүн болц, аарцан болц/ бүрийн хохирлыг үйлдвэр, санхүүгийн төлөвлөгөө буюу технологийн картанд тусгагдсан ургацаар тооцно.

6.5. Таримал ургамал бүрэн боловсорч хураалтын үе явагдаж байгаа үед учруулсан хохирлыг биологийн ургацаар /ургац тогтоолтоор нэг га-гаас авахаар тогтоосон ургацаар/ тооцож барагдуулна.

6.6. Төв суурин газрын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага мал тэжээвэр амьтдаа нэгдсэн хариулгад хамруулаагүйгээс таримал ургамалд хохирол учруулсан бол хохирлыг тухайн мал, амьтны эзэн бүрэн хариуцаж төлнө.

6.7. Таримал ургамлыг хашиж хамгаалсан талбайн хашаа, байгууламжийн эвдэж устгасан этгээдээр түүнийг сэргээн босгоход гарах зардлыг 2 дахин нугалж төлүүлнэ.

6.8. Хохирол учруулсан этгээд хохирлыг санаатайгаар барагдуулаагүй бол хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг сум, багийн Засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, хохирогч нар шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлнэ.

_____оОо_____

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 10 сарын 18-ны өдөр

Дугаар 26

Сүхбаатар

“Сэлэнгэ аймгийн хөгжлийн сангийн хөрөнгийг
бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ыг
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “в”, Төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 дахь хэсгийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. “Сэлэнгэ аймгийн хөгжлийн сан”-г байгуулж “Сэлэнгэ аймгийн хөгжлийн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Сэлэнгэ аймгийн хөгжлийг дэмжих сан”, 2010 оны 95 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан”-гийн журмыг тус тус хүчингүй болгож, тус хоёр санг татан буулгасугай.

3. “Сэлэнгэ аймгийн хөгжлийг дэмжих сан”, “Жижиг, дунд үйлдвэрийн сан”-гийн дансанд төвлөрсөн хөрөнгөөр аймгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж, энэ журамд заасны дагуу захиран зарцуулж явц, үр дүнг жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Бүрэнбат/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Аймгийн хөгжлийн бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг дэмжих санг /цаашид сан гэх/ бүрдүүлэх, сангийн хөрөнгийг удирдах, зарцуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Сан нь орон нутгийн тусгай сангийн данстай байх бөгөөд сангийн орлого, зарлагыг энэхүү дансаар дамжуулан гүйцэтгэнэ.

1.3 Сангийн орлого, зарлага нь аймгийн төсвийн сар бүрийн мэдээ, улирал, жилийн тайлан тэнцэлд тусгагдах бөгөөд тусгай сангийн орлого, зарлагын тайлан нь аймгийн нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.

Хоёр. Сангийн хөрөнгийн эх үүсвэр

2.1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 95 дугаар тогтоолоор баталсан “Жижиг, дунд үйлдвэрийн сан” нь татан буугдсантай холбогдуулж уг санд төвлөрч байсан хөрөнгөөс энэхүү сангийн хөрөнгийн эх үүсвэр бүрдэх бөгөөд сангийн хөрөнгийг дараахь эх үүсвэрээс нэмэгдүүлэн бүрдүүлж болно.

2.1.1. Гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн буцалтгүй тусламж;

2.1.2 Гадаадын тусламжийн мөнгөн хөрөнгө, тоног төхөөрөмж, бараа материал, бусад эд зүйлийг борлуулсанаас олох орлого

2.1.3. Сангаас олгосон зээлийн буцаан төлөлтийн орлого

2.1.4 Сангаас олгосон зээлийн хүүгийн орлого, алданги

2.1.5 Хуульд заасан бусад эх үүсвэр

2.2 Сангаас олгох хөнгөлөлттэй зээлийн хүү нь жилийн 3 хувь байна.

Гурав. Сангийн хөрөнгийн зориулалт, зарцуулалт

3.1 Сангийн хөрөнгийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгоно.

3.2 Сангийн нийт хөрөнгийн 80-аас доошгүй хувийн санхүүжилтийг энэ журмын 3.2.1-т заасан эргэн төлөгдөх зээлийн дэмжлэгт зарцуулна.

3.2.1 Аймгийн эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх иргэд, аж ахуйн нэгж болон олон нийтэд үр өгөөж өгөх, иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх бүтээн байгуулалт бүхий төсөлд зээлийн дэмжлэг үзүүлэх

3.3 Аймгийн хөгжилд түлхэц болох үндсэн зорилго чиглэлийн хүрээнд сангийн хөрөнгийн 20 хүртэл хувийг дараах зүйлд зарцуулж болно. Үүнд:

3.3.1 Аймгийн хэмжээнд тэмдэглэх аймаг, сумын түүхт ойн арга хэмжээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх

3.3.2 Аймгийн түүх, соёлын дурсгалт газрыг шинээр бий болгох, сан хөмрөгийг нэмэгдүүлэх, засаж сайжруулахад дэмжлэг үзүүлэх

3.3.3 Хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрийн хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын урилгаар зочлон ирсэн төлөөлөгчдийн болон дээрх гэрээ хэлцлийн хүрээнд гадаад улсад аймгийг төлөөлөн оролцох төлөөлөгчийн зардалд дэмжлэг үзүүлэх

3.3.4 Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх

3.3.5 Аймаг орон нутагт шаардлагатай мэргэжлийн боловсон хүчний нөөц бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

3.3.6 Дэвшилтэт технологи, шинэ санаачилга гаргасан иргэнийг урамшуулах

3.3.7 Иргэд, хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд зориулсан улс, бүсийн, олон улсын чанартай урлаг, соёл, спортын арга хэмжээ, тэмцээн уралдаан зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх

3.3.8 Нийгэм соёл, урлаг, спорт, эрүүл мэнд, хөдөө, аж ахуй, шинжлэх ухааны салбарт онцгой амжилт гаргасан аймгийн иргэдэд хүндэтгэл, тусламж үзүүлэх

3.3.9 Энэ журмын 3.2.1-д заасан чиглэлийг хөгжүүлэхээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх

3.3.10 Сангаас олгосон зээлийн хүүгийн орлогын 30 хүртэлх хувийг энэхүү журмын 4.5.2-д заасан сангийн хөрөнгийн зориулалт, зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих орон тооны бус ажлын хэсгийн үйл ажиллагааны зардал болон хөгжлийн сангийн орон тооны ажилтны цалин, үйл ажиллагааны зардалд зарцуулж үлдэх хувийг сангаас олгох зээлийн эргэлтийн хөрөнгө болгож ашиглах

3.4 Сангийн хөрөнгийг дор дурьдсан зориулалтаар зарцуулахыг хориглоно. Үүнд:

3.4.1 Төсвийн алдагдлыг нөхөх

3.4.2 Төсөвт байгууллагын урсгал зардлыг санхүүжүүлэх

3.4.3 Төрийн байгууллагын засвар үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх

3.4.4 Аймгийн Засаг даргын нөөц сангийн хөрөнгийг зарцуулах журмын хүрээний санхүүжилт хийх

3.4.5 Журамд зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг тус тус хориглоно.

Дөрөв. Сангийн удирдлага, зохион байгуулалт

4.1. Сангийн удирдлага нь аймгийн Засаг даргын зөвлөл байна.

4.2 Зөвлөл нь сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнахтай холбогдуулан дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.2.1 Тухайн санхүүгийн жилийн санхүүжилтийн хэмжээг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж батлуулах.

4.2.2 Зээлийн хүүгийн орлогоос энэхүү журмын 3.3.10-д заасан зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгийн төсвийг боловсруулж аймгийн Засаг даргаар шийдвэр гаргуулах.

4.2.3 Сангийн хөрөнгийн зориулалт зарцуулалтанд энэ журмын 3.2, 3.3-д заасан эрхийг хэрэгжүүлэх

4.2.4 Сангийн үйл ажиллагаанд хэрэгжүүлсэн нягтлан бодох бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу хөтлүүлж, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг гаргаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах

4.2.5. Энэ журмын 4.2.1-д заасан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан санхүүжилтийн хэмжээнээс хамааруулж тухайн санхүүгийн жилд нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг тогтоох

4.2.6 Төсөл сонгон шалгаруулахад зах зээлийн болон эрсдлийн судалгаа хийж холбогдох мэргэжлийн байгууллагаас санал, дүгнэлт, тодорхойлолт авч харгалзан үзэх боломжийг бүрдүүлэх

4.2.7 Төсөл шалгарсан иргэн, аж ахуйн нэгжтэй зээлийн гэрээ байгуулж, гэрээний биелэлтийг хангуулах, хэрэгжилтийн явц, үр дүнд байнгын хяналт тавьж ажиллах

4.2.8 Эргэн төлөгдөх зээл, зээлийн алданги, хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх;

4.2.9 Зөвлөл нь шийдвэр гаргахдаа үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болгох чиглэлээр гарсан бодлого, шийдвэрийг баримтлах

4.3 “Аймгийн хөгжлийн сан” нь орон тооны ажилтантай байх ба уг ажилтан ирүүлсэн төслийг нэгдсэн бүртгэлд бүртгэж, энэ журмын 6.1, 6.2-д заасан төсөл хүлээн авах шаардлага хангасан төслийг зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлж, зээл олголт, эргэн төлөлтийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөлд танилцуулна.

4.4 Зөвлөлийн төсөл сонгон шалгаруулж дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг ажиглагчаар оролцуулна.

4.5 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сангийн үйл ажиллагаанд дараах эрх, үүрэгтэй оролцоно. Үүнд:

4.5.1 Төсөл сонгон шалгаруулах явцад ажиглалт хийх иргэн, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулах

4.5.2 Сангийн хөрөнгийн зориулалт, зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих орон тооны бус ажлын хэсгийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч болон сан хариуцсан ажилтныг оролцуулан 3-5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр тухай бүр томилох

4.5.3 Сангийн үйл ажиллагааны төсвийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх

4.5.4 Сангийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн талаарх аймгийн Засаг даргын мэдээллийг сонсох.

4.5.5 Сангийн зарцуулалтын тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудит хийлгэж дүгнэлт гаргуулах.

4.5.6 Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шалгалтын дүн, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн шийдвэрлэх.

Тав. Төсөл хүлээн авах

5.1 Зөвлөл нь санхүүжилт хүссэн төсөл хүлээн авах хугацааг тогтоох бөгөөд энэхүү журмын 3.2.1, 6.1.1-д заасан чиглэлд нийцсэн, төсөлд тавигдах шаардлага хангасан төслийг сан хариуцсан ажилтан хүлээн авна. Төслийн онцлог болон орон нутгийн онцлогийг харгалзан нэмэлт шаардлага тавьж болно.

5.1.1 Сан хариуцсан ажилтан төслийг хүлээн авч судлаж нягтлаад шаардлага хангаагүй гэж үзсэн төслийн талаарх холбогдох танилцуулгыг аймгийн Засаг даргад танилцуулсанаас хойш ажлын 7 хоногийн дотор бичгээр болон зээл хүсэгчид мэдэгдэнэ.

5.1.2 Шаардлага хангасан төслүүдэд зээлийн шинжилгээ судалгаа хийж, танилцуулга мэдээллийг бэлтгэн зөвлөл хуралдахаас 3-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд хүргүүлж танилцуулна.

Зургаа. Төсөл сонгон шалгаруулах, шийдвэр гаргах

6.1 Зөвлөл нь сангаас зээл хүссэн иргэн, аж ахуйн нэгжийн боловсруулсан төслийг сонгон шалгаруулахдаа дараах шалгуурыг харгалзан үзэж төсөлд санхүүжилт олгох, эс олгох талаар шийдвэрийг олонхийн саналаар гаргана.

Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл нь дараах шалгуур үзүүлэлтийг хангасан байна. Үүнд

6.1.1 Аймгийн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын хүрээнд орон нутгийн давуу талд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох, орон нутгийн иргэдэд тулгамдаж байгаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн байх;

6.1.2. Хүрэх үр дүн, зорилт нь тодорхой байх

6.1.3 Төслийн үр дүнд бий болох бүтээгдэхүүн, үйлчилгээ нь шинэлэг, цаашид хөгжих бүрэн боломжтой байх

6.1.4. Төслийн үр ашиг, гэрээний хугацаанд зээлээ эргэн төлөх боломжтой байх. /Тухайн төслийн төлөвлөгөө нь санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрт багтаж бодитой биелэгдэхээр байх/

6.1.5. Төслийг хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлийг бодитой тодорхойлсон, эрсдэлийг даван туулах талаар тусгасан байх;

6.1.6.Ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн байх

6.1.7 Сумын Засаг даргаас дэмжсэн санал авсан байх

6.2. Сангийн хөрөнгөөс зээл авч төсөл хэрэгжүүлэх этгээд нь дараахь шаардлагыг хангасан байна:

6.2.1 Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан шалгуурыг хангасан Сэлэнгэ аймгийн харьяат, татварын хэлтэст бүртгэлтэй, аймагт үйл ажиллагаа гардан эрхлэж байгаа иргэн, аж ахуйн нэгж байх;

6.2.2 Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан, сум хөгжүүлэх сан, банкны болон татварын өргүй байх.

6.2.3 Хуулиар хориглоогүй барьцаа батлан даалттай байх ба зээлийн барьцаа нь үл хөдлөх эд хөрөнгө, бусдын өмчлөлд шилжүүлж болох эд хөрөнгийн эрх байхаас гадна тухайн төслийг хэрэгжүүлэхэд ашиглагдах тоног төхөөрөмж байж болно. /Төсөлд ашиглагдах тоног төхөөрөмж нь нийт барьцааны 30 хүртэл хувь байна/

6.2.4 Үйлдвэрлэл эрхлэхэд шаардагдах мэргэжлийн боловсон хүчин, /эсвэл бэлдэж байх/ ажлын байрны нөхцөлийг бүрдүүлсэн байх

6.2.5 Төслийн нийт санхүүжилтийн 30-аас доошгүй хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх чадвартай байх;

6.2.6 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нөхөрлөл, хоршоо, бүлгийн зохион байгуулалтанд орсон байх

6.3. Энэхүү журмын 6.2-т заасан шаардлага хангасан этгээд сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслөө сангийн төсөл хариуцсан ажилтанд ирүүлнэ. Төсөл сонгон шалгаруулах хугацааг "Засаг даргын зөвлөл"-өөс тогтооно.

6.4. Зөвлөл нь иргэн, аж ахуй нэгжийн ирүүлсэн төслийг энэхүү журмын 6.1, 6.2-т заасан шалгуур, шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянан үзэж, хурлаараа хэлэлцэн шийдвэрлэнэ. Зөвлөлийн шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор аймгийн Засаг дарга зээл олгох захирамж гаргана.

6.5. Шалгарсан төсөлд зээл олгох тухай зөвлөлийн хурлын тэмдэглэл, захирамжийг үндэслэн тухайн төслийг хэрэгжүүлэгч этгээдтэй байгуулах зээлийн гэрээг "Аймгийн хөгжлийн сангаас олгох зээлийн гэрээний үлгэрчилсэн загвар"-ын дагуу аймгийн Засаг дарга байгуулна

6.6 Сангийн зээлийн гэрээний хугацаа 3 хүртэл жил байна.

6.7 Зээлийн гэрээг байгуулснаас хойш 7 хоногийн дотор зээлийн хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгжийн дансанд шилжүүлнэ.

Долоо. Сангийн үйл ажиллагааг тайлагнах, хяналт тавих

7.1. Аймгийн Засаг дарга сангийн орлого, зарлагын дүн болон зарцуулалтын тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

7.2 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил бүр сангийн гүйцэтгэл, үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийлгэж, аудитын дүгнэлтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн Хурлаар хэлэлцүүлнэ.

7.3 Сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад иргэд хяналт тавих эрхтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт шалгалт хийлгэж, сангийн үйл ажиллагааг нийтэд мэдээлнэ.

7.4 Энэхүү журмын 4.5.2-д заасан ажлын хэсэг нь сангийн үйл ажиллагаа, зээлийн гэрээний хэрэгжилтэд тухайн санхүүгийн жилд 2-оос доошгүй удаа шалгалт хийж, дүнг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, иргэдэд ил тод, нээлттэй мэдээлж байна.

7.5 Сангийн үйл ажиллагаанд зөрчил гарвал түүнийг арилгах үүргийг аймгийн Засаг дарга хариуцна

Найм. Хариуцлага

8.1 Зөвлөлийн гишүүд нь өөрийн гэр бүл, хамаатан садан, хөрөнгө, хувь хамтран эзэмшигч нь хөнгөлөлттэй зээлд хамрагдах төсөл өргөдлийг ирүүлсэн тохиолдолд хурлын тухайн төсөл хэлэлцэх үед оролцохоос татгалзах үүрэгтэй.

8.2 Төсөл, хөтөлбөр боловсруулах, сонгон шалгаруулах үйл ажиллагаанд оролцогч гишүүн нь зээлдэгчтэй ашиг сонирхолын харилцаа тогтоох, төслийн талаар мэдээлэл нууцыг бусдад дамжуулах, бусдад давуу байдал бий болгох, үнэн зөв үнэлгээ хийхгүйгээс зээлийг эрсдэлд оруулах зэргээс татгалзаж хууль, журам зөрчихгүй байх үүрэгтэй.

8.3 Сангийн хөрөнгийг зарцуулах, зээл олгох, зээлийн хөрөнгийг ашиглах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааны талаар энэхүү журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

8.4 Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус ажлын хэсэг нь шалгалтын санал, дүгнэлтээ зөвлөлд хүргүүлж, зөрчлийг арилгуулж ажиллана.

8.5 Энэхүү журмын 6.2-т заасан зээлдэгч этгээд авсан зээлээ үр ашиггүй зарцуулсан, эсхүл зээлийн гэрээнд заасан зээл, түүний хүүг гэрээний хугацаа хэтрүүлж төлсөн болон зээлээ бүрэн төлсөн боловч зориулалтын дагуу ашиглаагүй зэрэг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайн иргэн, аж ахуйн нэгжид сангаас дахин зээл олгохгүй бөгөөд зээлийн гэрээнд заасны дагуу алданги тооцох, барьцаа хөрөнгийг тогтоосон журмын дагуу борлуулж өөрийн шаардлага хангах арга хэмжээ авна.

8.6 Сангаас хөнгөлттэй зээл авсан этгээд нь зээлийн гэрээнд заасан хугацаанд зээлийг төлөөгүй тохиолдолд төлөгдөөгүй үнийн дүнгээс хоног тутам 0,2 хувиар алданги тооцно.

8.7 Зээлийн гэрээ нь энэхүү журмын хариуцлагын салшгүй нэг хэсэг байх бөгөөд гэрээг биелүүлэхтэй холбогдон гарах аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөж замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Зөвшилцөж эс чадвал маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

_____оОо_____

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2013 оны 10 сарын 18-ны өдөр

Дугаар 27

Сүхбаатар

Орхон, Сайхан сумдын хилийн цэсийг
өөрчлөх саналын тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалт, Засгийн газрын 2002 оны 28 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Газар зохион байгуулалт хийх журам”-ын 2.20-д заасныг үндэслэн аймгийн Засаг даргын саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Орхон, Сайхан сумдын хилийн цэсийг өөрчлөх саналыг Монгол Улсын Засгийн газарт уламжилсугай.

2.Орхон сумын хилийн цэсийг өөрчлөх саналыг 1 дүгээр хавсралтаар, Сайхан сумын хилийн цэсийг өөрчлөх саналыг 2 дугаар хавсралтаар батлуулахаар санал болгосугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2013 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн
27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ОРХОН СУМЫН ХИЛИЙН ЦЭСИЙГ ӨӨРЧЛӨХ САНАЛ

№	Хилийн цэсийн эргэлтийн цэгийн нэр	Х	Ү
1	Орхон гол-Цагаан татуургын уулзвар	105° 06' 16.35	49° 06' 55.94
2	Орхон голын баруун эргээр уруудаж		
3	Ар булангийн доод үзүүр	105° 08' 57.64	49° 09' 04.24
4	Орхон голын баруун эргээр уруудаж		
5	Дэрст булан	105° 30' 11.44	49° 17' 16.24
6	Дэл толгой	105° 31' 06.10	49° 15' 31.71
7	Шинээр нэмэгдсэн	105° 31' 20.44	49° 15' 23.64
8	Шинээр нэмэгдсэн	105° 31' 47.36	49° 15' 17.23
9	Шинээр нэмэгдсэн	105° 31' 24.78	49° 10' 01.93
10	Шинээр нэмэгдсэн	105° 31' 19.74	49° 08' 41.5
11	Сайханы ам	105° 31' 30.49	49° 08' 35.14
12	Овоот уул	105° 31' 41.64	49° 07' 16.20
13	Шинээр нэмэгдсэн	105° 31' 20.52	49° 06' 00.9
14	Шинээр нэмэгдсэн	105° 31' 23.52	49° 04' 55.33
15	Шинээр нэмэгдсэн	105° 32' 15.35	49° 04' 14.72
16	Шинээр нэмэгдсэн	105° 33' 02.35	49° 04' 24.1
17	Шинээр нэмэгдсэн	105° 35' 59.74	49° 03' 05.88
18	Шохой нуруу	105° 38' 24.82	49° 04' 02.55
19	Шохой нуруу хярлаж	105° 41' 08.08	49° 02' 46.65
20	Хөтөл нарс толгой	105° 42' 59.82	49° 03' 20.75
21	Мааньт уул	105° 45' 56.04	49° 03' 53.91
22	Цахиурт	105° 46' 20.20	49° 03' 12.19
23	937.9	105° 48' 36.68	49° 02' 14.66

24	Бунхны хөтөл	105° 50' 36.10	49° 01' 37.27
25	Машин замаар		
26	Шувуутын даваа	105° 49' 14.14	48° 53' 16.58
27	Шувуутын баруун хөтөл	105° 36' 34.30	48° 50' 35.00
28	1353.8	105° 34' 31.90	48° 50' 14.11
29	Бүрэгтэйн зүүн хөтөл	105° 33' 40.16	48° 50' 07.18
30	Бүүрэгтэй нурууны /1469.5/	105° 31' 23.70	48° 49' 26.90
31	Богины эх	105° 27' 53.20	48° 48' 35.86
32	1381.9	105° 27' 32.00	48° 50' 59.84
33	1195.9	105° 24' 00.60	48° 53' 13.37
34	Ажинтын овоо /963.3/	105° 21' 5.66	48° 54' 26.75
35	Дуутын гозгор /1082.2/	105° 14' 13.97	48° 58' 32.23
36	1015.9	105° 11' 58.30	49° 01' 10.26
37	Цагаан хөтөл	105° 11' 11.60	49° 02' 38.50
38	Элстэй хөтөл	105° 07' 48.90	49° 04' 39.89
39	Өгөөмөр	105° 06' 24.89	49° 05' 21.69
40	Цагаан арлын татуургын урд эргээр уруудан		
1	Орхон гол-Цагаан татуургын уулзвар	105° 06' 16.35	49° 06' 55.94

САЙХАН СУМЫН ХИЛИЙН ЦЭСИЙГ ӨӨРЧЛӨХ САНАЛ

№	Хилийн цэсийн эргэлтийн цэгийн нэр	X	Y
1	Орхон-Хараа голын бэлчир	105° 49' 59.48	49° 37' 54.90
2	Хараа голоо өгсөж		
3	Ухаа хошууны гүүр	105° 53' 49.88	49° 23' 22.69
4	Хараа голоо өгсөж		
5	Хараа голын 8-р шон	105° 52' 19.10	49° 7' 42.60
6	1033.6	105° 49' 23.79	49° 7' 8.282
7	Бага номгон уул /1235.4/	105° 46' 27.27	49° 5' 10.45
8	Мааньт	105° 45' 56.04	49° 3' 53.91
9	Хөтөл нарс /1000.6/	105° 42' 59.82	49° 3' 20.75
10	Шохой нуруу хярлаж		
11	Шохой нуруу	105° 38' 24.82	49° 04' 2.55
12	Шинээр нэмэгдсэн	105° 35' 59.74	49° 03' 5.88
13	Шинээр нэмэгдсэн	105° 33' 02.35	49° 04' 24.1
14	Шинээр нэмэгдсэн	105° 32' 15.35	49° 04' 14.72
15	Шинээр нэмэгдсэн	105° 31' 23.52	49° 04' 55.33
16	Шинээр нэмэгдсэн	105° 31' 20.52	49° 06' 00.9
17	Овоот уул	105° 31' 41.64	49° 07' 16.2
18	Сайханы ам	105° 31' 30.49	49° 08' 35.14
19	Шинээр нэмэгдсэн	105° 31' 19.74	49° 08' 41.51
20	Шинээр нэмэгдсэн	105° 31' 47.36	49° 15' 17.23
21	Шинээр нэмэгдсэн	105° 31' 24.78	49° 10' 01.93
22	Шинээр нэмэгдсэн	105° 31' 20.44	49° 15' 23.64
23	Дэл толгой	105° 31' 06.10	49° 15' 31.71

24	Дэрст булан	105° 30' 11.44	49° 17' 16.24
25	Орхон голын баруун эргээр уруудаж		
1	Орхон-Хараа голын билчир	105° 49' 59.48	49° 37' 54.90

_____oOo_____

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2013 оны 10 сарын 18-ны өдөр

Дугаар 28

Сүхбаатар

Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар сумдын хилийн
цэсийг өөрчлөх саналын тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалт, Засгийн газрын 2002 оны 28 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Газар зохион байгуулалт хийх журам”-ын 2.20-д заасныг үндэслэн аймгийн Засаг даргаас оруулсан саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар сумдын хилийн цэсийг өөрчлөх саналыг Монгол Улсын Засгийн газарт уламжилсугай.

2.Сүхбаатар сумын хилийн цэсийг өөрчлөх саналыг 1 дүгээр хавсралтаар, Алтанбулаг сумын хилийн цэсийг өөрчлөх саналыг 2 дугаар хавсралтаар, Шаамар сумын хилийн цэсийг өөрчлөх саналыг 3 дугаар хавсралтаар батлуулахаар санал болгосугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

СҮХБААТАР СУМЫН ХИЛИЙН ЦЭСИЙГ ӨӨРЧЛӨХ САНАЛ

№	Хилийн цэсийн эргэлтийн цэгийн нэр	X	Y
1	Орхон-Сэлэнгэ голын бэлчир	106° 08' 24.71	50° 14' 47.95
2	Орхон голын зүүн эргээр уруудан		
3	Улсын хил /Сэлэнгийн татуургын уулзвар/	106° 05' 28.80	50° 20' 05.86
4	Улсын хилээр		
5	Хилийн 1021.4 тоот өндөрлөг		
6	958 тоот өндөрлөг	106° 17' 06.74	50° 16' 50.57
7	693 тоот өндөрлөг	106° 18' 39.23	50° 11' 01.77
8	1 дүгээр цэг	106° 16' 57.4	50° 10' 1.37
9	2 дугаар цэг	106° 12' 20.95	50° 10' 3.56
10	3 дугаар цэг	106° 11' 31.85	50° 10' 15.23
11	4 дүгээр цэг	106° 11' 25.23	50° 11' 42.86
12	Орхон голын урд эргээр уруудаж		
1	Орхон-Сэлэнгэ голын бэлчир	106° 08' 24.71	50° 14' 47.95

_____оОо_____

АЛТАНБУЛАГ СУМЫН ХИЛИЙН ЦЭСИЙГ ӨӨРЧЛӨХ САНАЛ

№	Хилийн цэсийн эргэлтийн цэгийн нэр	Х	Ү
1	Улсын хилийн 1021.4 тоот өндөрлөг		
2	Улсын хилээр		
3	Улсын хилээс 803.8 тоот тушаа эгц урагш улсын хилээс салж		
4	803.8 тоот	107° 18' 27.11	49° 59' 39.56
5	Наймаат /781.4/	107° 16' 39.47	49° 58' 09.61
6	962.3 тоот	107° 18' 29.01	49° 55' 45.01
7	Жаргалантын эхний уул	107° 18' 25.50	49° 53' 32.57
8	Хацууртын даваа	107° 19' 22.88	49° 50' 47.07
9	Шивэртийн даваа	107° 12' 57.45	49° 49' 12.84
10	1071.2 тоот	107° 09' 0.23	49° 47' 51.25
11	1133.4 тоот	107° 07' 5.63	49° 50' 32.88
12	1212.5 тоот	107° 02' 50.14	49° 50' 31.35
13	1263.3 тоот	107° 01' 53.61	49° 53' 08.68
14	Чаггайн даваа /1123.9/	106° 55' 10.75	49° 55' 31.38
15	Бөхлэйн даваа	106° 47' 23.94	49° 56' 47.86
16	1326.3 тоот	106° 41' 07.33	49° 58' 58.85
17	Их хөндлөн	106° 39' 36.19	49° 59' 12.92
18	Хангайн даваа	106° 37' 01.16	49° 54' 25.51
19	Цагаан даваа	106° 34' 15.32	49° 56' 31.65
20	Дэлгэрхаан уул /1553.8/	106° 24' 37.03	49° 57' 16.55
21	Гэр чулуу	106° 26' 07.11	49° 59' 49.91
22	Сонгино уул /1343.7/	106° 27' 43.96	50° 03' 05.59
23	Цагаан овоо /878.1/	106° 25' 53.15	50° 04' 51.31

24	769.8 тоот	106° 17' 45.00	50° 09' 21.40
25	1 дүгээр цэг	106° 16' 57.4	50° 10' 01.37
26	693 тоот	106° 18' 39.23	50° 11' 01.77
27	958 тоот	106° 17' 06.74	50° 16' 50.57
1	Улсын хилээр 1021.4 тоот өндөрлөг		

_____оОо_____

ШААМАР СУМЫН ХИЛИЙН ЦЭСИЙГ ӨӨРЧЛӨХ САНАЛ

№	Хилийн цэсийн эргэлтийн цэгийн нэр	X	Y
1	Хэлтгийн татуурга /613.9/		
2	4 дүгээр цэг	106° 11' 25.23	50° 11' 42.86
3	3 дугаар цэг	106° 11' 31.85	50° 10' 15.23
4	2 дугаар цэг	106° 12' 20.95	50° 10' 03.56
5	769.8 тоот	106° 17' 45.00	50° 09' 21.40
6	Цагаан овоо /878.1/	106° 25' 53.15	50° 04' 51.31
7	Сонгино уул /1343.7/	106° 27' 43.96	50° 03' 05.59
8	Гэр чулуу	106° 26' 07.11	49° 59' 49.91
9	Дэлгэрхаан уул /1353.8/	106° 24' 37.03	49° 57' 16.55
10	932.8 тоот	106° 20' 33.71	49° 55' 30.79
11	Талын толгой /763.2/	106° 16' 27.02	49° 53' 54.026
12	1 дүгээр шон	106° 16' 23.00	49° 52' 57.000
13	Ерөө голын хойд эргээр Ерөө голын гүүр дайран уруудаж		
14	Орхон-Ерөө голын бэлчир	106° 08' 12.48	49° 54' 58.48
15	Орхон голын баруун эргээр уруудаж		
16	Орхон гол-Хар усны уулзвар	106° 5' 59.100	50° 1' 30.300"
17	761.2 тоот	106° 4' 37.807	50° 2' 33.405"
18	Царам уул /894/	106° 1' 4.360"	50° 4' 6.071"
19	Пирамидтай өндөрлөг /630.5/	106° 3' 15.916	50° 8' 13.163"

- 20 Хэлтгий татуургын гарам 106° 3' 33.104 50° 8' 40.799"
- 21 Татуургын урд эргээр уруудаж
- 1 Хэлтгий татуурга /613.9/

_____oOo_____

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2013 оны 10 сарын 18-ны өдөр

Дугаар 30

Сүхбаатар

2012 оны төсвийн гүйцэтгэлийг
батлах тухай

Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.3, 64.1.4 дэх заалтуудыг үндэслэн аймгийн 2012 оны төсвийн гүйцэтгэлийг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Аймгийн 2012 оны төсвийн орлогыг 18070 084.3 мянган төгрөгөөр, төсвийн зарлагыг 15230 264.4 мянган төгрөгөөр баталсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2013 оны 10 сарын 18-ны өдөр

Дугаар 32

Сүхбаатар

“Аймгийн хөгжлийн сан”-гийн
төсөв батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.”Аймгийн хөгжлийн сан”-гаас 2013 оны зарцуулах хөрөнгийн хэмжээг 1360117,6 мянган төгрөгөөр баталсугай.

2.Батлагдсан хөрөнгийг “Сэлэнгэ аймгийн хөгжлийн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-д заасны дагуу зарцуулж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга С.Бүрэнбат/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 04-ний өдөр

Дугаар 35

Сүхбаатар

Үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “а” заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ аймгийн эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

2.Аймгийн эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан бодлогын зорилт, ажил, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг бүтэн жилээр гаргаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг аймгийн Засаг дарга /С.Бүрэнбат/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2014 ОНД
ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

№		Бодлогын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	Хариуцах байгууллага
Нэг. Эдийн засгийн бодлого				
1. 225,7 мянган тонн үр тариа, 56,5 мянган тонн төмс 35,0 мянган тонн хүнсний ногоо үйлдвэрлэж, 145,0 мянган га талбайд уринш, 165,0 мянган тонн малын тэжээл бэлтгэнэ.				
1	1	Тариалан эрхлэгчдийн нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулах	2014 онд салбарын хэмжээнд баримтлах бодлогыг тодорхойлж мөрдөх агротехнологийн чиглэлтэй болж, үйл ажиллагаагаа явуулах боломжоор хангагдана.	Аймаг, сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
2	2	150000 га-д үр тариа, тэжээл, тосны ургамал, 3500 га-д төмс, 2500 га-д хүнсний ногоо тариалж, 145000 га-д уринш бэлтгэх	2014 онд 150000 га-д үр тариа, тэжээл, тосны ургамал, 3500 га-д төмс, 2500 га-д хүнсний ногоо тариалж, 145000 га-д уринш бэлтгэж, талбайн ашиглалт 100 хувьд хүрнэ.	Аймаг, сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
3	3	Газар тариалангийн үйлдвэрлэлд хөрсний үржил шимийг хамгаалах тухай хууль, эрх зүйн заалтуудыг хэрэгжүүлж, хяналт тавих зорилгоор иргэд, аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулах журам боловсруулан хэрэгжүүлэх	Газар тариалангийн үйлдвэрлэлд хөрсний үржил шимийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт сайжирна.	Аймаг, сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
4	4	“Ээлжлэн тариалалтын систем” хөтөлбөрийг хэрэгжүүлж, таримлын сэлгээг мөрдөх ажлыг зохион байгуулах, тосны ургамлын хэмжээг эргэлтийн талбайн сэлгээний ургамлын 20 хувиас хэтрүүлэхгүй байх бодлого баримтлан аж ахуйн нэгж, иргэдтэй гэрээгээр баталгаажуулах	Таримлын төрлийн нэгдсэн хэтийн төлөвлөлттэй болж, хөрсний үржил шимийг хамгаалах, сайжруулах үндэслэл бий болно.	Аймаг, сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
5	5	Усалгаатай тариаланд мөрдөгдөх технологи боловсруулж, өндөр ашигтай таримлыг сонгох, үрийг нийлүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Усалгаатай тариалангийн талбайн ашиглалт сайжирч, га-аас авах ургацын хэмжээ нэмэгдэнэ.	Аймаг, сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар

6	6	Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлд ажиллагсад, үйлдвэрлэл эрхлэгчдийг мэргэшүүлэх, дадлагажуулах, мэргэжил олгох урт болон богино хугацааны сургалтанд хамруулж, тогтвортой ажиллуулах	Хөдөө аж ахуйн салбарт дадлага туршлагатай, мэргэжилтэй ажиллах хүчин нэмэгдэнэ.	Аймаг, сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
7	7	Сант, Баянгол, Мандал, Жавхлант, Шаамар сумдын төмс, хүнсний ногоо тариалагч иргэдэд зориулсан техник дундын үйлчилгээний төв байгуулахад дэмжлэг үзүүлэх	Техникийн үйлчилгээний нэгжийг байгуулснаар төмс, хүнсний ногоо тариалагчдын үйл ажиллагаанд дэмжлэг болно.	Аймаг, сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
8	8	Гурилын чанарыг сайжруулах зорилгоор хатуу буудайн тариалалтыг зах зээлийн эрэлтэд нийцүүлэн нэмэгдүүлэх	Сортын төрөл зүйл нэмэгдэж, гурилын чанар сайжирна.	Аймаг, сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
9	9	Хөрс, байгаль цаг уурын нөхцөлд дасан зохицсон таримал ургамлын үрийн нөөцтэй болгох	Хөрс, байгаль цаг уурын нөхцөлд дасан зохицсон таримал ургамлын үрийн нөөцтэй болсон байна.	Аймаг, сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
10	10	“Хүнсний ногоо” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, тариалалтыг нэмэгдүүлэх	“Хүнсний ногоо” хөтөлбөрийн хэрэгжилт хангагдаж, тариалалтын хэмжээ нэмэгдсэн байна.	Аймаг, сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
11	11	“Хамгаалагдсан тариалан” хөтөлбөрийн 2-р үе шатыг хэрэгжүүлж, тариалангийн талбайн хөрсний үржил шимийн үзүүлэлтийг сум бүрээр тодорхойлох	Төмс, хүнсний ногоо тариалагчдын 200 га талбайг хашаажуулсан байна. Хөрсний шим тэжээлийн хангамжийн судалгаатай болсон байна.	Аймаг, сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
12	12	Өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, хүлэмжинд тариалах ургамлын төрөл зүйлийг нэмэгдүүлэх	Иргэдийн санал санаачилгыг дэмжин, шинээр байгуулах хүлэмжийн тоо хэмжээг нэмэгдүүлж, тариалах ургамлын төрөл хэмжээ нэмэгдэнэ.	Аймаг, сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
13	13	Сумдад жимс, жимсгэнэ тариалсан талбайн тооллогыг зохион байгуулж, талбайн хэмжээг	Жимс жимсгэний тариалалт нэмэгдэнэ.	Аймаг, сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж

		нэмэгдүүлэх		ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
14	14	Газар тариалангийн үйлдвэрлэлийн таримлын үрийг ариутгах зориулалтын машин, техникийн хангамжийг нэмэгдүүлэх	Техникийн тоо, хүчин чадал нэмэгдэнэ.	Аймаг, сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
2.Цэвэр эрлийз, нутгийн шилмэл омгийн малын тоог урьд оныхоос 10 хувиар өсгөж, иргэдэд төрөөс үзүүлэх мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг чанартай, технологийн хугацаанд явуулж, малын тооны өсөлтөөс татгалзаж, эрүүл чанартай малтай болно.				
15	1	Мал сүргийг эрүүлжүүлэх, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулж, паразиттах өвчнөөс сэргийлэх тарилга туулгалт, угаалга, боловсруулалт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулах ажлыг чанартай хийж гүйцэтгэх	Мал сүрэгт урьдчилсан тандалт явуулж, дүнг үндэслэн малыг эрүүлжүүлэх арга хэмжээг хугацаанд нь чанартай хийсэн байна.	Аймаг, сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
16	2	Мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн эмч, мэргэжилтний мэргэжил, ур чадварыг дээшлүүлж, багаж тоног төхөөрөмж, эм урвалжийн хангалтыг нэмэгдүүлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээний чанар, үр дүнг сайжруулах	Үржлийн албаны ажлын багаж тоног төхөөрөмжийн хангамж сайжирч, ажлын бүтээмж дээшилнэ.	Аймаг, сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
17	3	Малчид, мал бүхий иргэдийн малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор иргэдийн санал хэрэгцээнд нийцүүлэн өндөр ашиг шимт малын гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийх, хээлтүүлэгчээр хангах	Цөм сүрэг, цэвэр эрлийз, өндөр ашиг шимт малын тоо, толгой 0,7 хувиар нэмэгдэнэ.	Аймаг, сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
18	4	Тариалангийн талбайн болон бэлчээрийн талбайн хөнөөлт мэрэгч амьтадтай байгаль орчин, хүн, мал амьтанд халгүй аргаар тэмцэх арга хэмжээ зохион байгуулах	Хөнөөлт мэрэгч амьтадтай тэмцэх байгаль орчинд халгүй арга ажиллагааг нэвтрүүлж, бэлчээрийн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.	Аймаг, сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
19	5	Бэлчээрийн усан хангамж, бэлчээр усжуулалтыг үе шаттайгаар зохион байгуулах	Бэлчээрийн усан хангамж сайжирна.	Аймаг, сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд

				үйлдвэрийн газар
20	6	Бэлчээрийг зүй зохистой ашиглах, талхалдал доройтлоос сэргийлэх, даац, багтаамжийг тодорхойлох чиглэлээр малчдын дунд сургалт зохион байгуулах	Бэлчээр ашиглалт сайжирна.	Аймаг, сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
21	7	Аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүй нөөцийг бүрдүүлж, тэдгээрийг хадгалах агуулахын асуудлыг судалж, шийдвэрлэх	Аймаг, сумын өвс, тэжээлийн нөөц бүрдсэн байна.	Аймаг, сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
22	8	2-оос доошгүй суманд тэжээлийн цех байгуулах саналыг холбогдох газарт хүргүүлэх	Бүсийн төвүүдэд тэжээлийн цех байгуулагдаж, тэжээлийн нөөц бүрдэнэ.	Аймаг сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
23	9	“Малын тэжээл” хөтөлбөрийг хэрэгжүүлж мал, амьтны бие махбодид зайлшгүй шаардлагатай биологийн идэвхт шимт бодисуудыг өөртөө агуулсан төрөл бүрийн тэжээлийн үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлэх	“Малын тэжээл” хөтөлбөрийн хэрэгжилт биелэгдэж, тэжээлийн үйлдвэрлэлийн тоо хэмжээ нэмэгдсэн байна.	Аймаг, сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
24	10	Ерөө суманд хонь ангилалт, Зүүнбүрэн суманд бог малын зохиомол хээлтүүлгийн үзүүлэх сургуулийг зохион байгуулах	Сүргийн бүтцийн зохистой харьцааг бүрдүүлж, өндөр ашиг шимт болон нутгийн шилмэл малын нийт малд эзлэх хувь тогтвортой нэмэгдэнэ.	Аймаг, сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
25	11	Мандал суманд “Шилмэл мал” үзэсгэлэн худалдааг зохион байгуулах	Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх малчдын тоо нэмэгдэж, цөм сүргийн малын тоо 10 хувиар нэмэгдэнэ.	Аймаг сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
26	12	Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд хүнсний зах, худалдааны төвүүдэд худалдаалагдаж буй мал аж	Хүн ам эрүүл аюулгүй хүнсээр хангагдах нөхцөл бүрдэнэ.	Аймаг сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд

		ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүнд анхан шатны үнэлгээ, ариун цэврийн магадлан шинжилгээ хийж гэрчилгээ олгох		үйлдвэрийн газар
27	13	Малчдад, малчны холбоо байгуулах ач холбогдол, давуу талыг сурталчилж, сум бүрт үлгэр жишээ хоршоо байгуулах	Хоршоодын үйл ажиллагаа сайжирна.	Аймаг сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
5. Байгаль орчныг хамгаалах талаар гарсан Монгол Улсын хуулиудын хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг эрчимжүүлж, уул уурхайн нөхөн сэргээлтийг нэмэгдүүлэн, цөлжилттэй тэмцэх ажлыг эрчимжүүлнэ.				
28	1	Ойн нөөцийг хамгаалах, ойг нөхөн сэргээх ажлыг зохион байгуулан улс, орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгөөр 1500 га талбайд ойжуулалтын ажил хийж гүйцэтгэх	Ойжуулсан талбайн нийт хэмжээ 1500 га-аар нэмэгдэнэ.	Аймаг, сумын ЗДТГ, Байгаль орчны газар
29	2	Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг зохион байгуулж, ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх сургалт зохион байгуулах	Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг 25000 га-д талбайд гүйцэтгэнэ.	Сумын Засаг даргын Тамгын газар, Байгаль орчны газар
30	3	Түлээний модыг бэлтгэх, тээвэрлэх журмыг боловсруулж батлуулан хэрэгжүүлэх	Түлээний мод бэлтгэх, тээвэрлэхтэй холбоотой санал гомдол багасна.	Аймаг, сумын ЗДТГ, Байгаль орчны газар
31	4	Сумдад түлээ, нүүрс борлуулах цэгийг бий болгож ажиллуулах	Иргэдэд үйлчилгээ ойртсон байна.	Сумдын ЗДТГ
32	5	Байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, албан байгууллага, нийтийн эзэмшлийн зам талбайг тохижуулж, мод бут, сөөг тарих, шаардлага хангасан хогийн саваар хангах ажлыг зохион байгуулах	Тохижилт болон ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдсэн байна.	Аймаг, сумын ЗДТГ, Байгаль орчны газар
33	6	Хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, Оргидог булаг, Хоёр элс, Дулаанхааны рашаан, Номтын рашаан зэрэг газруудыг хамгаалалтанд авах, тохижуулах ажлыг зохион байгуулах	Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ нэмэгдсэн байна.	Аймаг, сумын ЗДТГ, Байгаль орчны газар
34	7	Уул уурхайн ашиглалтын үйл	Нөхөн сэргээлтийн ажлыг	Аймаг, сумын

		ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд тогтмол хяналт тавьж, нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгүүлэх	стандартын шаардлагын дагуу гүйцэтгүүлнэ.	ЗДТГ, Байгаль орчны газар
35	8	Аймгийн хэмжээнд бичил уурхай эрхлэгчдийн судалгааг гарган, тэдгээрийг нөхөрлөлийн зохион байгуулалтанд оруулах	Бичил уурхай эрхлэгчид нөхөрлөлийн зохион байгуулалтанд орсон байна.	Аймаг, сумын ЗДТГ, Байгаль орчны газар
36	9	“Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах журам”-ыг шинэчлэн боловсруулж, батлуулж хэрэгжүүлэх	Журмын дагуу зохион байгуулагдсан байна.	Аймгийн ЗДТГ, Байгаль орчны газар
37	10	Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлж, сумдын төвийн суурьшлын бүсийн тэг, гортигийг шинэчилэн тогтоож, иргэдэд өмчлүүлэх боломжтой газрын нөөцийг тогтоох	Аймгийн хэмжээнд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил тодорхой болно.	Аймаг, сумын ЗДТГ, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
38	11	Цөлжилтийн судалгааны хүрээнд бэлчээрийн ургамлын төрөл зүйл, хөрсний бүтэц, эвдрэлийг тодорхойлж, аймгийн цөлжилтийн зураглал хийх	Цөлжилтийн зурган мэдээлэлтэй болж, зураглалын дагуу цөлжилтийн эсрэг арга хэмжээ авагдана.	Аймаг, сумын ЗДТГ, Байгаль орчны газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Ус, цаг уур орчны шинжилгээний алба
39	12	Цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулан, мөндөр зайлуулах ажлын судалгааг хийх	Хур тунадас оруулснаар хураан авах ургацын хэмжээ нэмэгдэнэ.	Аймгийн ЗДТГ, Ус, цаг уур, орчны шинжилгээний алба
6. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн болон жижиг, дунд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, худалдаа, ахуйн үйлчилгээний салбарт соёлч, шуурхай үйлчилгээг нэвтрүүлж, стандартын шаардлага хангасан аж ахуйн нэгжүүдийг бий болгоно.				
40	1	“Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих” аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй болно.	Аймгийн ЗДТГ
41	2	Аймгаас олгож байгаа зээл тусламжинд хамрагдсан иргэдийн судалгааг гарган	Зээлийн давхардалт багасаж, зээл зориулалт, ашиглалт сайжирна.	Аймаг, сумын ЗДТГ, Хөдөлмөрийн хэлтэс

		нэгдсэн мэдээллийн сан бий болгох		
42	3	Иргэдийн хэрэгцээнд зориулан нөөцийн мах гаргаж, үнийн өсөлтийг тогтворжуулах	Иргэдийн хэрэгцээнд зориулан нөөцийн мах гаргаснаар үнийн өсөлтийг тогтворжуулж, иргэдийн амьжиргаанд дэмжлэг болно.	Аймгийн ЗДТГ “Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ
43	4	Түгээмэл тархацтай байгалийн баялгийн нөөцөд тулгуурлан барилгын материалын үйлдвэрлэлийг эрхлэхэд дэмжлэг үзүүлэх	Барилгын материалын үйлдвэрлэлийн тоо хэмжээ нэмэгдсэн байна.	Аймаг, сумын ЗДТГ
44	5	Цагааннуур, Баянгол сумдад үйлдвэрлэл технологийн парк байгуулах саналыг холбогдох газарт тавьж шийдвэрлүүлэх	Сумдад үйлдвэрлэл технологийн парк байгуулах нөхцөл бүрдэнэ.	Аймаг, сумын ЗДТГ, Хөдөлмөрийн хэлтэс
45	6	Өрхийн үйлдвэрлэгчээс жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч болгох санаачилгыг дэмжиж, хөдөлмөрийн чуулган зохион байгуулах	Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо нэмэгдэнэ.	Аймаг, сумын ЗДТГ, Хөдөлмөрийн хэлтэс
46	7	Аймгийн хэмжээнд үйлдвэрлэгдэж буй бүтээгдэхүүний сав, баглаа, боодлыг сайжруулах чиглэлээр сав, баглаа, боодлын үйлдвэр барих иргэдийн санал, санаачилгад санхүүгийн дэмжлэг үзүүлэх	Брэнд бүтээгдэхүүнээ сурталчилах боломж бүрдэж, зориулалтын сав баглаатай болно.	Аймаг, сумын ЗДТГ Хөдөлмөрийн хэлтэс, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
47	8	Сумдын төмс, хүнсний ногоо тариалагчдыг “Намрын ногоон өдрүүд” арга хэмжээнд зохион байгуулан оролцуулах	Экологийн цэвэр бүтэгдэхүүнийг улсын хэмжээнд сурталчилж, борлуулалтын тоо хэмжээ, тариаланчдын ашиг орлого нэмэгдэнэ.	Аймаг, сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
48	9	Аймгийн хэмжээнд үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийн брэнд бүтээгдэхүүнийг бусад аймаг орон нутагт сурталчилах ажлыг зохион байгуулах		
49	10	“Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх” тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг төлөвшүүлэх	Архидалтаас хамааралтай аливаа зөрчил, дутагдал багасна.	Аймаг, сумын ЗДТГ

50	11	Аймгийн төвд эрүүл, ахуйн шаардлага хангасан, бизнесийн жишигт нийцсэн худалдааны төвийг ашиглалтанд оруулах	Эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан худалдааны төвтэй болсон байна.	Аймаг, сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар, Мэргэжлийн хяналтын газар
51	12	Үйлчилгээний салбарт ажиллагсдын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулах	Үйлчилгээний салбарын 80 хувь нь мэргэжлийн ажиллагсадтай болсон байна.	Аймаг, сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
4.2.	Эрүүл мэнд			3 811,2
4.2.1	эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	Иргэдэд эрүүл зан үйл, аж төрөх ёсыг хэвшүүлэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшин нэмэгдэж, халдварт бус өвчний гаралт багасч, нас баралтыг бууруулах, эмзэг бүлгийн хүн ам эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. Хүн амын 50 хувийг эрүүл мэндийн боловсрол олгох сургалтанд хамруулж, халдварт бус өвчний үзлэгийг 10 хувиар нэмэгдүүлж, эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоог нэмэгдүүлнэ.	Сумын эмнэлэг 20, өрхийн эмнэлэг-7 төвөөр хүн амд анхан шатны тусламж хүргэнэ.	462,2

		<p>Хүн ам, эх хүүхэд, ядуу, буурай, эмзэг бүлгийн хүмүүст хүрэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж, хамралтыг нэмэгдүүлж, чанартай анхан шатны нарийн мэргэжлийн болон яаралтай тусламж, үйлчилгээг сайжруулна.</p>	<p>Жирэмсний эхний 3 сартайд, хяналтанд хамрагдагсдын эзлэх хувийг 95-аас багагүй байлгана.</p>	<p>3 349,0</p>
<p>Нийт төрөлтөд гэрийн төрөлт, Эхийн эндэгдлийг гаргахгүй</p>	<p>0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлтөд/ 8,5-10,5 промилоос ихгүй байлгана.</p>			

			<p>Дархлаажуулалтын хамралтын хувийг /1 хүртэлх насны хүүхдийн/ 98 - аас доошгүй болгоно.</p> <p>Нийт халдварт өвчний гаралтыг бууруулна.</p>	
4.3.	Биеийн тамир, спорт хороо, клуб			653,3
	Нийтийн биеийн тамир спортын үйлчилгээ	Иргэдийн биеийн тамир спортод хандах хандлага сайжирч, хөдөлгөөний хомсдолоос үүдэлтэй халдварт бус өвчний тохиолдол буурч эрүүл чийрэг бие бялдартай болсноор дундаж наслалт хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэнэ.	<p>Биеийн тамираар хичээллэгчид /хүн амд эзлэх хувиар / -23 хувь</p> <p>Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдын тоо-386</p>	653,3
4.4.	Соёлын үйлчилгээ			2 777,0

4.4.1	Сумдын соёлын төв, соёлын ордон	Хөдөөгийн хөдөлмөрчдөд урлаг, уран сайхнаар үйлчилж, 1500-аад арга хэмжээ зохион байгуулж 250,0 мянган үзэгчдэд үйлчилнэ.	20 соёлын төв, 1 соёлын ордон	1 451,8
4.4.2	Орон нутгийн дуу бүжгийн чуулга	Жилдээ 2 уран бүтээл бэлтгэн ард иргэдэд хүргэж 20 сая төгрөгийн орлоготой ажиллана.	Аймгийн чуулга 1, Мандал сумын чуулга 1	924,7
4.4.3	Орон нутгийн музей	Музейн үзмэрийг баяжуулан ховор үзмэрийг улсын бүртгэлд бүртгүүлэн музейн үзмэрийн хадгалалтыг сайжруулна.	музей 1	153,5
4.4.4	Орон нутгийн номын сан	Номын фондыг нэмэгдүүлэн уншигчдын тоог 20 мянгад хүргэж хөдөөгийн иргэд, хөдөлмөрчид, албан газруудад явуулын номын сангаар үйлчилнэ.	номын сан 2	247,0
4.5.	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар			207,2

4.5.1	Барилга хот байгуулалт	Салбарын холбогдох хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Хөрөнгө оруулалт, их засварын ажилд техникийн хяналт тавьж, барилга угсралтын ажлын чанарыг сайжруулна.	207,2
4.5.2	Газрын харилцаа	Газрын төлбөр ноогдуулах, төвлөрүүлэх ажлыг зохион байгуулна.	Жилдээ 2-с доошгүй зохион байгуулна.	
4.6.	Орон нутгийн хү ү хдийн байгууллага			289,3
	Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс	Хүүхэд хамгаалал болон хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргын талаар эцэг эх, олон нийтийн мэдлэг, дадал, зан үйлийг өөрчлөх сургалтууд зохион байгуулснаар эцэг эхчүүд үр хүүхдээ зөв хүн болж төлөвшүүлэх мэдлэг чадвар дээшилнэ.	жилд 4 удаа	96,4

	<p>"Хүүхдийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах" олон нийтийн санал санаачлагыг өрнүүлэх. Хү ү хэд хамгааллын сургалтыг хү ү хдийн хөгжил оролцооны байгууллага, зуслангийн хөгжлийн хөтөлбөрөөр зохион байгуулснаар аливаа хү чирхийлэл аюул гамшгийн үед өөрийгөө болон бусдыг хамгаалах мэдлэгтэй болно.</p>	<p>жилд 4 удаа</p>	<p>96,5</p>
	<p>Шилдэг гэр бүл шалгаруулах, эцэг эхийн зөвлөгөөн зохион байгуулах ажил хийгдэнэ.</p>	<p>жилд нэг удаа</p>	<p>96,4</p>

оОо

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2013 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 37-р тогтоолын 2 дугаар хавсралт

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,
ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

/мянган төгрөг/

	Төсөл арга хэмжээний нэр хүчин чадал байршил		Эхлэх дуусах хугацаа	Төсөвт өртөг	2013 оны тодотголын дүн
1	ЗАСАГ ДАРГА /1=2+11+21+24/	1		1 568 033,4	1 568 033,4
1.1.	Хөрөнгө оруулалт /2=3+5/	2		928 671,3	928 671,3
	Шилжих хөрөнгө оруулалт /3=4/	3		140 000,0	140 000,0
1.1.1.	Түшиг сумын 75 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгын үлдэгдэл санхүүжилт	4	2013	140 000,00	140 000,00
	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	5		788 671,3	788 671,3
1.1.2.	Шинээр баригдсан сургууль хүртэлх дулааны шугамын өргөтгөл	6	2013	638 782,0	638 782,0
1.1.3.	Спортын сургуулийн хувьчлагдсан 2 өрөөг худалдан авах	7	2013	30 000,0	30 000,0
1.1.4.	Шинээр баригдсан сургуулийн гадна хуучин бетонон хашаа буулгах	8	2013	24 889,3	24 889,3
1.1.5.	Сүхбаатар сумын 5-р багт баригдсан 75 хүүхэдтэй цэцэрлэгийн барилгын цахилгааны эх үүсвэрийг шинээр тавих	9	2013	40 000,0	40 000,0
1.1.6.	Орон нутгийн өмчийн орон сууц худалдан авах	10	2013	55 000,0	55 000,0
1.2.	Тоног төхөөрөмж	11		464 000,0	464 000,0
1.2.1.	Цагдаагийн газарт компьютер техник хэрэгслэл	13	2013	15 000,0	15 000,0
1.2.2.	Сүхбаатар суманд хамгаалалтын камер тавих	14	2013	169 000,0	169 000,0
1.2.3.	Аймгийн ЗДТГазар парк шинэчлэлт	15	2013	160 000,0	160 000,0
1.2.4.	Орон нутгийн өмчийн албанд авто машин	18	2013	30 000,0	30 000,0
1.2.5.	Аймгийн аудитын газрын авто	19	2013	50 000,0	50 000,0

	машин				
1.2.6.	Аймгийн ЗДТГазар парк шинэчлэлт	20	2013	40 000,0	40 000,0
1.3.	Их засвар	21		26 700,0	26 700,0
1.3.1.	Цагдаагийн газрын барилгын засвар	22	2013	20 000,0	20 000,0
1.3.2.	Алтанбулаг сумын төрийн далбаа цогцолборын их засвар	23	2013	6 700,0	6 700,0
1.4.	Арга хэмжээ	24		148 662,1	148 662,1
1.4.1.	Ахмад, залуу үед зориулсан "Сэлэнгэ түмэн" арга хэмжээ	25	2013	50 000,0	50 000,0
1.4.2.	Зураг төсвийн үнэ	26	2013	98 662,1	98 662,1
2	АЙМГИЙН ИТХ-ЫН ДАРГА	27		47 966,6	47 966,6
2.1.	Тоног төхөөрөмж	28		47 966,6	47 966,6
2.1.1	Аймгийн ИТХ-ын төлөөлөлөгчдөд компьютер /зөөврийн/ модем	29	2013	47 966,6	47 966,6
	НИЙТ ДҮН /30=27+1/	30		1 616 000,0	1 616 000,0

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын хуралдааны 2013 оны 12 дугаар сарын
04-ний өдрийн 37-р тогтоолын 3 дугаар хавсралт

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН
ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

/мянган. төгрөг/

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил		Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	2013 онд санхү ү жү ү лэх дү н
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ /1=2+26+33/		1		2 252 593,0	2 252 593,0
1	Засаг дарга /2=3+26+33/	2		2 252 593,0	2 252 593,0
1.1.	Хөрөнгө оруулалт /3=4+8/	3		1 441 343,0	1 441 343,0
Шилжих хөрөнгө оруулалт		4		374 250,0	374 250,0
1.1.1	Шаамар сумын Дулаанхан тосгоны хүн эмнэлгийн барилгын үлдэгдэл санхү ү жилт	5	2013	95 000,0	95 000,0
1.1.2	Сү хбаатар сумын 5-р багт баригдаж буй соёлын төв ахуйн үйлчилгээний барилгыг гүйцээх	6	2013	239 250,0	239 250,0
1.1.3	Орхонтуул сумын халаалтын тогоо байрлуулах	7	2013	40 000,0	40 000,0
Шинээр эхлэх хөрөнгө оруулалт		8		1 067 093,0	1 067 093,0
1.1.4	Алтанбулаг сумын 1 км хатуу хучилттай авто зам	9	2013	140 000,0	140 000,0
1.1.5	Зүүнбүрэн сумын цагдаагийн кабоны барилга	10	2013	65 000,0	65 000,0
1.1.6	Зүүнбүрэн суманд цэнгэлдэх хүрээлэн барих	11	2013	56 000,0	56 000,0
1.1.7	Орхон суманд бэлчээрийн гүний худаг гаргах	12	2013	30 000,0	30 000,0
1.1.8	Сайхан сумын Хөтөл хотын доторх инженерийн шугам сүлжээ	13	2013	230 000,0	230 000,0
1.1.9	Орхонтуул суманд Wi Fi интернэтийн орчин бий болгох	14	2013	30 000,0	30 000,0
1.1.10	Баруунбүрэн суманд байрлах Амарбаясгалант хийдэд нийтийн ариун цэврийн өрөө барих	15	2013	60 000,0	60 000,0
1.1.11	Хүдэр суманд Wi Fi интернэтийн орчин бий болгох	16	2013	30 000,0	30 000,0

1.1.12	Жавхлант сумын эмнэлгийн барилгын өргөтгөл	17	2013	50 000,0	50 000,0
1.1.13	Жавхлант сумын баруун хороололд гүний худаг гаргах	18	2013	25 000,0	25 000,0
1.1.14	Жавхлант суманд ахмадын өргөө барих	19	2013	30 000,0	30 000,0
1.1.15	Түшиг сумын ЗДТГ-ын урд цэцэрлэгт хүрээлэн тохижуулах	20	2013	40 000,0	40 000,0
1.1.16	Хушаат сумын Дуулга хороололд цахилгааны шугам барих	21	2013	30 000,0	30 000,0
1.1.17	УЦУОША-нд үүлэнд зориудаар нөлөөлж хур тундас нэмэгдүүлэх	22	2013	30 000,0	30 000,0
1.1.18	"Сэлэнгэ-Энерго" Дулааны станцын үндсэн болон туслах тоноглолын их засварт	23	2013	78 233,8	78 233,8
1.1.19	Зураг төсвийн үнэ	24	2013	66 059,2	66 059,2
1.1.20	Сүхбаатар сумын дулааны шугам сүлжээний салбар шугам шинэчлэх	25	2013	76 800,0	76 800,0
1.2	Тоног төхөөрөмж	26		102 460,0	102 460,0
1.2.1	Орхон сумын сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж, хэрэгсэл	27	2013	23 550,0	23 550,0
1.2.2	Шаамар сумын сургуулийн ширээ сандал	28	2013	20 000,0	20 000,0
1.2.3	Шаамар сумын Дулаанхан тосгоны соёлын төвд хөгжим хэрэгсэл авах	29	2013	000,0 ⁵	5 000,0
1.2.4	Цагдаагийн газрын эрүүлжүүлэх баривчлах байрны орчин нөхцөл сайжруулах, ахуйн эд зүйл, цахилгаан хэрэгсэл худалдан авах болон Цагдан хорих байрны дулааны шугамд шаардлагатай 200 метр труба авах	30	2013	600,0 ⁶	6 600,0
1.2.5	Нэгдсэн эмнэлэг дурангийн хагалгаа, нярайн амьсгалын аппарат авах	31	2013	32 310,0	32 310,0
1.2.6	БТСГазарт боксын ринг авах	32	2013	15 000,0	15 000,0
1.3	Их засвар	33		708 790,0	708 790,0
1.3.1	Урсгал Ус ХХК-ий бохир усны цэвэрлэх байгууламжийн цэвэр усны ган хоолой засвар шинэчлэлтийн ажил	34	2013	20 000,0	20 000,0
1.3.2	Ерөө сумын эмнэлгийн цэвэр, бохир усны шугам засвар	35	2013	40 000,0	40 000,0

1.3.3	Орхон сумын 42-р зөрлөгийн хайрган авто зам сайжруулах	36	2013	56 690,0	56 690,0
1.3.4	Ерөө сумын сургуулийн дээврийн засварын ажил	37	2013	29 500,0	29 500,0
1.3.5	Сүхбаатар сумын 6-р сургуулийн дээврийн засварын ажил	38	2013	70 000,0	70 000,0
1.3.6	Сант сумын багийн байрны засвар	39	2013	30 000,0	30 000,0
1.3.7	Цагааннуур сумын цэцэрлэгийн сантехник, цахилгаан, барилгын засвар	40	2013	140 000,0	140 000,0
1.3.8	Баянгол сумын сургуулийн ариун цэврийн өрөөний засвар	41	2013	30 000,0	30 000,0
1.3.9	Баянгол сумын төвийн инженерийн шугам засвар	42	2013	30 000,0	30 000,0
1.3.10	Сайхан сумын 20-р цэцэрлэгийн сантехник засвар	43	2013	30 000,0	30 000,0
1.3.11	Баруунбурэн сумын дулааны шугам засвар	44	2013	45 000,0	45 000,0
1.3.12	Хүдэр сумын цэцэрлэгийн бохир усны гадна шугам засвар	45	2013	42 000,0	42 000,0
1.3.13	Хүдэр сумын эмнэлгийн гадна шугам засвар	46	2013	17 000,0	17 000,0
1.3.14	Түшиг сумын сургуулийн сантехник, ариун цэврийн өрөөний засвар	47	2013	50 000,0	50 000,0
1.3.15	Хушаат сумын хүн эмнэлгийн сантехник засвар, эргэлтийн эмийн сан, стандартын моорог, гараж барих	48	2013	40 000,0	40 000,0
1.3.16	Хушаат сумын сургуулийн цахилгааны засвар	49	2013	38 600,0	38 600,0
СУМЫН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНД ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ		50		4 921 607,0	4 921 607,0
НИЙТ ДҮН /51=50+1/		51		7 174 200,0	7 174 200,0

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2013 оны 12 дугаар сарын 04-ний
өдрийн 37-р тогтоолын 4 дүгээр хавсралт

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР
ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ЖАГСААЛТ**

/мянган төгрөг/

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	2013 онд санхүүжих дүн
ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ				
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ			330,750	330,750
1	Засаг дарга		330,750	330,750
1.1.	Их засвар		330,750	330,750
1.1.1	Алтанбулаг сумын зам засвар, замын тэмдэг	2013	16,500	16,500
1.1.2	Ерөө сумын зам засвар, замын тэмдэг	2013	16,500	16,500
1.1.3	Зүүнбүрэн сумын зам засвар, замын тэмдэг	2013	9,900	9,900
1.1.4	Мандал сумын зам засвар, замын тэмдэг	2013	82,500	82,500
1.1.5	Орхон сумын зам засвар, замын тэмдэг	2013	6,600	6,600
1.1.6	Сант сумын зам засвар, замын тэмдэг	2013	6,600	6,600
1.1.7	Цагааннуур сумын зам засвар, замын тэмдэг	2013	16,500	16,500
1.1.8	Баянгол сумын зам засвар, замын тэмдэг	2013	16,500	16,500
1.1.9	Сайхан сумын зам засвар, замын тэмдэг	2013	19,800	19,800
1.1.10	Орхонтуул сумын зам засвар, замын тэмдэг	2013	13,200	13,200
1.1.11	Баруунбүрэн сумын зам засвар, замын тэмдэг	2013	9,900	9,900
1.1.12	Шаамар сумын зам засвар, замын тэмдэг	2013	13,200	13,200
1.1.13	Хүдэр сумын зам засвар, замын тэмдэг	2013	6,600	6,600
1.1.14	Сүхбаатар сумын зам засвар, замын тэмдэг	2013	76,650	76,650
1.1.15	Жавхлант сумын зам засвар, замын тэмдэг	2013	6,600	6,600
1.1.16	Түшиг сумын зам засвар, замын тэмдэг	2013	6,600	6,600
1.1.17	Хушаат сумын зам засвар, замын тэмдэг	2013	6,600	6,600
НИЙТ ДҮН			330,750	330,750

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 04-ний өдөр

Дугаар 38

Сүхбаатар

Сэлэнгэ аймгийн 2014 оны төсөв
батлах тухай

Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулийн 11, 13 дугаар зүйлүүдийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг.Аймгийн 2014 оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

/мянган
төгрөг/

	Сэлэнгэ аймгийн төсвийн орлого бүгд	65 334 856,4
1.	Урсгал орлого	13 072 909,3
1.1	Татварын орлого	12 697 909,3
1.1.1	Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвар	10 225072,1
1.1.2	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	710 000,0
1.1.3	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-634228,4
1.1.4	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	539 065,6
1.1.5	Төсвийн тухай хуулийн 23.4.9-д зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамж	80 000,0
1.1.6	Газрын төлбөр	350000,0
1.1.7	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр	1 428000,0
1.2	Татварын бус орлого	225 000,0
1.2.2	Төсөвт байгууллагын өөрийн орлого	45 000,0

1.2.3	Хүү, торгуулийн орлого	100 000,0
1.2.4	Нэр зааж ангилагдаагүй орлого	80 000,0
2.	Хөрөнгийн орлого	150 000,0
2.1	Хөрөнгө борлуулсны орлого	150 000,0
3.	Тусламжийн орлого	52 261 947,1
3.2	Улсын төсвийн санхүүгийн дэмжлэг	4 230 264,7
3.3	Орон нутгийн хөгжлийн сан орлогын шилжүүлэг	9 852 352,8
3.4	Тусгай зориулалтын шилжүүлэг	38 179 329,6

Хоёр. Сэлэнгэ аймгийн 2014 оны төсөвт төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

/мянган төгрөг/

2.1	Засаг дарга	45 000,0
2.1.1	Аймгийн Засаг даргын Тамгын газрынөөрийнорлого	45 000,0

Гурав.Аймгийн 2014 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нарт дор дурдсан төсөв зарцуулах эрхийг олгосугай.

/мянган төгрөг/

3.1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	341 441,7
3.1.1.	Урсгал зардлын дээд хэмжээ	341 441,7
3.2	Засагдарга	64 993 414,7
3.2.1	Урсгал зардлын дээд хэмжээ	64 197 791,8
3.2.1.1	Үүнээс: Сумдад олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ	11 726 419,8
3.2.1.2	Сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг	5 911 411,7
3.2.1.3	Сумдад олгох тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээ	36 278 423,9
3.2.1.4	Аймгийн Засаг даргын даргын тамгын газар	1 222 884,0

3.2.1.5	Байгаль орчны газар	441 379,1
3.2.1.6	Худалдан авах ажиллагааны алба	48 342,7
3.2.1.7	Орон нутгийн өмчийн алба	42 988,3
3.2.1.8	Байгаль хамгаалах сан	883 593,3
3.2.1.10	Орон нутгийн нөөц хөрөнгө	612 846,6
3.2.1.11	Орон нутгийн мал мал эмнэлгийн үйлчилгээ	547 727,0
3.2.1.12	Жолоочийн даатгалын сан	43 719,4
3.2.1.13	Нийтийн тээврийн хөнгөлөлт	35 478,0
3.2.1.14	Аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг	3 940 941,1
3.2.1.15	Аймагт олгох тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээ	1 900 905,7
3.2.1.16	Бусад татаас шилжүүлэг	560 731,2
3.2.2	Хөрөнгийн зардлындээдхэмжээ	795 622,9

Дөрөв.Аймгийн 2014 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээг 65 334 856,4 мянган төгрөгөөр баталсугай.

Тав.Аймгийн 2014 оны төсвийн жилд аймгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын зардлын дээд хэмжээг 795 622,9 мянган төгрөгөөр баталсугай.

Зургаа.Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

/мянгантөгрөг/

1	Алтанбулаг	274 537,2
2	Баруунбүрэн	335 955,5
3	Баянгол	324 076,0
4	Ерөө	475 951,9
5	Жавхлант	236 418,6
6	Зүүнбүрэн	215 010,0
7	Мандал	769 275,3
8	Орхон	268 136,4
9	Орхонтуул	349 573,8
10	Сант	275 232,9

11	Сайхан	374 374,0
12	Сүхбаатар	547 665,8
13	Түшиг	300 194,0
14	Хү дэр	323 960,9
15	Хушаат	279 910,1
16	Цагааннуур	344 729,8
17	Шаамар	216 409,5
	НИЙТ ДҮН	5 911 411,7

Долоо.Аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

/мянгантөгрөг/

	Алтанбулаг	360781,2
2	Баруунбүрэн	459146,3
3	Баянгол	587945,0
4	Ерөө	748078,1
5	Жавхлант	376662,5
6	Зүүнбүрэн	500384,2
7	Мандал	1885591,5
8	Орхон	368676,3
9	Орхонтуул	534731,6
10	Сант	353859,2
11	Сайхан	878358,2
12	Сүхбаатар	2364664,4
13	Түшиг	293551,9
14	Хү дэр	350124,5
15	Хушаат	353333,6
16	Цагааннуур	627306,1
17	Шаамар	683225,2
	НИЙТ ДҮН	11 726 419,8

Найм.Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих зардлыгдор дурдсанаар баталсугай. Үүнд:

/мянган
төгрөг/

	Сумдын нэр	Сумын эмнэлэг өрхийн эмнэлэг	Соёлын төв	Ерөнхий боловсролын сургууль	Хүүхдийн цэцэрлэг	Биеийн тамир спортын ордон	Суурь зардлын дүн
1	Алтанбулаг	198 247,7	56 299,8	770 703,2	580 090,6	0,0	1 605 341,3
2	Баруунбүрэн	191 880,5	55 883,8	586 111,1	311 319,4	0,0	1 145 194,8
3	Баянгол	216 742,4	58 747,3	1 010 904,8	364 316,7	36 706,8	1 687 418,0

4	Ерөө	411 669,5	126 225,4	1 203 636,3	458 187,5	20 885,3	2 220 604,0	
5	Жавхлант	160 851,0	69 482,8	352 856,7	218 746,4	0,0	801 936,9	
6	Зүүнбүрэн	184 414,8	64 522,0	514 150,4	320 902,2	0,0	1 083 989,4	
7	Мандал	664 300,9	135 321,4	4 648 870,8	1 548 072,9	128 431,3	7 124 997,3	
	Мандал сумын хүүхдийн ордон							116 046,1
	Мандал сумын номын сан							80 547,2
	Мандал сумын Мөнгөн хараа чуулга							384 120,5
8	Орхон	184 748,9	65 112,4	374 347,8	197 250,8	0,0	821 459,9	
9	Орхонтуул	321 246,6	64 341,3	831 281,5	214 915,4	0,0	1 431 784,8	
10	Сант	180 551,2	59 039,7	483 093,8	192 909,5	0,0	915 594,2	
11	Сайхан	176 635,0	59 623,1	1 752 132,9	1 360 894,0	25 917,4	3 375 202,4	
	Сайхан сум Соёлын ордон							303 691,5
12	Сүхбаатар	255 448,3	0,0	4 544 341,7	2 317 348,3	0,0	7 117 138,3	
13	Түшиг	187 355,8	65 166,1	460 513,3	227 813,9	0,0	940 849,1	
14	Хүдэр	187 127,3	54 959,2	563 259,0	225 515,2	0,0	1 030 860,7	
15	Хушаат	161 316,3	70 314,7	339 525,0	159 098,7	0,0	730 254,7	
16	Цагааннуур	210 542,1	53 847,0	819 930,0	332 584,0	94 509,1	1 511 412,2	
17	Шаамар	341 217,2	107 543,7	854 695,7	546 524,0	0,0	1 849 980,6	
	Сумдын төсөв	4 234 295,5	1 166 429,7	20 110 354,0	9 576 489,5	306 449,9	36 278 423,9	
1	Спортын дунд сургууль			331 173,4			331 173,4	
3	ССАЖГазар					351 242,3	351 242,3	
4	Орон нутгийн музей						153 049,9	
5	Аймгийн төв номын сан						157 891,9	
6	Сэлэнгийн долгио чуулга						508 642,7	
7	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар						215 690,0	
8	Аймгийн хүүхэд гэр бүлхөгжлийн хэлтэс						183 215,5	
	Аймгийн төсөв	0,0	0,0	331 173,4	0,0	351 242,3	1 900 905,7	

	Нийт төсөв	4 234 295,5	1 166 429,7	20 441 527,4	9 576 489,5	657 692,2	38 179 329,6
--	-------------------	--------------------	--------------------	---------------------	--------------------	------------------	---------------------

Ес.Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Арав.Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр болон аймгийнтөсвийн хөрөнгөөрхийгдэх хөрөнгө оруулалт, их засварын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг 2,3,4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

Арван нэг. Энэ тогтоолын хүрээнд төсвийн бүрдүүлэлт, зарцуулалтанд байнгын хяналт тавьж, төсвийн хуримтлагдсан өр, авлагыг бууруулж, шинээр үүсгэхгүй ажиллахыг аймаг, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**ТӨСВИЙН ЭРХ ЗАХИРАГЧ НАРЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ
ХӨТӨЛБӨР, ХҮРЭХ ҮР ДҮН**

Д/д	Төсвийн захирагч тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр	Хүрэх үр дүн		Зарцуулах төсөв /сая төгрөг/
		Чанар	Тоо	
1.	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга			
1.1	Аймгийн ИТХ-ын үйл ажиллагаа	МУ-ын ЗЗНДНТУТХууль болон Төсвийн тухай хуульд заасан ИТХ-ын чиг үүргийг цаг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлнэ.	Хуралдаан төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй зохион байгуулагдсан байна.	304,4
2.	Аймгийн засаг дарга			
2.1	Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ			
2.1.1	Засаг даргын ажлын алба	Засаг даргын тамгын газар Аймгийнэдийнзасгийннийгмийнчадавхийгбэхжүүлж, төрийнүйлчилгээгиргэдэдшударга, шуурхайхүргэж, илтодбайдалдшинэчлэлхийж, үйлчлүүлэгчдийнсэтгэлханамж үнэлэмжийгдээшлүүлнэ	Ороннутгийнэдийнзасаг бэхжижиргэдийнсэтгэлх анамждээшилнэ.	1 236,9
2.1.2	Засаг даргын нөөц хөрөнгө	Сангийнсайдынтушаалаарбатлагдсаннөөцхөрөнгийнзахиранзарцуулахжурмыгхэрэгжүүлэх	ИТХ-аас баталсан төлөвлөлтийн хэмжээнд зарцуулагдсан байна.	655,6
2.1.3.	Ороннутгийн өмчийн алба	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль хэрэгжсэн байна.	Орон нутгийн өмчит байгууллагуудад үйлчилгээ үзүүлэх	42,9
2.1.4	Худалдан авах ажиллагааны алба	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хууль болон холбогдох хууль, журам хэрэгжсэн байна.	Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээг чанартай зохион байгуулна.	48,3

2.2	Байгальхамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ			883,6
2.2.1	Мод бэлтгэсэн болон ой хээрийн түймэр, хөнөөлт шавьжид нэрвэгдсэн талбайд ойжуулалт хийх /га/	Ойжуулсан талбайн хэмжээ нэмэгдэнэ.	500	100.0
2.2.2	Элсний нүүлт, цөлжилтөөс сэргийлэх зорилгоор Орхон, Жавхлант, Баянгол суманд хамгаалалтын ногоон зурвас байгуулах /га/	Элсний нүүлт, цөлжсөн талбайн хэмжээ багасна	10	11.0
2.2.3	Алтанбулаг суманд цөлжилт үүссэн талбайг хашиж, хамгаалан навчит модоор ойжуулалтын ажил хийх /га/	Цөлжилт үүссэн талбайн хэмжээ багасна	9	9.9
2.2.4	Мод үржүүлгийн газаргүй Цагааннуур, Орхонтуул, Жавхлант, Зүүнбүрэн, Сантсумдад мод үржүүлгийн газар байгуулах / ш/	Мод үржүүлгийн талбайн хэмжээ, модны төрөл зүйл нэмэгдэнэ	5	50.0
2.2.5	Мандал суманд үрийн байнгын талбай тусгаарлах ажлыг хийх	Үрийн байнгын талбайн хэмжээ нэмэгдэнэ.	10	5.0
2.2.6	Ойн хөнөөлт шавьжтай тэмцэх тэмцлийн ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх /га/	Ойн хөнөөлт шавьжид нэрвэгдсэн талбайн хэмжээ багасна.	8800	88.0
2.2.7	Ойн байгууллагын 90 жилийн ойд зориулан“Ойн салбарын өнөөгийн байдал” ном	Ойн салбарын өнгөрсөн, одоо, ирээдүйн тухай түүхийн номтой болно.	1	2.5

	хэвлүүлэх			
2.2.8	Гэрэлжүүлэх огтлолтыг Алтанбулаг, Түшиг, Хүдэр, Хушаат сумдад хийх /га/	Ойн хэвийн өсөлт хөгжилтийг ханган, ойн таваарлаг чанар сайжирна.	100	5.3
2.2.9	Анх удаа ойн санг гэрээгээр эзэмшиж буй нөхөрлөлийн ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулах /га/	Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлийн ойн сангийн ашиглалт хамгаалалт сайжирна.	29545	3.3
2.2.10	Цагааннуур, Мандал, Сант, Жавхлант сумдад булаг шандын эхийг тохижуулах	Булаг шандын эх хамгаалагдана.	5	10.0
2.2.11	Бүх нийтээр мод тарих өдрийг хавар, намрын улиралд зохион байгуулж, ногоон төгөл, ногоон байгууламжтай айл өрх, албан байгууллага, иргэнийг шагнаж урамшуулах	Ногоон байгууламж нэмэгдэнэ	2	5.0
2.2.12	Байгаль хамгаалах сарын аян зохион байгуулж, сургуулийн сурагчдын дунд уралдаан зарлан, урамшуулах	Сурагчдын байгаль хамгаалах дадал зуршил, төлөвшинө.	2	1.0
2.2.13	Агнуур зохион байгуулалтын ажлыг Алтанбулаг, Хүдэр, Ерөө, Мандал, Баянгол сумдад хийнэ.	Тухайн сумдын агнуурын эдэлбэр газар тодорхой болж хамгаалах арга хэмжээ авна.	1	45.0
2.2.14	Сүхбаатар суманд хог хаягдлыг ангилан ялгах цех байгуулна.	Хог хаягдал багасна.	1	90.0
2.2.15	Байгаль хамгаалагчдын зөвлөлгөөн зохион байгуулах	Үйл ажиллагаагаа дүгнэн цаашдын зорилтоо тодорхойлно.	1	3,2

2.2.16	“Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлийн гишүүдэд “ойн аж ахуйн арга хэмжээ” сэдэвт сургалт зохион байгуулах	Нөхөрлөлийн гишүүдийн чадвар сайжирна.	4	4.0
2.2.17	Байгаль орчны газрын цахим хуудас хийлгэх	Байгаль орчны холбогдолтой мэдээллийг олон нийтэд сурталчилах, мэдээллийг түргэн шуурхай авах болно.	1	2.0
2.2.18	Сум дундын Ойн ангийг чадавхжуулах сургалт зохион байгуулах	Сумын болон сум дундын ойн ангийн инженер, техникчид чадваржина.	2	2.6
2.2.19	Уур амьсгалын өөрчлөлтийн бодлого боловсруулан хэрэгжүүлж ажиллах	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамжтай болно.	1	1.3
2.2.20	Арчилгааны, огтлолтын сургалтыг сум дундын ойн ангийн /инженер техникийн ажилчдад/ зохион байгуулах	Сум дундын ойн ангийн инженер техникчийн ажил сайжирна.	2	1.3
2.2.21	Байгаль хамгаалах чиглэлээр сурталчилгааны самбарыг Алтанбулаг, Шаамар, Сүхбаатар, Баруунбүрэн, Баянгол суманд байрлуулах	Байгаль хамгаалах ажиллагааг олон нийтэд сурталчилах сурталчилгааны самбартай болно.	6	7.2
2.2.22	Байгаль орчны чиглэлээр зөвлөмж, нугалбар, санамж боловсруулан хэвлүүлэх	Сургалт, сурталчилгааны гарын авлага материалыг иргэд олон нийтэд хүргэнэ.	20.0	10.0
2.2.23	Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлийн	Нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгаалах менежмент	1	5.0

	“Байгаль хамгаалах үйлст хамтдаа” аймгийн зөвлөлгөөн зохион байгуулах	хэрэгжинэ		
2.2.24	Хил залгаа орнуудын байгаль хамгаалах газартай цөлжилт элсний нүүлтээс хамгаалах ажилд хамтран ажиллах. /Хятад улс/	Хил залгаа орнуудад туршлага судлан цөлжилт элсний нүүлтээс хамгаалах чадамжтай болно.	1	21.0
2.2.25	Ерөө, Хүдэр суманд улсын үйлдвэрийн газар ашиглаж байгаад орхигдсон газарт мэргэжлийн байгууллагаар нөхөн сэргээлт хийлгүүлэх	Эвдрэл орсон талбайн хэмжээ багасна.	66	400.0
2.3	Жолоочийн хариуцлагындаатгалын сан	Жолоочийн хариуцлагын даатгалын тухай хууль хэрэгжсэн байна.	Хуулийн дагуу суурь орлогын 10 хувиар тооцож төвлөрүүлнэ.	43,7
2.4	Хот доторх хүн тээврийн үйлчилгээнд үзүүлэх дэмжлэг	Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль, хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль, боловсролын тухай хуулийн зохих заалт хэрэгжсэн байна.	Хот доторх нийтийн хүн тээврийн үйлчилгээ ард иргэдэд үзүүлэх үйлчилгээнд нь төсвөөс дэмжлэг үзүүлнэ.	35,4
2.5	Í õî í í õõæéí ì àéú ì í ýëãèí ¿éè-èèãúú	Хувийн мал эмнэлэг үржлийн нэгжтэй гэрээ байгуулан төлөвлөгөөт малыг 100 хувь хамруулж, халдварт өвчний гаралт буурсан байна.	Малыг 100 хувь хамруулах	547,7
2.6	Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ			
2.6.1	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ	Хамрагдалтын тоог нэмэгдүүлж, сурах орчинг сайжруулан, авьяас чадварыг хөгжүүлнэ.	СӨБ-д 7297 хүүхэд, СӨБ-ын хувилбарт сургалтан д 1276 хүүхэд хамрагдана	9 576,5

2.6.2	Ерөнхий боловсролын үйлчилгээ	Сургалтын чанар үр дүнг дээшлүүлж, сурч боловсрох орчныг сайжруулан, чанартай хоолоор үйлчилнэ.	Хүүхдэд ая тухтай орчин бүрдүүлж /хоол, байр/ үйлчилнэ.	2 0441,5
2.6.3	Соёлын үйлчилгээ	Иргэдэд хүргэх соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Урлаг соёл, музей, номын сангаар үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлнэ.	2 812,0
2.6.4	Эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тасралтгүй, чанартай хүртээмжтэй үзүүлэх боломж бүрдэнэ.	Хяналт сайжирч, урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээнд хамрагдагсдыг нэмэгдүүлж, өвчлөл эндэгдэл буурна.	4 234,3
2.6.5	Соёл, спорт, аялал жуулчлалын бодлого, үйл ажиллагаа	Биеийн тамирын болон соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.	Иргэд, хүүхдийн бие бялдрыг хөгжүүлэх, спортын олон талт арга хэмжээг зохион байгуулж, соёлын үйлчилгээ, үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлнэ.	668,5
2.6.6	Газрын харилцаа, кадастрын үйлчилгээ	Газрын шинэтгэлийн бодлогыг эрчимжүүлнэ.	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, төлөвлөсөн үйл ажиллагааг хугацаанд нь хийж гүйцэтгэнэ.	216
2.6.7	Гэр бүлийн болон хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ	Гэр бүлийн болон хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Засгийн газрын хөтөлбөрүүдийг хугацаанд нь хэрэгжүүлж, хяналт, дүн шинжилгээ хийж, орон нутгийн бодлогод тусгаж ажиллана.	Гэр бүл, хүүхдийн хөгжил, оролцооны хөтөлбөр, стратегийг орон нутагт хэрэгжүүлж, орон нутгийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн талаарх бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, шинэчлэхэд хүүхэд, олон нийтийн оролцоог 80 хувьд хүргэж ажиллана.	299,3

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСӨЛ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

/мянган төгрөг/

Д/д	Төсөл арга хэмжээний нэр хүчин чадал байршил		Эхлэх дуусах хугацаа	Төсөвт өртөг	2014 онд санхүүжих дүн
1	ЗАСАГ ДАРГА /1=2+7+12+18/	1		302 149,0	302 149,0
1.1	Хөрөнгө оруулалт /2=3+4/	2		26 800,0	26 800,0
	Шилжих хөрөнгө оруулалт /3=3/	3		0,0	0,0
	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт /4=5+6/	4		26 800,0	26 800,0
1.1.1	Хөтөл хотын 5-р байрнаас цагдаагийн тасаг хүртэлх гэрэлтүүлэг	5	2014	10 800,0	10 800,0
1.1.2	Ерөө сумын цэцэрлэгийн тоглоомын шинэчлэл	6	2014	16 000,0	16 000,0
1,2	Тоног төхөөрөмж	7		106 000,0	106 000,0
1.2.1	Зүүнбүрэн сумын Засаг даргын авто машин	8	2014	40 000,0	40 000,0
1.2.2	Баруунбүрэн сумын Засаг даргын авто машин	9	2014	40 000,0	40 000,0
1.2.3	Худалдан авах ажиллагааны албаны авто машин	10	2014	20 000,0	20 000,0
1.2.4	Сайхан суманд техник хэрэгсэл авах	11	2014	6 000,0	6 000,0
1,3	Их засвар	12		78 349,0	78 349,0
1.3.1	Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн авто машины засвар	13	2014	5 500,0	5 500,0
1.3.2	Сант сумын төрийн албан хаагчдын байрны дээврийн засвар	14	2014	20 000,0	20 000,0
1.3.3	Мандал сумын ахмадын сувилалын засвар	15	2014	25 000,0	25 000,0
1.3.4	Мандал сумын Дарьт цэцэрлэгийн дээврийн засвар	16	2014	5 000,0	5 000,0
1.3.5	"Урсгал ус" ХХК-ий ус түгээх 6 байрны их засвар	17	2014	22 849,0	22 849,0
1,4	Арга хэмжээ	18		91 000,0	91 000,0
1.4.1	Баруунбүрэн сумын соёл, эдийн засгийн өдрүүд	19	2014	6 000,0	6 000,0
1.4.2	Зүүнбүрэн сумын соёл, эдийн засгийн өдрүүд	20	2014	6 000,0	6 000,0
1.4.3	Түшиг сумын соёл, эдийн засгийн өдрүүд	21	2014	6 000,0	6 000,0
1.4.4	Цагааннуур сумын соёл, эдийн засгийн өдрүүд	22	2014	6 000,0	6 000,0
1.4.5	Шаамар сумын соёл, эдийн засгийн өдрүүд	23	2014	6 000,0	6 000,0
1.4.6	Ерөө сумын соёл, эдийн засгийн өдрүүд	24	2014	6 000,0	6 000,0
1.4.7	"Сэлэнгэ түмэн" арга хэмжээ	25	2014	30 000,0	30 000,0

1.4.8	"Нээлттэй хаалга" арга хэмжээ	26	2014	25 000,0	25 000,0
2	АЙМГИЙН ИТХ-ЫН ДАРГА	27		100 000,0	100 000,0
2,1	Тоног төхөөрөмж	28		100 000,0	100 000,0
2.1.1	ИТХ-ын парк шинэчлэл	29	2014	100 000,0	100 000,0
	НИЙТ ДҮН /30=1+27/	30		402 149,0	402 149,0

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН
ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

/мянган төгрөг/

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил		Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ /1=2/		1		3 940 941,1	3 940 941,1
1	ЗАСАГ ДАРГА /2=3+34+38+47/	2		3 940 941,1	3 940 941,1
1.1	Хөрөнгө оруулалт /3=4+6/	3		3 312 741,1	3 312 741,1
Шилжих хөрөнгө оруула /4=5/		4		644 214,20	644 214,20
1.1.1	Сүхбаатар сумын гэр хороололд дулааны болон цэвэр усны шугам тавих	5	2014	644 214,2	644 214,2
Шинээр эхлэх хөрөнгө оруулалт		6		2 668 526,9	2 668 526,9
1.1.2	Хүдэр суманд хайрган хучилттай авто зам тавих	7	2014	50 000,0	50 000,0
1.1.3	Ерөө сумын ёслолын өргөө барих	8	2014	80 000,0	80 000,0
1.1.4	Жавхлант суманд хайрган хучилттай авто зам тавих	9	2014	25 000,0	25 000,0
1.1.5	Номгон тосгоны шороон замыг сайжруулах	11	2014	49 800,0	49 800,0
1.1.6	Орхонтуул сумыг хэрэглээний халуун усаар хангах	12	2014	60 000,0	60 000,0
1.1.7	Баруунбүрэн суманд Бүрэнхан цогцолбор барих	13	2014	100 000,0	100 000,0
1.1.8	Хушаат суманд 4 км цахилгаан эрчим хүч татах	14	2014	60 000,0	60 000,0
1.1.9	Түшиг сумын 04 Кв-т цахилгааны шугамын өргөтгөл	15	2014	40 000,0	40 000,0
1.1.10	Түшиг сумын бизнес хөгжлийн төвийн засвар	16	2014	20 000,0	20 000,0
1.1.11	Цагааннуур сумын сургуулийн засвар	17	2014	150 000,0	150 000,0
1.1.12	Зүүнбүрэн сумын соёлын төвийн засвар	18	2014	100 000,0	100 000,0
1.1.13	Баянгол сумын сургуулийн гал тогооны засвар	19	2014	50 000,0	50 000,0
1.1.14	Шаамар сумын төвийн цахилгааны шугамын шинэчлэл	20	2014	56 000,0	56 000,0
1.1.15	Шаамар сумын дэд бүтэц, тохижилтыг сайжруулах	21	2014	20 000,0	20 000,0
1.1.16	Сүхбаатар хотын нийтийн орон сууцнуудын дунд тохижилт, авто зогсоол барих /Шарын 6, 7, 8, 9, 10- ийн дунд, Цэнхэр 15, 16, 17,18-ын дунд, Цэнхэр 19, 20 урд /	22	2014	226 184,0	226 184,0

1.1.17	Сүхбаатар хотод явган хүний зам барих 2130 м	23	2014	139 531,0	139 531,0
1.1.18	Сүхбаатар хотын зүлэгжүүлэлт хийх 9546,5 м2	24	2014	49 671,0	49 671,0
1.1.19	Сүхбаатар хотын замын уулзварын тохижилтын ажил	25	2014	36 335,0	36 335,0
1.1.20	Сүхбаатар хотын нийтийн эзэмшлийн талбайд 10ш авто зогсоол барих	26	2014	249 102,6	249 102,6
1.1.21	Сүхбаатар хотын хүүхэд залуучуудын амралтын цогцолбор барих	27	2014	200 000,0	200 000,0
1.1.22	Оргидог булгийн тохижилт	28	2014	45 000,0	45 000,0
1.1.23	Зураг төсвийн үнэ	29	2014	50 000,0	50 000,0
1.1.24	Үүлэнд зориудаар нөлөөлж хур тунадас оруулах	30	2014	30 000,0	30 000,0
1.1.25	Ерөнхий боловсролын сургуулиудад микро автобус 32 ширхэг	31	2014	480 000,0	480 000,0
1.1.26	Сайхны хөтөлийн тохижилт	32	2014	15 000,0	15 000,0
1.1.27	Төмс, хүнсний ногоог худалдаанд гаргахын өмнөх боловруулах үйлдвэрийг дэмжих	33	2014	286 903,3	286 903,3
1.2	Тоног төхөөрөмж	34		74 000,0	74 000,0
1.2.1	Жавхлант сумын сургуульд тоног төхөөрөмж худалдан авах	35	2014	30 000,0	30 000,0
1.2.2	Баруунбүрэн сумын соёлын төвд хөгжим авах	36	2014	20 000,0	20 000,0
1.2.3	Шаамар сумын соёлын төвд хөгжим авах	37	2014	24 000,0	24 000,0
1.3	Их засвар	38		494 200,0	494 200,0
1.3.1	Алтанбулаг сумын цэвэр усны худаг, шугам засварлах	39	2014	47 200,0	47 200,0
1.3.2	Мандал сумын 1-р сургуулийн засвар	40	2014	238 900,0	238 900,0
1.3.3	Сайхан сумын спорт залны шалны засвар	41	2014	37 700,0	37 700,0
1.3.4	Баруунбүрэн сумын соёлын төвийн засвар	42	2014	20 000,0	20 000,0
1.3.5	Сант сумын багийн үйлчилгээний төвийн засвар	43	2014	60 000,0	60 000,0
1.3.6	Сүхбаатар хотын 16,17,18,19-р байрны дээвэр засвар	44	2014	60 000,0	60 000,0
1.3.7	Сүхбаатар хотын 5-р сургуулийн залны засвар	45	2014	20 400,0	20 400,0
1.3.8	Сүхбаатар хотын Хулан хатны цогцолборын засвар	46	2014	10 000,0	10 000,0
2	ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ	47		60 000,0	60 000,0
2.1.1	Баяр наадмын зардал	48	2014	50 000,0	50 000,0
2.1.2	Ерөнхий боловсролын сургуульд нум сум хөтөлбөр хэрэгжүүлэх	49	2014	10 000,0	10 000,0
Сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг		50		5 911 411,7	5 911 411,7
НИЙТ ДҮН /51=50+1/		51		9 852 352,8	9 852 352,8

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР
ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

/мянган төгрөг/

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	2014 онд санхүүжих дүн
ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ				
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ			393 473,9	393 473,9
1	Засаг дарга		393 473,9	393 473,9
1.1.	Их засвар		393 473,9	393 473,9
1.1.1	Алтанбулаг сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ	2014	20 000,0	20 000,0
1.1.2	Ерөө сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ	2014	20 000,0	20 000,0
1.1.3	Зүүнбүрэн сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ	2014	12 000,0	12 000,0
1.1.4	Мандал сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ	2014	85 000,0	85 000,0
1.1.5	Орхон сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ	2014	12 000,0	12 000,0
1.1.6	Сант сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ	2014	12 000,0	12 000,0
1.1.7	Цагааннуур сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ	2014	20 000,0	20 000,0
1.1.8	Баянгол сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ	2014	20 000,0	20 000,0
1.1.9	Сайхан сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ	2014	22 000,0	22 000,0
1.1.10	Орхонтуул сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ	2014	15 000,0	15 000,0
1.1.11	Баруунбүрэн сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ	2014	12 000,0	12 000,0
1.1.12	Шаамар сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ	2014	15 000,0	15 000,0
1.1.13	Хүдэр сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ	2014	12 000,0	12 000,0
1.1.14	Сүхбаатар сумын Салхит 3-р багт тойрог зам тавих	2014	80 473,9	80 473,9
1.1.15	Жавхлант сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ	2014	12 000,0	12 000,0
1.1.16	Түшиг сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ	2014	12 000,0	12 000,0
1.1.17	Хушаат сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ	2014	12 000,0	12 000,0
НИЙТ ДҮН			393 473,9	393 473,9

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 12 сарын 04-ний өдөр

Дугаар 39

Сүхбаатар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны ажлын тайлан

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны ажлын тайланг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2012 оны 12 дугаар сард сонгогдсоноос хойш Хурлын хуралдааны бэлтгэлийг ханган 6 удаа товлон хуралдуулж Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2013 оны Үндсэн чиглэл, төсөв, түүний тодотгол, 2014 оны төсөв, Сүхбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, зарим татвар төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох, “Малчид тариаланчидын үйл ажиллагааны зохицлыг хангах”, Аймгийн хөгжлийн сангийн журам зэрэг эдийн засаг, нийгмийн тулгамдсан бодлогын асуудлуудыг хэлэлцэн зохих шийдвэрүүдийг гаргуулсан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан 23 удаа хуралдаж Эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдал, цаашдын зорилт, Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах хөтөлбөр, “Ажилтай орлоготой Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааны тайлан, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам, Тохижилт, цэвэрлэгээний талаар албан байгууллага, аж ахуйн, айл өрх, иргэдээс дагаж мөрдөх журам, Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, Ахмадын байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай, Зарим бүтээлийг бүх нийтээр судлах, сурах зэрэг улс, аймаг орон нутгийн бодлогын зорилтуудад нийцсэн, ард иргэдийн санал хүсэлд үндэслэсэн олон асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

Хурлын Төлөөлөгч, Тэргүүлэгчид, Бодлогын хороодын үйл ажиллагааг тогтмолжуулах, Хурлын хуралдаан болон Тэргүүлэгчдийн хуралдааны бэлтгэлийг хангах, чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарч Хурлын Төлөөлөгчдийг төсвийн

хөрөнгөөр зөөврийн компьютер, модемоор ханган Хуралдааны материал, мэдээ мэдээллийг цахимаар хүргүүлэх, Бодлогын хороодын үйл ажиллагаанд тусгайлан төсөв зардал тусгаж эрхлэх асуудлын чиглэлээр нь хяналт шалгалтын ажлыг хийлгэж, мөн Төлөөлөгчдөд аймгийн ажил, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын үйл ажиллагааны талаар улирал бүр мэдээлэл, гарын авлага бэлтгэн өгөх зэрэг ажил арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчид бүрэн бүрэлдэхүүнээрээ зарим сум, байгууллагын ажил, ард иргэдийн амьдрал байдалтай танилцан Хурлын ажлыг сурталчилан, гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилттэй танилцаж, иргэдийн санал бодол, эрэлт хүсэлтийг сонсож, дүнгээ хуралдаанаараа хэлэлцэн шаардлагатай зарим асуудлаар шийдвэр гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг чиглэл өгч ажилласан байна.

Хууль, тогтоомж, Хурлын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх ажилд Тэргүүлэгчид, Бодлогын хороодыг оролцуулж сум, байгууллага, иргэдээс тавьсан зарим асуудлыг ажлын хэсэг томилон шалгуулж дүнг хуралдаанаараа хэлэлцэн авах арга хэмжээний талаар тогтоол шийдвэр гаргасан байна.

Хурлын хуралдаан болон Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэх зарим асуудлаар иргэний танхимын хэлэлцүүлэг зохион байгуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон түмэнд хүргэх, мэдээллийн самбарт байрлуулах зэргээр Хурлын тогтоол шийдвэрт иргэдийн оролцоог хангах, тэдний санал хүсэлтийг тусгах, Хурлын ажлыг нээлттэй ил тод байлгахад анхаарч ажилласан байна.

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын хүний нөөцийг чадавхижуулах зорилгоор шат шатны Хурлын дарга, Нарийн бичгийн дарга, Тэргүүлэгч, Төлөөлөгчдийн сургалт семинарыг тус тус зохион байгуулан Хурлын Төлөөлөгч, ажилтнуудын шаардлагатай сургалт, зөвөлгөөнүүдэд хамруулах ажлыг зохион байгуулсан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2013 онд дэвшүүлсэн зорилт, ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаа цаг хугацаанд бүрэн биелүүлснийг тэмдэглээд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн “в”, 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны үйл ажиллагааг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

Хоёр. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд ДААЛГАХ
НЬ:

1. Аймаг орон нутгаа илүү хурдацтай хөгжүүлэх ард иргэдийнхээ аюулгүй, тайван, тохилог орчинд ажиллаж амьдрах нөхцөл боломжийг хангахад чиглэсэн шинэлэг ажлуудыг санаачлан шийдвэрлэхэд Хурлын бодлого, үйл ажиллагааг чиглүүлж ажиллах;

2. Аймаг, сумдын төсвийн боловсруулалт, хуваарилалтыг бодитой тооцож үндэслэлийг сайжруулах, төсвийн зарцуулалт, гүйцэтгэлд Хурлаас тавих хяналтыг тогтмолжуулах, дотоод нөөц боломж, орлогын эх үүсвэрээ бүрэн дайчилж үйлдвэрлэл үйлчилгээг бий болгох, өргөжүүлэх замаар төсвийн орлогыг нэмэгдүүлэх ажлыг Хурлын бодлого, шийдвэрээр дэмжих;

3. Шууд ардчилал-Иргэний оролцооны талаар төрөөс баримталж буй бодлого, шийдвэр, стратеги баримт бичгүүдийг удирдлага болгон нийтийн эрх ашгийг хөндсөн аливаа шийдвэрт иргэдийн оролцоог хангах, тэдний санал бодлыг тусгах, Иргэний танхимын үйл ажиллагааг тогтмолжуулан сайжруулах

4.Хариуцлагатай уул уурхайг дэмжин хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчид, аж ахуйн нэгжүүдийн ашиг орлогоо нэмэгдүүлж үйлдвэрлэлээ өргөжүүлэх сонирхлыг аймаг, орон нутгийн хөгжил, иргэдийн нийгмийн асуудалтай уяалдуулан шийдвэрлэх бодлого баримтлах;

Гурав.Хурлаас дэвшүүлсэн зорилт, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн, Хурлын ажлыг тогтмолжуулан сайжруулахад бүтээлч санаачилга гарган идэвхитэй ажиллахыг Хурлын нийт Төлөөлөгчид, Бодлогын хороодын дарга нарт даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 03-ны өдөр

Дугаар 01

Сүхбаатар

“Улсын тэргүүний тариаланч хамт олон” –оор
шагнуулах тухай

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газраас оруулсан саналыг хэлэлцээд Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 70 дугаар тогтоолоор баталсан журмыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн, техник технологийн шинэчлэл хийж, тогтвортой амжилт гаргаж байгаа дор дурдсан аж ахуйн нэгжүүдийг “Улсын тэргүүний тариаланч хамт олон” –оор шалгаруулан шагнуулахаар Монгол Улсын Засгийн газарт уламжилсугай. Үүнд:

1.Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн сүүлийн 3 жилд 900-1037 га талбайд улаан буудай тариалж , 1 га-аас 22-24 цн ургац хураан, 140-160 тн үр нөөцөлж, 743-880 га уринш бэлтгэн тогтвортой өндөр ургац авч сум орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж байгаа Түшиг сумын “Бооцын тариа” ХХКомпани.

2.Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн сүүлийн 3 жилд техникийн шинэчлэлд 1,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, техникийн паркийг 100 хувь шинэчилж, жил бүр 1084-1120 га талбайд улаан буудай тариалж, 1 га-аас 25-31,9 цн ургац хураан, 300-1000 тн үр нөөцөлж, 1084-1120 га уринш бэлтгэн, тогтвортой өндөр ургац авч, сум орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж байгаа Орхонтуул сумын “Суварган тамир” ХХКомпани.

3.Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн жил бүр 650-1172 га талбайд улаан буудай тариалж, 1 га-аас 18-31 цн ургац хураан, 100-260 тн үр нөөцөлж, 574-1091 га уринш бэлтгэн , тогтвортой өндөр ургац авч сум орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж байгаа Сант сумын “Монгол газар шим” ХХКомпани.

4.Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн сүүлийн 3 жил эргэлтийн талбайгаа 100 хувь ашиглаж, 2078-2500 га талбайд улаан буудай тариалж, 1 га-аас 15-21 цн ургац хураан, 450-600 тн үр нөөцөлж, 2400-2822 га уринш бэлтгэн , тогтвортой өндөр ургац авч сум орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж байгаа Хүдэр сумын “Ургац хүдэр” ХХКомпани.

5.Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн сүүлийн 3 жил эргэлтийн талбайгаа 100 хувь ашиглаж, 3032-3479 га талбайд улаан буудай тариалж, 1 га-аас 14-21,6 цн ургац хураан, 450-514 тн үр нөөцөлж, 2693-3140 га уринш бэлтгэн , тогтвортой өндөр ургац авч сум орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж байгаа Цагааннуур сумын “Сэлэнгэ тариа” ХХКомпани.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 03-ны өдөр

Дугаар 02

Сүхбаатар

**“Улсын тэргүүний тариаланч”-аар
шагнуулах тухай**

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газраас оруулсан саналыг хэлэлцээд Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 70 дугаар тогтоолоор баталсан журмыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Хариуцсан техникийн засвар үйлчилгээг чанартай хийж тариалангийн үйлдвэрлэлийн технологийг чанд мөрдөн сүүлийн 3 жилд 542-1068 га талбайн ажил гүйцэтгэж, 8911-22520 цн ургац хурааж, 1380-2500 жишмэл га-д уринш бэлтгэж, журамд заасан үзүүлэлтийг 135.5-267 хувиар биелүүлж, өндөр үр бүтээлтэй ажиллаж байгаа Цагааннуур сумын “Баяндулаан Уул” ХХК-ний механикжуулагч Нямжавын Хишигсүрэнг “Улсын тэргүүний тариаланч”-аар шалгаруулан шагнуулахаар Монгол Улсын Засгийн газарт уламжилсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 03-ны өдөр

Дугаар 03

Сүхбаатар

“Улсын сайн малчин”- аар шагнуулах
саналыг дэмжих тухай

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газраас оруулсан саналыг хэлэлцээд Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 70 дугаар тогтоолоор баталсан журмыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Мал сүргээ өсгөн үржүүлэх ажилд олон жилийн хүч хөдөлмөрөө зориулан, сүүлийн 3 жилд 1545-2011 толгой мал хариуцан маллаж, хорогдолгүй онд оруулан 100 эхээс 100-105 төл бойжуулан 12-25 тн мах, 2,0-2,9 тн ноос, 35,7-42,1 мянган литр сүү, 92-123 кг ноолуур үйлдвэрлэж зах зээлд нийлүүлэн 34,6-56,2 сая төгрөгийн борлуулалт хийж, ядуу амьдралтай айл өрхийг малжуулахад зориулан 408 толгой мал өгсөн зэрэг амжилтыг үнэлэн Баянгол сумын малчин Лхамаахүүгийн Батнямыг “Улсын сайн малчин”- аар шалгаруулан шагнуулахаар Монгол Улсын Засгийн газарт уламжилсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 03-ны өдөр

Дугаар 04

Сүхбаатар

**Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд
дэмжлэг үзүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүээр зүйлийн 9.3 дахь хэсгийн заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Тус аймагт тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа амйгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо, аймгийн Ахмадын хороо, Залуучуудын холбоо, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн салбар, аймгийн Ажил олгогч эздийн холбоо, Авилгаас урьдчилан сэргийлэх төрийн бус байгууллагуудын ажлаа явуулах өрөө тасалгаа гарган өгч, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Бүрэнбат/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2013 оны 01 сарын 25-ны өдөр

Дугаар 06

Сүхбаатар

2013 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай
хэрэглээний мод, түлээ бэлтгэх хуваарийг батлах тухай

Ойн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2012 оны А-145 тоот тушаалыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрээс 2013 онд ойгоос бэлтгэх модны огтлолтын төрлөөр тогтоосон дээд хязгаарыг 1 дүгээр хавсралтаар, зориулалтын төрлөөр тогтоосон дээд хязгаарыг 2 дугаар хавсралтаар, Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ойн санд явуулах арчилгаа, цэвэрлэгээний огтлолтын талбай, бэлтгэх модны дээд хязгаарыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тогтоолоор баталсан хязгаарт багтаан ойгоос бэлтгэх модны төрөл, тоо хэмжээг байгууллага бүрээр тогтоон мөрдүүлэхийг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд, сумын Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрийг үндэслэн ойн мэргэжлийн байгууллага, ойн санг гэрээгээр эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагатай үйлдвэрлэлийн болон арчилгааны огтлолтоор мод бэлтгэх гэрээ байгуулж хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Үйлдвэрлэлийн зориулалтаар үндсэн ашиглалт, арчилгааны огтлолтоор бэлтгэх модыг зөвхөн ойн мэргэжлийн байгууллагаар, ахуйн зориулалтаар цэвэрлэгээний журмаар бэлтгэх хэрэглээний мод, түлээг ойн санг гэрээгээр эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, иргэнээр бэлтгүүлэх, иргэдийн ахуйн хэрэгцээний мод түлээний тодорхой хэсгийг сум дундын ойн ангиар бригад зохион байгуулж бэлтгүүлэхийг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт даалгасугай.

4. Ойн сангийн нөөцгүй Сүхбаатар, Жавхлант, Зүүнбүрэн, Орхон, Орхонтуул Сайхан, Шаамар зэрэг сумд нутаг дэвсгэрээс нь мод бэлтгэхээр энэ тогтоолд заасан сумдын Засаг дарга нартай мод бэлтгэх гэрээг тодорхой хугацаагаар байгуулж хоёр тал харилцан үүрэг хүлээж, хяналт тавьж ажиллахыг холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Тусгай хамгаалалтай газраас цэвэрлэгээний журмаар бэлтгэх түлээний модыг Сүхбаатар сумын иргэд, аж ахуйн нэгж байгууллагад олгохыг Тужийн нарсны байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргааны дарга /Д.Бямбаа/-д даалгасугай.

6. Ойн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг удаа дараа зөрчсөн, хууль тогтоомж зөрчсөн талаар иргэдээс удаа дараа гомдол санал ирсэн, 2012 онд улсын болон өөрийн хөрөнгөөр ойжуулалт, байгалийн сэргэн ургалтанд туслах ажил гүйцэтгээгүй болон дутуу хийсэн, аж ахуйн нэгж,

байгууллага, нөхөрлөлдмод бэлтгэх зөвшөөрөл олгохгүй байхыг сумдыниргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт даалгасугай.

7.Мод бэлтгэх эрх, зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн бэлтгэсэн ахуйн хэрэглээний модыг тэдний захиалгаар зүсмэл материал болгох үйлчилгээ үзүүлэх нэгжийг сум бүрт бий болгон зөвшөөрөл олгож ажиллуулахыг сумдын Засаг дарга, аймгийн Мэргэжлийн хяналтын газарт даалгасугай.

8.Мод бэлтгэх эрх зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөл, иргэний мод бэлтгэх, тээвэрлэх үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдүүлэн, хатуу хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга, сум дундын ойн анги, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт тус тус үүрэг болгосугай.

9.Ойгоос мод бэлтгэх ажлыг холбогдох заавар журмын дагуу гүйцэтгүүлж, бэлтгэсэн модны 100 м³ тутамд өөрийн хөрөнгөөр 3 га талбайд ойг тарьж ургуулах ажлыг гүйцэтгүүлэхийг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газарт үүрэг болгосугай

10.2013 онд сумдад хуваарилсан үйлдвэрлэлийн зориулалттай хэрэглээний модны бэлтгэл, зарцуулалтын дүнг нэгтгэж 2013 оны 4-р улиралд багтаан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Б.Батзориг/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Сумдад 2013 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаар зориулалтаар /шоо.метр/

№	Сумын нэр	Бэлтгэх сумын нэр	Огтлолтын төрөл									Хэрэглээний мод м3		Түлээ /м3/	Дүн	Гүйцэтгэх ажил /га/
			Үйлдвэрийн ашиглалт /м3/			Арчилгааны /м3/			Цэвэрлэгээний /м3/			Үйлдвэрлэлийн хэрэглээний	Ахуйн хэрэгцээний			
			Үйлдвэрлэлийн хэрэглээний	Түлээний	Дүн	Ахуйн хэрэгцээний	Түлээний	Дүн	Ахуйн хэрэгцээний	Түлээний	Дүн					
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
1	Алтанбулаг	өөрийн нутгаас							500	5000	5500		500	5000	5500	15
2	Баруунбүрэн	өөрийн нутгаас				500			500	2000	2500		1000	2000	3000	30
3	Баянгол	өөрийн нутгаас							500	3200	3700		500	3200	3700	15
4	Ерөө	өөрийн нутгаас	7305	1289	8594	1600	2400	4000	6100	5200	11300	7305	7700	8889	23894	450,15
5	Жавхлант	Ерөө сумын нутгаас							500	2000	2500		500	2000	2500	15
6	Зүүнбүрэн	Цагааннуур сумаас							500	1000	1500		500	1000	1500	15
		Түшиг сумаас								1000	1000			1000	1000	
7	Мандал	өөрийн нутгаас	5270	930	6200	3800	5700	9500	5842,5	23370	29212,5	5270	9642,5	30000	44912,5	447,375
8	Орхон	Баруунбүрэн сумаас							500	1000	1500		500	1000	1500	15
		Сант сумын нутгаас								1000	1000			1000	1000	

9	Орхонтуул	Баруунбүрэн сумаас							500	2000	2500		500	2000	2500	15
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
10	Сайхан	Баруунбүрэн сумаас							1250	5000	6250		1250	5000	6250	37,5
11	Сант	Өөрийн нутгаас				500			500	2000	2500		1000	2000	3000	30
12	Сүхбаатар	Алтанбулаг сумаас								20000	20000			20000	20000	
		Түшиг сумаас								10500	10500			10500	10500	0
13	Түшиг	Өөрийн сумаас	1600	282	1882	2000	3000	5000	2400	2000	4400	1600	4400	5282	11282	180
14	Хушаат	өөрийн нутгаас				2550	450	3000	512,5	2050	2562,5		3062,5	2500	5562,5	91,875
15	Хүдэр	өөрийн нутгаас	4105	900,88	6006	5200	2000	7200	1800	2100	3900	4105	7000	5000,88	16105,88	333,15
16	Цагааннуур	өөрийн нутгаас	5400	600	6000	800	1200	2000	1800	3000	4800	5400	2600	4800	12800	240
17	Шаамар	Цагааннуур сумаас							500	2000	2500		500	2000	2500	15
	Нийт		23680	4001,88	28682	16950	14750	30700	24205	95420	119625	23680	41155	114171,88	179006,9	1945,05
	Үлдэгдэл		9725	1893,12	11618	45,2	10743	5988	870	4880	2650	9725	915,2	17516	28156,12	

	Хуш /хуурай/	М3														4212,5				4212,5
Бүх дүн		М3	5500	30500	2500	23894	16106	2500	12800	11282	5562,5	2500	2500	2500	3700	44912,5	6250	3000	3000	179007

_____oOo_____

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2013 оны 1 дүгээр сарын 25-ны
өдрийн 06 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

**2013 онд Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн газар нутгийн ойн
санд явуулах арчилгаа, цэвэрлэгээний огтлолтын талбай, бэлтгэх модны
дээд хязгаар**

№	Улсын тусгай хамгаалалттай газрын нэр	Арчилгааны огтлолт	Ойн цэвэрлэгээ		Нийт	
		Талбай /га/	Талбай /га/	Нөөц /м3/	Талбай /га/	Нөөц /м3/
1	Тужийн нарсны БЦГ	10	50	1000	60	1000

Тайлбар: Арчилгааны огтлолтоор гарах модыг ашиглах нөөцөд тооцоогүй, ойн цэвэрлэгээгээр 1 га талбайгаас 20-25 шоо.метр модон материал авч ашиглахаар тооцсон болно.

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 25-ны өдөр

Дугаар 07

Сүхбаатар

Төлөвлөгөө батлах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг тухайн ажлыг хариуцах Тэргүүлэгч, Бодлогын хороо, холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж цаг хугацаанд нь бүрэн биелүүлж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /О.Буянтогтох/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 2013 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн жилд дэвшүүлсэн зорилт

- 1 Аймаг, сумын ИТХ-ын дарга, Тэргүүлэгч, Төлөөлөгчдийн сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж тэдний хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж Хурлын чадавхийг бэхжүүлэх.
- 2 Аймаг, сумын ИТХ-ын 2012-2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Хурлын сонгуультан, иргэд, олон нийтийн оролцоог ханган боловсруулж, хэлэлцэн баталж сонгуулийн бүрэн эрхийн хугацааны зорилго, зорилтоо тодорхойлох.
- 3 Шийдвэр гаргахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч нутаг дэвсгэрийн эдийн засаг нийгмийн хөгжил, төсөв болон иргэдийн амьдрал, ашиг сонирхолд нөлөөлөх асуудлыг иргэдээр хэлэлцүүлэн, тэдний саналыг тусган шийдвэрлэж байх.
- 4 Хурлын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа зарим дүрэм, журмуудыг шинээр гарсан хуулиудад нийцүүлэн шинэчлэн боловсруулж батлан мөрдүүлэх.
- 5 Аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдээс гаргасан дунд хугацааны хөтөлбөрүүдийн биелэлтийн явц, үр дүнг тооцон үнэлж дүгнэх.
- 6 Хурлын үйл ажиллагаа, шийдвэрийн талаар иргэдэд тогтмол мэдээлэл түгээж байх.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Нэг.Хурлын зохион байгуулалтын үйл ажиллагаа

А.Аймгийн ИТХ-ын хуралдаан

	Аймгийн ИТХ-ын III хуралдааны бэлтгэлийг ханган хуралдуулж доорхи асуудлуудыг хэлэлцүүлэх	II сард	Тэргүүлэгчид
1	Аймгийн ИТХ-ын бодлогын хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай	II сард	Ж.Санжжав
2	Аймгийн ИТХ-ын 2012-2016 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний төсөл	II сард	О.Буянтогтох
3	Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр	II сард	Ж.Санжжав
	Аймгийн ИТХ-ын IV хуралдааны бэлтгэлийг ханган хуралдуулж доорхи асуудлуудыг хэлэлцүүлэх	IV сард	Тэргүүлэгчид
1	Төрийн үйлчилгээний шударга, шуурхай, нээлттэй байдлыг хангаж, чанар хүртээмжийг сайжруулах хөтөлбөр /төлөвлөгөө/ батлах тухай	IV сард	Ж.Санжжав С.Бүрэнбат
2	Таримал ургамлыг мал, амьтнаас хамгаалах журмын төслийн шинэчилсэн найруулга	IV сард	С.Бүрэнбат
	Аймгийн ИТХ-ын V хуралдааныг бэлтгэлийг ханган хуралдуулж доорхи асуудлуудыг хэлэлцүүлэх	XI сард	Тэргүүлэгчид
1	Аймгийн эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтын тухай	XI сард	С.Бүрэнбат Эдийн засаг, хөгжлийн бодлогын хороо

2	Аймгийн 2014 оны төсвийн төсөл	XI сард	С.Бүрэнбат Төсвийн бодлогын хороо
3	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны ажлын тайлан	XI сард	Ж.Санжжав Нутгийн удирдлага, хууль хяналтын бодлогын хороо

Б.Тэргүүлэгчдийн хуралдаан

	Тэргүүлэгчдийн хуралдааныг сард 1-ээс доошгүй удаа бэлтгэлийг ханган хуралдуулж доорхи асуудлуудыг хэлэлцүүлэх	Сар бүр	Тэргүүлэгчид
1	Аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдийн 2013 оны ажлын төлөвлөгөө	I сард	О.Буянтогтох
2	2013 онд ойгоос бэлтгэх модны дээд хэмжээ тогтоох тухай	I сард	С.Бүрэнбат
3	2013 онд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээг батлах тухай	II сард	П.Батсайхан
4	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын 2012 оны ажлын тайлан	II сард	Ж.Санжжав
5	Сурын спортыг хөгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай	III сард	О.Буянтогтох
6	Сумын болон өрхийн эмнэлгүүдийн эмчилгээ үйлчилгээний байдал, цаашдын зорилтын тухай аймгийн ЭМГ-ын даргын илтгэл	III сард	Ч.Жаргалсайхан

7	Сэлэнгэ аймгийн нутагт ашигт малтмал олборлож байгаа Болд төмөр Ерөө гол, Бороо Гоулд, Рэдхилл Монголиа компаниудын захирлуудын мэдээлэл	IV сард	Ж.Санжжав
8	Аймгийн ИТХ, Тэргүүлэгчдээс газар тариалангийн талаар гаргасан тогтоол шийдвэрүүдийн биелэлтийн явц, үр дүнгийн тухай аймгийн ХХААЖДҮГ-ын даргын мэдээлэл	IV сард	Б.Пүрэвсүрэн
9	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн тухай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын мэдээлэл	V сард	Б.Энхбат
10	“Орон сууц” хөтөлбөрийн төсөл	VI сард	С.Бүрэнбат
11	Аймгийн нутаг дэвсгэрт загасны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах тухай /тогтоол, журам/	VIII срд	Ш.Оргил
12	Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль болон аймгийн ИТХ-аас мал аж ахуйн талаар гаргасан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх талаар зохиож байгаа ажлын тухай Орхонтуул сумын Засаг даргын илтгэл	IX сард	Ч.Жаргалсайхан
13	Халамжийн үйлчилгээг хэрхэн зохион байгуулж байгаа тухай аймгийн Халамж үйлчилгээний хэлтсийн даргын сонсгол	X сард	Б.Нарантуяа
14	Хүний эрхийг хангах төлөвлөгөөний биелэлтийн тухай аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн	XI сард	С.Бүрэнбат

даргын мэдээлэл

В.Хяналт шалгалтын ажил

1	Сумдын ИТХ-ын 2012 оны тайланд хяналт шинжилгээ үнэлгээ хийх	II сард	Ажлын алба
2	Сумын ИТХ, түүний Тэргүүлэгчдийн ажлыг шалган танилцаж мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх	Улирал бүр	Ажлын алба
	○ Алтанбулаг, Ерөө, Жавхлант, Хүдэр суманд	I улирал	Ажлын алба
	○ Баруунбүрэн, Орхон, Орхонтуул, Сайхан, Сант суманд	II улирал	Ажлын алба
	○ Зүүнбүрэн, Түшиг, Цагааннуур, Хушаат суманд	III улирал	Ажлын алба
	○ Баянгол, Мандал, Сүхбаатар, Шаамар суманд	IV улирал	Ажлын алба
3	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтын байдлыг Ерөө, Сант, Зүүнбүрэн, Сайхан сумдад шалгах	I улиралд	Төсвийн бодлогын хороо Орон нутгийн өмчийн алба
4	Аймгийн ИТХ-аас эрүүл мэндийн талаар гаргасан тогтоол шийдвэрийн биелэлтийг аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Цагааннуур, Сайхан сумдад шалгах	III сард	Нийгмийн бодлогын хороо
5	Жимс жимсгэнэ, Чацаргана хөтөлбөрийн биелэлтийн явц, үр дүнг	V сард	Үйлдвэр, хөдөө аж

	Баянгол, Зүүнбүрэн, Шаамар, Сүхбаатар суманд шалгах		ахуйн бодлогын хороо
6	Эмийн сангуудын үйл ажиллагаа болон эм хангамж, хүртээмж, үнийн асуудлыг хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн салбартай хамтран шалгах	VI сард	Нийгмийн бодлогын хороо
7	Усны тухай хууль, аймгийн Ус хөтөлбөрийн биелэлтийг Ерөө, Хүдэр суманд шалгах	IX сард	Байгаль орчин, уул уурхай, газрын бодлогын хороо
8	Нийгмийн дэг журам хөтөлбөр, аймгийн ИТХТ-ийн 2012 оны 107 дугаар тогтоолын биелэлтийг сумдад шалгах	IX сард	Нутгийн удирдлага, хууль хяналтын бодлогын хороо
9	Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, сумын хөгжлийн сангийн зарцуулалтын байдлыг Сүхбаатар, Мандал, Жавхлант суманд шалгах	X сард	Төсвийн бодлогын хороо
10	Хурлын бодлогын хороо, багийн ИНХ-ын ажлын байдлыг 3-аас доошгүй суманд шалган танилцаж дүгнэлт хийх	XI сард	Ажлын алба

Г.Орон нутаг, иргэдтэй ажиллах талаар

1	Хурлын Тэргүүлэгчид бүрэн бүрэлдэхүүнээрээ зарим сум, багийн ажил амьдралтай танилцаж, иргэдтэй уулзан санал хүсэлтийг сонсох	Жилдээ	Тэргүүлэгчид
	○ Орхонтуул, Сайхан, Баруунбүрэн суманд	IV сард	Тэргүүлэгчид
	○ Зүүнбүрэн, Шаамар суманд	X сард	Тэргүүлэгчид

2	Хурлын төлөөлөгчдийг сонгогдсон сум, багт нь ажиллуулж Хурлын шийдвэр, үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч санал хүсэлтийг сонсох	Улирал бүр	Ж.Санжжав
3	Аймгийн ИТХ-ын 2012-2016 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт орон нутаг, иргэдээс санал авах	Х сард	Тэргүүлэгчид ЗДТГ
4	Орон нутаг, иргэдийн ажил амьдралын тулгамдсан асуудал болон хуралдаанаар хэлэлцэх зарим асуудлаар иргэний танхимын хэлэлцүүлэг зохион байгуулах	Улирал бүр	О.Буянтогтох
5	ЗЗНДНТУТХуулийг өөрчлөх, шинэчлэх асуудлаар Хурлын ажилтан, сонгуультан, иргэдийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, гарсан саналыг нэгтгэн боловсруулж УИХ, Засгийн газарт тавих	II улиралд	Ж.Санжжав Ажлын алба
6	Хүүхдийн хүмүүжилд эцэг эх, гэр бүлийн гүйцэтгэх үүрэг, оролцоо сэдэв боловсруулж багийн ИНХ-аар хэлэлцүүлэх	V сард	Б.Нарантуяа

Д.Судалж боловсруулах асуудал

1	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны дэгийг шинэчлэн боловсруулах	I сард	Ажлын алба
2	Аймаг, сумдын Хурлын төсөвт судалгаа хийж асуудал боловсруулан аймгийн	II сард	Ж.Санжжав

Засаг дарга, Сангийн Яаманд тавих

- | | | | |
|---|---|----------|------------|
| 3 | Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын төсөл | II сард | Ж.Санжжав |
| 4 | Багийн ИНХ-ын хуралдааны үлгэрчилсэн дэгийн төсөл боловсруулах | III сард | Ажлын алба |
| 5 | Тохижилт, ариун цэвэр, цэвэрлэгээний талаар албан байгууллага, иргэдээс дагаж мөрдөх журам | V сард | |
| 6 | Малын төрөлжсөн зах байгуулах асуудлыг судалж боловсруулах | VI сард | Г.Бямбаа |
| 7 | Нийтийн эзэмшлийн өмч хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэн авах, бүртгэлээс хасах журмын төсөл | IX сард | С.Бүрэнбат |
| 8 | Сүхбаатар хотод агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого судалгаа хийх, агаарын бохирдлыг бууруулах бодлогын санал боловсруулах | IX сард | Ш.Оргил |

Е.Мэдээлэл сурталчилгааны ажил

- | | | | |
|---|--|-----------|------------|
| 1 | Аймгийн ИТХ, Тэргүүлэгчдээс 2012 онд гаргасан тогтоол шийдвэрийг эмхтгэл болгон хэвлүүлж сум, баг, номын сангуудад хүргүүлэх | I улиралд | Ажлын алба |
| 2 | Аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны талаар хэвлэлийн бага хурал хийж иргэд, олон нийтэд мэдээлж байх | Сар бүр | Ж.Санжжав |

- | | | | |
|---|--|------------|------------|
| 3 | Аймгийн ИТХ, Тэргүүлэгчдээс гаргасан шийдвэрийг орон нутгийн хэвлэлд нийтэлж, ханын самбарт тавьж байх | Сар бүр | Ажлын алба |
| 4 | Аймгийн ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалт, зарим шийдвэрийн төслийг нийтэд мэдээлэх, санал авах ажлыг зохион байгуулах | Улирал бүр | Ажлын алба |
| 5 | Аймгийн ажил байдал, хурлын шийдвэр, үйл ажиллагааны талаар Хурлын төлөөлөгчдөд мэдээлэл бэлтгэн өгч байх | Улирал бүр | Ажлын алба |

Ж.Сургалт семинар

- | | | | |
|---|---|--------------|--|
| 1 | Сумын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нарын сургалт | I сард | О.Буянтогтох |
| 2 | Газрын болон байгаль орчны тухай хуулиудаар аймаг, сумдын ИТХ-ын төлөөлөгчдийн сургалт зохион байгуулах | II, III сард | Аймаг, сумын ИТХ-ын
Тэргүүлэгчид
ГХБХБГазар
БОАЖГазар |
| 3 | Сумдын ИТХ-ын төлөөлөгчдийн сургалтыг МНУХ-той хамтран зохион байгуулах | Жилдээ | Ажлын алба |
| 4 | Багийн ИНХ-ын дарга нарын сургалтыг зохион байгуулах | IX сард | Ажлын алба |
| 5 | Сумын ИТХ-ын дарга нарыг удирдах ажилтны манлайллын сургалтанд хамруулах | X сард | Ж.Санжжав |

6	Сар бүрийн эхний 7 хоногийн баасан гаригт ажлын албаны ажилтнуудын сургалт зохион байгуулж хэвших	Сар бүр	О.Буянтогтох
7	Хурлын сонгуультан, ажилтнуудад зориулсан гарын авлага бэлтгэж гаргах	Улирал бүр	Ажлын алба
8	Аймаг, сумын Хурлын Төлөөлөгчдийн уншиж судлах зүйлийн жагсаалт гарган гарын авлага бэлтгэн өгч судлуулах	I улиралд	Ж.Санжжав
9	Монгол Улсын Ерөнхийлагчийн сонгуулийн хууль сурталчлах, сонгуулийн бэлтгэлийг хангаж зохион байгуулах асуудлаар семинар хийх	V срд	Тэргүүлэгчид
10	Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх асуудлаар хурлын төлөөлөгчдөд зориулан сургалт зохион байгуулах	IX сард	Ж.Санжжав

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 25-ны өдөр

Дугаар 08

Сүхбаатар

Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай

Орхон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тавьсан саналыг хэлэлцээд Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан журмын 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Орхон сумын эрүүл мэндийн төв үүсч байгуулагдсаны 70 жилийн ойг 2013 оны 7 дугаар сард тэмдэглэхийг зөвшөөрсүгэй.

2.Ойгоо угтаж хамт олны идэвх санаачилгыг өрнүүлэн байгууллага, орчноо тохижуулах, ажиллагсдын ажиллах нөхцөл боломжийг сайжруулах талаар тодорхой бүтээлч ажил зохион байгуулахыг тус эрүүл мэндийн төвийн удирдлагад даалгаж, хамт олонд уриалсугай.

3.Ой угтсан ажил болон ой тэмдэглэх арга хэмжээнд удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдын Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргад үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 25-ны өдөр

Дугаар 09

Сүхбаатар

Зөвшөөрөл олгох тухай

Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1.Сайхан сумын Хөтөл хотод Христийн шашны “Долоо дахь өдрийн адвентист” сүм байгуулж, дүрмийн дагуу шашны үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг 1 жилийн хугацаагаар олгосугай.

2.Сүмийн дүрэмд орсон өөрчлөлтийг тухай бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд мэдэгдэж, үйл ажиллагааныхаа тайланг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд жил бүр ирүүлж байхыг сүмийн ахлагчид зөвлөсүгэй.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 02 сарын 21-ний өдөр

Дугаар 17

Сүхбаатар

Соёлын өвийг бүртгэх тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8,2 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1.Аймгийн Морин спорт уяачдын холбооны санал санаачилга, хүч хөрөнгөөр Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын төв цэнгэлдэх хүрээлэнгийн өмнөх талбайд бүтээн босгосон Сэлэнгэ нутгийн бахархал болсон домогт хурдан хүлэг “Буган халиун” морины хөшөөгаймгийн хамгаалалтад байх соёлын өвийн бүртгэлд оруулсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 04-ний өдөр

Дугаар 19

Сүхбаатар

2013 онд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт,
байршил, хэмжээг батлах тухай

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2-т заасныг үндэслэн аймгийн Засаг даргаас оруулсан саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Аймгийн хэмжээнд 2013 онд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээг 1 дүгээр хавсралтаар сум тус бүрээр баталсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

ИРГЭНД 2013 ОНД ӨМЧЛҮҮЛЭХ ГАЗРЫН НИЙТ ХЭМЖЭЭ, БАЙРШИЛ, ЗОРИУЛАЛТ

д/д	Сумын нэрс	Өмчлүүлэх газрын байршил	Иргэнд өмчлүүлэх газрын нийт хэмжээ /га-гаар/	Өмчлүүлэх газрын зориулалт / га-гаар /							
				Иргэнд үнэгүй өмчлүүлэх газрын нийт хэмжээ	Үүнээс			Аж ахуйн зориулалтаар	Үүнээс		
					Одоо эзэмшиж байгаа газрын нийт хэмжээ	Шинээр өмчлүүлэх газрын нийт хэмжээ	Улсын чанартай авто замын дагуу өмчлүүлэх газрын нийт хэмжээ		Үр тарианы	Төмс, хүнсний ногооны	Газар тариалангийнхаас бусад аж ахуйн
А	1	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Алтанбулаг	Сумын төв	8,21	8,21	8,21			0			
		Солдатын зүүн хэсэг	170,4	170,4		170,4					
		Сумын төв Партизаны 9-р гудамжны урд	2,53	2,53		2,53					
		Сүхбаатар сумын 5-р багийн гэр хорооллын зүүн талд	3	3		3					
		Цэнхрийн булан	37,38	37,38				37,38			

		Номтын амын баруун хэсэг	12,25	12,25			12,25				
		Хиагтын хоолойгоос Сэлэмт хүртэл	13,58	13,58			13,58	0			
		Хөх өндөр	95	0				95	95		
		Хутаг өндөр	78	0				78	78		
		Хадат	75	0				75	75		
		Баруун хиагт	5	0				5		5	
		Солдат толгой	5	0				5		5	
		Хонд	6	0				6		6	
		Сумын төв, Найрамдлын гудамж, Хилийн боомтын дэргэд	5,5	0				5,5			5,5
		Хонд	0,5	0				0,5			0,5
сумын дүн			517,35	247,35	8,21	175,93	63,21	270	248	16	6
2	Баруунбүрэн	Шар хаданд	1,8	1,8	1,2	0,6		0			
		Фермерийн хороололд	2,2	2,2	1,5	0,7		0			
		Өндөр хороололд	3,6	3,6	2,6	1		0			
		Цагаан овоо	6,6	6,6	1,7	4,9		0			
		Усжуулах	7,8	7,8		7,8					
сумын дүн			22	22	7	15	0	0	0	0	0
3	Баянгол	Гонирын 14-р гудамжнаас хойш талбай	3	3		3		0			
		212-р зөрлөгийн төвд	2	2		2		0			
		221-р зөрлөгийн төвд	6,8	6,8	1,8	5		0			
		ТЗ-ын 8 байшин	0,87	0,87	0,87						

Будааны энгэрт	0,56	0,56	0,56						
Зүүнхараагийн замын урд	1,4	1,4			1,4	0			
Дэрстэйд айлуудын зүүн урд	1	1		1		0			
Төв замын зүүн тал Эрдэнэт-Орчлон ХХК-ны талбайгаас урагшаа	2	2			2	0			
Гонир багийн гудамж хоорондын сул зай	0,8	0,8		0,8		0			
Хуучин үйлдвэрийн урд жалганы 2 талд	2	2		2		0			
Цагаанчулуут төв замын урд	1	1			1	0			
179-р зөрлөг	2,8	2,8		2,8		0			
Эрхэт өртөө	4,61	4,61	1,61	3		0			
Сумын төв төв замын баруун талд									
Сумын төвд төв замын зүүн талд									
Загдалын голын хойд талд	1	1	1						
Сэтэрхий хөтөлийн урд энгэрт төв замын баруун талд	0,61	0,61			0,61	0			
Баянголын гүүрний орчимд төв замын баруун талд	4	4			4	0			
ТЗ-ын 196-р км замын зүүн хойд	8	8		8		0			

		талд								
		Зүүнхараагийн замын хойд талаар	3,79	3,79		3,79		0		
		Баян багийн гудамж хоорондын сул зай	0,6	0,6		0,6		0		
		Баянголын гүүрнээс урагшаа төв замын зүүн талд	4	4			4	0		
		Шарын голын замын уулзвараас урагшаа гүүр хүртэл төв замын зүүн талд	2	2			2	0		
		Дээжийн энгэрийн 1,2,3-р хэсэгт	0,41	0,41	0,41			0		
сумын дүн			53,25	53,25	6,25	31,99	15,01	0	0	0
4	Ерөө	Буурагчин баг Дэр эхийн хэсэг	18	18		18		0		
		Буурагчин багийн гэр хороолол	18	18	18			0		
		Тавин баг Гангын тохойд	14,4	14,4		14,4		0		
		Тавин багийн гэр хороолол	3	3	3			0		
		Бугант тосгон ходоодын хэсэгт	36	36		36		0		
		Ходоод жууцайн дов	7	7	7			0		
		Ходоодын замын зүүн талд	45	45	45			0		
		Өлөнт	2,4	2,4	2,4			0		

		Чулуутын 2-р хэсэг горхины цаана	6	6	6			0			
		Төвийн 1-р хэсэг	1,2	1,2	1,2			0			
		Ферм	2,4	2,4	2,4			0			
		Булгийн тохой	1,8	1,8	1,8			0			
сумын дүн			155,2	155,2	86,8	68,4	0	0	0	0	0
5	Жавхлант	Сумын төв	3,6	3,6	3,6			0			
		Сумын төв	6	6		6		0			
		Шарын голын тосгон	3,5	3,5		3,5		0			
		Сумын төв	0,05	0				0,05			0,05
сумын дүн			13,15	13,1	3,6	9,5	0	0,05	0	0	0,05
6	Зүүнбүрэн	Бэлчир 2-р баг	2,8	2,8		2,8					
		Бэлчир багийн Хойд хороолол	3	3	3						
		Жаргалант 1-р баг	3,5	3,5		3,5					
		Жаргалант толгойд	17,5	17,5		17,5					
		Бойны дов	7,5	7,5		7,5					
		Гахайн байр	12,5	12,5	12,5						
сумын дүн			46,8	46,8	15,5	31,3	0	0	0	0	0
7	Мандал	Төмөр зам 1-р баг	10	10	10			0			
		Ширхэнцэг 2-р баг	28	28	8	20		0			
		Баянсуудал 3-р баг	25	25	25			0			
		Хэрх 4-р баг	28	28	10	18		0			

		Түнхэл 5-р баг	16,9	16,9	8	8,9		0			
		Баянхангай 6-р баг	7,6	7,6	5	2,6		0			
		Минжийн хангай 7-р баг	10	10	10			0			
		Тарни 8-р баг	10	10	10			0			
		Баян арцат 9-р баг	8	8	8			0			
сумын дүн			143,5	143,5	94	49,5	0	0	0	0	0
8	Орхон	Сумын төв	18	18	10	8		0			
		Бэлэндалай	1	1		1		0			
		Цант	1,4	1,4		1,4		0			
		Шийр	7,25	7,25	6	1,25		0			
		Овоот	4,9	4,9	3,5	1,4		0			
		Жимстэйд	1,75	1,75		1,75					
		Дархан Эрэнэтийн зам дагуу	21	21			21	0			
		Сэртэнгийн хөндий	5,4	5,4	4		1,4	0			
сумын дүн			60,7	60,7	23,5	14,8	22,4	0	0	0	0
9	Орхонтуул	Гуртын хороолол	8,42	8,42	1,8	6,62					
		Дөхөм хороолол	6	6	1,03	4,97					
		Хонхор хороолол	2,59	2,59	2,07	0,52					
		Бор толгойн хороолол	2,42	2,42	2	0,42					
		Туулын дэнжид	1,81	1,81	1,51	0,3					

		Дэлийн хороолол	4,18	4,18	1,66	2,52					
сумын дүн			25,42	25,42	10,07	15,35	0	0	0	0	0
10	Сайхан	Овоот хороолол	18,9	18,9	1,4	17,5		0			
		Дөмбөн хороолол	10,5	10,5		10,5		0			
		Номгон хороолол	26,3	26,3	3,6	22,7		0			
		Ширээ нуруу	46,3	46,3	6,3	40		0			
		Ногоон модны гүүр	1,6	1,6	0,6	1		0			
сумын дүн			103,6	103,6	11,9	91,7	0	0	0	0	0
11	Сант	Төвийн хороолол	1,4	1,4	1,4	0	0				
		Дээд хороолол	1	1	1	0	0				
		Бургасны хороолол	1,11	1,11	0,48	0,63	0				
		Цагаан толгойн баруун энгэрт	2,5	2,5	0	2,5	0				
		Зэгстэй, гурамсан	14	14	0		14				
сумын дүн			20,01	20,01	2,88	3,13	14	0	0	0	0
12	Сүхбаатар	<i>1-р баг Хонгор морьт</i>	6	6	1	5					
		<i>2-р баг Могойтийн ам</i>	1,35	1,35	1	0,35					
		<i>3-р баг Салхитын ам</i>	2	2	2						
		<i>8-р баг мал эмнэлгийн хойд талаар</i>	28,48	28,48	3	25,48					

		5-р баг Бор гүвээ, Бойны тохой	13	13	3	10					
сумын дүн			50,83	50,83	10	40,83	0	0	0	0	0
13	Түшиг	1, 2-р багийн 1-4р хэсэг	3,8	3,8	3,8			0			
		1, 2-р багийн урд	3,5	3,5		3,5		0			
		Байв	7	7		7		0			
		Хүүхдийн овоо	10,5	10,5		10,5		0			
сумын дүн			24,8	24,8	3,8	21	0	0	0	0	0
14	Хушаат	Орхон хороолол	0,18	0,18		0,18					
		Ишгэнт хороололын ард	18	18	18						
		Рашаантын адаг	16	16	16						
сумын дүн			34,18	34,18	34	0,18	0	0	0	0	0
15	Хүдэр	Горбушкин найрамдал, Согоот	3	3	3			0			
		Баянцагаан 2-р хороолол	3	3	3			0			
		Сөдтэйд	60	60		60		0			
		Гахайны байрны урд	10	10		10		0			
сумын дүн			76	76	6	70	0	0	0	0	0

16	Цагааннуур	Хуурч	6	6		6		0			
		Тийрэг	9	9		9		0			
		Сумын төв	1	0				1			1
		Баянхангай Оргих	5	0				5		5	
сумын дүн			21	15	0	15	0	6	0	5	1
17	Шаамар	Сүхбаатар сум хорооллын урд хогийн хонхроос урагш талбайд	15	15		15					
		Шаамар 6, Цагдаагийн амралтын хойд хэсэг	10	10		10					
		Дэнж хойд хэсэг	10	10		10					
		Дэнж	5,2	5,2	0,2	5					
		Зөгий	0,32	0,32	0,32						
		Царам	0,21	0,21	0,21						
		3-р хороо	1	1	1						
		Малчны хороо	0,2	0,2	0,2						
		Дэнж зам дагуу	0,52	0,52	0,52						
		34-р км	3,5	3,5	1	2,5					
		49-р км	5,5	5,5	0,5	5					
		Хонхор	5,3	5,3	1,3	4					
		Ногооны талбайн хэсэг	2,5	2,5	2,5						
сумын дүн			59,25	59,25	7,75	51,5	0	0	0	0	0
Аймгийн хэмжээнд			1427,04	1150,99	331,26	705,11	114,62	276,05	248	21	7,05

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2013 оны 03 сарын 15-ны өдөр

Дугаар 28

Сүхбаатар

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын 2012 оны үйл ажиллагааны тухай

Орон нутгийн өмчит Сайхан сумын “Гавшгай ус”, Мандал сумын “Цант Орхон”, Сүхбаатар сумын “Урсгал ус”, “Сэлэнгэ энерго”, “Тариалан эрхлэлтийг дэмжих дундын үйлчилгээний техникийн төв”, “Сэлэнгэ үйлчилгээ” үйлдвэрийн газруудын 2012 оны үйл ажиллагааны тайланг аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ НЬ:

Орон нутгийн өмчит эдгээр үйлдвэрийн газрууд өөрийн чиг үүргийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага, айл өрх иргэдийн ажил амьдралын амин чухал хэрэгцээт үйлчилгээг хэвийн хэмжээнд гүйцэтгэж ирсэн байна.

Гэвч эдгээр байгууллагуудын үйл ажиллагаанд анхаарах хүндрэл бэрхшээлтэй асуудал цөөнгүй байна.

2012 оны санхүүгийн тайлан балансаар “Гавшгай ус”ХХК 847,1 сая төгрөгийн авлага, 638,9 сая төгрөгийн өглөгтэй, 91,1 сая төгрөгийн алдагдалтай, “Урсгал ус” компани 579,2 сая төгрөгийн авлага, 420,6 сая төгрөгийн өглөгтэй, 22,0 сая төгрөгийн алдагдалтай, “Цант Орхон” компани 19,3 сая төгрөгийн авлага, 4,7 сая төгрөгийн өглөгтэй, 11,4 сая төгрөгийн алдагдалтай, “Сэлэнгэ энерго”үйлдвэрийн газар 221,7 сая төгрөгийн авлага, 798,4 сая төгрөгийн өглөгтэй, 190,0 сая төгрөгийн алдагдалтай, Тариалан эрхлэлтийг дэмжих дундын үйлчилгээний техникийн төв 23,1 сая төгрөгийн авлагатай байна.

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын эдийн засаг, санхүүгийн байдал хүндэрч, үйл ажиллагаа нь өнөө, маргаашийг аргацаах төдий явагдаж байгаад дүгнэлт хийж бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, менежментийг сайжруулах, техник технологийн шинэчлэл хийх, үнэ тарифийг шинэчлэх, өр, авлагыг шийдэх зэрэг олон асуудлуудыг судалж шийдвэрлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Байгууллагынхаа үйл ажиллагаа, эдийн засаг, санхүүгийн байдалд бодитой дүгнэлт хийж бүтэц зохион байгуулалтаа боловсронгуй болгох, менежментээ сайжруулах, зардал хэмнэх, орлого ашгаа нэмэгдүүлэх, өр авлагаа барагдуулах талаар санаачилга гарган эрс өөрчлөлт хийж ажиллахыг “Гавшгай ус”, “Урсгал ус”, “Цант Орхон”, “Сэлэнгэ энерго”, Тариалан эрхлэлтийг дэмжих дундын үйлчилгээний техникийн төв, “Сэлэнгэ үйлчилгээ” Орон нутгийн өмчийн үйлдвэрийн газруудын Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосугай.

Хоёр. Аймгийн Засаг даргад ДААЛГАХ НЬ:

1.Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох менежментийг сайжруулах бодлого зохицуулалтын арга хэмжээ авч үйл ажиллагаанд нь тавих хяналтыг сайжруулах.

2.Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудаас эрхлэх асуудлынхаа хүрээнд иргэд байгууллагуудад үзүүлэх үйлчилгээг хэвийн явуулахад зайлшгүй

шаардлагатай байгаа техник, тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг жил бүрийн төсөвт тусган ээлж дараатай шийдвэрлэх.

3.Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудад үүссэн өр, авлагыг барагдуулах, өртөг зардлыг хямдруулах, мөрдөж байгаа үнэ тарифыг бодитой тогтоох асуудлыг судалж шийдвэрлэх.

4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдтэй жил бүр гэрээ байгуулан дүгнэж гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн, өмч хөрөнгийг зориулалтын бусаар ашигласан, үрэгдүүлсэн, шамшигдуулсан хүмүүст хариуцлага тооцож ажиллах.

5. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын ТУЗ-ийг хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх санал боловсруулж энэ оны 4 дүгээр сард багтан Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулах.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 15-ны өдөр

Дугаар 29

Сүхбаатар

**Орон нутгийн Сэлэнгэ телевизийг өөрчлөн
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “ж” заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Орон нутгийн Сэлэнгэ телевизийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хэвлэл мэдээллийн алба болгон өөрчлөн байгуулсугай.

2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хэвлэл мэдээллийн албаны дүрмийг боловсруулан Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулан батлуулахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /О.Буянтогтох/-д даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1999 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 04 сарын 16-ны өдөр

Дугаар 31

Сүхбаатар

Комисс байгуулах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн сайдын 2012 оны А/44 дүгээр тушаалыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор арилжааны банкаар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгох төслийг сонгон шалгаруулах аймгийн комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга	
С.Бүрэнбат	-Аймгийн Засаг дарга
Дэд дарга	
Л.Зоригтбаатар	-Хөдөлмөрийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга	
Г.Бат-Яруу	-Хөдөлмөрийн хэлтсийн жижиг дунд үйлдвэрийн бодлого хариуцсан мэргэжилтэн
Гишүүдэд:	
Ц.Амарсайхан	-Худалдаа аж үйлдвэрийн танхимын Сэлэнгэ аймаг дахь салбарын дарга
Г.Бямбаа	-Худалдаа, эд хэрэглэгчдийн хоршооны Сэлэнгэ дэх салбарын дарга /тохиролцсоноор/
П.Ганболд	-Хөдөлмөрийн хэлтсийн Жижиг дунд үйлдвэрийн хөнгөлөлт чөлөөлөлт, санхүүгийн дэмжлэг хариуцсан мэргэжилтэн
Ч.Даваадорж	-Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга
Х.Даваахүү	-Хүнс хөдөө аж ахуй жижиг дунд үйлдвэрийн газрын дарга
Ч.Дэмбэрэлсайхан	-Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга
Д.Уранбилэг	-Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дарга
Н.Энэбиш	-Ажил олгогч эздийн холбооны аймгийн салбарын тэргүүн /тохиролцсоноор/

2.Комиссын шийдвэрээр дэмжигдсэн төслүүдийг ажлын 5 хоногийн дотор зээлдүүлэгч банкинд шилжүүлэх, дэмжигдээгүй төслийн хариуг зээл

хүсэгчдэд албан бичгээр мэдэгдэхийг төсөл шалгаруулах дэд комисст даалгасугай.

3.Комисст ирүүлсэн төсөл болоод дэмжигдсэн төслийн мэдээг Хөдөлмөрийн яамны Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хүргүүлэх, шалгарсан төслийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөрийн хэлтсийн дарга /Л.Зоригтбаатар/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 04 сарын 16-ны өдөр

Дугаар 33

Сүхбаатар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн хуралдааны дэгийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.14 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны дэгийг хавсралтаар баталсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ДЭГ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Тэргүүлэгчдийн хуралдааныг товлон зарлаж, бэлтгэлийг хангах, хуралдуулах, асуудлыг хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргах, уг шийдвэрийг албан ёсны болгож холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргэх, олон нийтэд мэдээлэхэд энэ дэгийг мөрдөнө.

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид нь Хурлын хуралдааны чөлөө цагт түүний онцгой эрхэд хамааруулснаас бусад бүрэн эрхийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

3. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдаан /цаашид Тэргүүлэгчдийн хуралдаан гэнэ/ нь асуудлыг хамтын журмаар ажил хэрэгчээр хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэрлэнэ.

4. Тэргүүлэгчдийн хуралдааныг сард нэгээс доошгүй удаа хийнэ.

Хоёр. Тэргүүлэгчдийн хуралдааныг зарлах

1. Хуралдааныг ИТХ-ын дарга, түүний эзгүйд түүний санал болгосноор орлож байгаа Тэргүүлэгч товлон зарлана.

2. Хуралдаан болох газар, сар, өдөр, цаг, хэлэлцэх асуудлыг Тэргүүлэгчдэд нэн даруй зарлан мэдэгдэнэ.

Гурав. Хуралдаанд асуудал оруулах

1. Хуралдаанаар Хурлын жил, улирлын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан болон хуралдаанд асуудал оруулах эрх бүхий этгээдээс санаачлан өргөн барьсан асуудлыг хэлэлцэхээс гадна цаг үеийн шаардлагатай ямар ч асуудлыг хэлэлцэж болно.

2. Тэргүүлэгчдийн хуралдаанд асуудлыг санаачлан оруулж байгаа этгээд, эсвэл түүний даалгавраар тухайн асуудал хариуцсан эрх бүхий этгээд оруулна. Мөн ИТХ-ын Тэргүүлэгчдээс тодорхой асуудлыг судлах, боловсруулах, хянан шалгах чиглэлээр байгуулсан хороо, ажлын хэсгийн дарга, ахлагч тухайн асуудлыг оруулж болно.

3. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь Тэргүүлэгчдийн Хуралдаанаар асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно.

4. Хуралдаанд асуудал оруулах этгээд нь илтгэл, сонсгол, мэдээлэл, танилцуулга, шийдвэрийн төслийг энэ дэгд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулж Хурлын даргад өргөн барина.

5. Шаардлагатай гэж үзвэл хуралдаанаар хэлэлцэх асуудал, гаргах шийдвэрийн төслийг Иргэний танхимаар хэлэлцүүлж санал авч болно.

Дөрөв. Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг бэлтгэх

1.Хуралдааны бэлтгэл хангах үүргийг ИТХ-ын Нарийн бичгийн дарга хариуцан, техник зохион байгуулалтын бэлтгэл хангах үүргийг ИТХ-ын ажлын алба гүйцэтгэнэ.

2. Хуралдаанд илтгэл, сонсгол, мэдээлэл оруулах байгууллага, албан тушаалтанд 20-иос доошгүй хоногийн өмнө албан бичгээр мэдэгдэж бэлтгүүлнэ.

3. Хуралдаанд оруулах асуудлыг ИТХ-ын даргад хуралдаан болохоос 5-аас доошгүй хоногийн өмнө өргөн барина.

4. Хурлын даргад өргөн барьсан материалыг Хурлын ажлын алба хянан нягталж 3-аас доошгүй хоногийн өмнө хуралдаанд оруулан хэлэлцүүлэхээр бэлэн болгоно.

5. Хуралдаанаар хэлэлцэх асуудал /илтгэл, сонсгол, мэдээлэл, танилцуулга/, гаргах шийдвэрийн төслийг Тэргүүлэгчдэд хуралдаан болохоос 1-ээс доошгүй хоногийн өмнө цаасаар болон цахим хэлбэрээр хүргэнэ.

Тав. Хуралдаанаар хэлэлцэх асуудалд тавигдах шаардлага

1. Хуралдаанд оруулах асуудал нь дараахи шаардлагыг хангасан байна.

а/ Хуралдаанд хэлэлцүүлэх илтгэл, сонсгол, мэдээлэл, танилцуулга нь албан хэргийн стандартын дагуу боловсруулагдсан 10 хуудаснаас илүүгүй байна.

б/Хуралдаанаас гарах шийдвэрийн төсөл нь хууль тогтоомжид нийцсэн байна.

в/Хуралдаанаас гарах шийдвэрийн төсөлд холбогдох байгууллага, албан тушаалтны саналыг авсан байна.

г/Уг асуудалд холбогдох судалгаа, тооцоог хавсаргасан байна.

Зургаа. Хуралдааны ирц

1.Хуралдаанд Тэргүүлэгчдийн олонхи нь ирснээр хуралдаан хүчин төгөлдөр болно.

Долоо. Хуралдаанд баримтлах ёс зүй, хариуцлага

1. Тэргүүлэгч нь хуралдаанд оролцохдоо хуулийг дээдлэн хүндэтгэж, хуулийн хүрээнд ажиллана.

2. Тэргүүлэгч нь хуралдаанд үг хэлэх, санал дүгнэлт гаргахдаа үнэн зөв, бодитой, албан ёсны мэдээлэлд тулгуурлах бөгөөд бусдын нэр төр, алдар хүндийг гутаах, гүтгэхийг хориглоно.

3. Тэргүүлэгч нь Хурлын үйл ажиллагаанд оролцох явцад олж мэдсэн улс, байгууллага, хувь хүний нууцыг чанд сахин хамгаална.

4. Тэргүүлэгч нь хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбоотой шаардлагатай мэдээ, мэдээлэл, хууль тогтоомжийг судлан танилцаж хуралдаанд мэдлэг мэдээлэлтэй, идэвхи санаачилгатайгаар оролцоно.

5. Хуралдааныг хүндэтгэн үзэхээс бусад шалтгаанаар таслахыг хориглоно.

6. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа хуралдаан тасалсан болон энэ дэгийн 6, 7 дугаар зүйлд заасан ёс зүйн хэм хэмжээг ноцтой зөрчсөн Тэргүүлэгчийг сануулах, урамшууллыг хасах, шаардлагатай гэж үзвэл Хурлын хуралдаанд оруулж танилцуулна.

Найм. Хурлын Тэргүүлэгчид ашиг сонирхлын зөрчлөө мэдэгдэх, тайлбарлах

1. Тэргүүлэгчид хуралдаан эхэлэхээс өмнө тухайн хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудалтай ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар мэдэгдэл гаргана.

2. Ашиг сонирхлын зөрчилтэй Тэргүүлэгчийг тухайн асуудлыг хэлэлцэхэд оролцуулах эсэхийг шийдвэрлэхдээ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-д заасныг харгалзана.

Ес. Тэргүүлэгчдийн хуралдаанаар асуудал хэлэлцэх

1. Хуралдааныг ИТХ-ын дарга, түүний эзгүйд орлож байгаа Тэргүүлэгч даргална.

2. Хуралдаанаар хэлэлцэх асуудалд цаг тогтоохгүй.

3. Хэлэлцэх асуудлын дарааллыг ИТХ-ын дарга тогтооно.

4. Тэргүүлэгчдийн хуралдаанаар энэ дэгд заасан шаардлага хангасан, хэлэлцэх асуудлын дараалалд орж батлагдсан асуудлыг хэлэлцэнэ.

5. Хуралдаанд оруулж байгаа асуудлаар илтгэл, сонсгол, мэдээлэл тавих хугацаа 15 минутаас илүүгүй байна.

6. Хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Тэргүүлэгч асуулт асуух, түүндээ хариулт, тайлбар авах эрхтэй. Хуралдаанд асуудал оруулж байгаа этгээд Тэргүүлэгчийн асуултанд хариулж, тайлбар өгнө.

7. Хуралдаанд оролцогчид санал гаргахдаа хуралдаан даргалагчаас зөвшөөрөл авч, нэг асуудлаар нэг удаа санал гаргана.

8. Хуралдаанд хэлэлцэж буй асуудал бүр дээр үг хэлж санал гаргахад хүн бүр 5 минутаас хэтрэхгүй байх ба асуулт, хариулт, санал шүүмжлэл нь тухайн хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой, товч, тодорхой байвал зохино.

9. Тэргүүлэгчдээс гарсан зарчмын зөрүүтэй саналаар санал хурааж олонхийн саналаар шийдвэрлэнэ.

Арав. Тэргүүлэгчдийн хуралдаанаас гаргах шийдвэрийг батлах

1. Тэргүүлэгчээс зарчмын зөрүүтэй санал гарвал санал хурааж олонхийн саналаар шийдвэрлэнэ.

2. Шийдвэрийн төслийг бүхэлд нь батлах эсэх асуудлаар санал хурааж олонхийн саналаар шийдвэрлэнэ.

3. Санал хураахад цөөнх болсон Тэргүүлэгчдийн саналын үндэслэл тайлбарыг сонсож тухайн асуудлаар дахин нэг удаа санал хураана.

4. Хуралдаанаас тогтоол, тэмдэглэл гаргана.

5. Аймгийн эдийн засаг, нийгмийн тодорхой асуудлаар чиглэл удирдамж гаргах, өмч хөрөнгийн асуудал шийдвэрлэх, эрхийн хэм хэмжээ тогтоох, цаашид дагаж мөрдөх агуулгатай асуудлаар тогтоол гаргана.

6. Тогтоол гаргах шаардлагагүй асуудлыг хуралдааны тэмдэглэлд тэмдэглэх замаар шийдвэрлэнэ.

7. Хуралдааны тогтоолд Хурлын дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

8. Хуралдаанаас гарсан тогтоол, шийдвэр, тэмдэглэлийг 3 хоногийн дотор бэлэн болгож 7 хоногийн дотор холбогдох сум байгууллага, албан тушаалтанд хүргэх ажлыг Хурлын ажлын алба хариуцна.

Арван нэг. Тэргүүлэгчдийн хуралдааны ил тод байдлыг хангах, мэдээлэх

1. Хуралдаанаар хэлэлцэх шаардлагатай зарим асуудал шийдвэрийн төсөл, гаргасан шийдвэрийг иргэд олон нийтэд ил тод мэдээлэх бөгөөд вэб сайтад байрлуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлнэ.

2. Хуралдааны шийдвэрийг олон нийтэд мэдээлэх ажлыг Хурлын дэргэдэх хэвлэл мэдээллийн алба хариуцан зохион байгуулна.

3. Тэргүүлэгчдийн хуралдаанаар нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоох болон иргэдийн эрх ашигтай холбоотой нутаг дэвсгэрийн зарим асуудлыг

хэлэлцэхэд төрийн бус байгууллага, иргэний төлөөллийг оролцуулан 5 хүртэлх хүнийг хуралдаанд урилгаар оролцуулж болно.

4. Хуралдаанд урилгаар оролцогсод нь энэ дэгийг дагаж мөрдөх бөгөөд дэгийг зөрчвөл Хурал даргалагч сануулж, дахин зөрчвөл хуралдаанаас гаргана.

5. Хуралдаанд урилгаар оролцогсод нь хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан нэг удаа санал хэлж болно.

Арван хоёр. Хуралдааны тэмдэглэл хөтлөх

1. Хуралдааны ирц, эхэлсэн, дууссан хугацаа, хэлэлцсэн асуудал бүр дээр гарсан асуулт, хариулт, хэлсэн үг, гаргасан санал, санал хураалтын дүнг хэрхэн шийдвэрлэсэн томъёоллыг хуралдааны тэмдэглэлд тодорхой тусгана.

2. Хэлэлцсэн асуудалтай холбогдох сонсгол, мэдээлэл, судалгаа тооцоог хуралдааны тэмдэглэлд хавсаргана.

3. Хурлын тэмдэглэлийг Хурлын ажлын албаны ажилтан бичих бөгөөд хуралдааныг даргалагч хянаж гарын үсэг зурж баталгаажуулна.

4. Тэргүүлэгчид хуралдаанаар хэлэлцсэн асуудалтай холбоотой өөрийн санал дүгнэлтийг тусгай дэвтэрт бичиж тэмдэглэнэ.

5. Уг дэвтрийг аймгийн Хурлын ажлын албанд хадгална.

_____оОо_____

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 04 сарын 16-ны өдөр

Дугаар 34

Сүхбаатар

Аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл
ахуйн салбар хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах,
дүрмийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4 дэх заалт, Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2012 оны 04 дүгээр тогтоолыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван талт салбар хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, хорооны дүрмийг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван талт аймгийн салбар хорооны үйл ажиллагааны холбогдох зардлыг аймгийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг аймгийн Засаг дарга /С.Бүрэнбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2013 оны 04 дүгээр сарын 16-ны
өдрийн 34 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ , ЭРҮҮЛ АХУЙН
ГУРВАН ТАЛТ АЙМГИЙН САЛБАР ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

- Хорооны дарга: -Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга
- Нарийн бичгийн дарга: -Хөдөлмөрийн хэлтсийн дарга
- Хорооны гишүүдэд:
- МХГ-ын хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналтын улсын байцаагч
 - Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга
 - Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ-ын дарга, ҮЭХ-ны тэргүүлэгч гишүүн
 - “Алтан-боломж” ТББ-ын тэргүүн
 - Аймгийн Ажил олгогч эздийн холбооны тэргүүн
 - Хувийн эмнэлгүүдийн холбооны тэргүүн
 - “Шинэ бадрах” ХХК-ний захирал

_____оОо_____

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ГУРВАН ТАЛТ САЛБАР ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван талт Аймгийн салбар хороо/цаашид Салбар хороо гэнэ/ нь ажилтны эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэхэд оршино.

1.2.Салбар хороо нь Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль бусад хууль тогтоомжууд, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци болон энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа удирдлага болгоно.

1.3.Салбар хорооны хурлаар хэлэлцсэн асуудлыг талууд зөвшилцөн тогтоол болон зөвлөмж гаргана. Салбар хорооны хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан мэргэжлийн хүмүүсийг оролцуулж болно.

1.4.Салбар хорооноос гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангахад талууд хамтран оролцоно.

1.5.Салбар хороо нь ажлын онцлог шаардлагыг харгалзан ажлын хэсэг, мэргэжлийн зөвлөл байгуулан ажиллуулж болно.

1.6.Салбар хороо нь өөрийн үйл ажиллагааг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан төсөв, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах аймгийн дэд хөтөлбөрийн зардал бусад эх үүсвэрээс санхүүжинэ.

Хоёр. Салбар хорооны удирдлага, бүрэлдэхүүн

2.1.Салбар хороо нь аймгийн Засаг даргын Тамгын газар, Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэлийн холбооны төлөөлөл тус бүр 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

2.2.Сумд нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороотой байна. Аймгийн салбар хороо нь сумдын салбар хороодыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана. Сумдын салбар хорооны нарийн бичгийн дарга нь тухайн сумын хөдөлмөр эрхлэлт хариуцсан ажилтан байна.

2.3.Салбар хороо үйл ажиллагааны тайлангаа хагас, бүтэн жилээр гаргаж аймгийн салбар хороонд ирүүлнэ.

2.4.Аймгийн салбар хороо сумдын гаргасан тайланг нэгтгэн Үндэсний хороонд хагас, бүтэн жилээр тайлагнана.

2.5.Аймаг, сумдын салбар хороод жилийн ажлын төлөвлөгөө гарган салбар хорооны даргаар батлуулна.

Гурав. Салбар хорооны эрх, үүрэг

3.1.Салбар хороо нь дор дурдсан үүрэгтэй байна.

3.1.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал гаргах, эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, зохион байгуулах;

3.1.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан нөхцлийн талаар судалгаа, шинжилгээ хийлгүүлэх, зөвлөмж, санал гаргах;

3.1.3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа, гарын авлага гаргах;

3.1.4.Бусад.

3.2.Салбар хороо нь дор дурдсан эрхтэй байна.

3.2.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний талаар холбогдох газрын мэдээллийг хэлэлцэх, санал дүгнэлт гаргах;

3.2.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, холбогдох байгууллагатай хамтран хяналт шалгалт хийх, зөвөлгөө, зөвлөмж өгөх;

3.2.3.Сумдын салбар хороодын үйл ажиллагаанд хяналт тавих;

3.2.4.Салбар хороо нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, харилцан мэдээлэл солилцох тэргүүний ажилладаг гишүүдээ туршлага судлуулах;

3.2.5.Салбар хорооны тогтоол болон зөвлөмжийн биелэлтийг хангах арга хэмжээ авах.

Дөрөв. Салбар хорооны хурал

4.1.Салбар хорооны хуралд талууд төлөөллөө бүрэн оролцуулах үүрэг хүлээнэ. Хурлыг нийт гишүүдийн олонх оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцно.

4.2.Салбар хороо улиралд нэгээс доошгүй хуралдана. Хурлыг хорооны дарга зарлан хуралдуулна. Шаардлагатай үед аль нэг талын санаачилгаар хуралдана.

4.3.Салбар хорооны хурлаас гарах тогтоол, зөвлөмжийг олонхийн саналаар баталж, тэмдэглэлээр баталгаажуулан тал тус бүрийн төлөөлөл гарын үсэг зурна.

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 05 сарын 01-ний өдөр

Дугаар 45

Сүхбаатар

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл
ахуйн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх
зарим арга хэмжээний тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлын тухай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Энхсайханы мэдээллийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Тус аймагт сүүлийн жилүүдэд уул уурхай, барилга, зам тээвэр зэрэг салбар эрчимтэй хөгжиж олон арван үйлдвэр, уурхай ажиллаж, орчин үеийн том оврын машин техник, тэсэрч дэлбэрэх болон химийн бодистой харьцаж ажиллах болсон нь асар их эрсдлийг бий болгож байна.

Зарим аж ахуйн нэгж, байгууллагууд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандарт, дүрэм журмыг хангалтгүй хэрэгжүүлж байгаагаас үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тохиолдол, тоо хэмжээ өсөх хандлагатай байна. Сүүлийн 3 жилд үйлдвэрлэлийн осолд 31 хүн өртсө нөөс 12 хүн хүнд гэмтэж, 10 хүн амь насаа алдсан байна.

Энэ байдалд аймаг, сумын удирдлага, аж ахуйн нэгж, байгууллагууд нухацтай дүгнэлт хийж хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг онцгой анхааралд авч эрчимжүүлэх шаардлагатай байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Аймгийн Засаг даргад ДААЛГАХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль, тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг аймгийн хэмжээнд сум, байгууллага, аж ахуйн нэгж, ажлын түр байрыг хамруулан шалган дүгнэж, ажлын арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх, зөрчил дутагдлыг арилгах тодорхой ажил зохион байгуулах.

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх.

3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандарт дүрэм журмыг хэрэгжүүлэх асуудлаар аймгийн хэмжээний зөвлөлгөөн, сургалт семинарыг нэгдсэн болон төрөлжсөн хэлбэрээр холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж байх:

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад ДААЛГАХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар хийж байгаа ажлын талаар нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын илтгэл, сонсголыг хэлэлцэн дүгнэлт хийж, үүрэг чиглэл өгч ажиллах.

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх сургалт, сурталчилгаа, мэдээлэл, хяналт шалгалтын ажлыг тогтмолжуулах.

Аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал нарт ДААЛГАХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандарт, дүрэм журмыг үйлдвэрлэлийн нэгж, ажлын байр бүрт чанд мөрдүүлэх.

2.Ажлын байр бүр дээр эрсдлийн болон хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийж, эрсдлийг арилгах, нөхцлийг сайжруулах ажлыг ажилтны санал оролцоотойгоор тогтмол хийж байх.

3.Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалт сурталчилгааг тогтмолжуулан байгууллагад болон тухайн ажлын байранд мөрдөх дүрэм журмыг ойлгомжтой хялбар болгон, ажилтан бүрт ойлгуулах, байгууллагын дотоодын болон олон нийтийн хяналт шалгалтын байнгын механизм бий болгон ажиллах.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 05 сарын 01-ний өдөр

Дугаар 46

Сүхбаатар

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Сэлэнгэ аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хүсэлт, Орон нутгийн өмчийн албаны саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1."Сэлэнгэ БИТ" орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын балансад бүртгэлтэй байсан энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтад дурдсан 20995880,0 төгрөгийн эд хөрөнгийг Сэлэнгэ Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн балансад шилжүүлж орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсүгэй.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 77 дугаар тогтоолын 3 дугаар заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 05 сарын 01-ний өдөр

Дугаар 47

Сүхбаатар

**Ахмадын байгууллагын талаар авах
зарим арга хэмжээний тухай**

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Аймаг, сумын ахмадын байгууллагыг ажиллах нөхцөл боломжоор ханган ахмадын байр танхимтай болгох, түүнд шаардагдах хөрөнгө зардлыг аймаг, сумдын төсөвт тусган батлуулж байхыг аймгийн Засаг даргад даалгасугай.

2.Аймгийн ахмадын хорооны даргад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй, сумын ахмадын хорооны даргад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувиас багагүй хэмжээний урамшууллыг төсвөөс олгож байхаар тогтоож 2014 оноос эхлэн жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлэх.

3.Өөрийн байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан болон одоо ажиллаж байгаа ахмад настнуудыг нэгдсэн зохион байгуулалтад оруулж, тэдэнтэй байнгын харилцаа холбоо тогтоон ажиллах зорилгоор аж ахуйн нэгж, байгууллага бүр ахмадын байгууллага байгуулж ажилд нь дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллах.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 05 сарын 15-ны өдөр

Дугаар 49

Сүхбаатар

**“Сэлэнгэ энерго” үйлдвэрийн газрын талаар авах
зарим арга хэмжээний тухай**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 35 дугаар тогтоолоор томилогдсон ажлын хэсгээс “Сэлэнгэ Энерго” орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үйл ажиллагаа, эдийн засаг, санхүүгийн өнөөгийн байдлын талаар гаргасан санал дүгнэлт, аймгийн Засаг даргын саналыг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг.Аймгийн Засаг дарга /С.Бүрэнбат/-д ДААЛГАХ нь:

1.2014 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор “Сэлэнгэ Энерго” орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт 300,0 сая төгрөгийг Сангийн Яаманд асуудал тавьж төсвөөс зээл олгох замаар шийдвэрлэх.

2.Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудад түгээж буй халаалт, хэрэглээний халуун усны үнэ тарифыг өөрчлөх асуудлыг аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлд 5 дугаар сард багтаан тавьж шийдвэрлүүлэх.

3. “Сэлэнгэ Энерго” орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг цаашид тогтвортой жигд хэвийн ажиллуулахын тулд улсын болон орон нутгийн төсвөөс тодорхой хэмжээний санхүүгийн дэмжлэг татаас олгох асуудлаар тооцоо судалгаа хийж сангийн яаманд тавьж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулах.

4. “Сэлэнгэ Энерго” орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг төрийн өмчид шилжүүлэх асуудлыг холбогдох яам, газарт тавьж хамтран судалж, цаашид алдагдалгүй ажиллах, аймгийн төвийг дулаанаар найдвартай хангах нөхцлийг бүрдүүлэх.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 05 сарын 15-ны өдөр

Дугаар 50

Сүхбаатар

“Баруунхараа тохижилт үйлчилгээ” орон нутгийн
өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг
татан буулгах тухай

Сэлэнгэ аймгийн аудитын газрын дүгнэлт, Баянгол сумын Засаг даргын саналыг хэлэлцээд Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2-ын 4 дэх хэсгийн заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.“Баруунхараа тохижилт үйлчилгээ” орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь төсөв санхүүгийн хувьд алдагдалтай ажиллаж, өр төлбөр нэмэгдэн цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон тул татан буулгасугай.

2.“Баруунхараа тохижилт үйлчилгээ” орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын балансад бүртгэлтэй байгаа үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийг Баянгол сумын Засаг даргын Тамгын газрын балансад шилжүүлсүгэй.

3.Тус үйлдвэрийн газрын өмч хөрөнгийг сумын Засаг даргын Тамгын газарт шилжүүлэн хүлээлгэж өгөхийг Орон нутгийн өмчийн албаны дарга /П.Эрдэнэсайхан/-д, дуусгалтын баланс гаргуулан, өр төлбөрийн асуудлыг шийдвэрлэх талаар тодорхой ажил зохион байгуулахыг сумын Засаг дарга /Б.Энхбат/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 05 сарын 15-ны өдөр

Дугаар 51

Сүхбаатар

Тогтоол хүчингүй болгох тухай

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2013 оны А/97 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 1.3-ыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 18 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 05 сарын 15-ны өдөр

Дугаар 52

Сүхбаатар

**Мэргэжлийн комиссын бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 2.17.1 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн эргэлтийн цэгийг тодотгон солбицжуулах, баталгаажуулах ажлыг зохион байгуулах аймгийн мэргэжлийн комиссын бүрэлдэхүүнийг дор дурдснаар шинэчлэн баталсугай.

Комиссын дарга

С.Бүрэнбат

Аймгийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга

Д.Батдэлгэр

Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Гишүүдэд:

Д.Сундуй

Алтанбулаг сумын Засаг дарга

Б.Энхбат

Баянгол сумын Засаг дарга

Ж.Наранцэцэг

Баруунбүрэн сумын Засаг дарга

Б.Сэргэлэн

Ерөө сумын Засаг дарга

С.Нямсүрэн

Жавхлант сумын Засаг дарга

Б.Батчулуун

Зүүнбүрэн сумын Засаг дарга

Н.Нямдаваа

Мандал сумын Засаг дарга

Г.Булганчимэг

Орхон сумын Засаг дарга

С.Эрдэнэбаяр

Орхонтуул сумын Засаг дарга

Д.Өлзийбадрах

Сант сумын Засаг дарга

С.Энхтайван

Сайхан сумын Засаг дарга

М.Үүрийнтуяа

Сүхбаатар сумын Засаг дарга

Г.Галбадрах

Хушаат сумын Засаг дарга

Б.Наранцэцэг

Хүдэр сумын Засаг дарга

Ц.Отгонтүй

Түшиг сумын Засаг дарга

Ч.Жаргалсайхан

Цагааннуур сумын Засаг дарга

М.Баярбаатар

Шаамар сумын Засаг дарга

Сумдын газрын даамлууд, иргэдийн Төлөөлөл

2.Аймгийн болон сумдын ажлыг мэргэжлийн эрх бүхий байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажлын явц, саналаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулан, үр дүнг хурлын хуралдаанд оруулахыг мэргэжлийн комиссын дарга, аймгийн Засаг дарга /С.Бүрэнбат/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 05 сарын 15-ны өдөр

Дугаар 54

Сүхбаатар

Комисс байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 2.17.1 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Орхон, Сайхан сумдын хилийн цэст өөрчлөлт оруулах асуудлыг судалж санал боловсруулах комиссыг доорхи бүрэлдэхүүнтэй байгуулсугай.Үүнд:

Комиссын дарга:

С.Бүрэнбат

Аймгийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга:

Д.Батдэлгэр

Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Гишүүд:

Ч.Дэмбэрэлсайхан

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга

С.Энхтайван

Сайхан сумын Засаг дарга

Г.Булганчимэг

Орхон сумын Засаг дарга

Д.Банзрагч

Сайхан сумын газрын даамал

А.Хонгор

Орхон сумын газрын даамал

Сайхан сумын иргэний төлөөлөл 1 иргэн

Орхон сумын иргэний төлөөлөл 1 иргэн

2.Орхон, Сайхан сумдын хилийн цэсийн асуудлаар санал боловсруулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулахыг комиссын дарга бөгөөд аймгийн Засаг дарга /С.Бүрэнбат/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 05 сарын 15-ны өдөр

Дугаар 55

Сүхбаатар

Зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн “Шинэ сум” хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.11 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сум хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах чиг үүрэг бүхий аймгийн зөвлөлийг доорхи бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга

О.Буянтогтох

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
нарийн бичгийн дарга

Гишүүд

С.Отгонжаргал

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
дарга

Ч.Дэмбэрэлсайхан

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга

Э.Оюунболд

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
ажлын албаны ажилтан

Ч.Доржмягмар

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын Барилга хот
байгуулалтын ахлах мэргэжилтэн

ДАРГА

Ж.САНЖЖАВ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2013 оны 06 сарын 14-ний өдөр

Дугаар 62

Сүхбаатар

Эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдал, цаашдын зорилтын тухай

Аймгийн Эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдал, цаашдын зорилтын тухай аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Ж.Одын илтгэлийг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Эрүүл мэндийн газар нь Монгол Улсын болон Сэлэнгэ аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөр, 2006-2015 онд хэрэгжүүлэх эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө, салбарын хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж, 2009, 2010 онуудад 3-р байр, 2011 онд тусгай байр, Нийслэл, аймаг, дүүргийн эрүүл мэндийн газрууд, клиникийн эмнэлгүүдийн үнэлгээгээр салбарын хэмжээнд 2009, 2010, 2011 онуудад улсад 4-р байр, 2012 онд улсад 1-р байр эзэлсэн байна.

2012 онд "Эрүүл хүүхэд аян"-ыг зохион байгуулж 0-18 насны хүүхдийн 92 хувийг 1-р шатны үзлэгт хамруулж, улсдаа тэргүүлсэн байна.

2012 оны байдлаар 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл аймгуудын дунджаас 10,8 промил, улсын дунджаас 8,6 промил, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл аймгуудын дунджаас 11.0 промил, улсын дунджаас 8.4 промилээр тус тус доогуур, 2012 онд халдварт өвчний тохиолдол өнгөрсөн оныхоос 19.4, халдварт шар өвчин 7.3, сүрьеэ өвчин 3.8, бэлгийн замаар дамжих халдвар 3 промилээр тус тус буурсан байна.

Аймгийн Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд дээрх ололт амжилт байгаа боловч цаашид анхаарах, шийдвэрлэх асуудал, ажлын арга барилын дутагдал доголдол багагүй байна.

Аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгийн ажил үйлчилгээ, эмч мэргэжилтнүүдийн мэдлэг чадвар, оношлогоо эмчилгээ, үйлчилгээний талаар иргэдээс, Эрүүл мэндийн газрын удирдлагын ажлын арга барил, зан харьцааны талаар хамт олны дотроос санал, гомдол, шүүмжлэл байнга гарч байгаад нухацтай дүгнэлт хийж засаж сайжруулах талаар тодорхой арга хэмжээ авч ажил зохион байгуулах шаардлагатай гэж үзэж байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг.Аймгийн Засаг дарга /С.Бүрэнбат/-д ДААЛГАХ нь:

1.Эрүүл мэндийн салбарт хийгдэж байгаа шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлж аймгийн Нэгдсэн эмнэлэгт орчин үеийн техник, тоног төхөөрөмж бүхий оношлогооны төв байгуулах асуудлыг шийдвэрлэх.

2.Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумдын Эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлгүүдийг шаардлагатай эмч мэргэжилтнээр хангах, тэднийг тогтвор

суурьшилтай ажиллуулах, мэдлэг чадварыг дээшлүүлэх талаар тодорхой үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

3.Өрхийн эмнэлгүүдийг зориулалтын байртай болгох, Нэгдсэн эмнэлэг, сум дундын болон сумдын эрүүл мэндийн төвийг шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг салбарын яамтай хамтран ээлж дараатай шийдвэрлэх.

4.Ахмад настнуудын сувиллын газар болгон ажиллуулж байгаа аймгийн Цагдаагийн газрын балансад байгаа барилгуудыг Эрүүл мэндийн газарт шилжүүлэн өгөх асуудлыг судалж шийдвэрлэх.

Хоёр.Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга /Ж.Од/-д ДААЛГАХ нь:

1.Аймгийн эрүүл мэндийн салбарын ажлын ололт амжилтыг бататган, эрүүл мэндийн үйлчилгээг шинэ түвшинд гарган сайжруулах талаар тодорхой ажил, арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах.

2.Эрүүл мэндийн салбарын удирдлага, зохион байгуулалт, ажлын арга барил, зан харьцааны талаар иргэд, хамт олны дотроос гарч байгаа санал, гомдол, шүүмжлэлд анхааралтай хандаж нухацтай дүгнэлт хийж ажиллах.

Гурав.Сумдын Засаг дарга нарт ДААЛГАХ нь:

1.Нутаг дэвсгэртээ хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих ойрын болон хэтийн зорилго зорилтоо тодорхойлсон хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаараа батлуулан хэрэгжүүлэх.

2.Сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулахад анхаарах.

3.Сумын эрүүл мэндийн төвийг эмч, мэргэжилтнээр ханган тогтвор суурьшилтай ажиллуулахад онцгой анхаарч, энэ талаар аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран ажиллах.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 06 сарын 14-ний өдөр

Дугаар 69

Сүхбаатар

Нэрэмжит болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ын 6.2 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын эрүүл мэндийн төвийг тус сумын уугуул, нэрт эрдэмтэн, сурган хүмүүжүүлэгч, биологийн шинжлэх ухааны доктор Жамбалын Шагжийн нэрэмжит болгох саналыг дэмжиж Монгол Улсын Засгийн газарт уламжилсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 06 сарын 14-ний өдөр

Дугаар 70

Сүхбаатар

Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Түшиг сум байгуулагдсаны 90 жилийн ойг 2014 оны 07 дугаар сард тэмдэглэхийг зөвшөөрсүгэй.

2.Ойгоо угтаж байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, иргэдийн санаачилгыг өрнүүлэн сум, орон нутгаа хөгжүүлэх, төв суурингаа тохижуулах, үйлдвэрлэл үйлчилгээг нэмэгдүүлэх талаар тодорхой бүтээлч ажлуудыг зохион байгуулж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 06 сарын 14-ний өдөр

Дугаар 71

Сүхбаатар

Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай

Мандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тавьсан саналыг хэлэлцээд Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Зүүнхараад улсын тариалангийн сангийн аж ахуй байгуулагдсаны 90 жилийн ойг 2013 оны 11 дүгээр сард тэмдэглэхийг зөвшөөрсүгэй.

2.Ой угтсан ажил болон ой тэмдэглэх арга хэмжээнд удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргад үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 06 сарын 25-ны өдөр

Дугаар 74

Сүхбаатар

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 122, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 45 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрт батлагдсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны дарга /Ө.Сувдаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын эдийн засагт уул уурхай, барилга, зам, тээвэр эрчим хүч зэрэг салбаруудад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийн түвшин өсөх хандлагатай боллоо.

Аж ахуйн нэгж байгууллага хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, хууль журмыг хангалтгүй хэрэгжүүлж байгаагаас үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдол буурахгүй ажлын байранд ажиллагчдын амь нас эрүүл мэнд хохирох явдал гарсаар байна.

Аймгийн түвшинд сүүлийн 3 жилийн байдлаар 31 хүн үйлдвэрлэлийн осолд өртсөнөөс 10 хүн нас барж, 4 хүн хөнгөн, 5 хүн дунд зэрэг, 12 хүн хүнд гэмтэж, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас 895 иргэнд 1977.3 сая төгрөгийн тахир дутуугийн тэтгэвэр, 68 иргэнд 133.8 сая төгрөгийн тэтгэмж, 147 иргэнд 38.3 сая төгрөгийн сувилал, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж нөхөн олговорт 123 иргэнд 13.3 сая төгрөгийг нийтдээ 1233 иргэнд 2.1 тэр бум төгрөгийг тус тус олгосон байна.

Мөн 2012 онд аймгийн хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн 90 гаруй аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан хяналт шалгалт хийхэд гарсан 63 зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэн ажиллалаа.

Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 24.1.3, Засгийн газрын 2012 оны 122, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 45 дугаар тогтоолууд нь аймгийн дэд хөтөлбөр батлан хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл болж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, баримтлах зарчим

2.1. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгон, хэрэгжилтийг сайжруулж эрсдэлгүй, аюулгүй, эрүүл ажлын байрны орчинг бүрдүүлэх, ажиллагчдад аюулгүй ажиллах зан үйл соёлыг төлөвшүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн удирдлагын чадавхийг бэхжүүлэх замаар иргэдийн эрүүл аюулгүй орчинд хөдөлмөрлөх эрхийг хангуулж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдлыг бууруулахад оршино.

2.2 Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж ажиллана.

2.2.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, хууль эрх зүйн хэрэгжилтийг сайжруулж эрсдэлгүй, аюулгүй, эрүүл ажлын байрны орчинг бүрдүүлэх.

2.2.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи хууль тогтоомж, стандартыг аж ахуйн нэгж, байгууллага, ажлын байранд мөрдүүлж хэвшүүлэх.

2.2.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх.

2.2.4 Асбест, мөнгөн ус, цианид болон полихлорт бифенилээс үүссэн өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийн хэрэглээг бууруулах, бүр мөсөн хориглох арга хэмжээг шийдвэрлэх.

2.2.5 Олон нийтийн хяналт, тогтолцоог бүрдүүлэх.

2.2.6 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи сургалт сурталчилгаа, мэдээллийг сайжруулах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын чадавхийг бэхжүүлэх.

2.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтлана.

2.3.1 Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх.

2.3.2 Оролцоо санаачлага мэргэжлийн хандлагад тулгуурлах.

2.3.3 Нийгмийн хариуцлагатай хандах.

2.3.4 Ил тод байх.

2.3.5 Эрсдэл өндөртэй салбарт түлхүү анхаарах.

2.3.6 Орон нутгийн салбар зөвлөл аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах.

Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны

ЧИГЛЭЛ, ХҮРЭХ ҮР ДҮН

Хөтөлбөрийн хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлж, дор дурьдсан үр дүнд хүрнэ:

3.1 Нэгдүгээр зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1 Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох журам, дүрмийг шинэчлэх, шинээр гаргахад аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн саналыг тусгах арга хэмжээг зохион байгуулах.

3.1.2 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнийг бүртгэх, мэдээлэх журмыг боловсронгуй болгоход орон нутгийн онцлогтой холбоотой санал хүргүүлэх.

3.1.3. Мэргэжлээс шалтгаалах өвчний судалгаа хийж, мэргэжлээс шалтгаалах өвчний жагсаалтыг шинэчлэн гаргаж мөрдүүлэхэд саналаа хүргүүлэх.

3.1.4. Бичил уурхайд үйлдвэрлэлийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн стандарт мөрдүүлэх, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулахад чиглэсэн тусгай арга хэмжээ авах.

Хүрэх үр дүн: Аймгийн хэмжээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи хууль тогтоомж, журам, дүрмийг хэрэгжүүлснээр эрсдэлгүй, эрүүл, аюулгүй ажлын байрны орчинг бүрдүүлнэ.

3.2 Хоёрдугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1 Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч нь ажил олгогч, ажилтнуудад зөвлөн туслах замаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, зөрчлийг бууруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг мөрдүүлэх арга хэмжээ авах.

3.2.2 Хөдөлмөрийн нөхцөл аюулгүй байдал, эрүүл ахуйн олон нийтийн хяналтын тогтолцоог бэхжүүлэх.

3.2.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн удирдлагын менежментийн системийг нийт аж ахуйн нэгж, байгууллагад бүрэн нэвтрүүлэх.

3.2.4 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байранд мөрдүүлэх ажлыг зохион байгуулахад аймгийн Ажил олгогч эздийн холбоо, аймгийн Үйлдвэрчний холбооны оролцоог хангах.

3.2.5 Аж ахуйн нэгж байгууллагад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдлийн болон ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээг хийхэд ажилтны оролцоог нэмэгдүүлж, уг үнэлгээний үр дүнг хянах дотоодын хяналт шалгалтын систем бий болгох.

3.2.6 Албан байгууллага аж ахуйн нэгжүүдийн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажилтнуудыг туршлага солилцуулах зөвлөгөөн зохион байгуулах.

Хүрэх үр дүн: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль, тогтоомжийн хэрэгжилт сайжирч, зөрчил буурч, стандартын шаардлага хангасан ажлын байрны тоо нэмэгдсэн байна.

3.3. Гуравдугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.3.1 Аж ахуйн нэгж, байгууллагын мөрдөж байгаа дүрэм, журмыг ойлгомжтой, хялбар болгон ажилчдад хүргэх, ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаар сургалт зохион байгуулах санал, санаачилгыг дэмжих, уг сургалтын зардлын тодорхой хувийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас нөхөн олгох арга хэмжээ авах.

3.3.2 Ажилчдад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх дадал, заншил эзэмшүүлэх зорилгоор ажилчдын нийтлэг

гаргадаг алдаа зөрчил, түүний улмаас гарсан осол, өвчлөлийн үр дагаврыг харуулсан гарын авлага, ухуулга, сурталчилгааны материалыг салбар, мэргэжлийн онцлогийг харгалзан гаргаж, аж ахуйн нэгж, байгууллагад түгээх.

3.3.3 Аж ахуйн нэгж байгууллагад ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийх заавар, зөвлөмж, аргачлал боловсруулж гаргах, тэдгээрийг үндэслэн аж ахуйн нэгж, байгууллагад эрсдлээс сэргийлэх зан үйл дадлыг төлөвшүүлэх, эрсдэл өндөртэй ажлын байрны жагсаалт гаргах замаар ажиллагчдыг болзошгүй осол гэмтлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг үе шаттайгаар авах.

3.3.4 Аж ахуйн нэгж, байгууллагад эрсдэлийн үнэлгээ хийх чадавхи бий болгох, дадлага эзэмшүүлэхэд туслах ажлыг төрийн хяналт шалгалтын байгууллагын мэргэжил, арга зүйн удирдлагын дор мэргэжлийн холбоод энэ чиглэлээр мэргэшсэн төрийн болон төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх.

3.3.5 Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчид, ялангуяа үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчинд өртөх эрсдэл өндөртэй ажлын байранд ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах монгол улсад хэрэглэхийг хязгаарласан хорт хавдар үүсгэх, үр удамд нөлөөлөх үйлчилгээ бүхий химийн хортой болон аюултай бодис, материалтай харьцаж ажилладаг ажилтны эрүүл мэндийг хугацаат үзлэгт хамруулж өндөр өртөг бүхий оношлогоо, шинжилгээний зардлыг эрүүл мэндийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх асуудлыг судалж шийдвэрлүүлэх.

3.3.6 Аж ахуйн нэгж байгууллагад үйлдвэрлэлийн горим хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм журмыг зөрчихгүй байхыг сануулсан тэмдэг тэмдэглээ анхааруулга, сэрэмжүүлэг хэрэглэж төлөвшүүлэх.

3.3.7 Үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах зориулалт бүхий ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг үйлдвэрлэдэг дотоодын аж ахуйн нэгж, байгууллагад татварын хөнгөлөлт үзүүлэх асуудлыг шийдвэрлэх.

3.3.8 Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх зорилгоор оношлогоо, эмчилгээ, нөхөн сэргээх, тусламж үйлчилгээнд орчин үеийн дэвшилт арга, технологи нэвтрүүлэх чиглэлээр эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнийг чадавхийг сайжруулах.

Хүрэх үр дүн: Аж ахуйн нэгж байгууллагад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх зан үйл төлөвшиж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин буурсан байна.

3.4 Дөрөвдүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.4.1 Асбест, мөнгөн ус, цианид зэрэг химийн хортой бодис агуулсан бүтээгдхүүнтэй харьцах аюулгүй ажиллагааны журмыг мөрдөж ажиллах, үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах.

3.4.2 Асбест, мөнгөн ус, цианид зэрэг болон полихлорит бифенил агуулсан тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн хаягдалтай харьцаж ажилладаг ажиллагчдад зориулсан сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх.

3.4.3 Асбест, мөнгөн ус, болон полихлорит бифенил агуулсан тоног төхөөрөмж бараа бүтээгдэхүүнийг орлуулах бүтээгдэхүүний хэрэглээг аж ахуйн нэгж, байгууллага, ажилтан, иргэдэд сурталчлах, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах.

3.4.4 Барилгын материалын үйлдвэрүүд болон барилгын салбарт хэрэгжих "Цэнхэр карт" хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

Хүрэх үр дүн: Аймгийн хэмжээнд химийн хортой бодис агуулсан тоног төхөөрөмж ашиглан үйлдвэрлэл явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын нэгдсэн бүртгэл судалгаатай болж аюулгүй ажиллагааны хяналт сайжирч, зарим тоног төхөөрөмж, бүтээгдэхүүний хэрэглээг 2016 он гэхэд зогсоож, орлуулах бүтээгдэхүүний хэрэглээг дэмжсэнээр, химийн хортой бодис агуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ буурсан байна.

3.5 Тавдугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.5.1 Жил бүр аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг төсөвт тусган батлуулах.

3.5.2 Нийт иргэдэд эрүүл аюулгүй ажиллаж амьдрах осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зан үйлийг бий болгох соён гэгээрүүлэх ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, орон нутгийн сонинд тусгай нийтлэлийн булан ажиллуулах талаар хамтран ажиллахад шаардагдах хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн аймгийн салбар хороо төсөвт тусган хэрэгжүүлж ажиллах.

3.5.3 Аж ахуйн нэгж байгууллага ялангуяа орон нутагт үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг явуулын хэлбэрээр зохион байгуулах ажлыг аймгийн нийгмийн зөвшлийн 3 талт салбар хороо болон төрийн бус байгууллагатай хамтран үе шаттайгаар зохион байгуулах.

3.5.4 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр мэргэшсэн судлаач, сургагч багш бэлтгэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын орон тооны бус улсын байцаагч, үйлдвэр аж ахуйн газрын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан, үйлдвэрийн эмч, хөдөлмөрийн эрүүл ахуйч нарыг мэргэшүүлэх, давтан сургах сургалтыг аймгийн ХАБЭА-н салбар хороо болон мэргэжлийн бусад байгууллагын оролцоотойгоор зохион байгуулах.

3.5.5 Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчнийг судлан бүртгэх үйл ажиллагааг боловсронгуй болгож мэдээллийн нэгдсэн сантай болох замаар үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний талаархи статистик мэдээллийг сайжруулахын зэрэгцээ ажлын байрны аюултай хортой хүчин зүйлийн талаар мэдээллийн нэгдсэн сантай болох.

3.5.6 Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас санаачлан жил бүрийн 4 дүгээр сарын 28-нд зохин байгуулдаг "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэлхийн өдөр"-ийг бүх нийтээр тэмдэглэх, аж ахуйн нэгж, байгууллага бүр энэ өдөр үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, үйлдвэрлэлийн ослоор нас барагсдын дурсгалыг хүндэтгэх тал бүрийн үйл ажиллагааг зохион байгуулж хэвших.

Хүрэх үр дүн: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи олон нийтийн ойлголт, зан үйл, хандлага сайжирч, мэргэшсэн сургалт, сурталчилгаа, судалгааны байгууллагын төвшин дээшилсэн байна.

3.6.Зургадугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.6.1.Төрийн захиргааны байгууллага, ажил олгогчийн болон ажилтны төлөөллийн байгууллага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх.

3.6.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны /MNS-ILO-OSH-2001/ стандартыг уул уурхай, барилгын салбарт нэн тэргүүнд нэвтрүүлэх бусад салбарт түгээн дэлгэрүүлэх ажлыг аймгийн нийгмийн зөвшлийн 3 талт салбар хорооны оролцоотойгоор хэрэгжүүлэх.

Хүрэх үр дүн: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны үйл ажиллагаа сайжирч оролцогч талуудын чадавхи дээшилж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын орон тооны болон орон тооны бус улсын байцаагч, үйлдвэр, аж ахуйн газрын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан орон тооны ажилтны 50-иас доошгүй хувийг мэргэшүүлэх сургалтанд хамруулсан байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын /MNS-ILO-OSH-2001/ стандартыг нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, эрүүл болон аюулгүй ажлын байрны тоо нэмэгдсэн байна.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, удирдлага

4.1 Хөтөлбөрийг 2013-2016 онд хэрэгжүүлнэ

4.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн түвшинд удирдан зохион байгуулах үүргийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аймгийн салбар хороо, сумдын салбар хороотой хамтран хэрэгжүүлнэ.

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

5.1 Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ

5.1.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө

5.1.2 Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас энэ зориулалтаар гаргах хөрөнгө

5.1.3 Аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгө

5.1.4 Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн тусламж хандив

Зургаа. Хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээ

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлыг аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар хороо, аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран гүйцэтгэнэ.

6.2 Хөтөлбөрийн явцын дунд хугацааны хяналт шинжилгээг хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш 2 жилийн дараа эцсийн үнэлгээг хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараа хийнэ.

6.3 Хөтөлбөрийн хяналт шинжилгээ үнэлгээнд ажилтны болон ажил олгогчийн төлөөллийн байгууллага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулна.

6.4 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, түүний үр дүнгийн талаарх мэдээ, тайланг аймгийн вэб сайт болон орон нутгийн хэвлэл мэдээллээр дамжуулан олон нийтэд ил тод мэдээлнэ.

6.5 Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ үнэлгээнд дараах шалгуур үзүүлэлтийг ашиглана.

6.5.1 Тухайн жилд бүртгэгдсэн мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийн тохиолдолын тоо.

6.5.2 Тухайн жилд гарсан үйлдвэрлэлийн ослын тоо.

6.5.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн удирдлагын систем нэвтрүүлсэн аж ахуйн нэгжийн тоо.

6.5.4 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэшүүлэх сургалтад хамрагдсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын орон тооны болон орон тооны бус улсын байцаагч, үйлдвэр аж ахуйн газрын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны тоо.

6.5.5 Эрүүл мэндийн урьдчилан болон хугацаат үзлэг зохион байгуулсан аж ахуйн нэгж, байгууллага, хамрагдсан ажилчдын тоо.

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 06 сарын 25-ны өдөр

Дугаар 75

Сүхбаатар

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 154 дүгээр тогтоолын 5.2 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Ажилтай орлоготой Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж хяналт тавьж ажиллахыг аймаг, сумдын Засаг дарга нар болон холбогдох хэлтэс, агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ төлөвлөгөөнд тусгагдсан орон нутгийн хөрөнгөөр хийгдэх зорилт, үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгаж санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Бүрэнбат/-д даалгасугай.

4.“Ажилтай орлоготой Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх комиссыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**“АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
Зорилт 1. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:				
1.	Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулж хэрэгжүүлэх	2013	Аймгийн ИТХ	Аймгийн ЗДТГ
2.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, түүний үр дүнгийн талаархи мэдээ, тайланг холбогдох газарт тухай бүр хүргүүлж хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон цахим хуудсаар олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх	2013-2016	Аймгийн ЗДТГ	Хөдөлмөрийн хэлтэс
3.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллах	2013-2016	Аймгийн ЗДТГ ХАБЭА салбар хороо МХГ	Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ажил олгогч эздийн холбоо
4.	Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад тавих хяналтыг сайжруулах.	2013-2016	Аймгийн ЗДТГ	Хөдөлмөрийн хэлтэс
5.	Ажлын байр болон бүтээн байгуулалтын ажлыг ТВ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан, олны хүртээл болгох	2013-2016	Аймгийн ЗДТГ	Сумдын ЗДТГ Хөдөлмөрийн хэлтэс

6.	Орон нутагт зохистой хөдөлмөрийн шаардлага хангасан хамгийн олон ажлын байр бий болгосон аж ахуйн нэгж байгууллага, иргэнийг шалгаруулж урамшуулах ажлыг зохион байгуулах	2013-2016	Аймгийн ЗДТГ	Хөдөлмөрийн хэлтэс Аймгийн АОЭХ, ҮЭХ
7.	Аймгийн Засаг даргаас сумын Засаг дарга нартай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлж, санхүүжилт авах гэрээнд тусгагдсан ажлын байрыг бий болгох ажилд нөөц боломжоо дайчлан ажиллах	2013-2016	Аймгийн ЗДТГ	Сумын ЗДТГ Хөдөлмөрийн хэлтэс
Зорилт 2. Жижиг, дунд үйлдвэр болон хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэд, малчид, ногоочид, тариаланчдыг дэмжих чиглэлээр:				
1.	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих аймгийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх	2013-2014	Аймгийн ЗДТГ Хөгжлийн бодлогын хэлтэс	ХХААЖДҮГ, Хөдөлмөрийн хэлтэс
2.	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлд аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг хамруулж ажлын байрыг нэмэгдүүлэх, төслийг урьдчилан бэлтгүүлэх зохион байгуулах арга хэмжээ авах	2013-2016	Аймаг, сумдын ЗДТГ	Хөдөлмөрийн хэлтэс
3.	Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр шинээр бий болгох зорилгоор олгосон жижиг зээлийн хүүг нөхөн олгох, шаардлагатай зарим төслүүдийг батлан даалтын санд хамруулах	2013-2016	Хөдөлмөрийн хэлтэс	Аж ахуйн нэгж байгууллага
4.	Шинээр ажлын байр бий болгох жижиг, дунд үйлдвэр болон хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэд, малчдыг батлагдсан төсвийн хүрээнд зээлд хамруулах	2013-2016	Хөдөлмөрийн хэлтэс	Сумын ЗДТГ
5.	Жижиг, дунд үйлдвэр, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нөхөрлөл, бүлгийн зохион байгуулалтыг дэмжиж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нь худалдан борлуулахад дэмжлэг үзүүлэх	2014 он	Аймгийн ЗДТГ	Сумын ЗДТГ
6.	Ахуй үйлчилгээний цогцолбор төвийг бүх суманд байгуулах замаар ажлын байр нэмэгдүүлж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах	2013-2016	Аймгийн ЗДТГ	Сумын ЗДТГ

7.	Хөдөө аж ахуйн гаралтай үйлдвэрлэл, түүхий эд бэлтгэн нийлүүлэх нөхөрлөл, хоршоо байгуулахыг дэмжих	2013-2016	ХХААЖДҮГ	Сумдын ЗДТГ, Хөдөлмөрийн хэлтэс, Аж ахуйн нэгж байгууллага
8.	Сэлэнгэд үйлдвэрлэдэг болон үйлдвэрлэх боломжтой бараа, бүтээгдэхүүний дотоодын зах зээлийг хамгаалах, зээл санхүүгийн бодлогоор дэмжих	2014-2016	ХХААЖДҮГ	Хөдөлмөрийн хэлтэс
9.	Жижиг, дунд үйлдвэрлэл, бизнес инкубаторын төвийг Сүхбаатар, Мандал суманд байгуулж, үйл ажиллагааг тогтворжуулах	2013-2016	Сүхбаатар, Мандал сумын ЗДТГ	Хөдөлмөрийн хэлтэс
10.	Жижиг, дунд үйлдвэр эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авах, шинэ технологи нэвтрүүлэхэд зориулж төрөөс санхүү, эдийн засгийн болон татвар, гаалийн дэмжлэгийг сурталчлах	2014-2016	Хөдөлмөрийн хэлтэс	Сумдын ЗДТГ
11.	Аймгийн хэмжээнд үйлдвэрлэл, үйлчилгээний 3-5 хоршоог үлгэр жишээ загвар хоршоо болгон бэхжүүлж, үзүүлэх сургууль хийж, туршлагыг нийтийн хүртээл болгох, орон нутгийн төсвөөс урамшуулах арга хэмжээ авах	2013-2016	ХХААЖДҮГ	Аймаг, сумдын ЗДТГ

Зорилт 3. Хөдөлмөр эрхлэлт, бүтээн байгуулалт, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр:

1.	Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн 6000-с доошгүй байнгын ажлын байрыг шинээр бий болгох	2013-2016	Аймгийн ЗДТГ	Сумдын ЗДТГ Хөдөлмөрийн хэлтэс
2.	Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд сум бүр 2-оос доошгүй төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах	2013-2016	Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс	Сумын ЗДТГ Хөдөлмөрийн хэлтэс
3.	Аж ахуйн нэгж байгууллага жил бүр 1-ээс доошгүй шинэ ажлын байр бий болгох	2013-2016	Сумын ЗДТГ	Хөдөлмөрийн хэлтэс

4.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах “Нэг иргэн-нэг байгууллага” хөдөлгөөн өрнүүлэх аяныг хэрэгжүүлэх	2013-2016	Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс	Сумдын ЗДТГ
5.	Мандал, Сүхбаатар суманд оёдлын үйлдвэрийг байгуулж 100-аас доошгүй шинэ ажлын байрыг бий болгох.	2013-2014	Мандал, Сүхбаатар сумын ЗДТГ	Хөдөлмөрийн хэлтэс
6.	Сумдад байгаль орчинд сөрөг нөлөөгүй түлшний хэрэглээг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх үүднээс “Шахмал түлш”-ний үйлдвэрийг байгуулахад дэмжлэг үзүүлэх	2013-2014	Аймаг, сумдын ЗДТГ	Хөдөлмөрийн хэлтэс Аж ахуйн нэгж байгууллага
7.	Эрүүл ахуйн шаардлага хангасан бизнесийн жишигт нийцсэн худалдааны төвийг Сүхбаатар суманд шинээр барьж байнгын ажлын байр бий болгох	2013-2016	Аймгийн ЗДТГ	Сумын ЗДТГ
8.	Орон нутагт хүнсний үйлдвэр, цехийг шинээр байгуулж, ажлын байр бий болгох	2013-2016	ХХААЖДҮГ	Аймаг, сумдын ЗДТГ
9.	Аймгийн “Чацаргана”, “Хүнсний ногоо” дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, тариалалтыг 165 га-гаар нэмэгдүүлэн ажлын байр бий болгох	2013-2016	ХХААЖДҮГ	Аймаг, сумдын ЗДТГ
10.	Усалгаатай үр тарианы талбайн ашиглалтыг сайжруулах болон хүлэмжийн аж ахуйг байгуулж тариалалтыг 1200 га-гаар нэмэгдүүлэн, ажлын байр бий болгох	2013-2016	ХХААЖДҮГ	Аймаг, сумдын ЗДТГ
11.	Сайхан суманд хөнгөн бетоны, Бугант тосгонд хавтангийн үйлдвэр байгуулж ажлын байр шинээр бий болгох	2013-2016	Сайхан, Хушаат, Ерөө сумын ЗДТГ	Хөдөлмөрийн хэлтэс
12.	Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон үйлдвэрлэл, аж ахуйн нэгжийн орон нутагт дэд бүтэц хөгжүүлэн, байгалийн нөхөн сэргээлт хийх, иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх үүрэг оролцоог нэмэгдүүлэх	2013-2016	Аймгийн ЗДТГ БОГазар	Сумдын ЗДТГ
13.	Албан бус хөдөлмөр эрхлэгчдэд үзүүлэх зээл сургалт, зөвлөгөө, бизнес инкубацийн үйлчилгээний хамрах хүрээг өргөжүүлэх, үр дүнг дээшлүүлэх зохион байгуулалтыг сайжруулахад арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх	2013-2016	Хөдөлмөрийн хэлтэс	Сумын ЗДТГ

14.	Орон нутагт хэрэгжиж байгаа бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрт болон ялангуяа зам, барилга байгууламж барихад дагалдах үйл ажиллагааны орон тооны 50-иас доошгүй хувьд орон нутгаас ажилтан авах механизмыг хэвшүүлэх	2013-2016	Худалдан авах ажиллагааны алба	Сумдын ЗДТГ
Зорилт 4. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, хүнсний болон хөнгөн үйлдвэрүүдийг шинээр байгуулан, үйлдвэрлэл, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр:				
1.	Сэлэнгэчүүдийн үйлдвэрлэсэн нэрийн бүтээгдэхүүнүүдийг дотоод гадаадын зах зээлд нийлүүлэхэд дэмжлэг үзүүлж “Сэлэнгийн ногоо” хүнсний зах, “Сэлэнгэд үйлдвэрлэв”, “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдааг зохион байгуулах	Жил бүр	Аймгийн ЗДТГ ХХААЖДҮГ	Сумдын ЗДТГ
2.	Сумдад арьс ширний анхан шатны боловсруулалт хийх цэг байгуулж, ажлын байр бий болгох	2013-2016	ХХААЖДҮГ	Аж ахуйн нэгж байгууллага
3.	Сумдад үхэр хонины зохиомол хээлтүүлгийн цэг байгуулж, мэргэжлийн боловсон хүчнээр хангаж, 34 ажлын байр шинээр бий болгох	2013-2016	ХХААЖДҮГ	Аж ахуйн нэгж байгууллага
4.	Тариалан эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгжийг олон үйлдэлт хөдөө аж ахуйн машин тоног төхөөрөмжөөр хангах бодлого хэрэгжүүлэх	2013-2016	ХХААЖДҮГ Аймгийн ЗДТГ	Аж ахуйн нэгж байгууллага
5.	Зөгий, гахай, шувуу, туулай үржүүлэх иргэдийн санал санаачилгыг бүх талаар дэмжиж, ажлын байр нэмэгдүүлэх	2013-2016	Аймгийн ЗДТГ	ХХААЖДҮГ Аж ахуйн нэгж байгууллага
Зорилт 5. Хөдөлмөр эрхлэлт хөдөлмөрийн харилцаанд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, нийгмийн түншлэлийн байгууллагуудын идэвх, санаачилгыг дэмжих:				
1.	Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны хууль, журмыг иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулах	2013-2016	ХАБЭА Салбар хороо	Хөдөлмөрийн хэлтэс МХГ

			ХЭСалбар зөвлөл	
2.	Зохистой, бүтээмжтэй, аюулгүй ажлын байрыг бий болгон түүнийгээ тогтвортой хадгалж байгаа ажил олгогчийн үйл ажиллагааг нь дэмжих, сурталчлах, урамшуулах арга хэмжээг зохион байгуулах	2013-2014	ХАБЭА Салбар хороо Аймгийн ЗДТГ	Хөдөлмөрийн хэлтэс
3.	Хөдөлмөрийн суурь зарчим, хөдөлмөрлөх эрхтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавьж, хөдөлмөрийн харилцаанд шударга, тэгш байдлыг хангахад төр-хувийн хэвшлийн болон иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог дэмжих	2013-2016	Аймгийн ЗДТГ Ажил олгогч эздийн холбоо, ҮЭХолбоо	Хөдөлмөрийн хэлтэс Аж ахуйн нэгж байгууллага
4.	Хөдөлмөр эрхлэлтийн удирдлага, бодлого зохицуулалтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэн, төр-хувийн хэвшил, нийгмийн түншлэгч байгууллагуудын санал санаачилга, хамтын ажиллагааг дэмжиж, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах	2013-2016	Аймгийн ЗДТГ	Сумдын ЗДТГ Хөдөлмөрийн хэлтэс
5.	Төр-хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, төрийн зарим үйлчилгээг гэрээний үндсэн дээр хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх хүрээг өргөжүүлэн үр дүнг сайжруулах	2013-2016	Аймгийн ЗДТГ	Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ажил олгогч эздийн холбоо
6.	Бичил уурхайн аргаар ашигт малтмал олборлох хөдөлмөр эрхлэгч иргэдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, холбогдох дүрэм журмын дагуу хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах	2013-2016	МХГазар	БОГазар Хөдөлмөрийн хэлтэс
7.	Уул уурхайн салбарт албан бусаар хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн талаар мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, албан хөдөлмөр эрхлэлтэд шилжүүлэх арга хэмжээ авах	2013-2016	Хөдөлмөрийн хэлтэс	МХГазар БОГазар
8.	Аймгийн хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт салбар хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	2013-2016	Аймгийн ЗДТГ	Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ажил олгогч эздийн холбоо

9.	Гадаадын хөрөнгө оруулалттай ААНБ-ын нийгмийн хариуцлагын тогтолцоог сайжруулах	2013-2016	Аймгийн ЗДТГ	Сумын ЗДТГ
10.	Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн бүтээмжийн хөдөлгөөн өрнүүлж хөдөлмөрийн бүтээмжийн талаарх сургалт сурталчилгааг зохион байгуулан 5S –ийн зарчмыг нэвтрүүлэх хөдөлгөөнийг өрнүүлэх	2013-2014	Аймгийн ЗДТГ	Сумдын ЗДТГ Хөдөлмөрийн хэлтэс
Зорилт 6. Хөдөлмөрийн зах зээл дэх мэргэжил, ур чадварын эрэлт нийлүүлэлтийг үндэслэн ажил олгогчийн хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх чиглэлээр:				
1.	Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, ажил олгогчдын хэрэгцээг үндэслэн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад элсэгчдийг бүртгэх, төгсөгчдийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх	2013-2016	МСҮТөв	Аймгийн ЗДТГ, Хөдөлмөрийн хэлтэс
2.	Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдад хөдөлмөрийн харилцааны мэдлэг, ёс зүйг төлөвшүүлэн, мэргэжлийн чиг баримжаа олгох арга хэмжээг зохион байгуулах	2015	Хөдөлмөрийн хэлтэс	Боловсрол соёлын газар
3.	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын хичээл-дадлагын баазыг өргөтгөх, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэн, суралцагчдын сурах орчинг сайжруулан чадамжид суурилсан сургалтын тогтолцоог төлөвшүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	2013-2016	Аймгийн ЗДТГ	МСҮТөв
4.	“Цемент- шохой” ХК-ний дэргэд барилгын үйлдвэрлэлийн чиглэлээр МСҮТ байгуулах ажлыг судалж шийдвэрлэх	2014-2016	Аймгийн ЗДТГ	Хөдөлмөрийн хэлтэс, Цемент- шохой ХК
5.	Эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө бүхий салбаруудад шаардагдах мэргэжилтэй ажилтныг ажлын байран дээр болон үйлдвэрлэл дээр тодорхой гэрээний дагуу богино хугацаанд сургаж, улмаар ажлын байраар хангах арга хэмжээг зохион байгуулах	2013-2016	Хөдөлмөрийн хэлтэс	Аж ахуйн нэгж байгууллага

Зорилт 7. Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санг боловсронгуй болгох:				
1.	Хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны талаархи үндсэн мэдээлэл, динамикийг агуулсан бүртгэл, мэдээллийн тогтолцоог бий болгох	2013-2016	Хөдөлмөрийн хэлтэс	Сумдын ЗДТГ Статистикийн хэлтэс
2.	Ажил олгогчид болон ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийг нэгдсэн бүртгэлд хамруулж, бүртгэлтэй ажилгүй иргэнийг байнгын ажлын байранд зуучлан оруулсан баг, сумын ажилтныг урамшуулах	2013-2016	Хөдөлмөрийн хэлтэс	Сумдын ЗДТГ
3.	Сум бүрт хөдөлмөр эрхлэлтийн биржийг зохион байгуулж хөдөлмөр зуучлалын нэгдсэн сүлжээг бий болгох	2014-2016	Аймгийн ЗДТГ Хөдөлмөрийн хэлтэс	Сумдын ЗДТГ
4.	Ажлын байрны нэгдсэн мэдээлэл болон ажилд зуучлалын үйлчилгээг оршин суугаа харьяалал харгалзахгүй үзүүлэх боломжоор хангах	2013-2016	Аймгийн ЗДТГ Хөдөлмөрийн хэлтэс	Сумдын ЗДТГ
5.	Алслагдсан сум, тосгонд ажлын байрны захиалгыг модемоор холбогдож интернетийн орчинд үйлчилгээг үзүүлэх	2013	Хөдөлмөрийн хэлтэс	Аймгийн ЗДТГ
Зорилт 8. Албан бус хэвшилд ажиллагчид болон хүн амын бүлгүүдийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн ажил орлоготой болгоход дэмжлэг үзүүлэх чиглэлээр:				
1.	Аймгийн онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр тусгайлсан төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх	2013-2016	Аймгийн ЗДТГ	Нийгмийн Хөгжлийн хэлтэс Хөдөлмөрийн хэлтэс
2.	Орон нутагт цэргийн дүйцүүлэх алба хааж байгаа залуучуудыг бүтээн байгуулалтын болон ойжуулах, цөлжилттэй тэмцэх байгалийн нөхөн сэргээх зэрэг ажилд татан оролцуулах	2014	Хөдөлмөрийн хэлтэс	Аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб
3.	“Эзэнтэй Монгол” хөтөлбөрийн хүрээнд байгалийн аюулт үзэгдэл, доройтол, гамшгийн үр дагаврыг арилган, нөхөн сэргээх үйл ажиллагааг ажил эрхлээгүй, ажил эрхлэх боломжтой иргэдийг оролцуулан зохион байгуулж, орлогоор дэмжих	2013	Хөдөлмөрийн хэлтэс	Сумдын ЗДТГ

4.	Байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёлын дурсгал бүхий Ээж мод, Амарбаясгалант, Сайхны хөтөл, Оргидог булаг, Хоёр элс, Дулаанхаан, Номтын рашаан зэрэг газруудыг аймгийн хамгаалтанд авч байнгын ажлын байр бий болгох	2013-2014	Аймгийн ЗДТГ	Хөдөлмөрийн хэлтэс
5	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймгийн салбар зөвлөлөөс баталсан Хөдөлмөр эрхлэлтийн талаархи хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх	2013-2014	Хөдөлмөрийн хэлтэс	Аймаг, сумдын ЗДТГ

_____ оОо _____

“АЖИЛТАЙ ОРЛОГОТОЙ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга:

С.Бүрэнбат

Аймгийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга:

Н.Батдорж

Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд:

Ч.Дэмбэрэлсайхан

Аймгийн Засаг даргын Тамгын газрын

Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга

Х.Даваахүү

Аймгийн ХХААЖДҮГ-ын дарга

Ж.Батсайхан

Аймгийн Засаг даргын Тамгын газрын

Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Д.Энхсайхан

Аймгийн Мэргэжлийн хяналтын

газрын дарга

Л.Зоригтбаатар

Хөдөлмөрийн хэлтсийн дарга

Ж.Саранцэцэг

Аймгийн Үйлдвэрчний Эвлэлийн
холбооны дарга

Н.Энэбиш

Ажил олгогч эздийн холбооны тэргүүн

_____оОо_____

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 07 сарын 15-ны өдөр

Дугаар 87

Сүхбаатар

Наадам зохион байгуулах тухай

Иргэдийн хүсэлт, Сэлэнгэ аймгийн нутгийн зөвлөл, тус аймгаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийн санаачилга, аймгийн Засаг даргын саналыг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан журмын 3.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Ардын хувьсгалын 92 жилийн ой, Үндэсний их баяр наадмаар 9 даван түрүүлж “Монгол Улсын аварга” хэмээх Монгол бөхийн эрхэм дээд цол хүртсэн Сэлэнгэ аймгийн харъяат Гунаажавын Эрхэмбаярт хүндэтгэл үзүүлэх Сэлэнгэ түмний талархлын баяр наадмыг 2013 оны 08 дугаар сарын 02-ны өдөр аймгийн төв Сүхбаатар хотод зохион байгуулсугай.

2.Наадмын зардлыг 2013 оны аймгийн төсөвт тусгагдан батлагдсан “Сэлэнгэ түмэн” арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг дарга /С.Бүрэнбат/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 08 сарын 01-ний өдөр

Дугаар 88

Сүхбаатар

Сэлэнгэ аймгийн “Хүндэт иргэн”-ээр
өргөмжлөх тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1997 оны 72 дугаар тогтоолоор баталсан журмыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ түмний бахархал болсон үндэсний бөхийн Монгол Улсын 21 дэх аварга Гунаажавын Эрхэмбаярыг төрүүлж өсгөн хүмүүжүүлсэн ач гавъяаг нь үнэлж Мандал сумын иргэн Төржаргалын Даваадуламыг Сэлэнгэ аймгийн “Хүндэт иргэн”-ээр өргөмжилсүгэй.

2.”Хүндэт иргэн”-ний дагалдах мөнгөн шагналыг төсвөөс гаргахыг аймгийн Засаг даргад зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 08 сарын 28-ны өдөр

Дугаар 100

Сүхбаатар

Ой тэмдэглэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой тэмдэглэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Ерөө сум байгуулагдсаны 90 жилийн ойг 2014 оны 07 дугаар сард тэмдэглэхийг зөвшөөрсүгэй.

2. Ойгоо угтаж сумынхаа байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, иргэдийн идэвх санаачилгыг өрнүүлэн тодорхой бүтээлч ажил зохион байгуулж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад даалгаж, сумын нийт иргэдэд уриалсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 09 сарын 09-ний өдөр

Дугаар 103

Сүхбаатар

**Хилийн цэсийн эргэлтийн цэгүүдийг
хүлээн зөвшөөрсөн тухай**

Тус аймгийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийн эргэлтийн цэгүүдийг солбицжуулж, баталгаажуулах ажил гүйцэтгэсэн “Глобус” ХХК-ний ажлын тайлан, уг ажлыг хамтарч зохион байгуулсан аймгийн мэргэжлийн комиссын санал дүгнэлтийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ нь:**

1.ОХУ, Хэнтий, Төв, Булган, Орхон аймгуудтай хиллэж байгаа хилийн цэсийн эргэлтийн цэгүүдийн нэр, солбицлын жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар, Дархан-Уул аймагтай хиллэж байгаа хилийн цэсийн эргэлтийн цэгүүдийн нэр, солбицлын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус зөвшөөрч баталсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2013 оны 09 дүгээр сарын 09-ний
өдрийн 103 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХИЛИЙН ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙН НЭР,
ТООТЫГ ТОДОТГОН, СОЛБИЦОЛЖУУЛЖ НЭГТГЭСЭН ХҮСНЭГТ**

Дд	Хилийн цэсийн эргэлтийн цэгийн нэр	Х	Ү
1	Баруун хужиртын даваа	104° 25' 42.91	50° 18' 21.465
	Улсын хилээр		
2	Сэлэнгэ-Сэлэнгийн татуургын уулзвар	106° 5' 28.805	50° 20' 5.867"
	Улсын хилээр		
3	Хаданцайн-Бол улилэйн голын уулзвар 898.2	108° 1' 48.941	49° 37' 19.642
	Улсын хилээр		
4	Хаданцай-Ондолын голын уулзвар	108° 34' 49.16	49° 20' 8.538"
5	1274 тоот	108° 34' 33.31	49° 19' 21.223
6	1450.9 тоот	108° 31' 35.68	49° 11' 15.017
7	Минж-Захарын голын уулзвар	108° 30' 17.20	49° 9' 19.346"
	Минж голын урд эргээр		
8	Минж-Их Ухнын голын уулзвар	108° 7' 4.205"	49° 2' 17.793"
9	Сонгино уул 1752.6	108° 4' 1.442"	49° 2' 27.941"
10	Арцат уул 1984.6	107° 56' 8.257	49° 5' 59.835"
11	Улаан хад 1977.5	107° 45' 8.137	49° 5' 24.042"
12	Ерөөгийн халуун рашаан 1089	107° 32' 59.34	49° 1' 5.580"
13	Шар төвгөр уул 1847.4	107° 36' 13.83	48° 55' 44.969
14	Даваатын даваа	107° 38' 16.91	48° 54' 22.698
15	Ангал 1995	107° 42' 11.23	48° 53' 10.225
16	1960.9 тоот	107° 44' 2.588	48° 53' 4.688"
17	Ар матахын уул 2144.9	107° 46' 12.12	48° 50' 20.133
18	Өвөр матах уул 2120.5	107° 43' 55.50	48° 48' 59.846
19	Ест-Өвөр матах голын уулзвар	107° 41' 13.64	48° 43' 36.729
20	1545.7 тоот	107° 40' 31.29	48° 43' 5.362"
21	1646.5 тоот	107° 40' 17.83	48° 40' 45.688
22	Хүрэн даваа 1521	107° 41' 48.96	48° 39' 8.694"
23	Бага чулуут-Арцын арын голын уулзвар	107° 41' 28.54	48° 38' 17.227
	Бага Чулуут голын урд эргээр		
24	Их-Бага чулуут голын уулзвар	107° 35' 9.733	48° 38' 48.736
	Их Чулуут голын урд эргээр		
25	Чулуут-Нэмэхийн голын уулзвар	107° 30' 26.58	48° 39' 10.169
	Нэмэхийн голын хойд эргээр		
26	Нэмэх-Хурхын голын уулзвар	107° 22' 14.56	48° 36' 25.451
	Нэмэхийн голын хойд эргээр		

27	Нэмэхийн даваа 1678	107° 15' 40.47	48° 35' 37.087
28	Итэмийн даваа 1622.2	107° 12' 30.87	48° 36' 13.674
29	Гивчээгийн чулуут уул 1980.3	107° 9' 30.557	48° 38' 33.230
	Улаан шивэртийн нуруугаар		
30	Хараатын голын баруун гозгор 1918.3	107° 5' 32.077	48° 38' 52.006
31	Буянтын голын эх 1769	106° 59' 49.29	48° 37' 8.641"
32	Түнхэлийн урд нуруу 1804.7	106° 56' 30.61	48° 38' 5.429"
33	Булгийн гозгор уул 1620.8	106° 50' 15.95	48° 36' 29.091
34	Цогт Өндөр уул 1660.4	106° 48' 26.49	48° 35' 40.977
35	Хараа голын 1026.6	106° 47' 4.417	48° 34' 36.597
36	Хавчиргангын даваа 1210	106° 46' 37.40	48° 32' 50.692
37	1490.2 тоот	106° 39' 14.55	48° 32' 56.467
38	Хамар даваа 1349	106° 38' 20.65	48° 32' 52.511
39	Хар модот 1577.1	106° 33' 55.55	48° 33' 11.291
40	Зурамтын эх	106° 31' 42.60	48° 33' 14.905
41	Зуунмод	106° 32' 10.71	48° 35' 52.759
42	Бөмбөг уул 1575.5	106° 28' 0.950	48° 37' 8.238"
43	1598 тоот	106° 25' 54.99	48° 37' 46.982
44	1293.6 тоот	106° 23' 20.96	48° 39' 18.216
45	998.6 тоот	106° 18' 35.63	48° 40' 22.804
46	Нугын хушуу	106° 16' 45.81	48° 41' 11.976
47	Хар цавын гозгор 1198.7	106° 12' 25.56	48° 41' 28.811
48	Өвөр зүрхийн даваа 1217.3	106° 5' 25.727	48° 38' 47.683
49	1423.8 тоот	106° 1' 32.967	48° 42' 33.696
50	Баянцогт уул 1448.7	105° 57' 57.75	48° 43' 3.679"
51	Нарст 1033.7	106° 3' 44.647	48° 48' 56.796
52	Бор толгой	106°4'34.900"	48°51'10.100"
53	Бараат 1159.6	105° 55' 0.835	48° 53' 0.265"
54	Шувуутын даваа 1010	105° 49' 14.14	48° 53' 16.584
55	Шар хөтөл 1170	105° 36' 34.30	48° 50' 35.000
56	1353.8 тоот	105° 34' 31.90	48° 50' 14.111
57	Бүрэгтэйн зүүн хөтөл	105° 33' 40.16	48° 50' 7.181"
58	Бүрэгтэйн нурууны эх 1469.5	105° 31' 23.73	48° 49' 26.902
59	Долоон Гэлэн уул	105° 27' 53.23	48° 48' 35.862
60	Сэвсүүлийн даваа 1182.3	105° 26' 55.30	48° 46' 50.033
61	Сэвсүүлийн Үзүүр гозгор уул 1243.9	105° 27' 55.82	48° 44' 18.755
62	Мангина энгэр 1116.5	105° 28' 20.00	48° 40' 9.160"
63	Зүүн гозгор 1179.2	105° 22' 43.54	48° 36' 12.554
64	Давхар 1224.8	105° 19' 42.29	48° 36' 6.710"
65	Цээлийн хөх хошуу	105° 12' 54.16	48° 35' 22.490
66	Сүүл гозгор уул 1071.3	105° 10' 47.01	48° 34' 55.902
67	Баруун гозгор 1089.9	105° 4' 57.607	48° 33' 51.172
68	Эрээн хавирга уул 1286.8	105° 1' 1.142"	48° 31' 47.847

69	Үнэгтийн эх	104° 57' 2.511	48° 33' 0.865"
70	Хөөврийн шар толгой 1254.2	104° 51' 42.11	48° 34' 32.019
71	Хавцгайтын овоо 1291.7	104° 47' 57.60	48° 34' 5.933"
72	Завлайн шар 1310.9	104° 45' 1.990	48° 35' 34.032
73	Өвөр булгийн хавцал	104° 40' 1.518	48° 37' 44.572
74	Гэртийн тохой	104° 35' 42.97	48° 38' 38.016
75	Шар чулуутын урд үзүүр	104° 32' 43.34	48° 37' 33.000
76	Шар чулуут уул 1223.2	104° 30' 54.75	48° 39' 0.154"
77	840.2 тоот	104° 29' 45.63	48° 43' 16.375
	Орхон голын урд эргээр		
78	Орхон-Хангал голын билчир	104° 37' 28.24	48° 51' 3.977"
79	Бор овоо уул 1469.6	104° 31' 59.04	48° 50' 52.109
80	Цагаан овоо 1564	104° 27' 49.74	48° 53' 8.668"
81	Арцатын даваа 1327.4	104° 24' 34.83	48° 54' 57.184
82	Шанш толгой 1134.9	104° 28' 17.88	48° 57' 44.897
83	Чулуун хөшөө	104° 32' 10.13	49° 0' 46.677"
84	Бүдүүн хуст 1438.2	104° 37' 57.51	49° 3' 37.865"
85	Хөшөөтийн даваа 1310.2	104° 36' 57.58	49° 4' 51.323"
86	Хонгор морьтын даваа 1390	104° 35' 0.861	49° 6' 1.268"
87	Нарийн билчир	104° 34' 16.12	49° 7' 21.156"
88	Шувуутын даваа 1425.1	104° 32' 16.47	49° 8' 10.271"
89	Тувын нуруу 1577	104° 31' 15.98	49° 9' 52.380"
90	Нялхын гозгор уул 1602.2	104° 32' 7.808	49° 10' 53.342
91	1608.9 тоот	104° 32' 54.39	49° 12' 1.407"
92	Сангийн даваа 1415.8	104° 33' 4.690	49° 14' 56.249
93	Бэрхийн гозгор уул 1625.4	104° 35' 52.55	49° 17' 27.188
94	Шанд Оорцог уул 1747.2	104° 35' 55.38	49° 18' 49.599
95	Ажнайн даваа	104° 36' 59.30	49° 20' 4.365"
96	Хөх чулуу 1898.8	104° 36' 11.28	49° 20' 54.867
97	Бүрэн уул 1985.5	104° 36' 39.10	49° 25' 35.420
98	Урианхайн зүрх 1372.2	104° 41' 5.462	49° 28' 49.090
99	Гүн голын гүн чулуу 1426.5	104° 41' 44.58	49° 31' 18.545
100	Бугатын аяган 1235.2	104° 41' 42.22	49° 37' 29.312
101	Дөшлүүр	104° 42' 3.466	49° 39' 54.239
102	Сэлэнгэ-Сэлэнгийн татуургын уулзвар	104° 41' 19.00	49° 40' 10.000
	Сэлэнгэ голын урд эргээр		
103	Дэлгэр өндрийн урд үзүүр	104° 46' 50.73	49° 40' 50.582
104	Дэлгэр өндөр уул 1020.3	104° 46' 54.51	49° 41' 46.310
105	Манхтайн даваа 818	104° 45' 20.45	49° 44' 18.164
106	Дашлэнгийн овоо 1021.4	104° 41' 26.93	49° 46' 38.975
107	Асгат уул 1300.6	104° 35' 48.55	49° 49' 59.400
108	1418.3 тоот	104° 31' 31.06	49° 52' 34.428
109	Бүтээл уул 1392.7	104° 31' 51.03	49° 57' 22.477

110	1366.4 тоот	104° 31' 50.60	50° 0' 39.390"
111	1322.5 тоот	104° 34' 28.31	50° 5' 7.845"
112	Ар шүрэнгийн голын баруун хамар	104° 35' 1.671	50° 5' 51.039"
113	Ар шүрэнгийн голын баруун хамрын үзүүр	104° 33' 58.92	50° 8' 1.530"
	Зэлтэр голын урд эргээр		
114	Зэлтэр-Баруун хужирт голын билчир	104° 35' 37.28	50° 9' 8.987"
	Баруун хужиртын голын зүүн эргээр		
1	Баруун хужиртын даваа	104° 25' 42.91	50° 18' 21.465

_____оОо_____

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2013 оны 09 дүгээр сарын 09-ний
өдрийн 103 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ДАРХАН-УУЛ АЙМАГТАЙ ХИЛЛЭХ
ХИЛИЙН ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙН НЭР, ТООТЫГ ТОДОТГОН
СОЛБИЦОЛЖУУЛЖ НЭГТГЭСЭН ХҮСНЭГТ**

Д/д	Хилийн цэсийн эргэлтийн цэгийн нэр	Х	Ү
1	Орхон -Ерөө голын билчир	106° 8' 12.489	49° 54' 58.489
	Ерөө голын хойд эргээр		
2	Ерөөгийн гүүр	106° 14' 38.23	49° 52' 47.073
	Засмал замаар		
3	245-р км-н шон	106° 1' 39.754	49° 38' 56.995
4	Шарын голын 693.4	106° 3' 59.495	49° 38' 49.265
	Шарын голоор		
5	Билчирын хушуу	106° 25' 45.40	49° 31' 14.500
6	Шохойт өндөр 1022.4	106° 27' 17.97	49° 33' 23.602
7	Цахиурт толгой 1078	106° 28' 16.07	49° 35' 14.094
8	1090.5 тоот	106° 31' 30.09	49° 35' 13.078
9	Хөх чулуут уул 1278.9	106° 36' 13.51	49° 35' 43.701
10	Яргайтын даваа 997.4	106° 37' 54.38	49° 34' 55.474
11	Хонгорын даваа	106° 40' 43.92	49° 29' 1.630"
12	Бүхлээгийн баруун уул	106° 48' 7.095	49° 23' 48.093
13	Харганы Байц уул 1262.4	106° 47' 20.48	49° 22' 21.256
14	Элээт өндөр уул 1417.5	106° 45' 46.85	49° 19' 41.883
15	Могойн даваа 1333.4	106° 46' 21.47	49° 15' 57.707
16	Могойт өндөр уул 1397.8	106° 47' 8.414	49° 14' 3.473"
17	Хар модот уул 1649.7	106° 49' 26.99	49° 9' 34.821"
18	Гахайн овоо уул 1527.8	106° 45' 47.86	49° 11' 20.047

19	Хавчиг Шар Нарст уул 1246.9	106° 37' 48.11	49° 10' 40.405
20	Хар ямаат 1399.1	106° 32' 1.239	49° 10' 50.777
21	Тэхийн шээгт 1163.3	106° 28' 33.42	49° 10' 50.091
22	Ногоон хушуу	106° 26' 31.92	49° 10' 29.260
23	Уст толгой	106° 25' 59.67	49° 12' 3.363"
24	988.2 тоот	106° 23' 34.24	49° 12' 29.802
25	Байнга Их уул 1237.8	106° 20' 13.04	49° 13' 4.977"
26	Нарстай хөтөл 1025	106° 18' 4.540	49° 14' 0.818"
27	Ульдаг уул 1225.7	106° 11' 45.24	49° 12' 17.970
28	Тугалч уул 1242.7	106° 8' 42.655	49° 10' 24.723
29	Барзан 1194.1	106° 7' 24.695	49° 8' 11.165"
30	Хустын даваа	106° 2' 39.900	49° 8' 46.100"
31	Урд салхит 964.5	105° 55' 50.01	49° 7' 20.368"
32	Хараа голын 8-р шон	105° 52' 19.10	49° 7' 42.600"
	Хараа голын зүүн эргээр		
33	Ухаа хушууны гүүр	105° 53' 49.88	49° 23' 22.694
	Хараа голын зүүн эргээр		
34	Ногоон модны гүүр 1-р шон	105° 53' 52.40	49° 30' 46.297
	Хараа голын зүүн эргээр		
35	Орхон-Хараа голын билчир	105° 49' 59.48	49° 37' 54.900
	Орхон голын хойд эргээр		
36	748.6 тоот толгойн урд үзүүр	105° 53' 42.17	49° 41' 40.979
	Орхон голын хойд эргээр		
1	Орхон -Ерөө голын билчир	106° 8' 12.489	49° 54' 58.489

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 09 сарын 09-ний өдөр

Дугаар 104

Сүхбаатар

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7-д заасныг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журмыг хавсралтаар баталсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭД ХӨРӨНГИЙН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд хамаарах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө /цаашид “эд хөрөнгө” гэх/-ийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах тэдгээртэй холбогдон гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлт гүйцэтгэлийг тооцож, тайлагнахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгийг эрх бүхий байгууллагаас баталсан төсөв болон УИХ болон аймгийн ИТХ-ын шийдвэрээр баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу худалдаж авах, эсхүл хуулийн этгээд, хувь хүнээс үнэ төлбөргүй шилжүүлж авах, түүнчлэн хандив, тусламж, бэлэглэл, эрх залгамжлах журмаар олж авна.

1.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга /захирал/ нь орон нутгийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, үр өгөөжийг нь дээшлүүлэх, бүрэн бүтэн байдлыг хангах талаар хууль тогтоомжоор олгосон эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

1.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгө олж авах шинээр бий болгох өөрийн эзэмшилд байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл элэгдлийн хэмжээ нь дуусаагүй боловч ашиглалтын явцад эвдэрч гэмтсэнээс цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, актлах саналыг холбогдох материалыг бүрдүүлэн Орон нутгийн өмчийн албанд ирүүлнэ.

1.5. Орон нутгийн өмчийн алба нь орон нутгийн өмчит хуулийн этгээдээс ирүүлсэн саналыг хүлээн авч хянан үзээд аймгийн Засаг даргад танилцуулж, аймгийн Засаг дарга эд хөрөнгийг олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах саналыг аймгийн ИТХ-д оруулж шийдвэр гаргуулна.

1.6 Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь үйлдвэрлэл, ажил үйлчилгээний үр дүнд бий болсон эд хөрөнгө, хандив, банкны зээл, тусламж, бэлэглэл, эрх залгамжлах, нийгэмчилсэн, өр төлбөрт тооцон авсан, дайчилсан буюу хураан авах журмаар эд хөрөнгө олж авбал энэ тухай Орон нутгийн өмчийн албанд мэдэгдэж, уг хөрөнгийг бүртгэлд тусгана.

1.7 Тухайн байгууллагын хувьд илүүдэлтэй болон ашиглалтгүй, эсхүл сэргээн засварлаж ашиглахад эдийн засгийн хувьд үр ашиггүй болох нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг зөвхөн дуудлагаар худалдах бөгөөд худалдах шийдвэрийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид гаргаж дуудлага худалдааны доод үнийг тогтооно.

1.8. Эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах тухай аймгийн ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг тухайн хуулийн этгээдийн дарга /захирал/ хариуцан зохион байгуулж, биелэлтийг шийдвэрт заасан хугацаанд холбогдох материалын хамт аймгийн Орон нутгийн өмчийн албанд ирүүлэх үүрэг хүлээнэ.

1.9. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах тухай саналаа аймгийн Орон нутгийн өмчийн албанд ирүүлэхдээ тухайн харилцаанд хамааралтай баримтыг бүрдүүлнэ.

Хоёр. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн олж авсан эд хөрөнгийг бүртгэх

2.1. Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр зээл тусламжийн хөрөнгөөр бий болгосон худалдан авсан бараа, ажил үйлчилгээ болон гадаад дотоодын иргэн аж ахуйн нэгж байгууллагаас орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд өгсөн эд хөрөнгө, хөрөнгө оруулалт, их засвар, хандив, бэлэглэл, төслийн шугамаар бий болсон хөрөнгийг орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээд тайлан балансдаа тухай бүрт шууд бүртгэн авна.

2.2. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, зээл тусламжийн хөрөнгөөр шинээр олж авсан, бий болгосон үл хөдлөх болон хөдлөх үндсэн хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэж авах асуудлыг орон нутгийн өмчийн алба нэгдсэн жагсаалтаар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд оруулан шийдвэр гаргуулна.

2.3. Гадаад дотоодын хандивлагч байгууллага, иргэд, хуулийн этгээдээс хэрэгжүүлсэн төсөл, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг тухайн иргэн, хуулийн этгээдийн албан ёсны зөвшөөрлийг авсны үндсэн дээр үндсэн болон эргэлтийн хөрөнгөөр нь ангилан, ашиглах хугацаа, чанар байдлыг нь харгалзан ашигласан хугацааны элэгдэл, хорогдлын шимтгэлийг тооцож данс бүртгэлдээ тусгаж байх асуудлыг хөрөнгө хүлээн авч буй хуулийн этгээд өөрөө хариуцна.

2.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын хандивлагч байгууллага, иргэд, хуулийн этгээдээс хэрэгжүүлсэн төсөл, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн

хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй, маргаантай тохиолдолд аймгийн ИТХ-д асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ.

Гурав. Эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх

3.1. Эд хөрөнгийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн илүүдэлтэй буюу ашиглагддаггүй, эсвэл ашиглалтын шаардлага хангахгүй, засаж сэлбэн ашиглахад үр ашиггүй болсон эд хөрөнгийг цаашид зориулалтаар нь болон зориулалтыг нь өөрчлөн ашиглах боломжтой бол орон нутгийн өмчит нэг хуулийн этгээдээс орон нутгийн өмчит нөгөө хуулийн этгээдэд балансаас балансад шилжүүлж болно.

3.2. Барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай машин, тоног төхөөрөмжийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр, бусад эд хөрөнгийг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр шилжүүлнэ.

3.3. Эд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдон гарах зардлыг шилжүүлж авсан байгууллага хариуцна.

3.4. Эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэхэд дараах материалыг бүрдүүлнэ.

а/ Хуулийн этгээдийн эрх барих болон харьяа дээд байгууллагын зөвшөөрөл;

б/ Эд хөрөнгө шилжүүлэн өгөх, шилжүүлэн авах байгууллагын санал албан бичиг;

в/ Хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлт;

г/ Шилжүүлэх хөрөнгийн нэр төрөл, марк, дугаар, тоо ширхэг, анхны болон одоогийн үнэ өртөг, байгуулсан элэгдэл;

Дөрөв. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах

4.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хагас болон бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогын дүн, өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлт, саналыг үндэслэн хөрөнгө акталж данснаас хасах тухай асуудлаа тухай бүр Орон нутгийн өмчийн албанд ирүүлж зохих шийдвэр гарсны дараа хэрэгжүүлнэ.

4.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр данснаас хасна. Үүнд:

4.2.1. Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ нөхсөн, эсхүл ашиглалтын хугацаа нь дуусаагүй боловч ашиглах явцад хэн нэгний

буруутай үйлдлээс болж эвдэрч гэмтэн цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын дүгнэлт гаргуулан буруутай этгээдээр хохирлыг барагдуулсан тохиолдолд;

4.2.2. Техник, технологийн болон хэрэглээний хоцрогдолд орж, зайлшгүй шинэчлэх шаардлагатай болсон эд хөрөнгө;

4.2.3. Балансын үнээ бүрэн нөхөөгүй боловч байгалийн гэнэтийн аюул, техникийн осолд өртсөнөөс цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон эд хөрөнгө;

4.2.4. Ашиглалтын явцад эвдэрч гэмтсэнээс засвар шинэчлэл хийж ашиглахад эдийн засгийн хувьд үр ашиггүй болох нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгө;

4.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгө актлах саналаа Орон нутгийн өмчийн албанд ирүүлэхдээ дор дурдсан зүйлийг илэрхийлсэн байна.

а/ хуулийн этгээдийн эрх барих болон харьяа дээд байгууллагын зөвшөөрөл;

б/ худалдан авах эх үүсвэр санхүүжилтийг баталсан эрх бүхий байгууллагын шийдвэр, хуваарилагдсан төсөв;

в/ хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлт;

г/ мэргэжлийн байгууллагын акт, дүгнэлт; /Орон нутгийн өмчийн албаны тодорхойлолт /

д/ эдийн засгийн тооцоо, үндэслэл;

е/ ашиглалтын хугацаа, элэгдлийн хэмжээ дуусаагүй боловч эвдрэл, гэмтлийн улмаас ашиглах боломжгүй үндсэн хөрөнгийн эвдрэл, гэмтэл болон хуулийн этгээдэд учирсан хохирлын хэмжээг мэргэжлийн байгууллагаас тогтоосон акт дүгнэлт, хууль хяналтын байгууллагын шийдвэр, хохирол барагдуулсныг нотлох баримт, сэргээн засварлаж ашиглахад шаардагдах эдийн засгийн тооцоо үндэслэл;

ё/ үл хөдлөх хөрөнгийн хувьд хөрөнгийн үнэлгээний байгууллагын үнэлгээ;

и/ үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй номыг устгах талаар гаргасан холбогдох мэргэжлийн байгууллагын зөвшөөрөл;

й/ үндсэн хөрөнгөд бүртгэлтэй буу, галт зэвсгийг хураах талаар Цагдаагийн байгууллагын албан ёсны зөвшөөрөл;

к/ бусад шаардлагатай баримт, материал.

4.3.1. Үл хөдлөх хөрөнгийн хувьд энэ журмын 4.3-д зааснаас гадна доорх мэдээллийг ирүүлнэ:

а/ эзэмших болон ашиглах эрхийн гэрчилгээ, газар эзэмшүүлэх болон ашиглуулах гэрээ, барилга техникийн төлөв байдлын талаарх мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт, ашиглалт, их болон урсгал засвар, эд хөрөнгийн хариуцлагын /зээл, өрийн барьцаа, эрх бүхий байгууллагын шийдвэр/ талаарх мэдээлэл, барилгын паспорт, кадастрын зураг, орчны тойм зураг, байгуулалтын /план/ болон гадна, дотор талын өнгөт фото зураг, инженерийн сүлжээний техникийн зураг, бусад бичиг баримт.

4.3.2. Тээврийн хэрэгслийн хувьд доорх мэдээллийг ирүүлнэ:

а/ тээврийн хэрэгслийн гэрчилгээ болон бусад техникийн баримт бичгийн хуулбар, техникийн үзүүлэлт, 3 талаас нь авсан өнгөт фото зураг;

б/ төслийн шугамаар ашиглагдаж байсан бол гаалийн татвар төлөлтийн талаарх мэдээлэл, холбогдох баримт;

в/ ашиглалтын явцад хийж гүйцэтгэсэн ажлын хэмжээ;

г/ Сүүлийн 3 жилийн сэргээн босголтын зардал, /шинээр тавьсан сэлбэгийн нэр төрөл, үнийн дүн/

4.3.3. Механизм, тоног төхөөрөмжийн хувьд доорх мэдээллийг ирүүлнэ:

а/ механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын паспортын хуулбар;

б/ бусад шаардлагатай материал.

4.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн харилцааны зарим асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиас гадна Монгол Улсын хууль тогтоомж, Олон Улсын гэрээ, конвенц болон Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэрээр тусгайлан зохицуулсан тохиолдолд энэхүү журам үйлчлэхгүй.

4.5. Аймгийн ИТХ-ын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх хүртэлх хугацаанд тухайн эд хөрөнгийн иж бүрдэл, чанар байдал, бүрэн бүтэн байлгах асуудлыг байгууллагын удирдлага хариуцаж, харуул хамгаалалттай байлгах үүрэг хүлээх бөгөөд эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал алдагдвал хариуцлагыг зохих хууль

тогтоомжийн хүрээнд Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга /захирал/ хүлээнэ.

4.6. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид үндсэн байгууллагаас ирүүлсэн материал, орон нутгийн өмчийн алба, аймгийн Засаг даргын саналыг нягтлан хэлэлцээд доорх шийдвэрийн аль нэгийг гаргана.

а/ эд хөрөнгийг худалдах;

б/ бусад төрийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэх;

в/ сэлбэг, материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах;

г/ шууд устгах;

д/ өөрийн эзэмшилд байгаа газраа цаашид ямар зориулалтаар ашиглах талаар эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ;

е/ газар дээрх болон газар доорх барилга байгууламжийг буулгах, ашиглаж болох материалыг үнэ тогтоон орлогод авах, хог хаягдлыг цэвэрлэх, газрыг нөхөн сэргээх.

4.7. Орон нутгийн өмчит хуулийн этгээдээс үндсэн хөрөнгийг акталж сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах, данснаас хасах аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрийг Орон нутгийн өмчийн алба холбогдох байгууллагад хүргүүлж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.

4.8. Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгийг акталж сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах бол устгалын акт, эргэлтийн хөрөнгөд орлого болгосон тэмдэглэл тайланг Орон нутгийн өмчийн албанд өгнө.

_____оОо_____

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 09 сарын 09-ний өдөр

Дугаар 105

Сүхбаатар

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 126 дугаар тогтоолын 1 дэх заалтын “Бэлчир-Сэлэнгийн бүсийн сум дундын ойн ангийг Сүхбаатар суманд” гэснийг “Сэлэнгэ-Бэлчирийн бүсийн сум дундын ойн ангийг Цагааннуур суманд” гэж өөрчилсүгэй.

2.Уг тогтоолын 1 дүгээр хавсралтын сум дундын ойн ангийн байршил Сүхбаатар суманд гэснийг Цагааннуур, хамрагдах сумын нэр-Алтанбулаг, Зүүнбүрэн, Түшиг, Сүхбаатар, Шаамар гэж өөрчилсүгэй.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 09 сарын 09-ний өдөр

Дугаар 106

Сүхбаатар

Нэмэлт модны хуваарь батлах тухай

Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Аймгийн Засаг даргын оруулсан саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 онд 12 сарын 26-ны А/145 тоот тушаалаар баталсан 2013 онд ойгоос мод бэлтгэх дээд хязгаарт багтаан хуваарилагдаагүй үлдсэн нөөцөөс зарим суманд нэмэлтээр бэлтгэх модны хэмжээг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. 2013 онд Мандал суманд бэлтгэх модны төрлийг өөрчлөн шинэчилсэн хуваарийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3. Ойгоос мод бэлтгэх ажилд гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллахыг дээрх сумдын ИТХ, Засаг дарга, Байгаль орчны газар /Б.Батзориг/, Мэргэжлийн хяналтын газар /Д.Энхсайхан/ -т үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2013 оны 09 дүгээр сарын 09-ний
өдрийн 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОЛОН АХУЙН ЗОРИУЛАЛТААР 2013 ОНД НЭМЖ
БЭЛТГЭХ МОДНЫ ХЭМЖЭЭ**

Зориулалт	Модны төрөл	Хэмжих нэгж	Сумын нэр					Дүн
			Баянгол	Ерөө	Түшиг	Алтанбулаг	Баруунбүрэн	
Үйлдвэрлэлийн хэрэгцээ	Шинэс	М3		1000				1000
	Нарс	М3		2000				2000
	хус	М3						
Дүн		М3		3000				3000
Арчилгааны	Шинэс	М3						
	Нарс	М3			1500			1500
	Улиангар	М3						
	Улиас	М3						
	хус	М3						
Дүн		М3			1500			1500
Цэвэрлэгээний	Улиангар	М3	1800					1800
	Шинэс	М3						
	Нарс	М3			270	300	500	1070
	хус	М3	1700					1700
	Улиас	М3						
	Хуш /хуурай/	М3						0
Дүн		М3	3500		270	300	500	4570
Нийт дүн	Шинэс	М3		1000				1000
	Нарс	М3		2000	1770	300	500	4570
	хус	М3	1700					1700
	Улиас	М3						
	Улиангар	М3	1800					1800
	Хуш /хуурай/	М3						
Бүх дүн		М3	3500	3000	1770	300	500	9070

oOo

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2013 оны 09 дүгээр сарын 09-ний
өдрийн 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**МАНДАЛ СУМЫН 2013 ОНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОЛОН АХУЙН
ЗОРИУЛАЛТААР БЭЛТГЭХ МОДНЫ ХЭМЖЭЭ**

Зориулалт	Модны төрөл	Хэмжих нэгж	Бүгд
Үйлдвэрлэлийн хэрэгцээ	шинэс	м3	3200
	нарс	м3	
	хус	м3	
	хуш /хуурай /	м3	
дүн		м3	3200
Арчилгааны огтлолтоор	шинэс		
	нарс		9500
дүн			9500
Цэвэрлэгээний	шинэс	м3	
	нарс	м3	5000
	хус	м3	
	хуш /хуурай /	м3	3000
дүн			8000
Бүх дүн	шинэс	м3	3200
	нарс	м3	14500
	хус	м3	
	хуш /хуурай /	м3	3000
Нийт		м3	20700

оОо

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 09 сарын 09-ний өдөр

Дугаар 107

Сүхбаатар

**Гачууртын алтны үндсэн ордыг ашиглах
төслийг дэмжих тухай**

Баянгол сумын ахмадын хороо, Мандал сумын Түнхэл тосгоны ахмадын хороо, ахмадуудаас Монгол Улсын Их Хурал, Засгийн газарт хандаж гаргасан хүсэлт, иргэдийн саналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцээд Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Нутгийн иргэдийн санал хүсэлтийг иш үндэс болгон тус аймгийн нутаг дэвсгэрт тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаль орчинд ээлтэй, хүн малд хор хөнөөлгүй дэвшилтэт технологи нэвтрүүлэн ажиллаж, орон нутгийн хөгжлийг дэмжин хамтран ажиллаж хариуцлагатай уул уурхайг жинхэнэ утгаар хөгжүүлж байгаа Сентерра гоулд Монголия ХХК-ний Мандал сумын нутагт орших Гачууртын алтны үндсэн ордыг ашиглах төслийг дэмжих нь зүйтэй гэж үзсүгэй.

2.Тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр, 10 хувьтай тэнцэх хувьцааг орон нутаг /аймаг, сум/ эзэмших болзол нөхцөлтэйгээр төслийг хэрэгжүүлэх саналыг Монгол Улсын Их Хурал, Засгийн газарт уламжилсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2013 оны 10 сарын 01-ний өдөр

Дугаар 115

Сүхбаатар

Мал аж ахуйн талаар гаргасан тогтоол шийдвэрийн биелэлтийн тухай

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас мал аж ахуйн талаар гаргасан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх талаар зохиож байгаа ажлын тухай Орхонтуул сумын Засаг дарга С.Эрдэнэбаярын сонсголыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Орхонтуул сум нь 2013 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар 170,0 мянган толгой малтай, малын тоогоор аймагтаа тэргүүлэх сум болсон байна.

Сэлэнгэ үүлдрийн үхэр, Баяд, Сартуул, Керей омгийн хонь, Баяндэлгэр омгийн улаан, эрчимжсэн хар ямааг үндсэн сайжруулагчаар ашиглаж өсгөн үржүүлснээр нийт мал сүргийн дотор өндөр ашиг шимт шилмэл үүлдэр омгийн мал 20,4 хувийг эзлэх болсон байна.

Мал сүргийг эрүүлжүүлэх, үүлдэр угсааг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх талаар зарим ажлыг зохион байгуулсан байна.

Тухайлбал сумын хэмжээнд өндөр ашиг шимт үүлдэр, омгийн малыг өсгөн үржүүлэх баг, бүс нутгийг тогтоосон, үржлийн малын ангилалтыг тогтмол хийж, ашиг шимийг тодорхойлон үржлийн бүртгэлийг хөтөлдөг болсон, бэлчээрийг улирлын хуваарьтай ашигладаг зэрэг ажлуудыг хийж хэвшсэн байна.

Монголын мянганы сорилтын сангийн Хот орчмын бэлчээрийн менежмент төсөлд хамрагдсан 18 бүлгийн 52 малчин өрхөд 12,5 мянган га бэлчээрийг эзэмшүүлсэн, бэлчээрийг сэлгэн ашиглах, өнжөөх, олон наст ургамал тариалах арга хэмжээ авч орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3 худаг гаргасан байна.

Мал эмнэлгүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн мал эмнэлгийн үйлчилгээний иж бүрэн байр, бичил лаборатори, аптек, мал угаалгын ванн барьж өгсөн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Орхонтуул сумын Засаг дарга /С.Эрдэнэбаяр/-д ДААЛГАХ нь:

1.Мал сүргийг эрүүлжүүлэх, малын үржлийн ажлыг сайжруулах талаар хийж хэрэгжүүлж байгаа ажлаа улам эрчимжүүлэн энэ талаар “Загвар сум” болох зорилт дэвшүүлэн хэрэгжүүлсүгэй.

Хоёр.Сумдын ИТХ, Засаг даргад ДААЛГАХ нь:

1.Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, “Монгол мал” үндэсний хөтөлбөр, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас мал аж ахуйн талаар гаргасан тогтоол шийдвэрийн биелэлтийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн

Хурлаар хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгч, цаашид эрчимжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

2.Малын удмын санг хамгаалах, мал сүргийг эрүүлжүүлэх талаар Орхонтуул сумын ажлын арга туршлагаас санаа авч тодорхой ажил зохион байгуулах.

3.Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих талаар аймгийн ИТХ-аас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхэд онцгой анхаарч мах, сүүний үүлдрийн үхэр, мах, ноосны үүлдрийн хонь үржүүлэх, гахай шувууны аж ахуй эрхлэх иргэд, аж ахуйн нэгжийн санал санаачилгыг бүх талаар дэмжих.

4.Одоо ажиллаж байгаа мал эмнэлэг, үржлийн нэгжийг боловсон хүчин, материал санхүүгийн талаар бэхжүүлэх, шинээр байгуулах санал санаачилгыг дэмжих замаар мал эмнэлэг үржлийн ажил үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах.

5.Мал сүргийг эрүүлжүүлэх ажлыг онцгой анхаарч малын тарилга, угаалга, туулгалтыг хамрагдвал зохих малыг бүрэн хамруулан тогтмол чанартай хийж, малын халдварт өвчнөөр тайван сум болох зорилт дэвшүүлэн хэрэгжүүлэх.

6.Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг зааглан тогтоож бэлчээр ашиглалтын зохистой горим тогтоон мөрдөх.

7.Малчдын бүлэг хоршоог дэмжин хөгжүүлэх.

8.Малчин, тариаланчдын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулан, зохицлыг хангаж ажиллах.

Гурав.Энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар ханган мэргэжил аргазүйн дэмжлэг туслалцаа үзүүлж биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар /Х.Даваахүү/-т даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 10 сарын 01-ний өдөр

Дугаар 119

Сүхбаатар

Ой тэмдэглэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой тэмдэглэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Зүүнбүрэн сум байгуулагдсаны 90 жилийн ойг 2014 оны 07 дугаар сард тэмдэглэхийг зөвшөөрсүгэй.

2. Ойгоо угтаж сумынхаа байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, иргэдийн идэвх санаачилгыг өрнүүлэн тодорхой бүтээлч ажил зохион байгуулж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад даалгаж, сумын нийт иргэдэд уриалсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 10 сарын 01-ний өдөр

Дугаар 120

Сүхбаатар

Ой тэмдэглэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой тэмдэглэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Шаамар сум байгуулагдсаны 90 жилийн ойг 2014 оны 07 дугаар сард тэмдэглэхийг зөвшөөрсүгэй.

2. Ойгоо угтаж сумынхаа байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, иргэдийн идэвх санаачилгыг өрнүүлэн тодорхой бүтээлч ажил зохион байгуулж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад даалгаж, сумын нийт иргэдэд уриалсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 11 сарын 13-ны өдөр

Дугаар 130

Сүхбаатар

Журам батлах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь орон нутгийн өмчит хуулийн этгээд /цаашид ОНӨААТҮГ буюу ХК гэх/-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлд хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/ нь хуулийн хүрээнд, компаний дүрэмд нийцүүлэн үйл ажиллагаа явуулах, ТУЗ-ийн хурлыг бэлтгэж зохион байгуулах, Компаний тухай хууль болон компаний дүрэмд заасан асуудлыг хэлэлцэн зохих шийдвэр гаргах, биелэлтэд хяналт тавих, гишүүдийн идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллах нөхцөл бүрдүүлэх, ажлын цалин, хөлс олгох, ажлыг нь дүгнэх, хариуцлага хүлээлгэх зэрэгт энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.3. ТУЗ-ийн гишүүд /цаашид “гишүүн” гэх/ нь хэлэлцэж буй аливаа асуудалд ажил хэрэгч, идэвх санаачилгатай, үнэнч шударгаар хандан, зохих хууль тогтоомжийн хүрээнд, компаний эрх ашигт нийцсэн шийдвэр гаргах үүрэгтэй.

1.4. Шинээр гарсан хууль, тогтоомж болон удирдах дээд байгууллагын тогтоол, шийдвэр, компаний дүрэмд орсон өөрчлөлт зэрэгт нийцүүлэн энэ журамд зохих нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр оруулж байна.

ХОЁР. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

2.1. ТУЗ-өөс үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх үндсэн хэлбэр нь ТУЗ-ийн хурал байна.

2.2. ТУЗ-ийн ээлжит хурлыг улирал бүр хуралдуулна. Хурал хуралдуулах газар, огноог ТУЗ-ийн дарга товлож, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /цаашид “нарийн бичгийн дарга” гэх/ бэлтгэлийг хангана. Зарласан ээлжит хурлыг урьдчилан тохиролцож хойшлуулж болно.

2.3. Шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн хуралдааныг ТУЗ-ийн дарга, гишүүн, Компаний гүйцэтгэх захирлын санаачлага, шаардлагаар хуралдуулж болно. Хурлыг санаачилагч нь нарийн бичгийн даргатай хамтран хурлын бэлтгэлийг хангана.

2.4. ТУЗ-ийн хурал /цаашид “хурал” гэх/-аар ТУЗ-ын даргын баталж, урьдчилан тараасан материал, танилцуулга, шийдвэрийн төсөлтэй асуудлыг хэлэлцэнэ.

2.5. ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлыг компанийн ажил хариуцсан ажилтан ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай хамтран /зөвлөлдөн/ бэлтгэж, холбогдох материал /судалгаа, тооцоо, гэрээ, хэлэлцээр, түүний биелэлт болон бусад зүйл/-ыг хавсаргах бөгөөд компаний гүйцэтгэх захирал, холбогдох албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулсан байна. Хурлаар хэлэлцэхээр төлөвлөсөн асуудал бүр танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төсөлтэй байна.

2.6. Хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох материалыг Хурал хуралдах өдрөөс 2-оос доошгүй хоногийн өмнө гишүүдэд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хүргэсэн байна. Компаний бизнесийн нууцтай холбоотой тооцоо судалгаа болон хувилж олшруулахад техник ажиллагаа ихээхэн шаардагдах материалыг гишүүд компани дээр урьдчилан ирж танилцан, саналаа бэлтгэж болно.

2.7. Гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

2.8. Хурлыг ТУЗ-ийн дарга болон гүйцэтгэх захирлын саналаар өргөтгөн хийж болно.

2.9. ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих үүргийг гүйцэтгэнэ. ТУЗ-ийн даргыг түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын томилсон, эсхүл ТУЗ-ийн хурлаас шийдвэрлэсэн аль нэг гишүүн гүйцэтгэнэ.

2.10. Хуралд аливаа асуудлыг шийдвэрлэхэд гишүүн бүр саналын нэг эрхтэй байна. Хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно. Эхний санал хураалтаар шийдвэр хүчин төгөлдөр болж чадаагүй нөхцөлд уг асуудлыг дахин нягтлан хэлэлцэж, зөвшилцөх замаар дахин санал хурааж болно. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

2.11. ТУЗ-ийн хурлын шийдвэрийн хэлбэр нь тогтоол, хурлын тэмдэглэл байна. Тогтоолыг ТУЗ-ийн албан бланк дээр хэвлэн, ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж, компаний тэмдэг дарна.

2.12. Компаний болон ТУЗ-ийн дотоод асуудалтай холбоотой, түүнчлэн тухайн хурал дээр шийдвэрлэх боломжгүй, тодруулах, судлах шаардлагатай асуудал гарвал ТУЗ-ийн хурлаас “ТУЗ-ийн хурлын тэмдэглэлээс” гэсэн хэлбэртэй шийдвэр гаргаж болно.

2.13. Хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хөтлөх ба санал хураалтын дүнг гишүүдийн нэрээр гаргаж тэмдэглэнэ. Дэлгэрэнгүй тэмдэглэлийг аудио, видео техник ашиглан хийж болно. ТУЗ-ийн дарга хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлтэй танилцаж, гарын үсэг зурах бөгөөд тухайн тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцна.

2.14. Хурлаар асуудал хэлэлцэхдээ дараах дэгийг баримтлана.

- Асуудлыг компанийн гүйцэтгэх захирал (асуудлыг хариуцан боловсруулсан бол ТУЗ-ийн гишүүн), эсвэл компанийн тухайн ажил хариуцсан ажилтан танилцуулна.
- ТУЗ-ийн гишүүд асууж танилцана,
- ТУЗ-ийн гишүүд санал гаргана,

- Хурал даргалагч ТУЗ-ийн гишүүдийн саналд үндэслэн ТУЗ-өөс гаргах шийдвэрийн төслийг томъёолно.

- Санал хурааж, ТУЗ-өөс гарах шийдвэрийн төслийг баталгаажуулна.

2.15. Хурлаас гарсан шийдвэрийн нэг хувийг компаний захиргаанд нарийн бичгийн дарга хүлээлгэн өгнө. Шаардлагатай гэж үзвэл хурлын шийдвэрийг нийт ажилтнуудад танилцуулж болно.

2.16. Гишүүд хуралд биеэр оролцох үүрэгтэй.

2.17. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ТУЗ-ийн хуралд 3 ба түүнээс дээш удаа, эсвэл тухайн жилд хийсэн хурлын 50 хувьд биеэр оролцоогүй, ОНӨА-аас баталсан удирдамж, чиглэлийг баримтлаагүй гишүүнийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 6 дахь заалтын дагуу өөрчлөх саналыг ТУЗ-ийн дарга эрх бүхий газарт тавьж шийдвэрлүүлнэ.

2.18. ТУЗ-ийн зардлыг компанийн жил бүрийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тусган эрх бүхий байгууллагаар батлуулна.

ГУРАВ. ДОТООД АЖИЛ

3.1. ТУЗ-ийн хурлаас ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг томилж, түүний цалинг тогтооно. Нарийн бичгийн дарга орон тооны бус байна.

3.2. Нарийн бичгийн дарга нь компанийн дүрмэнд заасан бичиг баримтыг бүрдүүлэх, хадгалах ажлыг хариуцаж, түүний хэрэгжилтэнд хяналт тавих үүрэгтэй.

3.3. ТУЗ нь жилийн ажлын төлөвлөгөө гарган ажиллана.

3.4. Нарийн бичгийн дарга нь компанийн ажилтнуудаас ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар гаргасан санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч, ТУЗ-ийн даргад танилцуулан хариу өгч байна.

3.5. Нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн шийдвэрийн биелэлтийг улирал бүр гаргаж, ТУЗ-ийн хуралд танилцуулж байна.

3.6. ТУЗ-ийн дарга шаардлагатай гэж үзвэл компаний бизнес төлөвлөгөө батлах, төсөл хэрэгжүүлэх, зээл авах, үндсэн хөрөнгө авах, данснаас хасах, хөрөнгө оруулалт хийх, охин компани, салбар, нэгж байгуулах зэрэг ихээхэн хэмжээний хөрөнгө зарцуулахтай холбогдсон асуудал, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг хурлаар хэлэлцэхдээ ажлын хэсэг байгуулан нарийвчлан судалж, санал, дүгнэлт гаргасны үндсэн дээр шийдвэр гаргаж болно. Мөн төлөөлөн удирдах зөвлөл нь компаний менежмент, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр тодорхой үүрэгтэй ажлын хэсэг байгуулж, ажил үүргийг нь тогтоон өгч ажиллуулж болно.

3.7. ТУЗ нь батлагдсан зардлын төсвийг зориулалтын дагуу зарцуулах бөгөөд тайланг нарийн бичгийн дарга хагас, бүтэн жилээр гарган ТУЗ-ийн хуралд танилцуулж байна.

3.8. ТУЗ нь гишүүдэд тодорхой хариуцах ажил, үүргийн хувиар гарган өгч, компаний аппаратын үйл ажиллагаанд хяналт тавих, хуралд бэлтгэх, шийдвэрийн биелэлтийг хангуулах, судалгаа, дүгнэлт гаргах зэрэг үр нөлөө бүхий арга хэлбэрийг ашиглаж ажиллана.

3.9. Энэхүү журмаар зохицуулагдаагүй аливаа асуудлыг тухайн үед ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж, хууль эрх зүйн актад нийцүүлэн шийдвэрлэж байна.

----- о О о -----

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 11 сарын 13-ны өдөр

Дугаар 131

Сүхбаатар

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Ариун цэврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Тохижилт, цэвэрлэгээний талаар албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх иргэдээс дагаж мөрдөх журмыг хавсралтаар баталсугай.

2.Энэ журмыг нутаг дэвсгэртээ мөрдүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг аймаг, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

ТОХИЖИЛТ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ ТАЛААР АЛБАН БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖ, АЙЛ ӨРХ, ИРГЭДЭЭС ДАГАЖ МӨРДӨХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1 Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт оршин үйл ажиллагаа явуулж байгаа албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, иргэдээс хот, суурин газрын нийтийн эзэмшлийн газар, зам талбай, эд ахуйг арчлан хамгаалах, орчноо тохижуулах, цэвэр байлгах талаар хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлж, мөрдүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.2 Энэхүү журмыг аймгийн нутаг дэвсгэрт оршин үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага аж ахуйн нэгж, айл өрх, байнга болон түр оршин суугч бүх иргэн дагаж мөрдөнө.

1.3 Сумын Засаг дарга нар журмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан жил бүр орон нутагтаа хавар, намрын улиралд бүх нийтийн их цэвэрлэгээний аянг зохион байгуулах.

Хоёр.Албан байгууллага, аж ахуйн нэгжийн хүлээх үүрэг

2. Албан байгууллага, аж ахуйн нэгж нь өмчийн харъяаллаас үл хамааран орчны тохижилт, ариун цэврийн талаар дараах үүргийг хүлээнэ.

2.1 Байгууллага аж ахуйн нэгж бүр байршлын болон орчны тохижилтын зураг, түр цэгийн байршил гарган харъяалах сумын Засаг даргаар батлуулан, түүнийгээ хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах;

2.2 Өөрийн байгууллагын тохижилт, орчныг сайжруулж ажиллагсад болон үйлчлүүлэгчдийнхээ ажил, үйлчилгээний хэвийн тав тухтай орчин нөхцлийг бүрдүүлэх;

2.3 Өөрийн байгууллагын эзэмшлийн эдэлбэр газар болон сумаас хариуцуулсан нийтийн эзэмшлийн зам, талбай, явган хүний зам, хог, цас мөсийг цэвэрлэж хальтиргаа гулгаагүй байлгах, ил задгай хог хаягдал шатаахгүй байх.

2.4 Байгууллага бүр барилга, хашааныхаа гадаад өнгө үзэмжийг сайржуулах орчин үеийн загвар дизайн, архитектурын шийдэлээр тохижуулж, чимэглэж, хаяг реклам хийх;

2.5 Байгууллага бүр өөрийн эзэмшил газрын 20-оос доошгүй хувийг ногоон байгууламжтай болгож мод, бут, цэцэг, зүлэг тарьж, арчлах, ургуулж хамгаалах;

2.6 Бүх шатны байууллага, аж ахуйн нэгж нь өөрийн эзэмшил газраас гадна сумаас зааж хариуцуулсан нийтийн эзэмшлийн зам, талбай, ногоон байгууламж эд аж ахуйг арчлан хамгаалах, засаж тохижуулах үүрэг хүлээх;

2.7 Байгууллага, аж ахуйн нэгж нь жил бүр тохижилт цэвэрлэгээний ажлын төлөвлөгөө гаргах шаардагдах хөрөнгийг төсөвтөө тусгаж байх;

2.8 Байгууллага бүр гадна фасад, хана, цонх, хаалга, довжоо, хаяг рекламг тогтмол цэвэрлэж өнгө үзэмтэй байлгах;

2.9 Байгууллага бүр стандартын шаардлага хангасан бие засах газар, бохирын цооногтой байж ариутгалыг тогтмол хийж байх;

2.10 Байгууллага бүр өнгө үзэмж сайтай, эрүүл ахуйн шаардлага хангасан хогийн савыг дотор гадна талбайд байршуулах.

2.11 Мэргэжлийн байгууллагаар хог хаягдлаа тээвэрлүүлж хог хаягдал устгасны төлбөрөө цаг хугацаанд нь тогтмол төлж байх;

2.12 Долоо хоног бүр гадна орчноо цэвэрлэж, сум багаас зохион байгуулж байгаа их цэвэрлэгээний ажилд тогтмол оролцож байх;

2.13 Байгууллага бүр цэвэрлэгээний багаж хэрэгслийг хүрэлцэх хэмжээгээр бэлтгэсэн байх;

Гурав. Айл өрхийн хүлээх үүрэг

3. Айл өрх бүр тохижилт, ариун цэврийн талаар дараах үүргийг хүлээнэ.

3.1 Айл өрх бүр сум багаас зохион байгуулж байгаа тохижилт, их цэвэрлэгээний ажилд идэвхтэй оролцдог байх.

3.2 Нийтийн орон сууцанд амьдардаг айл өрх орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийг хайрлан хамгаалж, засаж сэлбэн, цэвэр, үзэмжтэй байлгах;

3.3 Гэр хороололд амьдардаг айл өрх, гэр байшин, хашаагаа засаж тордон жигд өнгө үзэмжтэй байлгах, хашааныхаа гадна орчны хог, зэрлэг ургамлыг цэвэрлэж байх.

3.4 Хашаандаа гэрэлтүүлэг, хаалгандаа нэгдсэн хаяг дугаартай байх;

3.5 Стандартын шаардлагад нийцсэн бие засах газар, бохир усны цооногтой байж ариутгалыг тогтмол хийж байх;

3.6 Айл өрх бүр хашаандаа мод, бут сөөг, цэцэг тарьж арчлан ургуулах;

3.7 Айл өрх бүр хог хаягдлаа савлаж тээвэрлүүлэхэд бэлтгэн, ангилан ялгаж, мэргэжлийн байгууллагаар тээвэрлүүлэх, хог хаягдал үүсгэсний төлбөрөө сар бүр тогтмол төлж байх;

3.8 Хашаандаа хог хаягдал ил задгай шатаахгүй байх.

3.9 Хотын гудамж талбай, гуу жалганд ил задгай хог хаяхгүй байх, хог хаяж, зөрчил гаргасан айл өрх, иргэнд шаардлага тавьж, холбогдох байгууллагад мэдэгдэж байх;

Дөрөв. Иргэдийн хүлээх үүрэг

4. Аймгийн нутаг дэвсгэрт байнга болон түр оршин суугч иргэд доорх үүргийг хүлээнэ.

4.1 Гудамж талбай, нийтийн эзэмшлийн болон олон нийтийн газарт хог хаяхгүй, соёлч бус байдал гаргахгүй байх.

4.2 Хотын нийтийн эзэмшлийн зам талбайг ногоон байгууламж, хайс хашаа хүүхдийн тоглоомын болон бусад тоног төхөөрөмж, эд аж ахуйг хайрлан хамгаалах;

4.3 Хот, нийтийн эд аж ахуйд хохирол учруулж буй буруутай үйлдэл, зөрчилд шаардлага тавих, холбогдох байгууллагад мэдэгдэх;

4.4 Ажлын байр, гэр орондоо ариун цэвэрч, соёлч байдлыг эрхэмлэх, үр хүүхдээ хог хаягдлын талаар зөв дадал зуршилд сургах.

4.5 Тохижилт, ариун цэврийн талаар албан байгууллага, айл өрхийн хүлээх үүргийг хамт олон, гэр бүлийн гишүүний хувьд сахин биелүүлэх;

4.6 Сум, баг, байгууллагаас зохион байгуулж байгаа тохижилт цэвэрлэгээний ажилд идэвхтэй оролцох;

Тав. Хяналт

5. Журмыг сум, багийн Засаг дарга, хот тосгоны захирагч нар, олон нийтийн болон Мэргэжлийн хяналтын байцаагч нар хариуцан зохион байгуулж хяналт тавьж хэрэгжүүлнэ.

Зургаа. Урамшуулал

6.Журмыг үлгэр жишээ дагаж мөрдсөн иргэн, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал үзүүлж болно.

Долоо. Хариуцлага

7. Энэ журмыг зөрчсөн иргэн, айл өрх, аж ахуйн нэгж байгууллагад дараах хариуцлагагыг хүлээлгэнэ.

7.1 Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, хариуцлага хүлээлгэх эрх бүхий байгууллага албан тушаалтнаас захиргааны хариуцлага хүлээлгэх.

7.2 Холбогдох хууль тогтоомжийн дагуу сум, багийн Засаг дарга нар, Мэргэжлийн хяналтын улсын байцаагч нар захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

_____оОо_____

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 11 сарын 13-ны өдөр

Дугаар 132

Сүхбаатар

Зарим бүтээлийг бүх нийтээр судлах, сурах тухай

XX зууны эхээр Монголын ард түмэн Тусгаар тогтнолоо байлдан олж Шинэ Монгол улсаа байгуулж хөгжүүлэхэд Сэлэнгэ нутгийн ард иргэд зон олны байгуулж бүтээсэн их гавъяа зүтгэлийг Төр засаг, ард түмэн өндрөөр үнэлж Төрийн 3 одонтой анхдагч аймаг болгон алдаршуулсан түүхэн замналаас суралцах, бахархах, аймаг орон нутгийнхаа ирээдүйд итгэх итгэл, бүтээлч сэтгэлгээг залуу өсвөр үеийнхэндээ төлөвшүүлэх зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ нутгийн хүн ардын хөдөлмөр бүтээл, зан заншил, байгалийн үзэсгэлэнг магтан дуулсан Г.Даваацэрэнгийн үг, Г.Дарамзагдын ая “Өргөн Сэлэнгэ”, С.Базарсадын үг, Н.Чулуунхүүгийн ая “Сэлэнгийн буудай”, Н.Сүхдоржийн үг, Ц.Чинзоригийн ая “Сэлүүн дэнжийн яргуй”, Н.Баянмөнхийн үг, Т.Сэр-Одын ая “Сэлэнгэ шүтээн” зэрэг дуунууд, Д.Гомбосүрэнгийн “Сэлэнгэ түмэн” найраглалыг ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрийн хүрээнд бүх хүүхдэд зааж сургах ажлыг 2013-2014 оны хичээлийн жилээс эхлэн аймгийн хэмжээнд зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсролын газрын дарга /Д.Загдгочоо/-д даалгасугай.

2.Сэлэнгэ сайхан нутгийг магтан дуулсан дээрх дуунуудыг дуулж суран, гадаад дотоодод нутаг орноо сурталчилж, өөрийгөө нээж авъяасаа үзүүлж, нутаг орноороо бахархаж явахыг Сэлэнгэ нутгийнхаа нийт иргэдэд уриалсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 11 сарын 13-ны өдөр

Дугаар 133

Сүхбаатар

Сэлэнгэ телевизийг татан буулгах тухай

Орон нутгийн Сэлэнгэ телевизийг 2014 оноос эхлэн төсвөөс санхүүжүүлэх боломжгүй болсон тул Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “ж” заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Орон нутгийн Сэлэнгэ телевизийг 2013 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгон татан буулгасугай.

2.Тус телевизийн эзэмшин ашиглаж байсан орон нутгийн өмчийн эд хөрөнгийг хүлээн авч цаашид хэрхэн ашиглах асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулан шийдвэрлүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны дарга / П.Эрдэнэсайхан/-д даалгасугай.

3.Сэлэнгэ телевизийг татан буулгасантай холбогдуулан тус телевизэд ажиллагсад хөдөлмөрийн хуульд заасны дагуу олгох тэтгэмжийг 2014 оны төсөвт тусган шийдвэрлэхийг аймгийн Засаг дарга / С.Бүрэнбат/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 11 сарын 13-ны өдөр

Дугаар 137

Сүхбаатар

Орон сууц хувьчлах тухай

Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн, Орон сууц хувьчлах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ аймгийн Ерөө сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй орон сууцыг одоо эзэмшиж байгаа төрийн албан хаагчид, Сэлэнгэ аймгийн Баянгол сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2 айлын орон сууцыг одоо эзэмшиж байгаа төрийн албан хаагчдад нь ирүүлсэн өргөдлийн дагуу тодорхой үнээр худалдахыг зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2013 оны 11-р сарын 13-ны
өдрийн 137 дугаар тогтоолын хавсралт

ХУВЬЧЛАХ ОРОН СУУЦНЫ ЖАГСААЛТ

№	Байгууллага аж ахуйн нэр	Хөрөнгийн нэр төрөл	Ашиглалтанд орсон он	Ашиглах хугацаа	Тоо ширхэг	Дансны анхны үнэ /мян.төг/	Байгуулсан элэгдэл /мян.төг/	Сэргээн босголт	үлдэгдэл үнэ	Үндсэн байгууллагын санал	орон нутгийн өмчийн алба	Засаг даргын санал	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн санал
1	Ерөө сумын ЗДТГ	Дүнзэн байшин	1997	15	1	5000000	5000000		0	Төрийн албаны тухай хуулийн 27.1.5 дахь заалтын үндэслэн эзэмшиж байгаа	хувьчлах		
2	Баянгол сумын ЗДТГ	Орон сууцны байр	1968	60	1	19861200	15061410		4799790	хувьчлах	хувьчлах		
3	Баянгол сумын ЗДТГ	Орон сууцны байр	1968	60	1	19861200	15061410		4799790	хувьчлах	хувьчлах		
	ДҮН					44722400	35122820		9599580				

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 11 сарын 13-ны өдөр

Дугаар 138

Сүхбаатар

Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ нь:**

1. Цагааннуур сум байгуулагдсаны 90 жилийн ойг 2014 оны 07 дугаар сард тэмдэглэхийг зөвшөөрсүгэй.

2.Ойгоо угтаж сумынхаа байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, иргэдийн санаачилгыг өрнүүлэн, тодорхой бүтээлч ажил зохион байгуулж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад даалгаж, сумын нийт иргэдэд уриалсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 11 сарын 13-ны өдөр

Дугаар 139

Сүхбаатар

Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын баатар Д.Дэмбэрэлийн нэрэмжит Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль байгуулагдсаны 90 жилийн ойг 2014 оны 07 дугаар сард тэмдэглэхийг зөвшөөрсүгэй.

2.Ойгоо угтаж хамт олны санаачилгыг өрнүүлэн байгууллага, орчноо тохижуулах, хүүхдийн өсч хөгжих, сурах орчин, ажиллагсдын ажиллах нөхцөл боломжийг сайжруулах талаар тодорхой бүтээлч ажлуудыг зохион байгуулахыг тус сургуулийн удирдлагад даалгаж, хамт олонд уриалсугай.

3.Ой угтсан ажил болон ой тэмдэглэх арга хэмжээнд удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргад үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 11 сарын 13-ны өдөр

Дугаар 142

Сүхбаатар

Тэмцээн зохион байгуулах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын ивээл дор зохион байгуулагдаж байгаа шатар сонирхогчдын улсын аварга шалгаруулах тэмцээний эхний шатны аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2013 оны 11 дүгээр сарын 23-24-ний өдрүүдэд зохион байгуулахаар тогтоосугай.

2.Шатар сонирхогчдын аймгийн аварга шалгаруулах тэмцээний бэлтгэлийг хангаж зохион байгуулж явуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Ш.Оргил

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч

Гишүүдэд:

Н.Гэрэлт-Од

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч

Б.Баттулга

Аймгийн соёл, спорт аялал жуулчлалын
газрын дарга

Н.Билэгсайхан

Аймгийн шатрын холбооны тэргүүлэгч

Э.Оюунболд

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
ажлын албаны ажилтан

Э.Оюун-Эрдэнэ

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 11 сарын 29-ний өдөр

Дугаар 146

Сүхбаатар

Түлээний мод бэлтгэх тухай

Монгол Улсын Ойн тухай хуулийн 17.1.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Хүдэр сумын нутгаас ойн цэвэрлэгээний журмаар бэлтгэх түлээний мод, Цагааннуур суманд бэлтгэх хусны хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Сүхбаатар, Шаамар сумын Засаг дарга нартай хавсралтад заасан түлээний модыг бэлтгэх, тээвэрлэх, худалдан борлуулах нөхцөл болзлоо тохиролцон гэрээ байгуулж ажиллахыг Хүдэр сумын Засаг дарга /Б.Наранцэцэг/-д даалгасугай.

3.Тухайн сумдын нутгаас түлээний мод, хус бэлтгэх талбайг тусгаарлан зориулалтын дагуу бэлтгүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Хүдэр сумын Ойн анги, Цагааннуур сум дахь Сум дундын ойн ангид даалгасугай.

4.Энэ тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Д.Энхсайхан/, Байгаль орчны газар /Б.Батзориг/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2013 оны 11 сарын 29-ны
өдрийн 146 дугаар тогтоолын хавсралт

Түлээний мод бэлтгэх нэмэлт хуваарь

д/д	Сумын нэр	Мод бэлтгэх сумын нэр	Модны төрөл		Бүгд /м ³ /
			Хус /м ³ /	Нарс /м ³ /	
1	Цагааннуур	Цагааннуур сумаас	3000		3000
2	Шаамар	Хүдэр сумаас		1000	1000
3	Сүхбаатар	Хүдэр сумаас		1000	1000
4	Хүдэр	Хүдэр сумаас		1000	1000
	Дүн		3000	3000	6000

_____оОо_____

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 11 сарын 29-ний өдөр

Дугаар 151

Сүхбаатар

Төсөлд хамруулах тухай

Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.58-д заасныг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1.Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Сумын төвийн шинэчлэл” төсөлд тус аймгаас Шаамар сумыг хамруулахаар тогтоосугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 26-ны өдөр

Дугаар 156

Сүхбаатар

Аймгийн Аудитын тайлангийн тухай

Аймгийн Аудитын газрын 2013 оны ажлын тайланг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1.Аймгийн Аудитын газрын 2013 оны үйл ажиллагааг “Хангалттай сайн” гэж дүгнэсүгэй.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 26-ны өдөр

Дугаар 157

Сүхбаатар

“Улсын сайн малчин”-аар шагнуулах
саналыг дэмжих тухай

Алтанбулаг сумын малчин Жанчивын Цолмонгийн тодорхойлолт, Аймгийн Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газраас оруулсан саналыг хэлэлцээд Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 70 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг.Мал сүргээ өсгөн үржүүлэх ажилд олон жилийн хүч хөдөлмөрөө зориулан, сүүлийн 3 жилд 390-534 мал хариуцан маллаж, хорогдолгүй онд оруулан 100 эхээс 100-105 төл бойжуулан 7.8-10.5 тн мах, 18.0-20.0 мянган литр сүү, 330-450 кг ноос, 24.0-27.0 кг ноолуур үйлдвэрлэж , зах зээлд нийлүүлэн 26.3-33.8 сая төгрөгийн борлуулалт хийж, малгүй иргэдийг малжуулахад туслан 100 мал өгсөн зэрэг амжилтыг үнэлэн тус аймгийн Алтанбулаг сумын малчин Жанчивын Цолмонг “Улсын сайн малчин”-аар шалгаруулан шагнуулахаар Монгол Улсын Засгийн газарт уламжилсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 26-ны өдөр

Дугаар 158

Сүхбаатар

**“Улсын сайн малчин”-аар шагнуулах
саналыг дэмжих тухай**

Сайхан сумын малчин Б.Төмөрбаатарын тодорхойлолт, Аймгийн Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газраас оруулсан саналыг хэлэлцээд Монгол улсын Засгийн газрын 2009 оны 70 дугаар тогтоолыг үндэслэн **ТОГТООХ** нь:

Нэг.Мал сүргээ өсгөн үржүүлэх ажилд олон жилийн хүч хөдөлмөрөө зориулан, сүүлийн 3 жилд 1089-1114 мал хариуцан маллаж, хорогдолгүй онд оруулан 100 эхээс 100-105 төл бойжуулан 7.8-9.6 тн мах, 28.6-33.0 мянган литр сүү, 3.2-3.3 тн ноос, 49.8-52.2 кг ноолуур үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлэн 63.9-70.2 сая төгрөгийн борлуулалт хийж, амьжиргааны түвшин доогуур ядуу амьдралтай, айл өрхийг малжуулахад зориулан 369 мал өгсөн зэрэг амжилтыг үнэлэн тус аймгийн Сайхан сумын малчин Бэгзийн Төмөрбаатарыг “Улсын сайн малчин”-аар шалгаруулан шагнуулахаар Монгол улсын Засгийн газарт уламжилсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 26-ны өдөр

Дугаар 159

Сүхбаатар

“Улсын сайн малчин”-аар шагнуулах
саналыгдэмжих тухай

Хушаат сумын малчин Сайндайн Мөнхбатын тодорхойлолт, Аймгийн Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газраас оруулсан саналыг хэлэлцээд Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 70 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг.Мал сүргээ өсгөн үржүүлэх ажилд олон жилийн хүч хөдөлмөрөө зориулан, сүүлийн 3 жилд 1164-1590 мал хариуцан маллаж, хорогдолгүй онд оруулан 100 эхээс 100-107 төл бойжуулан 11.7-14.3 тн мах, 5.6-5.9 мянган литр сүү, 1.2-1.8 тн ноос, 86.7-99.6 кг ноолуур үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлэн 79,1-119,8 сая төгрөгийн борлуулалт хийж, малгүй иргэдийг малжуулахад туслан 220 мал өгсөн зэрэг амжилтыг үнэлэн тус аймгийн Хушаат сумын малчин Сайндайн Мөнхбатыг “Улсын сайн малчин”-аар шалгаруулан шагнуулахаар Монгол Улсын Засгийн газарт уламжилсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 26-ны өдөр

Дугаар 160

Сүхбаатар

“Улсын тэргүүний тариаланч хамт олон”-оор
шагнуулах тухай

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газраас оруулсан саналыг хэлэлцээд Монгол улсын Засгийн газрын 2009 оны 70 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан журмыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн, техник технологийн шинэчлэл хийж тогтвортой амжилт гаргаж байгаа доор дурдсан аж ахуйн нэгжүүдийг “Улсын тэргүүний тариаланч хамт олон”-оор шагнуулахаар Монгол улсын Засгийн газарт уламжилсугай. Үүнд:

1. Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн сүүлийн 3 жилд 845-1295 га талбайд улаан буудай тариалж, га-аас 23,5-24,0 цн ургац хураан, 135-155 тн үр нөөцөлж, 845 гад уринш бэлтгэн, тогтвортой өндөр ургац авч, сум орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж байгаа Сайхан сумын “Ургацын-Ундраа ” Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани,

2. Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн жил бүр 956-1400 га талбайд улаан буудай тариалж га-аас 19,2-21,8 цн ургац хураан, 100-260 тн үр нөөцөлж, 625 га уринш бэлтгэн, тогтвортой өндөр ургац авч сум орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж байгаа Хушаат сумын “Өгөөж Мандал –Уул ” ХХКомпани,

3. Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн техникийн шинэчлэлд сүүлийн 3 жил 2,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж техникийн паркийг 100 хувь шинэчилэн, 2160 га талбайд улаан буудай тариалж, га-аас 12,2-18,6 цн ургац хураан, 520-613 тн үр нөөцөлж, 1998-2160 га уринш бэлтгэн, тогтвортой өндөр

ургац авч, сум орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж байгаа Цагааннуур сумын "Товхонхан" Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани,

4.Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн сүүлийн 3 жилд 2068-2725 га талбайд улаан буудай тариалж, га-аас 23.5-26.1 цн ургац хураан, 520-560 тн үр нөөцөлж, 878-1466 га уринш бэлтгэн, тогтвортой өндөр ургац авч сум орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж байгаа Цагааннуур сумын "Гацуурт" Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 26-ны өдөр

Дугаар 161

Сүхбаатар

“Улсын тэргүүний тариаланч”-аар
шагнуулах тухай

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газраас оруулсан саналыг хэлэлцээд Монгол улсын Засгийн газрын 2009 оны 70 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан журмыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Газар тариалангийн салбарт олон жил идэвхи зүтгэл үр бүтээлтэй ажиллаж сүүлийн 3 жилд тогтвортой амжилт гаргаж байгаа дор дурьдсан хүмүүсийг “Улсын тэргүүний тариаланч”-аар шалгаруулж шагнуулахаар Монгол Улсын Засгийн газарт уламжилсугай. Үүнд:

1. Хариуцсан техникийн засвар үйлчилгээг чанартай хийж, тариалангийн үйлдвэрлэлийн технологийг чанд мөрдөн сүүлийн 3 жилд 362-1477 га талбайн ажил гүйцэтгэж, 20310-59280 цн ургац хурааж, 3131-3437 жишмэл га-д уринш бэлтгэж, журамд заасан үзүүлэлтийг 260,9-286,9 хувиар биелүүлж, өндөр үр бүтээлтэй ажиллаж байгаа Цагааннуур сумын “Баяндулаан Уул” ХХК-ийн механикжуулагч Батхуяг овогтой Одмөнх;

2. Газар тариалангийн үйлдвэрлэлд шинэ техник, технологийг үр бүтээлтэй ашиглаж сүүлийн 3 жилд 1086-1775 га талбайн ажил гүйцэтгэж, 12861-40000 цн ургац хурааж, 3221-4575 жишмэл га-д уринш бэлтгэж, журамд заасан үзүүлэлтийг 268,4-381,4 хувиар биелүүлж, өндөр үр бүтээлтэй ажиллаж байгаа Цагааннуур сумын “Баяндулаан Уул” ХХК-ийн механикжуулагч Цэндсүрэн овогтой Цогжавхлан;

3. Газар тариалангийн үйлдвэрлэлд шинэ техник, технологийг үр бүтээлтэй ашиглаж сүүлийн сүүлийн 3 жилд 1104-1292 га талбайн ажил гүйцэтгэж, 16082-35000 цн ургац хурааж, 1532-2453 жишмэл га-д уринш бэлтгэж, журамд заасан үзүүлэлтийг 127,7-184,6 хувиар биелүүлж, өндөр үр бүтээлтэй ажиллаж байгаа Хушаат сумын ” Скрин” ХХК-ийн механикжуулагч Балдандорж овогтой Баатар;

4. Ногоон хувьсгал үндэсний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн сүүлийн 3 жилд 10-18 га талбайд төмс хүнсний ногоо тариалж, га-аас 230-240 цн буюу 240-414 тн ургац хураан тогтвортой өндөр ургац авч сум орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж байгаа Сант сумын иргэн ногоочин Лувсан овогтой Аварга;

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 26-ны өдөр

Дугаар 165

Сүхбаатар

Хөтөлбөр батлах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ээлжит хуралдаанаас
ТОГТООХ НЬ:

1.Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх “Олон нийтийн оролцоо-Төрийн үйлчилгээ”
хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, үр
дүнг тооцон ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Бүрэнбат/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**“ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО-ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ”
аймгийн хөтөлбөр**

Нэг. Өнөөгийн байдал, хэрэгцээ шаардлага

Төрийн байгууллага, төрийн албан хаагчдын үйл ажиллагаа ямар байгаа, ажил, үйлчилгээний чанар үр дүн иргэд, төрийн үйлчилгээ хүртэгчдийн санаа бодол, эрэлт хэрэгцээнд хир нийцэж байгааг иргэдээрээ үнэлүүлж дүгнүүлдэг тогтолцоо бий болгохыг үйл ажиллагааныхаа нэг гол зарчим болгон ажиллаж байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний шинэчлэл”-ийг нэвтрүүлэх зорилгоор төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагаанд иргэдийн үнэлгээ дүгнэлтийг авдаг, төрийн албан хаагчдын үйл ажиллагааны үр дүнг иргэдийн үнэлгээнд тулгуурлан үнэлдэг, цаашид авах арга хэмжээг тодорхойлдог тогтолцоог бүрдүүлэх зорилгоор өнгөрсөн хугацаанд аймгийн “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээгээр бүх, сүм тосгоны төрийн албан хаагч нэг бүрээр, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг бүрээр нийт **1215** иргэдээс асуумжийн хуудсаар санал асуулга авч, үр дүнг тооцоод байна.

Иргэдээс авсан судалгаануудын дүнд шинжилгээ хийж үзвэл төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг иргэд төдийлөн хангалттай үнэлэхгүй байгаа нь зарим нэг салбар чиглэлд төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж буй төрийн албан хаагчийн чадавх, ёс зүй, хариуцлагыг сайжруулахад анхаарал хандуулах шаардлага байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албад, сумдын ЗДТГ-ын төрийн захиргааны албан хаагчдаас авсан хууль эрх зүйн мэдлэг шалгах сорилын шалгалтуудад хамрагдагсдын дундаж оноо 58 хувиас хэтрэхгүй байгаа нь төрийн албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэгдсэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан төрийн бүх шатны байгууллагуудад хэрэгжүүлэх зүй ёсны хэрэгцээ байна.

Аймгийн Засаг даргын зүгээс төрийн албан хаагчдыг бүх талаар чадваржуулах, мэдлэг мэргэшил, харилцааны ёс зүйг дээшлүүлснээр төрийн бодлого зорилтыг төрийн

захиргааны бүх шатанд амжилттай, үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ гэж үзэж үйл ажиллагааны хөтөлбөртөө энэ чиглэлээр бие даасан зорилт дэвшүүлсэн.

Ийнхүү уг хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлснээр төрийн албан хаагчдын хариуцлага дээшилж, мэргэшлийн түвшин нэмэгдэж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжинд иргэдийн сэтгэл ханамжийн үнэлэмж дээшилнэ гэж үзэж байна.

Аймгийн хэмжээнд нийт **198** төр, төсвийн байгууллагад **5044** төрийн албан хаагч төрийн үйлчилгээг үзүүлж байна. Үүний дотор:

- Улс төрийн албан хаагч-110
- Төрийн захиргааны албан хаагч-642
- Төрийн тусгай албан хаагч-206
- Төрийн үйлчилгээний албан хаагч-4086 байна.

Нийт албан хаагчдын 80 хувь нь эрүүл мэнд, боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид байна.

Удирдах албан тушаалд-269, Гүйцэтгэх албан тушаалд-2979, Туслах албан тушаалд-1022, Гэрээт албан тушаалд-524 албан хаагч ажиллаж байгаагийн 32.5 хувь буюу 1558 эрэгтэй, 67.5 хувь буюу 3236 эмэгтэй төрийн албан хаагч байна.

Шинэчлэлийн Засгийн газраас баримталж буй бодлого чиглэл, аймгийн Засаг даргын бүрэн эрхийн хугацааны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Хүнээ дэмжиж, Хөгжилд түүчээлье” эрхэм зорилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, шийдвэр гаргах түвшинд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдыг чадавхжуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Иймд аймгийн Засаг дарга, түүний ажлын албанаас олон улсын Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2008 стандартыг нутгийн захиргааны байгууллагуудад нэвтрүүлэх ажлын эхлэл болгож аймгийн Засаг даргын Тамгын газарт хэрэгжүүлж эхлээд байна. Тус ажлын хүрээнд нутгийн захиргааны төв байгууллагын зүгээс төрийн үйлчилгээг хэрэглэгчдийнхээ хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тэдгээрийн сэтгэл ханамжийн үнэлгээг дээшлүүлэхээр аймгийн Засаг даргын Тамгын газрын “Алсын хараа”, “Эрхэм зорилго”-ыг дараах байдлаар тодорхойлсон. Энэ нь тус хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай нийцэж байна. Үүнд:

- “АЛСЫН ХАРАА”: “Олон улсын жишигт нийцсэн мэргэшсэн нутгийн захиргааны байгууллага болно.”
- “ЭРХЭМ ЗОРИЛГО”: “Бид төрийн үйлчилгээний стандартыг үйл ажиллагаандаа шинэлэг арга хэлбэрээр хэвшүүлж, хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг эрхэмлэнэ.”

Хоёр. Хөтөлбөрийн зорилго:

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь олон нийтийн оролцоонд тулгуурлан оновчтой бодлого зохицуулалтаар хэрэглэгчдийнхээ шаардлагад нийцсэн төрийн үйлчилгээг байнга сайжруулан хүргэхэд оршино.

Энэ нь иргэний хэрэгцээг хангахуйц төрийн үйлчилгээг бий болгож, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, орон нутгийн төрийн байгууллагуудын ил тод, нээлттэй байдлыг хангах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэднийг идэвхижүүлэх, дэмжлэг үзүүлэх, орон нутгийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдэнэ.

Гурав. Хөтөлбөрийн зорилт:

3.1 Шийдвэр гаргах түвшинд иргэд, олон нийтийн оролцоог хангадаг тогтолцоог бүрдүүлнэ.

3.2 Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ.

3.3 Төрийн албан хаагчдыг чадавхжуулж, гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.

3.4 Төрийн үйлчилгээний ил тод нээлттэй байдлыг хангана.

3.5 Төрийн байгууллага, албан хаагчийн манлайллыг төлөвшүүлнэ.

3.6.Хариуцлагын болон урамшууллын тогтолцоог сайжруулна.

3.7.Мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан төрийн үйлчилгээнд цахим үйлчилгээг нэвтрүүлнэ.

3.1.1. Шийдвэр гаргах түвшинд иргэд, олон нийтийн оролцоог хангадаг тогтолцоог бүрдүүлнэ.

Үйл ажиллагааны чиглэл:

3.1.1. Мэдээллийн технологийн дэвшилтэт хэлбэрийг ашиглан аймгийн цахим хуудас нээн иргэд олон нийтийн санал, сэтгэгдлийг нээлттэй шууд хүлээн авч, шуурхай шийдвэрлэж ажиллах

3.1.2.Төрийн байгууллагуудад “Олон нийттэй харилцах чиг үүрэг”-ийг бий болгож хэрэгжүүлэх

3.1.3. Мэдээллийн ил тод байдлыг хангаж, нийтэд хамаарал бүхий асуудлаар бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэхэд , иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах ажлыг өргөн хүрээнд төрөл бүрийн арга хэлбэрээр /нээлттэй хэлэлцүүлэг, санал асуулга, уулзалт, зөвлөгөөн/ зохион байгуулах

3.1.4. Санал хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах утас, цахим хуудас /e.mail, facebook, twitter/ ажиллуулан, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэн, иргэдэд хугацаа алдалгүй хариу хүргэдэг байх

3.1.5. Аймаг, сумдад “Иргэдээ сонсьё” арга хэмжээг зохион байгуулж үр дүнг тооцох

3.1.6. Санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх, иргэдийг биечлэн уулзах боломжийг хангах ажлыг зохион байгуулан ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариуг нь заавал өгч хэвших.

3.2. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ.

Үйл ажиллагааны чиглэл:

3.2.1. Нутгийн захиргааны зарим байгууллагуудад олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2008 стандартыг нэвтрүүлэх боломж, нөхцлийг судалж, хэрэгжүүлэх

3.2.2. Иргэдэд эрэлт хэрэгцээ ихтэй төрийн зарим үйл үйлчилгээг /хөдөлмөр магадлах комиссын хурал, эд хөрөнгийн бүртгэл/бүсийн төвүүдээр дамжуулан иргэдэд хүрч үйлчлэх

3.2.3. “Хүлээж биш, хүрч үйлчилье” уриаг төрийн бүх шатны байгууллагуудад хэрэгжүүлж ажиллах

3.2.4. Төрийн албан хаагчдын ажлын хариуцлагыг дээшлүүлж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, /хүнд сурталгүй байх/ албан хаагчдын ажилд үнэлгээ өгөхдөө иргэдийн өгсөн үнэлгээг харгалзан үздэг арга хэлбэрийг нэвтрүүлэх

3.2.5. Төрийн албан хаагчдаас иргэд олон нийтэд үзүүлж буй төрийн үйлчилгээ, ёс зүй, харилцааны талаар хэрэглэгчдээс сэтгэл ханамжийн үнэлгээг авч, үр дүнг тооцох

3.2.6. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, хэрэглэгчидийн сэтгэл ханамжийг судлах “Иргэдтэй уулзах цаг” олон талт арга хэмжээг зохион байгуулах

3.2.7. Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаархи сэтгэл ханамжийн судалгааг авч шаардлагатай арга хэмжээг зохион байгуулах

3.3. Төрийн албан хаагчдыг чадавхжуулж, гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.

Үйл ажиллагааны чиглэл:

3.3.1. Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг ажлын байранд нь чиглүүлэх, дадлагажуулах, мэргэшүүлэх

3.3.2. Төрийн албан хаагчдыг цаг үеийн эрэлтэд нийцсэн сургалтын хэрэгцээг тодорхойлон, салбар чиглэл бүрээр сургалтанд хамруулах /төрөлжсөн, зорилтот, захиалгат, төлөвлөгөөт/

3.3.3. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг байгууллагын хөдөлмөрийн дотоод журманд нарийвчлан тусгах

3.3.4. Байгууллагын үйл ажиллагаа болон холбогдох асуудлыг иж бүрэн хамруулах зорилгоор дотоод хяналт шалгалтыг Засаг даргын нэрэмжит үзлэг, бусад байгууллагатай хамтарсан хяналт шалгалтын хэлбэрээр зохион байгуулах

3.3.5. Дотоод хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэшил, арга зүйн зөвлөгөө авах, эрх бүхий байгууллагаар дүгнэлт гаргуулах, хамтран ажиллах талаар санал боловсруулах

3.4.Төрийн үйлчилгээний ил тод нээлттэй байдлыг хангана.

Үйл ажиллагааны чиглэл:

3.4.1. Төрийн үйлчилгээний чиглэл, нэр төрөл, үйлчилгээ авахтай холбоотой баримт бичгийн жагсаалтыг боловсруулан гаргаж, ил тод байршуулах

3.4.2. Төрийн байгууллагын төсөв, санхүүгийн ил тод байдлыг цахим хуудас болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр нээлттэй мэдээлж, мэдээллийг тэгш хүртээмжтэй авах нөхцлийг бүрдүүлэх

3.4.3. Аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын дэргэдэх “Иргэний танхим”-ын үйл ажиллагааг тогтмолжуулах

3.4.4. Аймаг, сумдын болон төрийн байгууллагуудын цахим хуудасны мэдээ, мэдээллийг тогтмол шинэчлэн иргэд, олон нийтэд мэдээлэх

3.4.5. Төвийн болон Орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж, цаг үеийн мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх

3.4.6.Төрийн байгууллагын сул орон тоо, ажлын байрны зарыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй хүргэх ажлыг тогтмолжуулах

3.4.7. Аймаг орон нутагт хэрэгжиж буй гадаад, дотоодын төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар иргэд ,олон нийтэд нээлттэй мэдээллэх

3.4.8. Аймгийн Засаг даргын Тамгын газар, зарим сумын Засаг даргын Тамгын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар зэрэг байгууллагуудад үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, телекамерийн систем нэвтрүүлэх

3.6 Төрийн байгууллага, албан хаагчийн манлайллыг төлөвшүүлнэ.

Үйл ажиллагааны чиглэл:

3.5.1. Байгууллагын удирдлага болон ажилтнууд өөрсдийн чиг үүргийг сайн гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлагыг эзэмшсэн байх

3.5.2. Байгууллага бүр “Суралцагч байгууллага” болох хөдөлгөөн өрнүүлэх, ажилтан албан хаагчдын байнга суралцах идэвхи, санаачлага, эрмэлзлэлийг дэмжих

3.5.3. Төрийн албаны өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлагыг хангаж ажиллахын тулд албан хаагч бүр тасралтгүй үргэлжлүүлэн суралцдаг байх

3.5.4. Байгууллагын удирдлага нь бүхий л төрлийн сургалтын үйл ажиллагааг дэмжиж урамшуулдаг, шинэ санаачлага, арга барилыг нэвтрүүлдэг, хөрөнгө санхүү, хүний нөөцийг оновчтой хуваарилдаг, таатай үлгэр жишээ үзүүлдэг орчин, нөхцлийг бүрдүүлдэг байх

3.7 Хариуцлагын болон урамшууллын тогтолцоог сайжруулна.

Үйл ажиллагааны чиглэл:

3.6.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэшил, ур чадварын түвшинг тогтоох шалгалтыг /аттестатчилал/ зохион байгуулах

3.6.2. Төрийн албан хаагчдад мэргэжил ,ур чадварын түвшингээр урамшуулал олгох, хариуцлага тооцдог байх

3.6.3. Төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйлийг үйлажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах

3.6.4. Төрийн албан хаагчдын үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшний үнэлэх үйл ажиллагаанд иргэд олон нийтийн санал, хүсэлтийг харгалзах асуудлыг тусгайлан боловсруулсан журмаар зохицуулна.

3.7. Мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан төрийн үйлчилгээнд цахим үйлчилгээг нэвтрүүлнэ.

Үйл ажиллагааны чиглэл:

3.7.1. Үйлчилгээний хүртээмж, ил тод, нээлттэй, тэгш байдлыг бий болгож үйлчлүүлэгчийн хэрэгцээг хангасан үйлчилгээг үзүүлэх.

3.7.2. Төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, шуурхай байдлыг хангах үүднээс "E-office" "E-government" программыг нэвтрүүлж хэвшүүлэх,

3.7.3. Төрийн үйлчилгээний "Лавлах үйлчилгээ"-г нэвтрүүлэх.

3.7.4. Нэг цонхны үйлчилгээний төвөөр үзүүлэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, холбогдох байгууллагуудыг сүлжээнд холбох, "Цахим ТҮЦ машин" ажиллуулах.

3.7.5. "Иргэдийн санал, хүсэлт"-ийг 24 цагаар хүлээн авах нөхцөл боломжоор ханган ажиллах.

3.7.6. Төрийн байгууллагууд иргэдэд үйлчилгээ үзүүлэх шаардлага хангахуйц интернетийн орчин нөхцлийг бий болгох талаар үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

Дөрөв. Хамрах хүрээ, зарчим

Хөтөлбөр нь төрийн үйлчилгээ үзүүлж буй аймгийн бүх шатны төр, төсвийн байгууллагын үйл ажиллагааг хамарна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хууль дээдлэх, ил тод, нээлттэй, ёс зүйтэй, хариуцлагатай, хүртээмжтэй, үр дүнтэй байх зарчмыг баримтална.

Тав.Хэрэгжих хугацаа

Хөтөлбөрийг 2013-2016 онд хэрэгжүүлнэ.

Зургаа. Удирдлага, зохион байгуулалт

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгжийн удирдлагыг төсвийн ерөнхий болон шууд захирагч нар, ерөнхий удирдлага зохицуулалтаар хангаж, хяналт тавих үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газар гүйцэтгэнэ.

6.2. Хөтөлбөрийг түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг, бусад төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулан хэрэгжүүлнэ.

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- Улсын болон орон нутгийн төсөв
- Үндэсний болон гадаадын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө
- Иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын дэмжлэг
- Бусад эх үүсвэр

Найм. Хөтөлбөрийн үр дүн

8.1. Төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг хангаснаар иргэд олон нийтийн мэдээллийн хүртээмж нэмэгдэнэ.

8.2. Шийдвэр гаргах түвшинд **иргэд олон нийтийн оролцоо нэмэгдсэнээр** хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ хангагдах нөхцөл бүрдэнэ.

8.3. Бүх шатны төрийн албан хаагчдын **мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, ёс зүй, хариуцлагын тогтолцоо шинэ түвшинд** хүргэснээр төрийн үйлчилгээний чанар хүртээмж дээшилнэ.

8.4. **Төр, иргэний харилцан итгэлцэл бэхжиж**, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшинд ахиц гарна.

Ес. Хяналт- шинжилгээ, үнэлгээ

9.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

9.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж байна.

9.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдлыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлнэ.

_____оОо_____

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 26-ны өдөр

Дугаар 166

Сүхбаатар

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг жил бүрийн аймаг, сумдын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Бүрэнбат/, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Нэг: Хөтөлбөр боловсруулах үндэслэл

Монгол Улсын “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” хууль, Засгийн газрын 2009 оны 299-р тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр”, 2005 оны 64-р тогтоолоор батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр”, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2007 оны 38-р тогтоолоор батлагдсан “Сэлэнгэ аймгийн хөгжлийн хөтөлбөр”-үүдийн хэрэгжилтийг орон нутагт эрчимжүүлж, жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн явц, үр дүнг сайжруулахаар аймгийн “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих” хөтөлбөрийг боловсрууллаа.

Хоёр. Сэлэнгэ аймгийн жижиг, дунд үйлдвэрийн өнөөгийн байдал

Сэлэнгэ аймагт жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр анх 2004-2008 онд Өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлж ажилгүйдэл, ядуурлыг бууруулан амьжиргааны чадавхийг дээшлүүлэх бодлогын зорилт тавин, аймаг орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажилласнаар өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг тогтворжуулж, 2004-2008 онд өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн тоог 6946 өрх буюу 68,5 хувиар нэмэгдүүлж, нийт өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо 2008 онд 17080 болсон нь жижиг дунд үйлдвэрлэл хөгжих эхлэл суурь болсон.

Аймгийн хэмжээнд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр 2009 оноос өрхийн үйлдвэрлэл дээр суурилсан жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх бодлого, чиглэл баримтлан 2009 оныг “Тохижилт-Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих” жил болгон зарлаж, зарласан жилийн хүрээнд орон нутгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Засгийн газрын болон аймгийн “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан” байгуулан үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийг 3 жилийн хугацаатайгаар олгож эхэлсэн.

2009-2012 онд Засгийн газрын болон аймгийн “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан”-гаас нийт 7,0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 400 гаруй иргэн, аж ахуйн нэгж, нөхөрлөл, хоршоо, иргэнд олгосноор жилд дунджаар 3-6 үйлдвэр

шинээр ашиглалтанд орж, үйлдвэрлэл үйлчилгээний бүтээгдэхүүн үйлдвэрлэлт нэмэгдэж байна.

2012 оны байдлаар татварт бүртгэлтэй 1711 аж ахуйн нэгж, үүнээс 1339 хязгаарлагдмал хариуцлагатай компани, 253 бүрэн бус нөхөрлөл, 119 хоршоо аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж тэдгээрт 8,5 мянган иргэн хөдөлмөрийн харилцаанд орон ажиллаж байна.

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нэр төрөл, тоо хэмжээгээр нь авч үзвэл 2009 онд гурил 458,1 тн, талх, нарийн боов, гурилан бүтээгдэхүүн 622,7 тн, ундаа 33,4 мянган литр, зайрмаг 17,0 мянган ширхэг, сүү 300,9 мянган литр, мах 6893,3 тн, хивэг 112,3 тн, зүсмэл 4486 м³, тоосго, блок 2489,3 мянган ширхэг, арматур төмөр 450 тн, хонины ноос 792,1 тн, ноолуур 139,5 тн, адууны шир 4833 ширхэг, үхрийн шир 14384 ширхэг, хонины арьс 78529 ширхэг, ямааны арьс 87101 ширхэг, төмс 43,6 мянган тн, хүнсний ногоо 29,2 мянган тн, зөгийн бал 7,4 мянган кг, гахайн мах 102,1 тн, өндөг 462,7 мянган ширхэг, тосны ургамал 3062 тн, хадлан тэжээл 22156,5 тн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 89,0 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна.

2012 онд гурил 80 тн, талх, нарийн боов, гурилан бүтээгдэхүүн 830,8 тн, ундаа 14,5 мянган литр, зайрмаг 8,4 мянган ширхэг, сүү 300,2 мянган литр, мах 8236,5 тн, хивэг 42 тн, зүсмэл 9350,6 м³, тоосго, блок 2818,4 мянган ширхэг, арматур төмөр 849,8 тн, хонины ноос 753,2 тн, ноолуур 124,4 тн, адууны шир 6543 ширхэг, үхрийн шир 23540 ширхэг, хонины арьс 74105 ширхэг, ямааны арьс 61099 ширхэг, төмс 62,2 мянган тн, хүнсний ногоо 34,0 мянган тн, зөгийн бал 15,6 мянган кг, гахайн мах 87,9 тн, өндөг 818,8 мянган ширхэг, тосны ургамал 7586 тн, хадлан тэжээл 26187 тн-ийг тус тус үйлдвэрлэж, 168,2 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Дээрх бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн нэр төрөл, тоо хэмжээг 2009 оныг 2012 онд харьцуулан дүгнэхэд 73,4 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Сум бүрт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээний тархац харьцангуй жигд биш байна. Орон нутгийн хэмжээнд өрхийн аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн тоо, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдэж байгаа хэдий ч дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд эзлэх хувь хэмжээ 31,2 хувийг бүрдүүлж байна.

Гурав: Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн зорилго, зорилт

3.1. Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь: Жижиг, дунд үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлж өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, өрхийн аж ахуй эрхлэгчдэд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх тааламжтай нөхцлийг бүрдүүлэх, ажлын байр шинээр бий болгох, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэхэд оршино.

3.2. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна:

3.2.1. Аймгийн хэмжээнд хөгжүүлэх жижиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх чиглэлийг бүсчлэн тогтоох;

3.2.2. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх таатай нөхцөл бололцоог бүрдүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй болгож, дэмжлэг үзүүлэх;

3.2.3. Жижиг, дунд үйлдвэрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, сургалт зохион байгуулах, мэдээллээр хангах, зөвлөх үйлчилгээг бий болгох;

3.2.4. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлж, борлуулалтын хэмжээг нэмэгдүүлэх;

3.2.5. Өрхийн аж ахуйн үйлдвэрлэлийг эрхлэх таатай орчинг бий болгож, жижиг дунд үйлдвэр болгон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, нөхцөл бололцоог бүрдүүлэх;

Дөрөв: Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. Аймгийн хэмжээнд хөгжүүлэх жижиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх чиглэлийг бүсчлэн тогтоох зорилтын хүрээнд:

4.1.1. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих аймгийн тэргүүлэх чиглэлийг тооцоо судалгаанд үндэслэн тодорхойлж, батлуулах;

4.1.2. Жижиг, дунд үйлдвэрийг Засгийн газраас хэрэгжүүлж буй үйлдвэрлэл технологийн паркттай уялдуулан хөгжүүлэх;

4.1.3. Жижиг, дунд үйлдвэрлэлд зориулсан санхүүгийн эх үүсвэрийг тодорхой чиглэл, зорилготойгоор үр өгөөжтэй зарцуулах, хөрөнгө оруулалт, үр ашигтай хэлбэрүүдийг нэвтрүүлэх;

4.2. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх таатай нөхцөл бололцоог бүрдүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй болгож, дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд:

4.2.1. Жижиг, дунд үйлдвэрийн эрх зүйн байдлын тухай хуулийг жижиг дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдэд сурталчлах;

4.2.2. Хувийн хэвшлийн бүтээлч шинэлэг, санал, санаачилгыг дэмжих;

4.2.3. Жижиг, дунд үйлдвэрлэлд орчин үеийн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн түвшинг нэмэгдүүлэх;

4.2.4. Нэмүү өртөг шингэсэн экспортын бараа бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх;

4.2.5. Орон нутгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд тэргүүн ээлжинд оролцуулах;

4.2.6. Аймаг, сумын хэмжээнд жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагаанд явуулдаг хяналт, шалгалтын давхардлыг арилгах;

4.2.7. Жижиг, дунд үйлдвэрийн чиглэлээр гаргах шийдвэрийн төслийг боловсруулах, хэлэлцэхдээ олон нийтийн санал, санаачилгыг тусгадаг байх;

4.2.8. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн холбоодын үйл ажиллагааг дэмжих;

4.3. Жижиг, дунд үйлдвэрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, сургалт зохион байгуулах, мэдээллээр хангах, зөвлөх үйлчилгээг бий болгох зорилтын хүрээнд:

4.3.1. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;

4.3.2. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг сургалт семинарт хамруулж, шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг тогтмолжуулах;

4.3.3. Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг түшиглэн жижиг, дунд үйлдвэрийн салбарт ажиллагсдын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах;

4.3.4. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зориулсан аймаг, орон нутгийн цахим хуудас ажиллуулах;

4.3.5. Бизнес эрхлэгчдэд зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах бизнес мэдээллийн төв, бизнес аялал бий болгох;

4.4. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлж, борлуулалтын хэмжээг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

4.4.1. Сэлэнгэ аймагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний танилцуулгыг бэлтгэн, иргэд олон нийтэд сурталчлах зорилгоор аймгийн төвд сумдын “Соёл, эдийн засгийн өдөрлөг”, бусад аймагт үзэсгэлэн худалдаа зохион байгуулах;

4.4.2. Сав баглаа, боодолтой бараа бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлэх;

4.4.3. Зураасан кодтой болон тохирлын тэмдэгтэй бараа бүтээгдэхүүнийг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;

4.4.4. Байгууллага, аж ахуйн нэгж, томоохон үйлдвэрүүдийн туслах материалыг орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах ажлыг зохион байгуулах /шуудай, ажлын хувцас, бараа материал, хүнсний бүтээгдэхүүн гэх мэт/

4.4.5. Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй нэгдсэн арга хэмжээнүүдийн хангамж, үйлчилгээнд аймгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хэрэглэдэг болох;

4.4.6. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн хүнсний хэрэгцээнд жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр хангах ажлыг зохион байгуулах;

4.5. Өрхийн аж ахуйн үйлдвэрлэлийг эрхлэх таатай орчинг бий болгож, жижиг дунд үйлдвэр болгон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж нөхцөл, бололцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд:

4.5.1. Өрхийн аж ахуй эрхлэгчдийн мэдээллийн сан бий болгож, бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн мэдээг улирал, хагас бүтэн жилээр статистик мэдээнд оруулах;

4.5.2. Өрхийн аж ахуй эрхлэгчдийг жижиг дунд үйлдвэр болгох, хоршоо нөхөрлөлийн зохион байгуулалтанд оруулах чиглэлээр сургалт, сурталчилгааг зохион байгуулах;

4.5.3. Хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг өрхийн аж ахуй эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг боловсруулах чиглэлээр бодлого боловсруулан хэрэгжүүлэх;

Тав: Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах санхүүгийн эх үүсвэрийг ашиглана. **Үүнд:**

5.2.1. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөрөнгө оруулалт, хөгжлийн сан

5.2.2. Олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламж

5.2.3. Бусад эх үүсвэрээс

Зургаа: Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, үе шат

Хөтөлбөрийг 2014 оноос эхлэн 4 жилийн хугацаатайгаар хэрэгжүүлнэ.

Долоо: Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүн

7.1. Аймгийн эдийн засгийн өсөлт хурдасна.

7.2. Аймгийн жижиг, дунд үйлдвэрүүдийн зах зээл дээр өрсөлдөх чадвар нэмэгдэнэ.

7.3. Хүн амын хөдөлмөр эрхлэлт нэмэгдэнэ.

7.4. Ажилгүйдэл ядуурал буурна.

7.5. Хүн амын өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэлтийг нэмэгдүүлнэ.

7.6. Импортын барааг орлох бүтээгдэхүүний тоо хэмжээ өснө.

7.7. Мэргэжилтэй, мэргэшсэн ажилчдын тоо нэмэгдэнэ.

Найм: Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

8.1. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын шалгуур үзүүлэлт: Аймгийн хэмжээнд хөгжүүлэх жижиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх чиглэлийг бүсчлэн тогтоож,

бүсийн төв, сумдын жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийн өсөлтийн тоо хэмжээ зэрэг болно.

8.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын шалгуур үзүүлэлт: Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдээс өгсөн үнэлгээ-санал асуулгын дүнгээр төрийн үйлчилгээний талаарх бизнес эрхлэгчдээс гарсан гомдлын тооны бууралт, хяналт-шалгалтын үр дүн, үр нөлөө, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг мэдээ мэдээллээр хангасан байдал, түүний хүртээмж, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, хөгжлийн сан, арилжааны банкнаас олгосон зээлийн өсөлт зэрэг болно.

8.3. Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын шалгуур үзүүлэлт: Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зориулсан сургалт, зөвлөгөө, үйлчилгээний тоо хэмжээ, түүний үр нөлөө, байгуулсан бизнес инкубатор, тэдгээрийн үр дүн, үр нөлөө, төрийн бус байгууллага, үүсгэл санаачилгын байгууллага, иргэдийн оролцооны өсөлт зэрэг болно.

8.4. Хөтөлбөрийн 4 дүгээр зорилтын шалгуур үзүүлэлт: Жижиг, дунд үйлдвэрийн тоо болон тэдгээрийн үйлдвэрлэл, борлуулалтын өсөлт, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ зэрэг болно.

8.5. Хөтөлбөрийн 5 дугаар зорилтын шалгуур үзүүлэлт: Өрхийн аж ахуй эрхлэгчдийг жижиг, дунд үйлдвэр болгон нэмэгдүүлсэн тоо, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн мэдээллийн сан, тэдгээрт зориулсан сургалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн өсөлт, үйлдвэрлэлээ өргөжүүлсэн зэрэг болно.

_____оОо_____

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 26-ны өдөр

Дугаар 168

Сүхбаатар

Ой тэмдэглэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдалын ой тэмдэглэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1.Мандал сум байгуулагдсаны 90 жилийн ойг 2014 оны 08 дугаар сард тэмдэглэхийг зөвшөөрсүгэй.

2.Ойгоо угтаж сумынхаа байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, иргэдийн идэвх санаачилгыг өрнүүлэн тодорхой бүтээлч ажил зохион байгуулж ажиллахыг тус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад даалгаж, сумын нийт иргэдэд уриалсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 26-ны өдөр

Дугаар 169

Сүхбаатар

Ой тэмдэглэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдалын ой тэмдэглэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1.Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Улсын Тэргүүний 4 дүгээр цэцэрлэг байгуулагдсаны 70 жилийн ойг 2014 оны 09 дүгээр сард тэмдэглэхийг зөвшөөрсүгэй.

2.Ойгоо угтаж байгууллага, хамт олныхоо идэвх санаачилгыг өрнүүлэн тодорхой бүтээлч ажил зохион байгуулж ажиллахыг тус цэцэрлэгийн хамт олонд уриалсугай.

3.Ой угтсан ажил болон ой тэмдэглэх арга хэмжээнд удирдлага зохион байгуулалтын дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Эхийг бэлтгэсэн: Ш.Баярмаа
Хянасан: Ж.Санжжав
Э.Оюунболд